



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙН
ҮЕД БОЛОВСРОЛЫН ЧАНАР,
ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ



Төслийн дугаар: L3594-MON

2021 оны 11 сар

**МОНГОЛ УЛС: ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙН ҮЕД БОЛОВСРОЛЫН
ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ**

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАХ БИЧИГТ ХИЙСЭН
ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮНГИЙН ТАЙЛАН**

Тайланг хүлээн авсан:

(Т.Ням-Очир, БШУЯ-ны БДБГ-ын
дарга)

Тайланг хүлээлгэн өгсөн:

Төслийн багийн ахлагч Доктор,
Профессор С.Төмөр-Очир

Академич, Б.Жадамба

Доктор, Проф. Ц. Өнөрбаян

Доктор, Проф. Ч.Ганзориг

Доктор, С.Цогбадрах

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	3
1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ДИЗАЙН	7
2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	8
3. ХЭСГҮҮДИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ДҮГНЭЛТ	14
4. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ	118
5. ХАВСРАЛТ.....	122

ӨМНӨХ ҮГ

Ази, номхон далайн улс орнууд XXI зууны суралцагчдын шинэ чадамжийг тодорхойлсон байдлыг авч үзэхэд бүтээлч болон шинэлэг сэтгэлгээний айн хүрээнд (бүтээлч сэтгэх, зохион бүтээх, хувиараа бизнес эрхлэх, хэрэглэх, эргэцүүлэн бодох, шийдвэр гаргах); хүмүүс хоорондын харилцааны айн хүрээнд (харилцан ойлголцох, зохион байгуулах, багаар ажиллах, хамтарч амьдрах, нийтэч байх, эвсэг байх, өөрийгөө бусдын байр сууринд тавих); хувь хүний айн хүрээнд (хувийн сахилга бат, бие даан суралцах, дасан зохицох, өөрийгөө мэдэх, хувийн сэдэл тэмүүлэл, шударга, өөрийгөө хүндлэх); дэлхийн иргэний айн хүрээнд (дэлхийн иргэний мэдлэг, ойлголттой байх, хүлээцтэй, нээлттэй, хариуцлагатай, ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах, ёс суртахуунтай, олон талт соёлыг ойлгох, зөрчилдөөнийг шийдвэрлэх, чөлөөт оролцоо, шийдвэр гаргах, хүрээлэн буй орчиндоо хайр гамтай хандах, үндэсний онцлогоо мэдэх, бусдаас хамааралтай гэдгээ мэдэх); мэдээллийн технологийн айн хүрээнд (мэдээлэл харилцааны технологи хэрэглэн мэдээлэл олж авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, мэдээллийн технологийг ёс суртахуунтай хэрэглэх) тус тус тодорхойлжээ (эх сурвалж: ЮНЕСКО-ын Бангкок дах ERI-Net судалгааны төв, 2015).

Дэлхийн инновацын 2018 оны барометр тайланд улс оронд инновацын гол тоглогч нь жижиг үйлдвэр, компани байхаа больж их сургуулиуд, судалгааны лабораториуд болон өөрчлөгдөж буй төлөв байдал болдгийг тэмдэглэжээ. Түүнээс гадна инновацыг үр ашигтай хөгжүүлж нэвтрүүлэхэд саад болж байгаа гол хүчин зүйл бол авьяастай залуучууд болон шаардлагатай ур чадвар эзэмшсэн хүний дутагдал гэж дэлхийн томоохон компаниудын удирдлагуудын 64 хувь нь үзэж байна.

Боловсролын тогтолцооны хамгийн том өөрчлөлт бол багшлахаас суралцахууд шилжих шилжилт юм. Бүтээлч сэтгэлгээ, асуудал шийдэх, шинийг санаачлах, харилцааны соёл, хамтран ажиллах зэрэг зөөлөн ур чадварыг робот хийх боломжгүй учраас боловсролын тогтолцоо тийм зүйлсийг агуулсан ур чадварыг эзэмшүүлэхэд илүүтэй анхаарах болж байна гэж үзжээ (Бадарч, 2019, х.32, 34).

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын “Ирээдүйн боловсрол ба ур чадвар 2030” төсөлд XXI зууны иргэнд төлөвшүүлэх, өдөр тутмын амьдралдаа ашиглах суурь эрдэмд бичиг үсэгт тайлагдах, тоо бодох, шинжлэх ухааны, мэдээлэл харилцаа холбооны болон санхүүгийн мэдлэг, соёл хийгээд иргэний боловсролыг; Нарийн төвөгтэй асуудлуудыг шийдвэрлэхэд ашиглах чухал ур чадваруудад шүүмжлэлт болон асуудал шийдвэрлэх, бүтээлч сэтгэлгээ, харилцааны ур чадвар, багаар ажиллах чадварыг; Хүрээлэн буй орчин, нийгмээ өөрчлөхөд ашиглах хувийн давуу чанаруудад сониуч, санаачилгатай, тууштай байдал, дасан зохицох чадвар, манлайлал, нийгэм ба соёлын ухамсар зэрэг ур чадваруудыг авч үзсэн байна.

ЮНЕСКО-ын ТХЗ-ын төлөөх боловсрол суралцахуйн зорилт зөвлөмжид тогтолцооны сэтгэлгээний, урьдчилан тооцоолох, хэм хэмжээний, стратегийн, хамтран ажиллах, шүүмжлэлт сэтгэлгээ, өөрийгөө таньж мэдэх зэрэг долоон цогц чадамж дээр тэдгээрийг хамтад нь хэрэглэж асуудал шийдвэрлэх нэгдсэн цогц чадамжийг нэмж тогтвортой боловсролын түлхүүр цогц чадамж гэж нэрлэжээ (Тогтвортой хөгжлийн боловсролыг ерөнхий боловсролын сургуулийн сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд интеграцчилах арга зүй, 2018, х.95).

XXI зууны эхний хагасын Монголын боловсролын зорилго нь бага боловсролын агуулга дахь монгол хүний төлөвшлийн суурийг шинэ зууны дэлхийн иргэнд шаардагдаж буй боловсролын нийтлэг шаардлагад нийцүүлэн олгох, дунд боловсролоор монгол хүнийг хөгжүүлэх сургалтын агуулгыг олон улсын түвшинд, түүний дотор зэргэлдээх хоёр том үндэстний хүүхэд залуучуудын боловсролоос дутахгүй түвшинд эзэмшүүлэх гэж хэлж болохоор байна. Манай бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгчид зах зээлийн шинэ хэрэгцээг анхааралтай ажиглаж, монгол хүнээ боловсруулж хөгжүүлэхдээ түүнд байгаа цаашид хөгжүүлэн авч явах сайхан чанарууд, бага наснаас нь дарж унтраавал зохих муу шинжүүд, бусад хүчирхэг үндэстнүүдээс суралцаж эзэмшвэл зохих ур чадварууд гэсэн бүрэлдэхүүн бүхий сургалтын агуулгын философийг боловсролын бодлогодоо тусгаж, монгол хүнээ хөгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна (Н.Бэгз, 2019, х.26,29).

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын боловсролын хөгжлийн стратеги, удирдлага, зохион байгуулалтын 3 дугаар зүйлд: Сургуулийн өмнөх, бага болон дунд боловсролын сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн стандартыг шинэчлэн боловсронгуй болгоно гэжээ. (төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, 2014-2024 он)

Бага, дунд боловсролын түвшинд хэрэглэгдэх багшийн болон сурагчийн ном, цахим, аудио, видео зэрэг сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүнээс бүрдсэн сурах бичигт тавигдах шаардлага, стандартыг шинэчлэн боловсруулна гэж заажээ. (Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр, 2013, 6.5.4 дэх заалт)

Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн нь бага, дунд боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан байна гэж тусгажээ. (Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр, 2013) Өнөөдрийг хүртэл бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага буюу (MNS5418:2018) стандартыг сурах бичгийн эх зохиох, эх бэлтгэхэд мөрдөж ирсэн хэвээр байна.

2014-2015 оны хичээлийн жилээс бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг, 2015-2016 оны хичээлийн жилээс суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг, 2016-2017 оны хичээлийн жилээс бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг практикт хэрэгжүүлж, эдгээр цөм хөтөлбөрийн дагуу бага, суурь, бүрэн дунд боловсролын сурах бичгүүдийг зохиож, сургалтад хэрэглэж ирлээ.

Сурах бичгийн хангамжийн оновчтой, тогтвортой тогтолцоо бүрэлдэж төлөвшөөгүйтэй холбоотойгоор сурах бичгийн хөгжил бүрэн хангагдаагүй байгаа бөгөөд сурах бичгийн чанар тасралтгүй сайжирч байх, хөрөнгө оруулалт үр ашигтай байх зарчмууд алдагдах хандлагатай байна. 2009-2018 оны хооронд бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлагын (MNS5418:2018) дагуу нийт 217 сурах бичиг шинээр хэвлэгдсэнээс өнөөдрийн байдлаар 106 сурах бичгийг сургалтад хэрэглэж байгаа бөгөөд хэвлэгдсэн нийт сурах бичгийн 48.8 хувь буюу 111 сурах бичгийг албан ёсоор сургалтад хэрэглэхгүй болжээ. 2013 оноос хойш хэвлэгдсэн V, VI, VII, X, XI, XII дугаар ангийн 80 орчим сурах бичиг 2-3 жил хэрэглэгдээд хүчингүй болсон бөгөөд хүчингүй болохоор байна.

БШУ-ны сайдын 2021 оны 3 сарын 31-ний өдрийн А/134 тоот тушаалаар батлагдсан ажлын хэсэг 2021 оны 4 сарын 1-ээс 10 сарын 1 хүртэл 6 сарын турш ажиллаж тайлангаа бичлээ. Сурах бичиг, түүний дагалдах багцын (дасгалын ном, багшийн ном, хэрэглэгдэхүүн) өнөөгийн хөгжлийн төлөв байдалд дүгнэлт хийж, цаашид сурах бичгийн талаарх үзэл баримтлал, баримтлах бодлого, стандарт, үнэлгээний үндсэн асуудлуудыг шинээр авч үзэн, шийдвэрлэх арга замыг тодорхойлох нь судалгааны үндсэн зорилго байлаа. Сурах бичгийг

шинжлэхдээ ангилах, харьцуулах, тайлбарлах, задлан шинжилгээ хийх, үнэлэх, бүтээх, асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах, шинжлэн судлах аргуудыг хэрэглэн бодлого, дасгал, даалгавар, туршилт сорилын ажил, кейстэй ажиллаж үйлийн явцдаа мэдлэгт суралцахаас гадна амьдрахуй ухааны арга, ёс суртахууны хүмүүжил төлөвшлийн арга зүйг дэмжих боломжтой эсэхийг тодрууллаа. Сурах бичиг бүхий багцад дэлхийн иргэний боловсрол, тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санаа, сурагчдын танин мэдэхүй, нийгэмшил, сэтгэл хөдлөл, зан үйл, үнэт зүйл, хандлагын агуулга болон Монголын түүх, соёл, өв уламжлалын талаар хэрхэн тусгасан байгааг илрүүлж тогтоосон юм.

Судлагдахуун бүрээр МУИС, МУБИС, ШУА-ийн эрдэмтэд, ерөнхий боловсролын сургуулийн багшаас бүрдсэн 45 хүний бүрэлдэхүүнтэй ерөнхий болон тухайн мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн 13 дэд ажлын хэсэг ажиллалаа. Ерөнхий ажлын хэсгийн ахлагчаар Стратеги судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, Монгол улсын гавьяат багш, доктор, профессор С.Төмөр-Очир, гишүүдээр МУБИС-ийн БСС-ийн боловсролын суурь судалгааны төвийн эрхлэгч, Ардын багш, академич Б.Жадамба, МУБИС-ийн Монгол судлалын төвийн эрхлэгч, Ардын багш, доктор, профессор Ц.Өнөрбаян, МУИС-ийн лабораторын эрхлэгч доктор, профессор Ч.Ганзориг, Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор С.Цогбадрах нар ажиллалаа. Монгол хэл, уран зохиолын дэд ажлын хэсэгт ШУА-ын Хэл зохиолын хүрээлэнгийн захирал, доктор, профессор Ж.Бат-Ирээдүй, Магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн ажлын албаны мэргэжилтэн Г.Даваажаргал, Монгол судлалын үндэсний академийн эрдэм шинжилгээний ажилтан А.Мөнхцэцэг, Орхон аймгийн 4 дүгээр сургуулийн багш Б.Чимэгбаяр. Гадаад хэлний дэд ажлын хэсэгт МУИС-ийн гадаад хэлний сургалтын төвийн эрхлэгч дэд профессор Д.Отгонтуяа, МУИС-ийн тэнхмийн эрхлэгч, дэд профессор М.Даариймаа, ШУТИС-ийн багш, доктор, профессор Г. Томтогтох, Нийслэлийн 49 дүгээр сургуулийн багш Н.Нямдаваа. Математикийн дэд ажлын хэсэгт МУИС-ийн багш, доктор, дэд профессор Д.Түмэнбаяр, МУБИС-ийн математик, байгалийн ухааны сургуулийн захирал, доктор, Т.Ганбаатар, МУБИС-ийн ерөнхий боловсролын сургуулийн багш Д.Амгалан. Мэдээлэл зүйн дэд ажлын хэсэгт МУИС-ийн багш, доктор, дэд профессор А.Энхбаяр, МУБИС-ийн багш, доктор, профессор М.Мижиддорж, ерөнхий боловсролын” Сант” сургуулийн багш Б.Цогтбаатар. Дүрслэх урлаг, технологийн дэд ажлын хэсэгт Хангай дээд сургуулийн багш, доктор, профессор Ц.Цэвээн, МУБИС-ийн Дүрслэх урлаг, технологийн сургуулийн захирал, доктор, дэд профессор А.Энхмаа, Хөгжмийн дэд ажлын хэсэгт СУИС-ийн багш, Төрийн соёрхолт С.Соронзонболд, МУБИС-ийн багш О.Шинэбаяр, ерөнхий боловсролын ”Монгол тэмүүлэл” сургуулийн багш Г.Эрдэнэбат. Биологийн дэд ажлын хэсэгт МУИС-ийн багш, доктор, дэд профессор Д.Нарангарвуу, МУБИС-ийн багш, доктор Г.Онолрагчаа, ерөнхий боловсролын “Шинэ үе” сургуулийн багш Б.Чинзориг, Физикийн дэд ажлын хэсэгт ШУА-ын Физик, технологийн хүрээлэнгийн захирал, академич Ж.Даваасамбуу, МУБИС-ийн захирал, доктор, дэд профессор О.Алтангоо, Нийслэлийн 1 дүгээр сургуулийн багш Г.Ганбаяр. Химийн дэд ажлын хэсэгт МУБИС-ийн зөвлөх багш, доктор, профессор Ц.Сумъяа, ерөнхий боловсролын ”Шинэ Монгол” сургуулийн багш Г.Ганжаргал. Газар зүйн дэд ажлын хэсэгт МУИС-ийн тэнхмийн эрхлэгч, доктор, профессор В.Батцэнгэл, МУБИС-ийн багш, доктор, профессор С.Хадбаатар, ерөнхий боловсролын “Арвист Хангай” сургуулийн багш Б.Энхсүрэн.

Нийгмийн ухааны дэд ажлын хэсэгт МУИС-ийн багш, доктор, профессор Р.Дарьхүү, МУБИС-ийн багш Б.Батзаяа, ерөнхий боловсролын “ЖЭТ тэмүүлэл” сургуулийн багш Э.Баасанцэрэн. Түүхийн дэд ажлын хэсэгт МУИС-ийн тэнхмийн эрхлэгч, доктор, профессор П.Дэлгэржаргал, ерөнхий боловсролын “Харамафүжи” сургуулийн багш

Б.Баярмаа, “Үй-цай” сургуулийн түүхийн багш Н. Наранжаргал, Казак сурах бичгийн дэд ажлын хэсэгт МУБИС-ийн багш, доктор, профессор Ц.Гантулга, МУИС-ийн багш, доктор, профессор Б.Алтангул, Монгол улсын гавьяат багш, доктор, профессор Н.Оюунцэцэг нар ажиллав. Ажлын хэсэгт ахмад, дунд насны болон залуу багш нарыг оролцууллаа. Ажлын хэсэгт эрдмийн зэрэг цолтой профессорууд 34, ерөнхий боловсролын сургуулийн 11 багш ажиллав. Математикаас бусад дэд ажлын хэсэг тус бүр өөрсдийн хариуцсан мэргэжлийнхээ чиглэлийн сурах бичгүүдийг контент анализын арга зүйн дагуу шинжилсэн. Математикийн дэд ажлын хэсэг “TIMMS”-ийн хүрээний сурах бичиг судлалын арга зүйн дагуу 1-12 дугаар ангийн математикийн сурах бичгийг шинжилсэн.

Ажлын хэсэг Боловсролын ерөнхий хуульд 14 санал, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хуульд 4 санал боловсруулж БШУЯ-д хүргүүлсэн болно.

Мөн Стандартчлал, Хэмжил зүйн Үндэсний Зөвлөлийн 2008 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 06 тоот тогтоолоор баталсан Монгол улсын стандарт, Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага (MNS 5418.2008) ыг шинэчлэх, сурах бичиг зохиох, хэвлэх түгээх тогтолцоо, сурах бичиг зохиох, хэвлэх түгээх журам, Бага дунд боловсролын хэвлэмэл болон цахим сурах бичигт тавигдах шаардлагын төсөлд санал өглөө. Саналууд бараг бүгд боловсролын баримт бичигт тусгагдсан талаар БШУЯ-аас хариу ирсэн болно.

Ажлын хэсэг Стандартчлал, Хэмжил зүйн Үндэсний Зөвлөлийн 2008 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 06 тоот тогтоолоор баталсан Монгол улсын стандарт, Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага (MNS 5418.2008)-д үндэслэн ерөнхий боловсролын сургуульд одоо ашиглаж байгаа 35 судлагдахууны (казах хэл дээрх сурах бичиг давхардан тоологдсон) 174 сурах бичигт (34 нь казах сурах бичиг) агуулга, арга зүй, найруулга, зөв бичгийн дүрэм (логик холбоо) болон дизайн д тавигдах шаардлага гэсэн 4 үзүүлэлтээр SWOT шинжилгээ хийж нийт 2500 орчим хуудас судалгааны эх бэлтгэж БШУЯ, Боловсролын хүрээлэнд хүлээлгэн өглөө.

Сурах бичгийн шинжилгээний дүнг 2021 оны 9 дүгээр сарын 18 -ний өдөр Их, дээд, ерөнхий боловсролын сургуулийн профессор багш нар, Боловсролын хүрээлэнгийн эрдэмшинжилгээний ажилчин, эрдэмтэд, ТББ-ын төлөөлөгчид нийт 97 хүн оролцсон ONLINE хэлэлцүүлэгт танилцуулж 55 хүний санал сэтгэгдлийг нь авсан болно. Мөн 2021 оны 10 дугаар сарын 1-ний өдөр БШУ-ны сайд, газрын дарга нарт биечлэн танилцуулж саналыг нь авлаа.

Энэ бүхнийг нэгтгэн бид нэр томъёоны тайлбар; судалгааны зорилго, дизайн, судалгааны арга зүй, хэсгүүдийн шинжилгээний үр дүн, дүгнэлт ерөнхий дүгнэлт; ашигласан материал; хавсралт гэсэн бүтэц бүхий тайлан болгон та бүхэнд танилцуулж байна.

Төгсгөлд нь энэ бүх ажлыг гүйцэтгэхэд ихээхэн туслалцаа үзүүлж хамтарч ажилласан БШУ-ны яамны бодлого төлөвлөлтийн болон бага дунд боловсролын газрын ажилтнууд, Боловсролын хүрээлэнгийн эрдэмшинжилгээний ажилчид, эрдэмтэд, Азийн хөгжлийн банкны мэргэжилтнүүдэд талархал илэрхийлье.

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

1. Сурах бичгийн багц нь багш суралцагчийн ном, багшийн гарын авлага, дасгал бодлогын хураамж, тестийн ном, суралцагчийн ажлын дэвтэр иж бүрдэл.
2. Сурах бичиг нь боловсролын бодлого, сургалтын хөтөлбөрийн зорилгод нийцсэн, суралцахуйн онол, арга зүйн дидактик шийдлийг цогцоор шийдвэрлэсэн, (шинжлэн судлах, асуудал шийдвэрлэх, мэдээлэлтэй ажиллах арга барилд суралцаж, бие даан болон хамтын үйл ажиллагаагаар хэрэгцээт мэдлэгээ бүтээж, мэдлэгээ хэрэглэн аливаа тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд дэмжих дидактик шийдэлтэй), үндсэн болон сонгох хувилбар бүхий багц хэрэглэгдэхүүн юм.
3. Сурах бичгийн агуулга нь нэг талаас суралцагчдын шинжлэх ухааны мэдлэг, чадвар, хандлага төлөвшүүлэх, мэдлэг бүтээх үйлийг дэмжсэн дидактик боловсруулалтын цогц нөгөө талаас мэдлэг, чадвар, хандлага төлөвшүүлэх, мэдлэг бүтээх үйлийг дэмжсэн бичвэр (шинжлэх ухааны мэдээ, мэдээлэл) болон бичвэр бус (зураг, хүснэгт, график, диаграмм, бүдүүвч гэх мэт) мэдээллийн дидактик боловсруулалт юм. Сурах бичгийн агуулга нь түүнд тавих шаардлага, шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдоно.
4. Сурах бичгийн арга зүй нь нэг талаас суралцагчдын суралцах болон шинжлэх ухаанч арга барил, мэдлэг бүтээх үйл, хандлагыг дэмжсэн дидактик шийдэл нөгөө талаас сурах бичгийн бүлэг сэдэв бүрт шинжлэх ухаанч, асуудал шийдвэрлэх, мэдээлэлтэй ажиллах, бүтээлч эрэл хайгуул хийх туршилт, дадлага ажил, дасгал, даалгавруудыг боловсруулсан, тэдгээр нь суралцагч бие даан болон хамтарч суралцах арга барил эзэмшихэд нь чиглэсэн дидактик шийдэл юм.
5. Баримтын мэдлэг - тухайн сэдвээр асуудал шийдэхэд зайлшгүй хэрэг болох хэн, юу гэсэн асуултанд хариулагдах суурь ойлголт, ухагдахуун, мэдээ, баримт.
6. Концепцийн буюу ухагдахууны мэдлэг нь суралцагчдын эзэмшвэл зохих аливаа юмс үзэгдлийн дотоод мөн чанар, зүй тогтол, учир шалтгаан, холбоо хамаарал, онол, концепци.
7. Үйлийн мэдлэг нь арга, аргачлал, алгоритм, ур дүй ашиглан аливааг хэрхэн хоорондоо нягт уялдсан эрэмбэ дараалалтай гүйцэтгэх, шинжлэн турших үйлдлүүдийн цогц.
8. Метакогнитив мэдлэг нь суралцагчдын сэтгэж танин мэдэх үйлийг жолоодох аливааг яаж мэдэж, ойлгож байгаага мэдэхүй, түүний үр дүн.

1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ДИЗАЙН

Судалгааны зорилго


Сурах бичиг, түүний дагалдах багцын (дасгалын ном, багшийн ном, хэрэглэгдэхүүн) өнөөгийн хөгжлийн төлөв байдалд дүгнэлт хийж, цаашид сурах бичгийн талаарх үзэл баримтлал, баримтлах бодлого, стандарт, үнэлгээний үндсэн асуудлуудыг нээн илрүүлж шийдвэрлэх арга замыг тодорхойлоход судалгааны үндсэн зорилго оршино.

Сурах бичгийг ангилах, харьцуулах, тайлбарлах, задлан шинжилгээ хийх, үнэлэх, бүтээх, асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах, шинжлэн судлах аргуудыг хэрэглэн бодлого, дасгал, даалгавар, туршилт сорилын ажил, кейстэй ажиллаж үйлийн явцдаа мэдлэгт суралцахаас гадна амьдрахуй ухааны арга, ёс суртахууны хүмүүжил төлөвшлийн арга зүйг дэмжих боломжтой эсэхийг тодруулна.

Сурах бичиг бүхий багцад XXI зууны боловсрол, дэлхийн иргэний боловсрол, тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санаа, сурагчдын танин мэдэхүй, нийгэмшил сэтгэл хөдлөл, зан үйл, үнэт зүйл, хандлагын агуулга болон монголын түүх, соёл, өв уламжлалын талаар тусгасан байгааг илрүүлж тогтооно.

Судалгааны дизайн

Одоо ашиглагдаж байгаа 1-12 дугаар ангийн бүх мураг бичгүүдийн ажлын хэсэг дараах судалгааны дизайны дагуу шинжилсэн болно.



2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

2.1 Сурах бичгийн онол, арга зүй

Сурах бичгийг бүтээхэд баримтлах онолын үндэс: Орчин үеийн сурган хүмүүжүүлэх сэтгэл судлалын ухаанд суралцахуйн үйл ажиллагааны онол томоохон байр суурь эзэлдэг.

Швейцарийн эрдэмтэн Жан Пиаже (1896-1980), Джером Брунер, Хейнц Вернер нарын зэрэг когнитив сэтгэл судлаачид хүн мэдээллийг зөвхөн хүлээн аваад зогсохгүй түүнийг бүтээлчээр боловсруулж бүтээж чаддаг онцлогтойгоос гадна хүн бүр сэтгэгч, бүтээгч гэж тайлбарласан байдаг. Хүний хөгжил нь мэдээлэл боловсруулах арга барил хэр эзэмшсэнтэй ихээхэн холбоотой гэж үздэг. Хүүхдийн гаднаас хүлээн авч буй мэдээлэл түүний оюун ухааны бүтцэд (урьд нь эзэмшсэн мэдлэгийн бүтцэд) тохирч байвал хүүхэд тэрхүү мэдээллийг хүлээн авч ойлгодог. Энэ процессийг ассимиляц хэмээн нэрлэжээ.

Мэдээлэл нь хүүхдийн урьд нь эзэмшсэн мэдлэгийн бүтцэд тохирохгүй бол тэрээр хүлээн авдаггүй, мэдээллийг үгүйсгэдэг. Ийм тохиолдолд урьд нь бий болсон оюун ухааны бүтцийг өөрчилдөг байна. Түүнийг аккомодац гэж нэрлэжээ. (Цогбадрах, 2018, х.35)

Швейцарын эрдэмтэн Ж.Пиажегийн онолыг сурах бичгийн дидактикийн хүрээнд авч үзвэл:

- Сурах бичгийн туршилт, дадлага ажил, бичвэр, зураг, хүснэгт, график, бүдүүвч, дасгал, даалгавар зэргийг ассимиляц (шинэ мэдлэгийг өмнөх мэдлэг, чадвартай холбож ойлгох) болон аккомодац (өмнөх мэдлэгээ сэргээн санаж, идэвхтэй үйлийг

бие дааж гүйцэтгэсэнээр шинэ мэдлэгтэй холбож ойлгох) хэлбэрээр тооцон боловсруулахыг шаардана.

Нийгэм, соёлын Конструктив онолын гол төлөөлөгч Оросын эрдэмтэн Л.С Выготский (1896-1934) хүний сэтгэцийн хөгжлийг нийгмийн орчин, соёл, түүхэн нөхцөлтэй салшгүй холбоотой авч үзжээ. Энэ онол нь хүн төрөлхтний боловсруулсан соёлыг өсвөр залуу үе нь эзэмших, хөгжих өвөрмөц үйл явц болох суралцахуйн мөн чанар болон онцлогийг судалдаг.

Нийгэм, соёлын онол (Л.С Выготский)- ыг сурах бичгийн дидактикийн хүрээнд авч үзвэл:

- Бичвэр болон бичвэр бус мэдээлэлтэй (зураг, график, хүснэгт, бүдүүвч) дасгал, даалгавар, туршилт, дадлага ажлыг суралцагч өөрөө бие дааж хийхээс гадна багш, бусад суралцагчдын дэмжлэгтэйгээр боловсруулж хэрэглэнэ.
- Туршилт, дадлага ажил, тэдгээрийг гүйцэтгэх дараалал болон даалгавар тус бүрийн аргачлал суралцагчдад тодорхой байхаар боловсруулна гэж ойлгоно.(Цогбадрах, 2018, х.36-37)

Конструктив онолын нэгэн чиглэл болох суралцахуйн үйл ажиллагааны онолд эзэмшихүй, суралцахуй, үйлийн баримжаа гэсэн ухагдахуунууд гол байр эзэлдэг.Үйл ажиллагааны онолоор мэдлэг бүтээх зүй тогтлыг эзэмших үйл явц гэж үздэг юм.

Эзэмшихүйн зүй тогтлын дагуу явагдах учир шалтгаант үйл ажиллагааны дүнд хүн хөгждөг.Эзэмшихүй нь олон үе шаттай бөгөөд түүний мөн чанар нь үйлийн гадаад, дэлгэрэнгүй, материаллаг хэлбэрээс завсрын тодорхой хэлбэрүүдийг дамжин дотоод, хураангуй оюуны хэлбэрт шилждэгт оршино. Суралцагсадад оюуны үйлийг төлөвшүүлэхдээ сэтгэцийн үйлийн залгамж холбоотой байх зарчмын дагуу материалжсан хэлбэрээр сэрж мэдрэх түвшинд, дараа нь бусадтай, өөртэй нь яриулах гадаад ярианы түвшинд, эцэст нь эргэцүүлэн бодох дотоод ярианы хэлбэрээр сэтгэхүйн түвшинд эзэмшүүлдэгийг тогтоосон байна. Үйл нь эдгээр үе шатуудыг дамжин гадаад, дэлгэрэнгүй, дотоод хураангуйлагдсан автомат дадал болон хувирахдаа сэтгэцийн шинэ бүрдэл болон төлөвшдөг. Мэдлэг бүтээх үйл явцын төрөл чиглэлийг гадаад хэлбэрээс дотоод хэлбэрт шилжих интероризацийн үйл явц, дотоод хэлбэрээс гадаад хэлбэрт шилжих экстроризацийн үйл явц гэж ангилж, энэ нь үйлийн баримжааны үндэс болдог. Мэдлэг бүтээх үйлийн үе шатуудыг үйлийн баримжааг ялган таних, үйлийн баримжааг эзэмших, үйлийн баримжааг хөгжүүлэх, үнэлэх гэж авч үзсэн.

Үйлийн тодорхой чанарын ертөнц бүхий дүрийг санаандаа төлөвшүүлж байдаг сэтгэцийн үйлийн өвөрмөц хэлбэрийг баримжаа гэдэг. Тухайн үйл ажиллагаа нь үйлээс, үйл нь үйлдлээс тогтдог. Үйл ажиллагааны агуулга нь тухайн зорилго болон тэр үйлийн зайлшгүй байх үндсийг тодорхойлдог. Үйлийн баримжааны үндсийг эзэмшсэн тохиолдолд тэр нь тухайн судлагдахуун болон түүнтэй харьцах үйл ажиллагаа (ур ухааны)-ны тухай мэдлэг болон хувирч цаашид тэр мэдлэгийн баримжаагаар ажиллахад чадвар, дадал бүрэлдэн төлөвшдөг. Суралцахуй бол хувь хүн онол, практикийн тодорхой хэмжээний мэдлэгийг, мэдлэг сэргээн үйлдвэрлэх ур ухаантай нь хамтатган эзэмшиж, өөртөө бүтээлч ур чадвар, дадал төлөвшүүлэхийг зорьж товлон гүйцэтгэж буй танин мэдэхүйн өвөрмөц үйл ажиллагаа юм (Нэргүй, 1998, х.15, 23-24).

Бүдүүвч 1.Сурах бичгийг боловсронгуй болгох гол үзэл санаа



Уламжлалт сурах бичгийг бүтээхэд бихевиоризм, реализмын үзэл баримтлал, багш төвтэй зарчим, агуулга, арга зүйг үндэслэж байсныг өөрчилж, прагматизм болон конструктивизмын үзэл, онолыг баримжаалсан, судлагдахууны онцлогтой мэдлэг бүтээх зарчим, шинжлэх ухаанч, мэдээлэл боловсруулж асуудал шийдвэрлэх, бүтээлч эрэл хайгуул хийх арга барилд суурилсан сурах бичгийг бүтээх нь чухал байна (Цогбадрах, 2018, х.36-37).

Сурах бичгийн арга зүйн үндэс: Сурах бичгийн дидактик нь агуулга, арга зүй, үнэлгээ түүний зүй тогтол, тэдгээрийг бүтээх, хөгжүүлэх шинжлэх ухааны үндэслэлийг тодорхойлдог.Сурах бичиг бүтээх онол арга зүйн үндэс нь түүний үзэл санаа, зарчим, арга техникийн нийцтэй тогтолцоо бөгөөд багшлахуй болон суралцахуйн зүй тогтлыг судалдаг шинжлэх ухааныг дидактик гэж үзжээ.

Судлагдахууны онцлогтой сурах бичгийн арга зүйн үндэс


- Суралцагчийн шинжлэх ухаанч арга барилыг хөгжүүлэх арга зүй нь асуудал дэвшүүлэх, туршилт ажил төлөвлөх, аргачлалын дагуу туршилт хийх, нотлох баримт гаргах, боловсруулалт хийх, дүгнэлт гаргах арга барил эзэмшүүлнэ.
- Суралцагчийн мэдээлэл боловсруулж асуудал шийдвэрлэх арга зүй нь ойлгох, төлөвлөх, гүйцэтгэх, шалгах арга барил эзэмшүүлнэ.
- Суралцагчийн мэдээлэл, харилцаа холбооны технологийг хэрэглэн мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх арга барилыг хөгжүүлэх арга зүй нь мххт, мэдээллийг таньж тодорхойлох, мэдээлэл боловсруулах ажлыг төлөвлөх, аргачлал боловсруулах, технологи сонгон мэдээллээ боловсруулах, мэдээлэл мххт-ийг хэрэглэх, үнэлэх, түгээх, хамтран ажиллах арга барил эзэмшүүлнэ.
- Суралцагчийн мэдээлэлтэй ажиллах арга барилыг хөгжүүлэх арга зүй нь мэдээлэл хүлээн авах, мэдээлэл боловсруулах, илэрхийлэх арга барил эзэмшүүлнэ.

- Суралцагчийн бүтээлч эрэлхийлэлийн арга барилыг хөгжүүлэх арга зүй нь асуудал болон хэрэгцээг илрүүлэх, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, шинэ санаа, шийдэл гаргах, бүтээх хөгжүүлэх, үнэлэх үр дүнгээ танилцуулах арга барил эзэмшүүлнэ. (ЕБСийн суурь ба бүрэн дунд боловсролын хөтөлбөр, 2019.).

Сурах бичгийг шинжлэх арга: Сурах бичгийг шинжлэхдээ контент анализын, шкалын болон "TIMSS" аргуудыг хэрэглэлээ.

Контент анализ бол ихээхэн хэмжээний бичмэл сэдвийг тоон үзүүлэлтэд оруулж, түүнд статистик боловсруулалт, математик шинжилгээ хийх арга юм.

Контент анализ хийх үндсэн үйл ажиллагааны үе шат



Шкал нь нийгмийн үзэгдэл, юмсын шинж чанарын илрэх хэм хэмжээ, тоо харьцааг тусган илэрхийлсэн эрэмбэлэлт тоо болон тэдгээрийн харьцааны тогтолцоо юм.

Шкал байгуулах үндсэн үйл ажиллагааны үе шат



Математикийн сурах бичигт шинжилгээ хийсэн 'timss'-ийн арга зүй: Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сурах бичиг хамгийн чухал үүрэг гүйцэтгэдэг юм. Эрдэмтэн Гельфман, Подстригич, Лосинская (Gelfman, Podstrigich, and Losinskaya, 2004) нар сурах бичгийн үүрэг зориулалтыг

- Сурагчдад шинэ мэдлэг эзэмшихэд, багш түүнийг заахад дэмжлэг болох
- Мэдээллийг нэг бүрчлэн нарийвчлан өгөх ба хэсэгчлэн өгөх эсэх тэнцвэртэй байдлыг хангах
- Логик болон тохирох математик системээр хангах
- Шинэ асуултуудад хүргэх
- Сурагчдыг идэвхтэй, бүтээлч, олон талт мэдээллээр хангах юм гэжээ.

Мөн түүнчлэн Валверде (2002) нарын авч үзсэнээр сурах бичгийн өөр гол үүрэг нь төлөвлөсөн болон хэрэгжүүлж буй сургалтын хөтөлбөрүүдийн хоорондох хамгийн гол холбогч нь болдог гэжээ.

Тиймээс TIMSS олон улсын судалгааны хүрээнд сургалтын хөтөлбөр ба сурах бичгүүдийн хоорондох хамаарал өндөр байх тусам тэрээр «орлох сургалтын хөтөлбөр болно» гэж авч үздэг. Энэ үүднээс авч үзвэл сурах бичгийн олон талт шинжилгээний үр дүнг амжилттай хэрэглэснээр сургалтын хөтөлбөрийн хөгжилд чухал дэмжлэг болно. Иймд бид математикийн сурах бичгийг TIMSS олон улсын судалгааны хүрээнд эрдэмтдийн боловсруулсан дараах анализын бүтэц, шалгуур тодорхойлогчдыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Сурах бичгийн анализ нь дараах гурван хэсгээс бүрдэнэ. Эдгээрт:

- Сурах бичгийн бүтэц, агуулгын шинжилгээ
- Математик хэлний шинжилгээ
- Сурах бичиг дэх дасгал даалгаврын шинжилгээ багтана.

Сурах бичгийн шаардлага, шалгуур, үзүүлэлт Шаардлага нь үйл, ажлыг гүйцэтгэх, бүтээхэд зайлшгүй холбогдох нөхцөл бололцоог нээх, илрүүлэхүй юм. Сурах бичгийн агуулгад тавих шаардлага түүний үзүүлэлт, шалгуурыг тодорхой хэмжигдэхүүн болгох шаардлага гарч байна.

Хэмжинэ гэдэг нь судлагдаж буй үзэгдэл, үйлийн шинжийг тоон болон чанарын хувьд бодитой тодорхойлно гэсэн үг. Хэмжилт хийхийн тулд шалгуур, үзүүлэлт боловсруулах шаардлагатай.

Шалгуур нь боловсролын тухайд мэдлэг, чадвар, хандлага, зан үйл, сурах арга барилтай болох зэрэг сургалтын үйл явц, түүний үзүүлэлтүүдийн цогц юм. Өөрөөр хэлбэл, шалгуур нь тогтолцоо бүхий турших, шалгах, хэмжих, багаж гэсэн үг.

Үзүүлэлт гэдэг нь шалгуур хангалтын байдал, түвшин буюу тоон ба чанарын хэмжүүр юм.

Хүний хүртэхүй, анхаарал, зохион бодохуй, ой тогтоолт, сэтгэхүй, хэл ярианы чадварыг танин мэдэхүйн хөгжил гэнэ. Хөгжлийг хэмжихийн тулд судалгаанд зайлшгүй шалгуур, үзүүлэлт байна. Шалгуур нь аливаа зүйлийг үнэлэх хэм хэмжээний цогц бөгөөд шинж чанар, үндэслэл, дүрэм журам байж болно. Зарим тохиолдолд шалгуур нь ямар нэгэн үйл явц, хүний зан үйлийн тодорхой илрэл, мэдлэг, чадвар, туршлагад тавигдах шаардлагуудын цогц ажээ. Иймд хөгжлийн шалгуур нь хөгжлийг үнэлэх, түүний түвшинг тогтоох үндэслэл, илрэл-шинжүүдийн нэгдэл. Хөгжлийн үзүүлэлт нь тодорхой хүрээнд жишээлбэл, эрүүл мэнд, боловсрол, жендрийн тэгш байдал, хүний хөгжлийн төлөвшил, эдийн засгийн нөхцөл гэх мэт холбоотой хөгжлийн онцлог, илрэл түвшинг үнэлэх хэмжүүр бүхий ойлголт ба илрэл нь тоон хэлбэр байна (Бэгз, Санжаабадам, Энхбаяр, Лхагвасүрэн, Баяраа, Баярсайхан 2018, х.82).

Шалгуур нь турших явцад хамрагдагчдын эзэмших, хөгжих, боловсронгуй болгох мэдлэг, чадвар, хандлага зан үйл зэрэг шалгах зүйл, түүний агуулга хүрээ юм. Шалгуур нь турших зүйл, агуулга буюу шалгах зүйлийг заадаг. Үзүүлэлт нь шалгуур хангалтын байдал, түвшин буюу суралцагчдын үзүүлэх тоо ба чанарын илрэл юм (Байгальмаа, 2015, х. 119-120)

Ерөнхий боловсролын сургуулийн бага, суурь, бүрэн дунд боловсролын сурах бичигт судлагдахуун бүрээр хийсэн шинжилгээний үр дүн.

Судлагдахуун

ЕБС-ийн бага, суурь бүрэн дунд боловсролын 174 сурах бичиг.

Судлах зүйл: сурах бичгийн агуулга, арга зүй, хэл хайруулга, дизайн гэсэн 4 хэсгээс тогтоно. Агуулгын хэсэг 7, арга зүйн хэсэг 12, хэл найруулга 2, дизайн 1 шаардлага бүхий хувьсагчаас бүрдсэн.

Өгөгдөл цуглуулах үйл явц.

Судалгааны материалыг 2021 оны 5 дугаар сараас 1-ээс 10 дугаар сарын 1 хүртэл сайдын тушаалаар батлагдсан экспертийн багийн бүрэлдэхүүн батлагдсан арга зүйн дагуу хийж гүйцэтгэсэн. Оролцогч бүрээс судалгааг авсаны дараа SPSS программ ашиглан кодлож статистик боловсруулалт хийлээ.

Агуулгын хүрээнд цуглуулсан өгөгдлийн найдвартай байдал

Өгөгдлийн найдвартай байдлыг үнэлэхийн тулд бүлэг хувьсагч тус бүрийн Кронбах альфа коэффициентийг SPSS 21.0 программ ашиглан тооцоолов. Бүх өгөгдлийн Кронбах альфа утга 0.754, Ухагдахуун, онол, хууль, зарчим, тодорхойлолт, нэр томъёог хэрэглээ болон танин мэдэхүйн түвшинд тохируулан буулгаж, зөв оновчтой томъёолсон, шинжлэх ухааны хувьд алдаагүй, хялбаршуулж оруулсан Кронбах альфа утга 0.581, сурах бичгийн бүтэц 0.654, Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг сурах бичигт тусгасан байдал Кронбах альфа утга 0.914 байгаа нь судалгааны хувьсагчдын өгөгдөл найдвартай байгааг илэрхийлж байна.

Аргазүйн хүрээнд цуглуулсан өгөгдлийн найдвартай байдал

Бүх өгөгдлийн Кронбах альфа утга 0.907, шаардлага тус бүрийг авч үзвэл мэдлэг эзэмшүүлэх даалгаврын Кронбах альфа утга 0.677, чадвар төлөвшүүлэх Кронбах альфа утга 0.793, даалгаврын хүнд, хөнгөн, хариултын хувилбар, контекстийн Кронбах альфа утга 0.827, тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага Кронбах альфа утга 0.975, хэл найруулга 0.815 тус тус байгаа нь судалгааны хувьсагчдын өгөгдөл найдвартай байгааг илэрхийлж байна.

3. АЖЛЫН ХЭСГҮҮДИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН, ДҮГНЭЛТ

МОНГОЛ ХЭЛ, УРАНЗОХИОЛ

ЕБС-ийн I-XII ангийн монгол хэлний 12 сурах бичиг, VI-XII ангийн уран зохиолын 7 сурах бичигт, өгөгдсөн аргачлалын дагуу шинжилгээ хийлээ. Судалгааны зөвлөх багийн өгсөн чиглэлийн дагуу хичээл тус бүрийн сурах бичигт судалгаа хийх багийн гишүүд анги тус бүрийн сурах бичигт нарийвчилсан судалгаа хийсэн болно. Энэхүү судалгааг дараах байдлаар нэгтгэн дүгнэлээ.

Хүснэгт 1. Монгол хэл, Уран зохиолын сурах бичгийн суралцахуйн зорилтыг (агуулга) боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэв хоорондын залгамж холбоотой боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн

Сурах бичиг	Анги хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн ангийн бүлэг сэдвийн залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн бүлгийн сэдэв хоорондын залгамж холбоо, эрэмбэ дараалал
Монгол хэл (I-XII)	2	2	2
Уран зохиол (VI-XII)	3	2	2


Монгол хэл уран зохиролын сурах бичгийн агуулгын босоо, хэвтээ залгамж холбоо хангалтгүй байна. Учир нь агуулгын өргөжин гүнзгийрүүлэх шаардлагад нийцээгүй. Үүний шалтгаан нь анги бүрийн зохиогчийн баг өөр өөр учраас агуулга арга зүйн залгамж холбоо сул байгааг засаж сайжруулах хэрэгтэй.

Хүснэгт 2. Монгол хэл, Уран зохиолын сурах бичгийн мэдлэгийн хэлбэрт хийсэн шинжилгээний дүн

Сурах бичгийн нэр/ Анги	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Мэдлэгийн төрөл				
		Баримтын мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Метокөгнитив мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо
Монгол хэл(I-XII)	654	271/19%	101/41%	64/15%	96/10%	122/15%
Уран зохиол (VII-XII)	356	82/6%	114/23%	82/32%	57/23%	21/16%

Монгол хэлний сурах бичигт ухагдахууны мэдлэг 41 хувь, баримтын мэдлэг 19 хувь, үйлийн болон метакогнитив мэдлэг 15 хувь, ахуйн мэдлэг 10 хувийг тус тус эзэмшүүлэхээр агуулгын сонголт хийгдсэн байна. Монгол хэлний сурах бичигт баримт ухагдахууны мэдлэг олгох сэдэв нь давамгайлаад ялангуяа үйлийн болон ахуйн мэдлэг олгох сэдэв харьцангуй бага байна. Өөрөөр хэлбэл онол давамгайлсан тал ажиглагдаж байна.

График 1. Уран зохиолын сурах бичгийн мэдлэгийн хэлбэрт хийсэн шинжилгээний дүн




Үйлийн мэдлэг 32 хувь, ухагдахууны болон ахуйн мэдлэг тус бүр 23 хувь, метакогнитив мэдлэг 16 хувь, баримтын мэдлэг 0.6 хувийг тус тус эзэмшүүлэхээр агуулгын сонголт хийгдсэн байна. Уран зохиолын сурах бичигт уран сайхныг задлан шинжлэх онол ухагдахууны мэдлэг харьцангуй дутмаг, унших сэдвийн сонголт сайн хийгдээгүй байна. Өөрөөр хэлбэл сурагчдад яруу сайхны мэдрэмж олгох талын агуулга дутмаг байна.

Хүснэгт 3. Монгол хэл, Уран зохиолын сурах бичгийн хандлагад хийсэн шинжилгээний дүн


Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр /Анги	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Суралцах ёс суртахууны хүмүүжил төлөвшил				
		Хамтарч ажиллах сэдвийн тоо	Байгаль орчноо хайрлах хамгаалах сэдвийн тоо	Өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хөгжүүлэх сэдвийн тоо	Өөрийгөө хүмүүжүүлэх сэдвийн тоо	Ёс суртахууны төлөвшил эзэмшүүлэх сэдвийн тоо
Монгол хэл(I-XII)	591	35/5%	311/53%	160/27%	55/9%	30/5%
Уран зохиол (VII-XII)	328	25/8%	115/35%	110/34%	47/14%	31/9%

График 2. Монгол хэлний сурах бичгийн хандлагад хийсэн шинжилгээний дүн



53 хувь нь байгаль орчноо хамгаалах 27 хувь нь өөрийгөө танин мэдэх, 9 хувь нь өөрийгөө хүмүүжүүлэх, 5 хувь нь ёс суртахууны агуулгыг төлөвшүүлэх сонголт хийгдсэн байна.

График 3. Уранзохиолын сурах бичгийн хандлагад хийсэн шинжилгээний дүн



35 хувь нь байгаль орчноо хамгаалах, 34 хувь нь өөрийгөө танин мэдэх агуулга, 14 хувь нь өөрийгөө хүмүүжүүлэх, 9 хувь нь ёс суртахуун, 8 хувь нь хамтран ажиллах хандлагын хэлбэрийг эзэмшүүлэхээр агуулгын сонголт хийгдсэн байна. Монгол хэл, уран зохиолын сурах бичигт сонгосон эхийн бүрэлдэхүүнд байгаль эхээ хамгаалах, өөрийгөө танин мэдэх, хамтарч ажиллах агуулгатай эх голлож байгаа нь давуу талтай боловч тухайн эхэд зориулсан даалгаврын тоо цөөн байна.

Хүснэгт 4. Монгол хэл, Уран зохиолын сурах бичгийн сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлын шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Үнэлгээ: хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1	
	Сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, жишээ баримттай бичвэр, дасгал, даалгавар, туршилт ажил, дадлага ажлыг сурах бичигт оруулсан эсэх	Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг сурах бичигт тусгасан эсэх
Монгол хэл (I-XII)	2	1
Уран зохиол (VII-XII)	2	1


Монгол хэл, уран зохиолын сурах бичигт үндэсний түүх, соёл уламжлалыг тусгасан эх бусад хичээлтэй харьцуулбал илүү боловч анги, түвшин тус бүрийн онцлогийг харгалзаагүй дутагдал байна. Сонгосон эхүүдэд хүүхдийн сонирхол хэрэгцээ, нас сэтгэхүйн онцлогт тохироогүй, тохиолдлын шинжтэй сонголтууд давамгайлж байна.

СУРАХ БИЧГИЙН АРГАЗҮЙД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

Хүснэгт 1. Монгол хэл, Уран зохиолын сурах бичгийн даалгаврын мэдлэгийн хэлбэр шинжилгээний дүн.


Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Мэдлэгийн төрөл				
		Баримтын мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Метакогнитив мэдлэг эзэмшүүлэх мэдлэгийн тоо
Монгол хэл (I-XII)	4947	56/1%	805/16%	2610/53%	486/10%	990/20%
Уран зохиол (VII-XII)	2029	36/2%	318/16%	862/45%	336/17%	389/20%

График 1. Монгол хэлний сурах бичгийн даалгаврын мэдлэгийн хэлбэр шинжилгээний дүн



Даалгаврын 53 хувь нь үйлийн, 20 хувь нь метакогнитив, 16 хувь нь ухагдахууны, 10 хувь ахуйн, 1 хувь нь баримтын мэдлэг эзэмшүүлэхээр боловсруулсан.

График 2. Уранзохиолын сурах бичгийн даалгаврын мэдлэгийн хэлбэр шинжилгээний дүн




Даалгаврын 25 хувь нь задлан шинжлэх, 15 хувь нь жишээгээр тайлбарлах, 16 хувь нь дүгнэлт, 13 хувь нь хэрэглээ, 7 хувь нь бүтээх, ангилах, 11 хувь нь метакогнитив, 6 хувь нь жишиж харьцуулах чадварыг дэмжсэн байна.

Хүснэгт 2. Монгол хэл, Уран зохиолын сурах бичгийн тодорхой чадварт хийсэн шинжилгээний дүн.


Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Чадварын тоо							
		Ойлгох чадвар тоо				Хэрэглэх чадварын тоо	Задлан шийжлэх чадварын тоо	Бүтээх чадварын тоо	Метакогнитив
		Ангилах	Жишиж харьцуулах	Жишээгээр тайлбарлах	Дүгнэлт гаргах				
Монгол хэл (I-XII)	4947	239/5%	195/4%	503/10%	576/12%	1026/21%	989/20%	795/16%	623/12%
Уран зохиол (VII-XII)	2029	155/7%	118/6%	320/15%	341/16%	285/13%	535/25%	149/7%	236/11%

График 3. Монгол хэлний сурах бичгийн тодорхой чадварт хийсэн шинжилгээний дүн



Даалгаврын 20 хувь нь задлан шинжлэх, 21 хувь нь хэрэглэх, 16 хувь нь ангилах, 12 хувь нь дүгнэлт, бүтээх, 10 хувь нь жишээгээр тайлбарлах, 5 хувь нь ангилах, 4 хувь нь жишиж харьцуулах чадварыг дэмжсэн байна.

График 4. Уранзохиолын сурах бичгийн тодорхой чадварт хийсэн шинжилгээний дүн



25 хувь нь задлан шинжлэх, 16 хувь нь дүгнэлт, 15 жишээгээр тайлбарлах, 13 хувь нь ангилах, 11 хувь нь метакогнитив, 6 хувь нь жиших, 7 хувь нь бүтээх болон хэрэглэх чадварыг дэмжсэн байна. Цаашдаа монгол хэлний сурах бичигт хэрэглэх чадвар голлож, задлан шинжлэх, бүтээх даалгавар дагалдсан, уран зохиолын сурах бичигт задлан шинжлэх голлож, дүгнэлт гаргах, танин мэдэх даалгавар дагалдсан, хэрэглэх бүтээх даалгавар голлосон арга зүйг баримтлах нь зүйтэй гэж үзэж байна. Дээрх судалгаанаас үзвэл ихэнх сурах бичгийн дасгал даалгаврын тавил, арга зүй нь зохих шалгуурт нийцэж байна гэж үзлээ.

Хүснэгт 3. Монгол хэл, Уран зохиолын сурах бичгийн даалгаврын хүндрэл, хариултын хувилбарт хийсэн шинжилгээний дүн

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Даалгаврын хүндрэлийн түвшний тоо		Даалгаврын хариултын хувилбарын тоо		
		Хөнгөн	Хүнд	Нээлттэй хариулт	Хаалттай хариулт	Олон сонголттой
Монгол хэл (I-XII)	4947	1478/51%	1445/49%	736/18%	1312/33%	1932/49%
Уран зохиол (VII-XII)	2029	660/44%	833/56%	568/34%	516/31%	588/35%

Монгол хэлний сурах бичгийн даалгаврын 51 хувь нь хөнгөн, 49 хувь нь хүнд боловсруулсан байна. Уранзохиолын сурах бичгийн даалгаврын 44 хувь нь хөнгөн, 56 хувь хүнд боловсруулсан байна. Монгол хэлний сурах бичгийн даалгаврын хариултын 33 хувь нь хаалттай, 49 хувь олон хувилбартай, 18 хувь нь нээлттэй хувилбартай боловсруулсан байна. Уранзохиолын сурах бичгийн даалгаврын хариултын 31 хувь нь хаалттай, 35 хувь олон хувилбартай, 34 хувь нь нээлттэй хувилбартай боловсруулсан байна.

Хүснэгт 4. Монгол хэл, Уран зохиолын сурах бичгийн даалгаврын контекст, сурах арга барилд хийсэн шинжилгээний үр дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Контекстийн хэлбэр /тоо			Сурах арга барил			
		Шинжлэх ухаан	Зохиомол	Бодит амьдралын жишээ	Асуудал	Мэдээлэл	Шинжлэн судлах	Эрэлхайгуул
Монгол хэл (I-XII)	4947	2245/35%	2256/36%	1862/29%	447/9%	1877/36%	2168/41%	735/14%
Уран зохиол (VII-XII)	2029	868/34%	943/31%	554/35%	174/9%	622/31%	776/39%	414/21%

35 хувийг шинжлэх ухааны, 36 хувийг зохиомол, 29 хувийг ахуйн даалгаврууд эзэлж байна. Уранзохиолын сурах бичгийн 34 хувийг шинжлэх ухааны, 31 хувийг зохиомол, 35 хувийг ахуйн даалгаврууд эзэлж байна. Монгол хэлний сурах бичгийн 41 хувийг шинжлэн судлах, 36 хувийг мэдээлэл боловсруулах, 14 хувийг эрэл хайгуул, 9 хувийг асуудал шийдвэрлэх арга барилыг дэмжсэн даалгаврууд эзэлж байна. Уранзохиолын сурах бичгийн 39 хувийг шинжлэн судлах, 31 хувийг мэдээлэл боловсруулах, 9 хувийг асуудал шийдвэрлэх, 21 хувийг эрэл хайгуул хийх арга барилыг дэмжсэн даалгаврууд эзэлж байна (анги тус бүрийн дэлгэрэнгүй анализыг эх материалд хавсаргав).

Хүснэгт 5. Монгол хэл, Уран зохиолын сурах бичгийн тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага, сэдэлжүүлэлт, хэл найруулга, дизайнд хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Үнэлгээ: хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1			
	Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага	Сэдэл	Хэл найруулга	Техник
Монгол хэл	1	1	2	3
Уран зохиол	1	1	3	3

Монгол хэл, уран зохиолын сурах бичигт сэдэлжүүлэх болон тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлагын талаарх агуулга хангалтгүй тусгагджээ.

Монгол хэлний сурах бичгийн хэл найруулгыг бусад хичээлтэй харьцуулбал харьцангуй сайн боловч зарим сурах бичигт зөв бичгийн дүрмийн болон үг сонголтын алдаа тохиолдож байгааг залруулж, аль ч сурах бичигт орсон шинжлэх ухааны нэр томъёо, ойлголт ухагдахууны тайлбар заавал хийх хэрэгтэй. Анги тус бүрийн сурах бичигт нэг өгүүлбэрт байх үгийн тоог оновчтой тогтоох шаардлага ажиглагдлаа. Ихэнх сурах бичигт авсан зураг, хүснэгт, загварын сонголтыг боловсронгуй болгох хэрэгцээ байна (анги тус бүрийн дэлгэрэнгүй анализыг эх материалд хавсаргав).

ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

Монгол хэлний сурах бичиг:

1.Бага ангийн сурах бичиг

Давуу тал:

Бага ангийн суралцахуйн зорилт (агуулга)-ыг тухайн анги, бүлэг хоорондын залгамж холбоотой боловсруулсан бөгөөд сурах бичгийн агуулгад суралцагчийн нас, сэтгэхүйн онцлогоос хамаарч ухагдахуун, үйлийн мэдлэг олгох агуулга нь их орсон бол анги ахих тусам метакогнитив мэдлэг олгох агуулгын тоо нэмэгдэж байна.

Сурах бичигт дасгал, даалгавар боловсруулахдаа хоёр болон түүнээс дээш мэдээллийн хэлбэрийг хослуулан ашиглаж, суралцагчийн нас, сэтгэхүйн онцлогтой холбоотойгоор шинжлэн судлах, эрэл хайгуул хийх, өөрийгөө удирдах, эргэцүүлэн бодох, ёс суртахууны шийдвэр гаргах асуудлыг тусгасан дасгал, даалгаврыг түлхүү оруулж өгсөн байна. Анги ахих тусам задлан шинжлэх, хэрэглэх түвшний дасгал, даалгавар нэмэгдэж байгаа бол дүгнэлт гаргах, задлан шинжлэх, бүтээх чадвар эзэмшүүлэх дасгал, даалгаврын тоо жигд боловсруулжээ.

Сул тал

Сурах бичгийн агуулгын бүтцийн элементүүд (экспертийн эксел файлын дагуу) тодорхой биш бөгөөд сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилт (агуулга)-ын томъёоллуудын дийлэнх нь дасгал, даалгаврын тавил байдлаар боловсруулсны улмаас суралцахуйн зорилтууд нь сурах бичгийн агуулга, бүлэг сэдэвт хангалттай тусгагдаагүй. Ахуйн мэдлэг эзэмшүүлэх, байгаль орчноо хайрлан хамгаалах, өөрийгөө хүмүүжүүлэх сэдвийн тоо бага байна. Сурах бичиг дэх тэмдэг, тэмдэглэгээ цөөн, ойлгомжгүй бөгөөд анги бүрд жигд биш. Монгол сэтгэлгээ, түүх, соёл, үнэт зүйлийн сэдэв агуулга цөөн, ухагдахуун, онол, тодорхойлолт, нэр томъёог тусгайлан оруулаагүй.

Сурах бичгийн зарим дасгал даалгаврын боловсруулалт цэгцгүй. Зургаар үзүүлсэн дасгал даалгаврын заавар ойлгомжгүй, эргэлзээтэй, үг, үсгийн алдаатай учраас бие даан гүйцэтгэхэд хүндрэлтэй. Сурах бичгийн зарим бүлгийн ялгасан өнгө нь бүдэг учраас дасгал даалгаврын зааврууд үзэгдэц муу, хэтэрхий бүдэг.

Зургийн агуулгаар Монголын түүх, соёл уламжлалыг харьцангуй бага илэрхийлсэн бол нэг зургийг олон хэсэг тасалж, олон хувилбар болгон оруулсан байна.

Сайжруулах санал

Сурах бичгийн элементүүдийг жигдлэх, хамтарч ажиллах, байгаль орчноо хайрлан хамгаалах, ёс суртахууны төлөвшил, ахуйн мэдлэг эзэмшүүлэх, өөрийгөө хүмүүжүүлэх, Монгол Улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын талаарх сэдвийн тоог нэмэгдүүлэх;

Сурах бичиг дэх дасгал даалгаврын хүнд, хөнгөн түвшний харьцааг жигд боловсруулж, сурах бичгийн дасгал, даалгаврыг хөнгөнөөс хүнд түвшин рүү чиглэх байдлаар зохиож, Монгол Улсын түүх, уламжлал, соёл үнэт зүйлтэй холбоотой зургийг оруулах;

Дасгал даалгаврын зааврыг ойлгомжтой, цэгцтэй, тодорхой, зөв бичгийн дүрмийн алдаагүй боловсруулж, нэр томъёог нэг мөр болгож, сурах бичгийн тайлбар толь хэсэгт заавал оруулж байх. Монгол соёл сэтгэлгээ, нүүдэлчин ахуй, өв соёлыг шингээсэн зураг, дүр зэргийг сонгож ашиглахдаа өнгө будаг, үзэгдэцэд анхаарах.

Суурь боловсролын сурах бичиг.

Давуу тал:

Суурь боловсролын монгол хэлний сурах бичгийн агуулгад ухагдахууны болон метакогнитив мэдлэг олгох агуулга жигд хэмжээтэй орсон. Сурах бичгүүдэд эх бичвэр, дасгал, даалгаврыг хангалттай хэмжээнд оруулсан бөгөөд ухагдахууны болон метакогнитив мэдлэг эзэмшүүлэх, ойлгох, задлан шинжлэх, дүгнэлт гаргах, жишээгээр тайлбарлах, хэрэглэх, задлан шинжлэх, метакогнитив, бүтээх чадвар эзэмшүүлэх дасгал даалгаврыг жигд харьцаатайгаар боловсруулсан байна.

Монгол үндэстэн, ястны соёл, боловсрол, сэтгэлгээ, хүн хүний харилцааны ёс суртахууны үнэт зүйлийг агуулсан сэдвийг тодорхой хэмжээнд оруулсан. Түүнчлэн тухайн судлагдахууны онолын шинж, онцлог бүхий контексттэй дасгал даалгавар, зохиомол контексттэй даалгавар, бодит амьдралын жишээ баримтад тулгуурласан контексттэй дасгал даалгаврын тоо жигд. Сурах бичигт тавигдах ерөнхий шаардлага хангасан байна.

Сул тал

Сурах бичгийн агуулгын бүтцийн элементүүд (экспертийн эксел файлын дагуу) тодорхой биш бөгөөд сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилт (агуулга)-ын томъёоллуудын дийлэнх нь дасгал, даалгаврын тавил байдлаар боловсруулагдсаны улмаас суралцахуйн зорилтууд нь сурах бичгийн агуулга, бүлэг сэдэвт хангалттай тусгагдаагүй, зарим суралцахуйн зорилт огт тусгагдаагүй байна. Баримтын, ухагдахууны, ахуйн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулга бага, зарим сурах бичигт ороогүй. Сурах бичгүүдийн тэмдэг, тэмдэглэгээ нэг стандартаар хийгдээгүй. Ухагдахуун, онол, тодорхойлолт, нэр томъёог тусгайлан оруулаагүй.

Зарим сурах бичигт бага ангидаа сурагчийн уншиж судалсан эхийг дахин сонгосон. Суралцагчийн суралцах ёс зүйн хүмүүжил төлөвшил олгох сэдвүүдээс хамтарч ажиллах, байгаль орчноо хамгаалах, өөрийгөө хүмүүжүүлэх, ёс суртахууны төлөвшил эзэмшүүлэх сэдвийн агуулга маш цөөн орсон. Баримтын болон ахуйн мэдлэг олгох, үнэлэх, асуудал шийдвэрлэх арга барилд суралцах дасгал даалгавар болон олон сонголттой дасгал, даалгаврын тоо харьцангуй цөөн. Боловсролын талаарх дэлхийн чиг хандлага, тогтвортой хөгжлийн агуулга, иргэний зайлшгүй эзэмшсэн байх чадваруудыг хангалтгүй оруулсан.

Сайжруулах санал

Суралцахуйн зорилт (агуулга)-ыг анги хоорондын залгамж холбоотой боловсруулж, хамтарч ажиллах, байгаль орчноо хайрлах, хамгаалах, өөрийгөө таних сээмшүүлэх сэдвийн тоог жигд оруулах. Зарим сурах бичгийн дасгал даалгавруудын зааврыг тодорхой болгож, уялдаа холбоог сайжруулах, таних тэмдгийн тайлбар, заавар оруулж, тэмдэг тэмдэглэгээг тодорхой, ойлгомжтой болгох.

Сурах бичиг дэх дасгал даалгаврын хүнд, хөнгөн түвшний харьцааг жигд боловсруулж, сурах бичгийн дасгал, даалгаврыг хөнгөнөөс хүнд түвшин рүү чиглэх байдлаар зохиож, Монгол Улсын түүх, уламжлал, соёл үнэт зүйлтэй холбоотой зургийг оруулах. Нэр томъёог нэг мөр болгож, сурах бичгийн тайлбар толь хэсэгт заавал оруулж байх. Нэг өгүүлбэр дэх үгийн тоог стандартын дагуу байхаар тооцоолж сурах бичгээ боловсруулах. Мэдээллийн хэлбэрүүдийг зохистой харьцаагаар хослуулан ашиглаж, дасгал даалгаврын тоог цөөлж, чанарт анхаарах, асуулт асуухаас өөр хэлбэрийг эрэлхийлэх.

Бүрэн дунд боловсролын сурах бичиг

Давуу тал:

Бүрэн дунд боловсролын Монгол хэлний хичээлийн суралцахуйн зорилт (агуулга)-ыг тухайн анги, бүлэг хоорондын залгамж холбоотой хангалттай хэмжээнд боловсруулсан бөгөөд үйлийн мэдлэг олгох агуулга, өөрийгөө танин мэдэх болон хөгжүүлэх сэдвийн тоо хангалттай. Сурах бичиг дэх тэмдэг, тэмдэглэгээ ойлгомжтой. Зөв бичгийн дүрмийн алдаагүй, зураг, хүснэгтийн тайлбар үгийн алдаагүй.

Сурах бичигт дасгал, даалгавар боловсруулахдаа хоёр болон түүнээс дээш мэдээллийн хэлбэрийг хослуулж, дасгал даалгаврын хүнд, хөнгөнтүвшний харьцааг жигд боловсруулсан, суралцагчийн нас, сэтгэхүйн онцлогт тохируулан үйлийн мэдлэг эзэмшүүлэх, шинжлэн судлах, дүгнэлт гаргах, жишээгээр тайлбарлах, хэрэглэх, задлан шинжлэх, бүтээх, метакогнитив мэдлэг, чадвар эзэмшүүлэх дасгал, даалгаврыг жигд боловсруулжээ.

Сул тал

Сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилт (агуулга)-ын томъёоллуудын дийлэнх нь дасгал, даалгаврын тавил байдлаар боловсруулсны улмаас суралцахуйн зорилтууд нь сурах бичгийн сэдвийн агуулгад хангалттай тусгагдаагүй. Баримтын, ахуйн мэдлэг эзэмшүүлэх, хамтарч ажиллах болон өөрийгөө хүмүүжүүлэх, амьдрал ахуйн холбоотой жишээгээр тайлбарласан сэдэв болон дасгал даалгавар, харьцуулан жиших аргаар тайлбарласан сэдэв цөөн, зарим ангид огт тусгагдаагүй.

Бүтээх, жишиж харьцуулах чадвар эзэмшүүлэх болон сэргээн санах, асуудал шийдвэрлэх, эрэл хайгуул хийх арга барилд суралцах дасгал даалгаврын тоо цөөн буюу зарим ангид огт тусгагдаагүй, дасгал даалгаврын контекстын тоо харилцан адилгүй.

Сайжруулах санал

Суралцахуйн зорилт (агуулга)-ыг тухайн бүлгийн сэдэв хоорондын залгамж холбоотой боловсруулж, хангалттай бүрэн хэмжээнд тусгах, хамтарч ажиллах, байгаль орчноо хайрлан хамгаалах, өөрийг танин мэдэх, хөгжүүлэх, хүмүүжүүлэх, ёс суртахууны төлөвшил эзэмшүүлэх, Монгол Улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын талаарх сэдвийн тоог нэмэгдүүлж, жигд оруулах;

Дасгал даалгаврын боловсруулалтад баримтын, ахуйн, ухагдахууны мэдлэг, жишиж харьцуулах чадвар, сэргээн санах, үнэлэх түвшний болон асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах, эрэл хайгуул хийх дасгал даалгавруудыг тоог нэмэгдүүлэх;

Нэг өгүүлбэр дэх үгийн тоог стандартын дагуу байхаар тооцоолж оруулж байх, сурах бичигт батлагдсан нэр томъёог хэрэглэх тал дээр анхаарах. Монгол соёл сэтгэлгээ, нүүдэлчин ахуй, өв соёлыг шингээсэн зураг, дүр зэргийг сонгохдоо чанарын шаардлага хангасан эх зураг ашиглах хэрэгтэй.

АНГЛИ ХЭЛ

ЕБС-ийн V-XII ангийн англи хэлний сурах бичигт өгөгдсөн аргачлалын дагуу шинжилгээ хийлээ. Судалгааны зөвлөх багийн өгсөн чиглэлийн дагуу хичээл тус бүрийн сурах бичигт судалгаа хийх багийн гишүүд анги тус бүрийн сурах бичигт нарийвчилсан судалгаа хийсэн болно. Энэхүү судалгааг дараах байдлаар нэгтгэн дүгнэлээ.

Хүснэгт 1. Суралцахуйн зорилтыг (агуулга) боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэв хоорондын залгамж холбоотой боловсруулсан байдалд хийсэн үр дүн.

Сурах бичиг	Анги хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн ангийн бүлэг сэдвийн залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн бүлгийн сэдэв хоорондын залгамж холбоо, эрэмбэ дараалал
Англи хэл (V-XII)	3	3	3

Англи хэлний сурах бичиг тус бүрийн анги, тухайн ангийн бүлэг сэдвийн тухайн бүлгийн сэдэв хоорондын залгамж холбоо, эрэмбэ дараалал агуулгын залгамж холбоо зохих шаардлагад нийцэж байна.

Хүснэгт 2. Тодорхой мэдлэгт суралцахаар боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн

Сурах бичгийн нэр/Анги	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Мэдлэгийн төрөл				
		Баримтын мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Метокогнитив мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо
Англи хэл (V-XII)	1126	118/17%	458/10%	160/41%	201/14	189/18

Англи хэлний сурах бичгийн (V-XII) агуулгын боловсруулалтын дүнгээс үзэхэд 41 хувь нь үйлийн, 17 хувь нь баримтын, 18 хувь нь метакогнатив, 10 хувь нь ухагдахуун, 14 хувь нь ахуйн мэдлэг эзэмшүүлэхээр агуулгын шийдэл хийсэн байна. Үйлийн мэдлэг эзэмшүүлэх агуулга ихэнх хувийг эзлэж байна (анги тус бүрийн дэлгэрэнгүй анализыг эх материалд хавсаргав).

Хүснэгт 3. Сурах бичгийн хандлагад хийсэн шинжилгээний дүн

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр/Анги	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Суралцах ёс суртахууны хүмүүжил төлөвшил				
		Хамтарч ажиллах сэдвийн тоо	Байгаль орчноо хайрлах хамгаалах сэдвийн тоо	Өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хөгжүүлэх сэдвийн тоо	Өөрийгөө хүмүүжүүлэх сэдвийн тоо	Ёс суртахууны төлөвшил эзэмшүүлэх сэдвийн тоо
Англи хэл (V-XII)	559	281/50%	54/10%	115/20%	60/11%	49/9%

График 1. Сурах бичгийн хандлагад хийсэн шинжилгээний дүн



50 хувь нь хамтран ажиллах, 20 хувь нь өөрийгөө танин мэдэх, 10 хувь нь байгаль орчноо хамгаалах, 9 хувь нь ёс суртахууны, 11 хувь нь өөрийгөө хүмүүжүүлэх агуулга эзэлж байна.

Хүснэгт 4. Сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлын шинжилгээний дүн.

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Үнэлгээ хангалттай ³ , сайжруулах ² , хангалтгүй ¹	
	Сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, жишээ баримттай бичвэр, дасгал, даалгавар, туршилт ажил, дадлага ажлыг сурах бичигт оруулсан эсэх	Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг сурах бичигт тусгасан эсэх
Англи хэл (V-XII)	2	1


Англи эх сонголтод монгол ёс заншил, үндэсний соёл уламжлалыг хангалтгүй сонгосон эхүүдэд хүүхдийн сонирхол хэрэгцээ, нас сэтгэхүйн онцлогт тохироогүй, тохиолдлын шинжтэй сонголтууд давамгайлж байгаа тул сайжруулах хэрэгтэй байна.

СУРАХ БИЧГИЙН АРГАЗҮЙД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

Хүснэгт 1. Сурах бичгийн даалгаврын мэдлэгийн хэлбэрт хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр / Анги	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Мэдлэгийн төрөл				
		Баримтын мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Метакогнитив мэдлэг эзэмшүүлэх мэдлэгийн тоо
Англи хэл(V-XII)	3400	200/6%	625/18%	1181/33%	680/19%	867/24%

График 1. Сурах бичгийн даалгаврын мэдлэгийн хэлбэрт хийсэн шинжилгээний дүн




Даалгаврын 33 хувь нь үйлийн, 24 хувь нь метакогнитив, 18 хувь нь ухагдахууны, 19 хувь нь ахуйн, 6 хувь нь баримтын мэдлэг эзэмшүүлэх, хөгжүүлэх шийдэл хийсэн байна.

Хүснэгт 2. Дасгал, даалгаврыг тодорхой чадварт суралцахаар боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Чадварын тоо							
		Ойлгох чадвар тоо				Хэрэглэх чадварын тоо	Задлан шинжлэх чадварын тоо	Бүтээх чадварын тоо	Метакогнитив
		Ангилгах	Жишиж харьцуулах	Жишээгээр тайлбарлах	Дүгнэлт гаргах				
1 Англи хэл (V-XII)	3400	178/6%	102/3%	209/7%	339/11%	782/25%	449/14%	525/17%	523/17%

График 2. Англи хэлний дасгал, даалгаврыг тодорхой чадварт суралцахаар боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн



Дээрх судалгаанаас үзвэл 25 хувь нь хэрэглэх, 17 хувь нь бүтээх, метакогнитив, 14 хувь нь задлан шинжлэх, 11 хувь нь дүгнэлт, 7 хувь нь жишээгээр тайлбарлах, 6 хувь нь ангилгах, 3 хувь нь жишиж харьцуулах чадварыг дэмжсэн даалгаваруудтай.

Хүснэгт 3. Даалгаврын хүндрэл, хариултын хувилбарт хийсэн шинжилгээний дүн.


Сурах бичгийн нэр /Анги	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Даалгаврын хүндрэлийн түвшний тоо		Даалгаврын хариултын хувилбарын тоо		
		Хөнгөн	Хүнд	Нээлттэй хариулт	Хаалттай хариулт	Олон сонголттой
Англи хэл(V-XII)	3400	1422/56%	1118/44%	908/39%	827/36%	590/25%

56 хувь нь хөнгөн, 44 хувь хүнд даалгавар боловсруулсан байна. Даалгаврын хөнгөн болон хүнд даалгаврын харьцаа тохиромжтой гэж үзэж болно. Сурах бичгийн даалгаврын 39 хувь нь нээлттэй, 36 хувь хаалттай, 25 хувь нь олон хувилбартай хариулт бүхий даалгаврууд эзэлж байна.

Хүснэгт 4. Даалгаврын контекст, сурах арга барилд хийсэн шинжилгээний дүн.


Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Контекстийн хэлбэр /тоо			Сурах арга барил			
		Шинжлэх ухаан	Зохиомол	Бодит амьдралын жишээ	Асуудал	Мэдээлэл	Шинжлэн судлах	Эрэл хайгуул
Англи хэл (V-XII)	3400	908/39%	827/36%	590/25%	318/22%	614/43%	355/25%	143/10%

График 3. Даалгаврын контекстийн шинжилгээний дүн



39 хувийг шинжлэх ухааны, 36 хувийг зохиомол, 25 хувийг ахуйн контексттэй даалгаврууд эзэлж байна.

График 4. Сурах арга барилын шинжилгээний үр дүн.



43 хувийг мэдээлэл боловсруулах, 25 хувийг шинжлэн судлах, 22 хувийг асуудал шийдвэрлэх, 10 хувийг эрэл хайгуул хийх арга барилыг дэмжсэн даалгаврууд эзэлж байна.

Хүснэгт 5. Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага, сэдэлжүүлэлт, хэл найруулга, дизайн д хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1			
	Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага	Сэдэл	Хэл найруулга	Техник
Англи хэл(V-XII)	2	2	2	2

Англи хэлний сурах бичигт тогтвортой хөгжлийн үзэл санаа, янз бүрийн аргаар сэдэлжүүлэх, хэл найруулга, дизайны тухайд сайжруулах хэрэгтэй гэж үзсэн байна.

ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

Англи хэлний сурах бичиг.

V анги

Сурах бичиг 10 бүлэгтэй. Бүлэг тус бүр 5 нэгж сэдэвтэй. 5 дугаар ангийн сурагчдын нас, сэтгэхүйн онцлогт тохирсон сэдэв, зурган өгөгдлийг багтаасан байна. 6 дугаар ангийн сурах бичигтэйгээ сэдвийн агуулгын хувьд уялдаа холбоотой мэт харагдаж байгаа боловч энэ сурах бичигт үг үсэг, бичвэр огт байхгүй учир агуулгыг бүрэн тодорхойлох боломжгүй. Харин бага ангийн сурагчдын сонирхол, хэлний түвшин, насны онцлогт тохирсон, танил сэдвийг ашигласан байна. Сурах бичигт зөвхөн зургууд бус сургалтын идэвхитэй аргуудыг хамарсан дасгал ажлыг оруулах, зургуудад тохирсон үг хэллэг, бичвэр, тайлбар оруулах, анхан шатны энгийн үг (5-10) хэллэг, бичвэр оруулж 5 дугаар ангийн сурах бичгийг шинээр боловсруулах хэрэгтэй гэж үзэж байна.

VI анги

6-р ангийн англи хэлний сурах бичиг нь нийт 4 ай, 10 бүлэг сэдэв, 151 суралцахуйн зорилтуудтай. Сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилтын хүрээнд нийт сэдвийн 40 хувь нь агуулгадаа тохирсон бол 60 хувь нь агуулгын хувьд дутуу эсвэл хэтэрсэн тул суралцахуйн зорилтуудыг нэмж оруулах хэрэгтэй. Харин суралцахуйн зорилтын боловсролын түвшин, анги, бүлэг сэдэв хоорондын залгамж холбооны хувьд тухайн ангийн бүлэг сэдвийн холбоо хамаарлаас бусад категори нь хангалттай сайн боловсрогдсон байна. Сурах бичгийн агуулгын хувьд сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тохирсон, ахуйн мэдлэг, үйлийн мэдлэг, ухагдахууны мэдлэг, баримтын мэдлэг, метакогнитив мэдлэг зэргийг багтааж өгсөн ч баримтын мэдлэгийн агуулга нь бусдаасаа бага тусгагдсан бол сурагчдын хувь хүний хөгжил рүү чиглэсэн хандлага төлөвшлийн агуулгад өөрийгөө хөгжүүлэх, багаар ажиллах, өөрийгөө танин мэдэх, ёс суртахууны төлөвшил эзэмшүүлэх зэрэг мэдлэгийг тусгасан. Түүнчлэн сурагчдын амьдралтай ойр жишээ баримт, үг, өгүүлбэрүүдийг ашиглан шинэ мэдлэг олгож байгаа нь давуу тал байлаа. Харин монголын түүх соёл, үнэт зүйлийг сурах бичгийн агуулгад хангалттай тусгаж өгөөгүй тул монгол соёл иргэншлийг шингээсэн баримт жишээ (гэр, мал ахуй, уламжлалт баяр наадам, тоглоом наадгай үлгэр тууж, зураг) оруулах хэрэгтэй. Сурагчдын авиа зүйн дуудлагыг сайжруулах үүднээс шинэ үг хэллэгийн ард үгийн галиг нэмж оруулбал сурагчид номноос бие даан зөв дуудаж сурах ач холбогдолтой.

Нийт даалгаврын 80 хувь нь хөнгөн, 20 хувь нь хүнд байна. Бүлэг сэдэв бүр дээр ажиллах үед ярих чадварыг хөгжүүлэх дасгал даалгавруудыг хангалттай оруулсан нь ажиглагдсан боловч асуулт асуух, асуултанд хариулах дасгал даалгаврууд нэлээд давтагдсан

байсан. Ярианы олон төрлийн дасгал даалгавруудыг тусган боловсруулах, дүрд тоглох болон зургийг ажиглаад үлгэр зохиох зэрэг дасгал даалгавруудыг нэмэгдүүлэх хэрэгтэй. Судалгааны явцад ажиглагдсан нэг давуу тал нь сурах бичгийн зураг болон сонирхолтой байдлын хувьд сурагчдыг сэдэлжүүлэхүйц амархан, энгийн үг хэллэгтэй эх бичвэр, зураг, дасгал даалгавруудтай хэдий ч дүрмийн хэсгийн хувьд төдийлөн сурагчдын анхаарлыг татахуйц өнгөөр ялгаагүй ерөнхийдээ бүх зургийн өнгөний ялгарлыг сайжруулж тодруулах хэрэгтэй.

VII анги

Сурах бичиг нь 4 ай, 10 бүлэг, 140 суралцахуйн зорилтоос бүрдсэн. Суралцахуйн зорилт нь сургалтын хөтөлбөрийн зорилго зорилттой нийцсэн боловч сэдэв хоорондын залгамж холбоо хангалттай сайн хэмжээнд боловсруулагдаагүй байгаа тул цаашид сайжруулалт хийх нь зүйтэй. Бүлэг сэдэв тус бүрт оруулсан эх бичвэрүүд, дасгал даалгаврын агуулга найруулгын алдаагүй боловч үг үсгийн алдааг дахин нягталж засах шаардлагатай. Сурагчдын багаар ажиллах, хамтран гүйцэтгэх, байгаль орчноо хамгаалах талаар бага оруулжээ. Бичих чадварыг хөгжүүлэхэд түлхүү анхаарсан дасгал ажлуудыг агуулгаар нь багтаасан нь ажиглагдлаа. Харин сэдэв бүр сурагчдын нас сэтгэл зүйн онцлогт тохирсон байдал нь дунд зэрэг, Монгол үндэстний ахуйн соёл, үнэт зүйлсийн талаарх бичвэр, дасгал даалгавар хомс байна. Дасгал даалгаврын хүндрэлийн түвшин харьцангуй жигд буюу 47 хувь нь хөнгөн, 53 хувь нь хүнд байна. Цаашид сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тохирсон эх бичвэр, дасгал даалгавраар баяжуулах, үг үсгийн алдааг нягт нямбай шалгах, дуу, шүлэг, график зэргийг цаг үетэй нийцүүлсэн жишээгээр оруулах, сурагчдын өөрийгөө хөгжүүлэх, хүмүүжүүлэх дасгал даалгаврын тоог нэмэх, сурах хүсэл эрмэлзлийг төрүүлэх үүднээс нэгэн хэвийн уйтгартай дасгал даалгаврыг сонирхол татахуйц болгон өөрчлөх, дүрмийн хэсгийг ойлгомжтой хүртээмжтэй байдлаар онцлон байршуулах, сурах бичгийн зураг, дүрслэл, өнгө үзэмжийг сайжруулах, туршилт дадлага ажлын тоог нэмэгдүүлэх, загварчилсан бүдүүвчийг түлхүү ашиглах, сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тохируулан дасгал даалгаврыг сонирхолтой тоглоомын аргаар хийх боломжтой болгох зэргийг анхааран үзэж сайжруулах саналтай байна.

VIII анги

Сурах бичиг нь 10 бүлэг, 196 суралцахуйн зорилтын дагуу бичигдсэн. Агуулга нь сургалтын хөтөлбөрийн суралцахуйн агуулгын дагуу бичигдсэн 6 бүлэг, сайжруулалт хийх хэрэгтэй 4 бүлэгтэй. Сургалтын хөтөлбөрийн боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэв хоорондын залгамж холбоо хангалттай сайн боловч тухайн ангийн бүлэг сэдвийн залгамж холбоо, эрэмбэ дарааллыг сайжруулах хэрэгтэй. Мэдлэг, хандлага төлөвшүүлэх талаас баримтын, ухагдахууны, үйлийн, ахуйн, метакогнитив мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгыг тодорхой хэмжээнд тусган оруулсан. Харин ёс суртахууны хүмүүжил хандлага төлөвшүүлэхийн тулд хамтарч ажиллах, байгаль орчноо хайрлан хамгаалах, өөрийгөө танин мэдэх, хөгжүүлэх сэдвийг түлхүү оруулсан боловч өөрийгөө хүмүүжүүлэх, ёс суртахууны төлөвшил эзэмшүүлэх сэдвийг цөөн тоогоор багтаажээ. Сурагчдын сонирхлыг татсан сэдэлжүүлэх агуулгатай бичвэр, график, дасгал даалгавар, дадлага ажил, тэмдэг тэмдэглэгээг хангалттай оруулсан ч дуу, шүлэг, диаграмм, туршилт ажлыг цөөн тоогоор оруулсан байна. Дасгал даалгавраар дамжуулан дүгнэлт гаргах, хэрэглэх, бүтээх, задлан шинжлэх зэрэг танин мэдэхүйн чадварыг эзэмшүүлэхээр боловсруулсанаас гадна дасгал даалгаврын хүндрэлийн түвшин харьцангуй жигд буюу хөнгөн даалгавар 44 хувь, хүнд даалгавар 56 хувь байна. Сурах бичгийн нийт 455 дасгал даалгавраар дамжуулан асуудал

шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах, шинжлэн судлах арга барилд суралцуулахаар зохиожээ. Өмнөх түвшинд үзсэн үгийн сангийн тоо, хүндрэл дараагийн түвшинд нэмэгдсэн байхаар анги тус бүрт тодорхой болгож өгөх хэрэгтэй байна.

Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг сурах бичигт сэдэв тус бүрээр тодорхой хэмжээнд тусган оруулах шаардлагатай. Сурах бичгийн арга зүйн тухайд ойлгох чадвар олгох, ангилах, жишиж харьцуулах, жишээгээр тайлбарлах зэрэг дасгал даалгаврууд дутмаг байгаа тул бусад эзэмших чадварын дасгал даалгаврын тоотой адилтган тэнцвэржүүлэх, олон сонголттой хариулттай даалгаврыг загварчилж оруулах, эрэл хайгуул хийх дасгал даалгаврыг сурагчид өөрсдөө бие даан мэдлэг олж авах, бүтээх арга барилд суралцах тал дээр анхааран үзэж сонирхолтой байдлаар сайжруулалт хийж дасгалын тоог нэмэх нь зүйтэй. Боловсролын талаарх дэлхийн чиг хандлага, тогтвортой хөгжлийн агуулга, иргэд зайлшгүй эзэмшсэн байх урьдчилан тооцох, шүүмжлэх сэтгэлгээ, өөрийгөө таньж мэдэх, хариуцлага хүлээх, ухамсартай зөв сонголт хийх, нийгэмд эв зүйтэй амьдрах чадваруудыг хөгжүүлэх агуулгыг тусган оруулах, хэл найруулгын тухайд дахин хянан сайжруулах, техникийн тухайд сурах бичгийн бүлэг сэдэв бүрийг хуудсаар нь ангилан ялгах, нүдэнд харагдахуйц өнгөөр ялган тоог тавих, шинэ үгсийг зөвхөн арын хуудсанд байрлуулахаас илүүтэй бүлэг сэдэв тус бүрт хайрцаглан оруулах, үгээр тайлбарлах шаардлагагүй зүйлийг ойлгомжтой тэмдэг тэмдэглэгээгээр солих, бүх зургийн чанарыг сайжруулах, ижил төстэй бус өөр өөр зурагнууд ашиглах хэрэгтэй.

IX анги

Сурах бичиг нь 4 ай 10 бүлэгтэй, суралцахуйн зорилтын хувьд дунджаар 1 бүлэгт 14-15 зорилтыг хэлэхүйн 4 чадвар болон дүрмийн мэдлэгт суурилан боловсруулсан. Сурах бичгийн анги хоорондын холбоо хамаарал хангалттай бөгөөд 8-р ангид үздэг хичээлтэй холбоотой үг хэллэг нь 9-р ангийн номонд арай хүндэрч орж ирсэн хэдий ч шинэ үгийн сангийн тоо хэт буурсан. Суралцахуйн зорилго, зорилтын холбоо хамаарал хийгээд сурах бичгийн агуулга хоёрыг харьцуулахад хангалттай сайн гэж үзээгүй бөгөөд зарим бүлэгт суралцахуйн зорилтод тусгагдаагүй агуулга, дүрэм, чадвар зэргийг оруулсан байна. Сурах бичгийн онцлог нь сонирхол татахуйц эх бичвэрээр баялаг, бодит амьдралын жишээ баримтад тулгуурласан контексттэй даалгавар болон хувь хүний хөгжил талаас сургасан контекст бичвэрүүдийг багтааж өгсөн нь сурагчдад өөрийгөө хөгжүүлэх, танин мэдэх, багаар ажиллах, ёс суртахууны төлөвшил тогтох зэрэг ач холбогдолтой болжээ. Дасгал даалгаврын хүндрэлийн түвшингийн хувьд 60 хувь нь хөнгөн, 40 хувь нь хүнд байна. Арга зүйн хувьд сурагчид өөрсдөө мэдлэг бүтээх байдлаар боловсруулсан байгаа нь харагдаж байсан бөгөөд олон төрлийн дасгал даалгавар, жишээ баримт зэргийг оруулсан байна. Дүрмийн хэсгийг нүдэнд шууд тусгагдахуйц тусдаа өнгөөр тэмдэглэсэн төдийгүй, энгийн өгүүлбэрээр, харьцуулан жиших байдлаар, бүдүүвчээр зэрэг өөр өөр арга барилуудыг ашиглан хялбаршуулан оруулжээ. Харин бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, эргэцүүлэн бодох, кэйс дээр ажиллах зэрэг дасгал даалгаврууд дутмаг байна. Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл бүхий бичвэр, байгаль орчноо хайрлан хамгаалах сэдвийн агуулгыг сурах бичигт заавал тусган оруулах шаардлагатай. Техникийн хувьд сурах бичигт хэд хэдэн дасгалын дугаарыг буруу тэмдэглэснээс болоод дасгалуудыг өөр хооронд нь андуурах, эргэлзүүлэх алдаа гарсан. Зураг дүрслэл бүрийн нягтаршлыг сайжруулах хэрэгтэй.

X анги

Сурах бичиг нь 4 ай, 10 бүлэгтэй, нэг бүлэгт 15 суралцахуйн зорилтыг агуулсан. Суралцахуйн зорилт хийгээд ангийн холбоо хамаарлын хувьд хангалттай. 10 бүлгийн

агуулга нь сурагчдад бусадтай хамтарч ажиллах, өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хөгжүүлэх, байгаль орчноо хайрлан хамгаалах зэрэг хандлагыг суулгах зорилготой сэдвүүдийг багтаасан төдийгүй, үгсийн сан болон дүрмийн хэсэг нь сурагчдаар өөрсдөөр нь шинжлэн судлуулж, нээн илрүүлж эзэмшүүлэх байдлаар боловсруулагдсан сайн талтай хэдий ч нэг бүлэгт буй дүрмийн агуулга дахин давтагдах байдал ажиглагдсан. Тиймээс дүрмийн мэдлэг болон хэлэхүйн 4 чадвар хоорондын холбоо хамаарлыг сайжруулах хэрэгтэй. Дасгал даалгаврын хүндрэлийн түвшин харьцангуй жигд буюу 58 хувь нь хөнгөн, 42 хувь нь хүнд байна. Арга зүй болоод дасгал даалгаврын хувьд сурагчдыг сэдэлжүүлэхүйц олон төрлийн дасгал даалгавруудыг багтаасан ч ярианы асуултын агуулга 8-10 анги хүртэл нэг сэдэв тойрсон асуултуудтай, сурагчдад өөрийн санаа бодлоо баталгаа нотолгоон дээр үндэслэн илэрхийлэх чадвар олгох тал дээр дутагдалтай байна. Иймд төрөл бүрийн ярианы сэдэвтэй агуулгуудыг оруулж, зөвхөн бодлоо илэрхийлэх болон асуултанд хариулах биш харин сурагчдад ахисан шатны эх бичвэр бичих, өөрийн санаагаа дэлгэрэнгүй илэрхийлэх, нээлттэй асуулт тавих, кэйс дээр ажиллах, хэлэлцүүлэг хийх боломж олгохуйц сэдвүүдийг нэмэгдүүлэх, мөн хэл зүйн дүрмийн хэрэглээний хязгаарлагдмал байдлыг засаж сайжруулах хэрэгтэй.

XI анги

Сурах бичиг нь 10 бүлэг, 152 суралцахуйн зорилтын дагуу бичигдсэн. Сурах бичгийн агуулга нь сургалтын хөтөлбөрийн суралцахуйн агуулгын дагуу бичигдсэн 9 бүлэг, сайжруулалт хийх хэрэгтэй 1 бүлэг байна. Сургалтын хөтөлбөрийн боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэв хоорондын залгамж холбоо, тухайн ангийн бүлэг сэдвийн залгамж холбоо эрэмбэ дарааллыг хангалттай сайн боловсруулсан. Мэдлэг, хандлага төлөвшүүлэх талаас баримт, метакогнитив мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгыг хангалттай сайн оруулсан бол ухагдахуун, үйлийн, ахуйн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгыг тодорхой хэмжээнд тусган оруулсан. Харин ёс суртахууны хүмүүжил хандлага төлөвшүүлэхийн тулд хамтарч ажиллах, өөрийгөө танин мэдэх, хөгжүүлэх сэдвийг түлхүү оруулсан боловч өөрийгөө хүмүүжүүлэх, байгаль орчноо хайрлан хамгаалах, ёс суртахууны төлөвшил эзэмшүүлэх сэдвийг цөөн тоогоор оруулжээ. Даалгаврын хувьд 40 хувь нь хөнгөн, 60 хувь нь хүнд байна. Сурагчдын сонирхлыг татсан сэдэлжүүлэх агуулгатай бичвэр, график, дасгал даалгавар, дадлага ажил, тэмдэг тэмдэглэгээг хангалттай сайн оруулсан ч дуу, шүлэг, диаграмм, туршилт ажлыг цөөн тоогоор оруулсан байна. Сурагчдыг дасгал, даалгавраар дамжуулан мэдлэгт суралцуулахаар боловсруулсан баримтын, ухагдахууны, үйлийн, ахуйн, метакогнитив даалгаврыг хангалттай тусгажээ. Мөн дасгал даалгавраар дүгнэлт гаргах, хэрэглэх, бүтээх, задлан шинжлэх зэрэг танин мэдэхүйн чадварыг эзэмшүүлэхээр боловсруулагдсанаас гадна дасгал даалгаврын хүндрэлийн түвшин харьцангуй хүнд даалгавар давамгайлсан буюу хөнгөн даалгавар 40 хувь, хүнд даалгавар 60 хувийг эзэлсэн байна. Сурах бичгийн нийт 510 дасгал даалгавраар дамжуулан асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах, шинжлэн судлах арга барилд суралцуулахаар зохиогджээ. Сурах бичгийн хэл найруулгын тухайд сайжруулах санал бүхий зөв бичгийн дүрмийн алдаа, үг үсэг сольж бичсэн алдаа илэрсэн ч ерөнхийдөө хангалттай сайн хянагджээ. Цаашид сургалтын хөтөлбөрийн зорилтын дагуу боловсруулагдсан 10 бүлгийг хянан сайжруулах, агуулгын дагуу тухайн ангийн бүлэг сэдвийн залгамж холбоог сайжруулах, өөрийгөө хүмүүжүүлэх, ёс суртахууны төлөвшил эзэмшүүлэх хандлага бүхий сэдвийн тоог нэмэх, сурагчдын сонирхлыг татахуйц дуу, шүлэг, диаграмм, туршилт, дасгал ажлаар баяжуулах, загварчилж тайлбарласан, бүдүүвчээр тайлбарласан сэдвийн тоог олшруулах, Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг сэдэв тус бүрээр нь тодорхой хэмжээнд тусган оруулах саналтай байна.

ХII анги

Сурах бичиг нь 10 бүлэг, 172 суралцахуйн зорилтын бүтцийн элементүүд хангалттай сайн боловсруулсан. Тус ном нь 4 ай, 10 бүлэг, 40 дэд бүлэг, 10 нэгж сэдэв, 40 дэд сэдэв, 10 сэдвийн агуулга гарчгийн тоотой байна. Сурах бичгийн агуулга нь сургалтын цөм хөтөлбөрийн суралцахуйн агуулгын дагуу бичигдсэн, боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэв хоорондын залгамж холбоо, тухайн ангийн бүлэг сэдвийн залгамж холбоо эрэмбэ дараалал хангалттай. Мэдлэг, хандлага төлөвшүүлэх талаас баримт, метакогнитив, үйлийн, ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх сэдэв хангалттай тусгагдсан боловч ахуйн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулга тусгагдаагүй байна. Харин ёс суртахууны хүмүүжил хандлага төлөвшүүлэхийн тулд хамтарч ажиллах, өөрийгөө танин мэдэх, хөгжүүлэх сэдвийг оруулсан боловч өөрийгөө хүмүүжүүлэх, байгаль орчноо хайрлан хамгаалах, ёс суртахууны төлөвшил эзэмшүүлэх сэдвийг цөөн тоогоор боловсруулжээ. Сурагчдын сонирхлыг татсан сэдэлжүүлэх агуулгатай бичвэр, график, дасгал даалгавар, дадлага ажил, тэмдэг тэмдэглэгээг хангалттай сайн оруулсан ч дуу, шүлэг, диаграмм, туршилт ажлыг цөөн тоогоор оруулсан байна. Мөн дасгал даалгавраар дүгнэлт гаргах, хэрэглэх, бүтээх, задлан шинжлэх зэрэг танин мэдэхүйн чадварыг эзэмшүүлэхээр боловсруулагдсанаас гадна дасгал даалгаврын хүндрэлийн түвшин харьцангуй хөнгөн даалгавар давамгайлсан буюу хөнгөн даалгавар 60 хувь, хүнд даалгавар 40 хувийг эзэлсэн байна. Сурах бичгийн нийт 482 дасгал даалгавраар дамжуулан асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах, шинжлэн судлах арга барилд суралцуулахаар зохиогджээ. Цаашид өөрийгөө хүмүүжүүлэх, ёс суртахууны төлөвшил эзэмшүүлэх хандлага бүхий сэдвийн тоог нэмэх, сурагчдын сонирхлыг татахуйц дуу, шүлэг, диаграмм, туршилт ажлаар дасгал ажлыг баяжуулах, загварчилж тайлбарласан, бүдүүвчээр тайлбарласан сэдвийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай. Сурах бичигт тавигдах үндсэн шаардлагуудыг хангасан сурах бичиг болжээ.

ОРОС ХЭЛНИЙ СУРАХ БИЧИГ

Хүснэгт 1. Суралцахуйн зорилтыг (агуулга) боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэв хоорондын залгамж холбоотой боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн.


Сурах бичиг	Анги хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн ангийн бүлэг сэдвийн залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн бүлгийн сэдэв хоорондын залгамж холбоо, эрэмбэ дараалал
Орос хэл (V-XII)	3	3	3

Орос хэлний хичээлийн сурах бичгийн тухайд анги, бүлэг, сэдэв хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал хангалттай гэж дүгнэж байна.

Хүснэгт 2. Орос хэлний сурах бичгийн мэдлэгийн хэлбэрт хийсэн шинжилгээний дүн

Сурах бичгийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Мэдлэгийн төрөл				
		Баримтын мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Метакогнитив мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо
1 Орос хэл (V-XII)	741	134/18%	141/19%	174/23%	177/24%	115/16%

График 1 Орос хэлний сурах бичгийн мэдлэгийн хэлбэрт хийсэн шинжилгээний дүн



23 хувь нь үйлийн, 24 хувь нь ахуйн, 19 хувь нь ухагдахууны, 18 хувь нь баримтын, 16 хувь нь метакогнитив мэдлэгийг эзэмшүүлэхээр агуулгын сонголт хийгдсэн байна.

Хүснэгт 3. Орос хэлний сурах бичгийн хандлага, (ёс суртахууны хүмүүжил төлөвшүүлэх)-ын шинжилгээний дүн

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Суралцах ёс суртахууны хүмүүжил төлөвшил				
		Хамтарч ажиллах сэдвийн тоо	Байгаль орчноо хайрлах хамгаалах сэдвийн тоо	Өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хөгжүүлэх сэдвийн тоо	Өөрийгөө хүмүүжүүлэх сэдвийн тоо	Ёс суртахууны төлөвшил эзэмшүүлэх сэдвийн тоо
Орос хэл (V-XII)	741	170/23%	111/15%	148/20%	148/20%	164/22%

Хандлагыг авч үзвэл 23 хувь нь хамтарч ажиллах, 22 хувь нь ёс суртахуун, хүмүүжүүлэх, 20 хувь нь өөрийгөө танин мэдэх, хүмүүжүүлэх, 15 хувь нь байгаль орчноо хамгаалах чиглэлээр агуулгын сонголт хийсэн.

Хүснэгт 4. Сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлын талаарх шинжилгээний дүн

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1	
	Сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, жишээ баримттай бичвэр, дасгал, даалгавар, туршилт ажил, дадлага ажлыг сурах бичигт оруулсан эсэх	Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг сурах бичигт тусгасан эсэх
Орос хэл (V-XII)	2	3


Бага, суурь, бүрэн дунд боловсролын сурах бичиг бүрт бичвэр, зураг, диаграмм, дасгал, даалгавар болон тэмдэг тэмдэглэгээгээр сурагчдын сонирхол, хэрэгцээ, танин мэдэхүйн онцлогт тохируулан дэд сэдвийн агуулга бүрт сонгож оруулсан нь сурах бичгийн агуулгыг судлахад суралцагчийг сэдэлжүүлэхээс гадна мэдээллийн төрлүүдийг хослуулан хэрэглэх, харьцуулан жиших, хэрэгтэй мэдээллээ олж авах боломжоор хангаж байгаа хэдий ч цаашид сайжруулах хэрэгтэй гэж үзсэн байна. Харин дээрх сурах бичгүүдэд Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйлсийг мэдлэг эзэмшүүлэх агуулга, дасгал даалгавар хангалттай хэмжээнд тусгасан байна.

СУРАХ БИЧГИЙН АРГА ЗҮЙД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

Хүснэгт 1. Сурах бичгийн даалгаврын мэдлэгийн хэлбэрт хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Мэдлэгийн төрөл				
		Баримтын мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Метакогнитив мэдлэг эзэмшүүлэх мэдлэгийн тоо
1 Орос хэл	1540	339/22%	169/11%	416/27%	462/30%	154/10%

График 1. Сурах бичгийн даалгаврын мэдлэгийн хэлбэрт хийсэн шинжилгээний дүн




Даалгаврын 30 хувь нь ахуйн, 27 хувь нь үйлийн, 22 хувь нь баримтын, 11 хувь нь ухагдахууны, 10 хувь нь метакогнитив мэдлэгийг дэмжсэн байна.

Хүснэгт 2. Сурах бичгийн дасгал, даалгаврыг тодорхой чадварт суралцахаар боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний үр дүн.

	Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Чадварын тоо							
			Ойлгох чадвар тоо				Хэрэглэх чадварын тоо	Задлан шинжлэх чадварын тоо	Бүтээх чадварын тоо	Метакогнитив
			Ангилал	Жишиж харьцуулах	Жишээгээр тайлбарлах	Дүгнэлт гаргах				
1	Орос хэл	1540	123/8%	231/15%	231/15%	108/7%	293/19%	154/10%	200/13%	200/13%

График 2. Сурах бичгийн дасгал, даалгаврыг тодорхой чадварт суралцахаар боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний үр дүн.



Даалгаврын 21 хувь жишээгээр тайлбарлах, 19 хувь нь хэрэглэх, 15 хувь нь жиших, 13 хувь нь бүтээх, 10 хувь нь задлан шинжлэх, 8 хувь нь ангилах, 7 хувь нь метакогнитив чадварыг дэмжсэн байна.

Хүснэгт 3. Даалгаврын хүндрэл, хариултын хувилбарт хийсэн дүн.


Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Даалгаврын хүндрэлийн түвшний тоо		Даалгаврын хариултын хувилбарын тоо		
		Хөнгөн	Хүнд	Нээлттэй хариулт	Хаалттай хариулт	Олон сонголттой
Орос хэл	1540	1156/75%	384/25%	0	0	0

Даалгаврын 75 хувь нь хөнгөн, 25 хувь хүнд даалгавар боловсруулсан байна.

Хүснэгт 4. Даалгаврын контекст, сурах арга барилд хийсэн шинжилгээний дүн.


Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Контекстийн хэлбэр /тоо			Сурах арга барил			
		Шинжлэх ухаан	Зохиомол	Бодит амьдралын жишээ	Асуудал	Мэдээлэл	Шинжлэн судлах	Эрэл хайгуул
	1540	364/24%	378/24%	798/52%	464/30%	585/38%	254/17%	237/15%

График 3. Даалгаврын контекстийн шинжилгээний дүн



Даалгаврын 24 хувь нь шинжлэх ухааны, 24 хувийг ахуйн, 52 хувийг зохиомол контекст тус тус эзэлж байна.

График 4. Сурах арга барилын шинжилгээний үр дүн.



Даалгаврын 38 хувийг мэдээлэл, 30 хувийг асуудал шийдвэрлэх, 17 хувийг шинжлэх, 15 хувийгэрэл хайгуул хийх арга барилыг дэмжсэн даалгаврууд эзэлж байна.

Хүснэгт 5. Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага, хэл найруулга, дизайнд хийсэн шинжилгээний дүн

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1		
	Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага	Хэл найруулга	Техник
Орос хэл	1	3	3

Бага, суурь, бүрэн дунд боловсролын орос хэлний сурах бичигт тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлагын талаарх агуулгыг хангалтгүй тусгасан, хэл найруулга болон техникийн шаардлагыг хангасан гэж үзсэн байна. Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлагын талаарх агуулга хангалтгүй тусгасан.

ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

Нийтлэг давуу тал:

- Анги бүр сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилт (агуулга)-той сурах бичгийн агуулга бүрэн нийцэж байна.
- Суралцахуйн зорилт боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэв хоорондын залгамж холбоо тухайн сурах бичиг дотор, дараах ангийн сурах бичигт нарийн тогтоогдсон. Тухайн сурах бичгийн агуулга, дасгал даалгаврын тогтолцоо, мөн өмнөх болон дараагийн ангийн сурах бичгийн агуулга, дасгал даалгаврын залгамж холбоо, уялдаа холбоог хангалттай сайн гаргасан.
- Баримтын, ухагдахууны, үйлийн, ахуйн, метакогнитив мэдлэг олгох агуулга орос хэлээр ярих, сонсох, унших, бичих суурь мэдлэг, чадвар олгох нөхцөлийг хангалттай сайн бүрдүүлж байна.
- Сэдэлжүүлэх баримт материалыг сурах бичгийн бүлэг, дэд бүлэгт зохистой, харилцан уялдаатай оруулсан. Сэдэлжүүлэх хэрэглэгдэхүүний эзлэх хэмжээ нэг сурах бичгээс нөгөөд, суурь боловсролоос, бүрэн дундаж шилжихэд аажмаар өөрчөгдөж байна.
- Ухагдахуун, онол, нэр томъёог хэрэглээ болон танин мэдэхүйн түвшинд тохируулан, зөв оновчтой томъёолсон. Ойлгомжгүй ухагдахуун нэр томъёо байхгүй. Хэл шинжлэл, заах аргын нэр томъёог тусгайлан орчуулж тайлбарласан.
- Орон судлал, соёлын мэдлэг олгох нь орос хэлний хичээл, орос хэлний сурах бичигт тавигдаж байгаа үндсэн зорилтын нэг гэж үзсэн. Соёлын мэдлэгийг бүлэг сэдэв, дэд сэдэв бүрт монгол ахуй, түүх соёл, заншилтай нягт уялдуулж, зохистой харьцаагаар сурах бичигт тусгасан.

Сайжруулах санал:

1. Бүлэг, сэдэв бүрийн агуулга нь бодит ахуй, нийгэм, соёлын амьдралтай нягт холбоотой учир сэдэлжүүлэх агуулгаар баяжуулах өргөн боломж байна.
2. Анги тус бүрийн сурах бичигт найруулга нь оновчтой, товч, энгийн ойлгомжтой, хэл найруулгын болон зөв бичих дүрмийн алдаагүй байх тал дээр цаашид сайжруулах хэрэгтэй. Анги бүрийн сурах бичгийн зөв бичих, найруулагын сайжруулах асуудлыг тодорхой дасгал, агуулгын сэдэв бүрийг баримтжуулж сайжруулах саналыг дэлгэрэнгүй өгсөн болно.

МАТЕМАТИК

Бага, суурь боловсролын сурах бичгийн хувьд:

1. Үүрэг зориулалтын нэг болох “Логик болон тохирох математик системээр хангах” гэсэн зорилтыг хангахгүйд хүрч байна.

Шинэ нэр томъёо, ухагдахуун, чанар, тодорхойлолтыг хялбаршуулан хэрэглэх, тайлбарлахад гарч буй алдаа нь зөвхөн сурагч (математикийн хэлд буруу орвол цааш залруулахад хэцүү, мөн дараа дараагийн сурах үйл явцад сөргөөр нөлөөлнө) төдийгүй багш нар арга зүйн алдаа гаргахад нөлөөлнө. Тухайлбал, бага ангийн бүх сурах бичигт хэмжигдэхүүн агуулгын хүрээнд биеийн жин, шингэний эзлэхүүн, савны багтаамж, талбай гэх мэт ухагдахууныг хялбаршуулахдаа хүндийг хэмжих, шингэнийг хэмжих, талбайн хэмжээ гэсэн ухагдахуун оруулж, зарим тохиолдолд эдгээрийг хольж хэрэглэсэн ба энэ нь сурагчдад альтернатив ойлголт төрүүлнэ. Тухайн нэг жишээг иш татах байдлаар ухагдахууны тодорхойлолт, чанарыг томъёолох тохиолдол нийтлэг байна. Гүйцэд болон гүйцэд биш индуктив оюун дүгнэлт, ажиглах, турших, ангилах ялгах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, хийсвэрлэх гэх мэт оюуны үйл дээр тулгуурлан тухайн ухагдахуун, чанар зүй тогтлын талаар төсөөлөл өгсний дараа тухайн анги түвшинд тохирсон үг хэллэг ашиглан, логик алдаагүй, өөр өөр ойлголт төрүүлэхгүй байхаар томъёолох нь зүйтэй юм.

Ухагдахууныг тодорхойлох үндсэн зарчмыг зөрчсөн тохиолдол цөөнгүй байна. Тодруулбал, ухагдахууныг төрөл олонлогоос нь гол шинжээр (зайлшгүй бөгөөд хүрэлцээтэй нөхцөл) ялгах замаар тодорхойлох, нийцтэй ухагдахууны олонлогийг шинж чанараар нь үл огтлолцох ангиудад хуваах замаар тодорхойлох гэх мэт үндсэн зарчмыг баримтлаагүй, аль нь чанар, аль нь тодорхойлолт нь вэ гэдгээ зөв ялгаж салгаагүйгээс гарсан алдаа нийтлэг байна.

2. Сурагчдын танин мэдэхүйн зүй тогтлыг алдагдуулсан. Тодруулбал:

- Агуулгын залгамж холбоо— алдагдсан, шинэ ухагдахуун тодорхойлоход өөр мэдэхгүй ухагдахуун, нэр томъёо ашигласан байдал бодлогод ажиглагдаж байна.
- Сурагчид мэдлэгээ бататгах гол хэрэгсэл, суралцахуй болон багшлахуйн үйл ажиллагаанд чухал үүрэгтэй дасгал даалгаврын төрөл, танин мэдэхүйн хүндрэл, тавил, хариултын хэлбэрийн хувьд бүтэц алдагдсан. Бага, суурь боловсролын математикийн хөтөлбөрийн хувьд ухагдахууны сүлжээг бүтээж, анализ хийх замаар ухагдахууны тодорхойлолт, спирал загвар, дасгал даалгаврын систем, арга зүйн санааг бүхэлд нь сайжруулах боломжтой.
- Сэдэв бүрийг жишээгээр (ихэвчлэн өгүүлбэртэй бодлого) эхэлж байгаа боловч тэр нь математикийн хувьд эсвэл танин мэдэхүйн хувьд сурагчдад ямар асуудал дэвшүүлж байгаа нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл асуудалд суурилсан сургалтын арга зүйн санааг багтаах гэж оролдсон боловч асуудал нь тодорхойгүй байна. Сурагчид мэдлэгийг өөрийн идэвхитэй үйл ажиллагаагаар бүтээх боломжийг олгодог ухагдахуун таниулах аргын гол үндэслэл болсон юмсыг шинж чанараар нь ангилах жишээг зарим сэдвийн хувьд авах гэж оролдсон боловч энэ нь шаардлага хангахгүй, оновчгүй байна. Нөгөө талаас зарим сэдвийн хувьд агуулгын залгамж холбоог тооцоогүйгээс эхэнд авч үзэж буй жишээ нь тохиромжгүй байна.

3. Зохиомол болон бодит агуулгатай бодлогын хувьд бодлогын контекст дээр анхаарах. Тодруулбал,

- Тогтвортой хөгжлийн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц контексттэй
- Монголын түүх, ёс заншил, ахуй соёл, үнэт зүйлтэй холбоотой
- Хувийн санхүү, мэргэжил, зохион байгуулалттай холбоотой
- Бусад хичээлтэй холбоотой,
- Бодит түүх, мэдээлэл, эрдэмтдийн судалгааны болон статистикийн тоо баримт өгөгдлийн ашиглах, эх сурвалжийг дурдах шаардлагатай байна.

4. Номын бүтэц дизайн дээр анхаарах, ялангуяа бага ангийн сурах бичгийн хувьд

Б. Бүрэн дунд боловсролын математикийн сурах бичгийн хувьд:

1. Сурах бичиг хөтөлбөрийн дагуу бичигдсэн ба хөтөлбөрт “Хязгаар” агуулгыг тодорхой хэмжээнд оруулж ирээгүйгээс “анализын эхлэл” агуулгын хувьд математик тодорхойлолт өгч чадахгүйд хүрч зарим тодорхойлолт болон чанарын баталгааг хялбаршуулан хэрэглэхээс аргагүйд хүрсэн. Гэхдээ энэ дүгнэлт нь хязгаар агуулгыг заавал оруулах ёстой гэсэн үг биш бөгөөд хэрэв оруулбал ямар түвшинд оруулах вэ гэдгийг анхаарах нь зүйтэй гэсэн санаа юм.

2. Сурагчид мэдлэгээ бататгах гол хэрэгсэл, суралцахуй болон багшлахуйн үйл ажиллагаанд чухал үүрэгтэй дасгал даалгаврын төрөл, танин мэдэхүйн хүндрэл, тавил, хариултын хэлбэрийн хувьд бүтцийг дахин сайжруулахаас гадна бүрэн дунд боловсролын түвшний математикийн хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хангахуйц бодлого даалгаврын системээр хангах шаардлагатай.

В. Бодлогын хувьд

Хууль эрх зүйн орчин, боловсролын тогтолцооны хувьд:

- 1963 оноос хойш батлагдан гарсан боловсролын тухай хууль, тэдгээрийн “хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (НӨОТХ)”-иудад хийгдсэн судалгааны үр дүнгээс харахад 2002 оноос хойш мөрдөгдөж буй боловсролын багц 7 хуульд нийт 38 удаагийн нэмэлт, өөрчлөлт орсноос 19 удаа (50%)-гийн НӨОТХ нь Боловсролын хуулийг бусад хууль тогтоомжтой нийцүүлэхтэй холбоотой байна. Зарим зүйл, заалтад хийгдэх нэмэлт өөрчлөлтийн давтамж их, зарим тохиолдолд маш ойрхон хугацаанд нэг нь нөгөөгөө үгүйсгэсэн нэмэлт өөрчлөлт хийгдэж байгаа ба хоорондоо нийцгүй, зөрчилтэй заалтууд ч байна.

Хөтөлбөрийн хөгжил, шинэчлэл, судалгааны хувьд

- Өнөөдрийг хүртэл хийсэн хөтөлбөрийн хөгжлийн бодлого, шинэчлэл нь СӨБ, бага, дунд боловсролын бодлогод гарсан өөрчлөлт, бүтэц тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэхтэй холбоотойгоор хийгдэж ирсэн ба менежментийн хувьд гадаад дотоодын санхүүжилттэй төслийн хүрээнд, гадаад, дотоод зөвлөхүүдээс бүрдсэн багаар удирдуулан боловсруулж иржээ. Өөрөөр хэлбэл, үндэсний хэмжээнд хөтөлбөрийн хөгжил, шинэчлэлийн талаар нэгдсэн судалгаа бодлого, төлөвлөлт хийдэг, түүнийг хөгжүүлдэг, хэрэгжүүлдэг бүтэц, судалгааны институт бүрэн утгаараа хөгжөөгүй, судлаачид бэлтгэгдээгүй, судалгааны арга зүй дизайн нь хөгжөөгүй, хоцрогдсон байдалтай байна.

Сурах бичиг бичих баг, редакцын зөвлөл, хугацааны хувьд

- Тухайн чиглэлээр мэргэшсэн багш нар оролцохоос гадна тухайн шинжлэх ухааны болон танин мэдэхүйн шинжлэх ухааны өндөр мэдлэг, ур чадвартай судлаачдаас бүрдсэн баг бичих шаардлагатай. Энэ харьцаа ямар байх вэ гэдгийг анхаарах зайлшгүй шаардлагатай
- Редакцын зөвлөлийн үүрэг хариуцлага тодорхой байх шаардлагатай бөгөөд редакцын багийн бүрдүүлэлт, харьцааг зөв оновчтой тогтоох шаардлагатай.
- Сурах бичиг бичих хугацааг хангалттай урт болгож, туршиж, сурах бичгийн судалгааг тасралтгүй хийдэг засан сайжруулдаг байх шаардлагатай.

Сурах бичиг бичих, судлах засан сайжруулах үйл ажиллагаанд мэргэжлийн холбоодын үүрэг оролцоог сайжруулах шаардлагатай байна.

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

СУРАХ БИЧГИЙН АГУУЛГАД ТАВИХ ШААРДЛАГАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН.

Хүснэгт 1. Суралцахуйн зорилтыг (агуулга) боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэв хоорондын залгамж холбоотой боловсруулсан байдалд хийсэн үр дүн.


Сурах бичиг	Анги хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн ангийн бүлэг сэдвийн залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн бүлгийн сэдэв хоорондын залгамж холбоо, эрэмбэ дараалал
Мэдээллийн технологи (VI-XII)	3	3	3

Мэдээллийн технологийн сурах бичгийн тухайд анги, бүлэг, сэдэв хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал, хөтөлбөрийн дагуу боловсруулсан байна.

Хүснэгт 2. Сурах бичгийн мэдлэгийн хэлбэрт хийсэн шинжилгээний дүн

Сурах бичгийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Мэдлэгийн төрөл				
		Баримтын мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Метокөгнитив мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо
Мэдээллийн технологи (VI-XII)	151	30/20%	51/34%	60/40%	9/6%	1/0

График 1. Сурах бичгийн мэдлэгийн хэлбэрт хийсэн шинжилгээний дүн




40 хувь нь үйлийн, 34 хувь нь ухагдахууны, 20 хувь нь баримтын, 6 хувь нь ахуйн мэдлэгийг эзэмшүүлэхээр агуулгын сонголт хийгдсэн байна (анги тус бүрийн дэлгэрэнгүй анализыг эх материалын тайланд хавсаргав).

Хүснэгт 3. Хандлага, (ёс суртахууны хүмүүжил төлөвшүүлэх)-ын шинжилгээний дүн

Сурах бичгийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Суралцах ёс суртахууны хүмүүжил төлөвшил)				
		Хамтарч ажиллах сэдвийн тоо	Байгаль орчноо хайрлах хамгаалах сэдвийн тоо	Өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хөгжүүлэх сэдвийн тоо	Өөрийгөө хүмүүжүүлэх сэдвийн тоо	Ёс суртахууны төлөвшил эзэмшүүлэх сэдвийн тоо
Мэдээллийн технологи (VI-XI)	212	13/6%	13/6%	161/76%	9/4%	16/8%

График 2 Хандлага, (ёс суртахууны хүмүүжил төлөвшүүлэх)-ын шинжилгээний дүн.



76 хувь нь үйлийн, 8 хувь нь ёс суртахууны, 6 хувь нь өөрийгөө хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах, 4 хувь нь өөрийгөө хүмүүжүүлэх хандлага эзэмшүүлэхээр агуулгын сонголт хийгдсэн байна (анги тус бүрийн дэлгэрэнгүй анализыг эх материалын тайланд хавсаргав).

Хүснэгт 4. Сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлын талаарх шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1	
	Сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, жишээ баримттай бичвэр, дасгал, даалгавар, туршилт ажил, дадлага ажлыг сурах бичигт оруулсан эсэх	Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг сурах бичигт тусгасан эсэх
Мэдээллийн технологи (VI-XI)	2	2


Мэдээллийн технологийн сурах бичигт сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, жишээ баримттай бичвэр, дасгал, даалгавар, туршилт ажил, дадлага ажил монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг хангалтгүй тусгасан, монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг сайжруулж тусгах хэрэгтэй гэж үзсэн байна.

СУРАХ БИЧГИЙН АРГАЗҮЙД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Хүснэгт 1. Сурах бичгийн даалгаврын (мэдлэгийн хэлбэр) шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Мэдлэгийн төрөл				
		Баримтын мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Метакогнитив мэдлэг эзэмшүүлэх мэдлэгийн тоо
Мэдээллийн технологи (VI-XI)	361	45/2%	79/21%	207/54%	38/10%	11/3%

График 1. Сурах бичгийн даалгаврын (мэдлэгийн хэлбэр) шинжилгээний дүн



Даалгаврын 54 хувь нь үйлийн мэдлэг, 21 хувь нь ухагдахууны, 12 хувь нь баримтын, 10 хувь нь ахуйн, 3 хувь нь метакогнитив мэдлэгийн хэлбэрийг дэмжсэн байна (анги тус бүрийн дэлгэрэнгүй анализыг эх материалын тайланд) үзүүлэв.

Хүснэгт 2. Сурах бичгийн даалгаврын (тодорхой) шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Чадварын тоо							
	Ойлгох чадвар тоо				Хэрэглэх чадварын тоо	Задлан шинжлэх чадварын тоо	Бүтээх чадварын тоо	Метакогнитив
	Ангилал	Жишиж харьцуулах	Жишээгээр тайлбарлах	Дүгнэлт гаргах				
Мэдээллийн технологи (VI-XI)	9/1%	30/8%	71/20%	45/12%	164/45%	32/9%	10/5%	3/0

45 хувь нь хэрэглэх, 20 хувь нь жишээгээр тайлбарлах, 12 хувь нь дүгнэлт гаргах, 8-9 хувь нь задлан шинжлэх, жиших, 1 хувь ангилал чадварыг дэмжсэн байна.

Хүснэгт 3. Даалгаврын хүндрэл, хариултын хувилбарт хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр/Анги	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Даалгаврын хүндрэлийн түвшний тоо		Даалгаврын хариултын хувилбарын тоо		
		Хөнгөн	Хүнд	Нээлттэй хариулт	Хаалттай хариулт	Олон сонголттой
Мэдээллийн технологи (VI-XI)	361	227/62.8%	134/37.2%	177/49%	110/30.4%	74/20.6%

62.8 хувь нь хөнгөн, 37.2 хувь хүнд даалгавар боловсруулснаас үзэхэд хөтөлбөрийн үнэлгээний зорилтын жинд баримжаалж боловсруулах хэрэгтэй. Даалгаврын 49 хувь нь нээлттэй, 30.4 хувь нь хаалттай, 20.6 хувь нь олон сонголттой хувилбар бүхий хариулттай байна.

Хүснэгт 4. Даалгаврын контекст, сурах арга барилд хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Контекстийн хэлбэр /тоо			Сурах арга барил			
	Шинжлэх ухаан	Зохиомол	Бодит амьдралын жишээ	Асуудал	Мэдээлэл	Шинжлэн судлах	Эрэл хайгуул
Мэдээллийн технологи (VI-XI)	121/33.5%	90/25%	150/41.5%	166/46%	97/27%	60/17%	38/10%

42 хувь нь зохиомол, 33 хувь нь шинжлэх ухаан, 25 хувь нь ахуйн контексттэй 46 хувь нь асуудал шийдвэрлэх, 27 хувь мэдээлэл боловсруулах, 17 хувь нь шинжлэн судлах, 10 хувь нь эрэл хайгуул хийх арга барилыг дэмжсэн даалгаврууд эзэлж байна.

Хүснэгт 5. Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага, Хэл найруулга, дизайнд хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1		
	Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага	Хэл найруулга	Техник
Мэдээллийн технологи (VI-XI)	2	3	3

Мэдээллийн технологийн сурах бичигт тогтвортой хөгжил болон дэлхийн чиг хандлагын талаарх агуулгыг сайжруулж, хэл найруулга болон техникийн шаардлага хангалттай түвшинд бичигдсэн байна.

ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

Манай багийн гишүүд өгөгдсөн удирдамжийн дагуу суурь болон дунд боловсролын “Мэдээллийн технологи” сурах бичгүүдэд шинжилгээ хийсэн. Тус хичээлийг заадаг мэргэжлийн багш нартай уулзаж ярилцах, хичээлийн хөтөлбөртэй танилцах, мэргэжлийн багш нартай онлайн хэлэлцүүлэг хийх зэрэг үйл ажиллагааг явуулсан. Эдгээрт үндэслэн сурах бичигтэй холбоотой дараах санал зөвлөмжийг хүргүүлж байна. Мэдээллийн технологийн сурах бичгүүд хөтөлбөрийн дагуу зохиогдсон, ашиглахад тохиромжтой сайн сурах бичгүүд болсон. Энэ талаар тухайн сурах бичгүүдийг багш нар ам сайтай, санал нэгтэй байсныг дуулгахад таатай байна. Гэвч мэдээлийн технологи гэх энэхүү салбар нь бусад шинжлэх ухааны салбаруудтай харьцуулахад маш хурдацтай хөгжиж байгаа тул тус хичээлийн агуулгуудыг хурдан шинэчлэх шаардлага нэн түрүүнд тавигдаж байна. Сурах бичиг болон хөтөлбөрийн агуулгыг жил бүр өөрчлөөд байх боломжгүй учир зарим нэг агуулгыг сурах бичигт ерөнхийлсөн байдлаар тусгаж харин энэ агуулгад хамаарагдах програм хангамж, аппликейшнийг тухайн хичээлийг зааж байгаа багш өөрөө сонгон заах боломжтой байхаар оруулах, Мэдээллийн технологи хичээлийн нэр томъёонд гадаад үг, нэршил ихээр ашиглагдаж байгаа тул нэр томъёоны нэгдсэн толь, тайлбарыг ашиглах

Сурах бичгийн хуудасны тоо хязгаартай, шинэ технологи, программын хэрэглээ байнга хувьсан өөрчлөгддөг зэргээс хамаарч

- Мэдээллийн технологи хичээлтэй холбоотой нэгдсэн сургалтын платформтай болох
- Сорил даалгаврын тооны хязгаарт баригдахгүй
- Шинэ мэдлэг, технологийн хэрэглээ гарахад цаг алдалгүй шинэчлэл хийж болох зэрэг боломжуудыг олгох
- Монгол улсын зарим сургуулиуд гадаад улсын маш сайн хөтөлбөрийг хэрэгжүүлж буй туршлага байна. Үүнээс санаа авч цаашид суралцагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн хөтөлбөр, сурах бичиг бусад орчныг бүрдүүлэх
- Цаашид баримт бичиг, сурах бичгүүдийг боловсруулахад оролцогч баг, гишүүдийн тоог нэмэгдүүлэх
- Мэдээлэл харилцаа, технологийн боловсролыг бага ангиас эхлэн олгох талаар нарийвчилсан судалгааг яаралтай хийх
- Сурах бичигт орсон дасгал даалгаврыг бусад хичээлийн агуулгатай уялдуулж өгөх
- Жишээ, дасгалд дан ганц компьютерийн програм хангамжийн тухай биш гар утас, таблет гэх мэт бусад смарт төхөөрөмжүүдийн аппликейшн, түүний хэрэглээг оруулж өгөх
- Сурах бичгийн жишээ дасгалд MS Office-ийн Excel, Word зэрэг өндөр үнэтэй лиценз шаарддаг програмууд ашиглахаасаа илүүтэй нээлттэй байдлаар ашиглаж болох програм хангамжуудыг ашиглах
- Сүүлийн 2 жилд цахим, онлайн, теле байдлаар төрөл бүрийн технологийг сургалтанд эрчимтэй ашиглаж эхэлсэн. Үүнтэй уялдуулан сургалтын агуулгад технологийн давуу талыг ашиглаж хэрхэн суралцах боломжуудыг тусгах

- Сүүлийн жилүүдэд шинээр боловсруулж хөгжүүлсэн монгол хэл дээрх сургалтын нээлттэй платформуудын талаарх мэдээлэл, түүний хэрэглээний талаар мэдээлэл нэмэх
- Ахлах, дунд ангийн мэдээллийн технологийн сургалтын хөтөлбөрт өргөн хэрэглээний оффисын програм ашиглан текст бичих, хүснэгт байгуулах гэх мэт уламжлалт загвараас өөрөөр, илүү өргөн хүрээнд сонирхолтой апп татаж ажиллах, жижиг хэмжээний програмыг хөгжүүлэх сургалтуудыг оруулах
- Ахлах, дунд ангийн сурагчдад сурах бичгээр дамжуулан орчин үед дэлхий даяар ямар шинэ технологи нэвтэрч байгаа, мэдээллийн технологийн салбарын өнөөгийн хөгжил, түүнтэй энэ сэдэв хичээл хэрхэн уялдаж байгааг талаар тодруулах
- Суралцагч нь онолын мэдлэгийг илүү практик жишээнээс санаа авах байдлаар ойлгох, түүнийгээ бодит амьдралын жишээн дээр харьцуулах, олж авсан онолын мэдлэг дээрээ тулгуурлаж сорил тестийг бодит техник төхөөрөмж дээр турших боломжтой нь уялдуулах.

Дээрх санал зөвлөмжийг Мэдээллийн Технологийн сурах бичгүүдэд тусган сайжруулбал орчин үеийн технологийн дэвшилд нийцсэн илүү сайн сурах бичиг болно гэж үзэж байна.

БИОЛОГИ

СУРАХ БИЧГИЙН АГУУЛГАД ТАВИХ ШААРДЛАГАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН.

Хүснэгт 1. Сурах бичгийн суралцахуйн зорилтыг (агуулга) боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэв хоорондын залгамж холбоотой боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичиг / Анги	Анги хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн ангийн бүлэг сэдвийн залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн бүлгийн сэдэв хоорондын залгамж холбоо, эрэмбэ дараалал
Биологи (I-XI)	3	3	3

Биологийн сурах бичгийн тухайд анги, бүлэг, сэдэв хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалалтай бичигдсэн.

Сурах бичиг тус бүрд боловсролын түвшингээр хийсэн шинжилгээний дүн

Бага боловсрол

Хүн орчин I-III, Хүн байгаль IV-V сурах бичгүүдийн анги, бүлэг, сэдэв хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал алдагдаагүй хангалттай түвшинд бичигдсэн гэж үзсэн.

Хүн орчин I сурах бичгийн агуулгын 91 хувь нь баримтын болон ухагдахууны, 9 хувь нь ахуйн мэдлэг, Хүн орчин II сурах бичгийн агуулгын 66.6 хувь нь баримтын, 25 хувь нь ухагдахууны, 8 хувь нь үйлийн мэдлэг, Хүн орчин III сурах бичгийн агуулгын 60 хувь нь баримтын, 40 хувь нь үйлийн болон ахуйн мэдлэг, Хүн байгаль IV сурах бичгийн агуулгын 66.6 хувь нь баримтын болон ухагдахууны, 33.4 хувь нь үйлийн болон ахуйн мэдлэг, Хүн байгаль V сурах бичгийн агуулгын 80 хувь нь баримтын болон ухагдахууны, 20 хувь нь үйлийн мэдлэг эзэмшүүлэхээр боловсруулжээ(анги тус бүрийн дэлгэрэнгүй шинжилгээг эх тайланд хавсаргав).

Суурь ба бүрэн дунд боловсрол

Сурах бичгүүдийн анги, бүлэг, сэдэв хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал алдагдаагүй хангалттай түвшинд бичигдсэн байна. IX ангийн сурах бичгийн 1,2 дугаар сэдвийн хүрээнд агуулга давхардсан, суралцахуйн зорилт дутуу бичигдсэн байна (сурах бичиг тус бүрийн анализыг эх материалын тайланд хавсаргав).

Хүснэгт 2. Агуулгын (тодорхой мэдлэгт суралцах) шинжилгээний дүн


Сурах бичгийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Мэдлэгийн төрөл				
		Баримтын мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Метоконгитив мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо
Биологи (I-XI)	244	75/31%	71/29%	29/12%	61/25%	8/3%

Сурах сурах бичигт 31 хувь нь баримтын, 29 хувь нь ухагдахууны, 25 хувь нь ахуйн, 12 хувь үйлийн, 3 хувь нь метакогнитив мэдлэгийг дэмжсэн агуулгын шийдэл хийсэн байна (анги тус бүрийн дэлгэрэнгүй шинжилгээг эх тайланд хавсаргав).

Хүснэгт 3. Хандлага (ёс суртахууны хүмүүжил төлөвшүүлэх)-ын шинжилгээний дүн

Сурах бичгийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Суралцах ёс суртахууны хүмүүжил төлөвшил				Ёс суртахууны төлөвшил эзэмшүүлэх сэдвийн тоо
		Хамтарч ажиллах сэдвийн тоо	Байгаль орчноо хайрлах хамгаалах сэдвийн тоо	Өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хөгжүүлэх сэдвийн тоо	Өөрийгөө хүмүүжүүлэх сэдвийн тоо	
Биологи	244	37/22%	36/22%	83/49%	12/7%	0

График 1. Хандлага (ёс суртахууны хүмүүжил төлөвшүүлэх)-ын шинжилгээний дүн



49 хувь нь өөрийгөө танин мэдэх, 22 хувь нь хамтран ажиллах болон байгаль орчноо хамгаалах, 7 хувь нь өөрийгөө хүмүүжүүлэх хандлагыг дэмжсэн агуулгын шийдэл хийсэн байна(анги тус бүрийн дэлгэрэнгүй шинжилгээг эх тайланд хавсаргав).

Бага боловсрол

Хүн орчин I-III, Хүн байгаль IV-V сурах бичгийн агуулга нь байгаль орчноо хамгаалах, өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хөгжүүлэх, олгоход чиглэсэн байхаар агуулгыг боловсруулсан байна. Тухайлбал, Хүн байгаль IV-V хамтарч ажиллах 33.3 хувь, өөрийгөө хүмүүжүүлэхэд чиглэсэн агуулга 46.6 хувь, байгаль орчноо хамгаалахад чиглэсэн агуулга 13.3 хувь, ёс суртахууны хандлага төлөвшүүлэх агуулга 6.8 хувь тус боловсруулсан байна (анги тус бүрийн дэлгэрэнгүй шинжилгээг эх тайланд хавсаргав).

Хүснэгт 4. Сэдэлжүүлэлт, Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын талаарх шинжилгээний дүн.

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1	
		Сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, жишээ баримттай бичвэр, дасгал, даалгавар, туршилт ажил, дадлага ажлыг сурах бичигт оруулсан эсэх	Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг сурах бичигт тусгасан эсэх
Биологи(I-XI)	244	2	2

Бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд авч сурах бичиг бүрт бичвэр, зураг, диаграмм, дасгал, даалгавар болон тэмдэг тэмдэглэгээгээр сурагчдын сонирхол, хэрэгцээ, танин мэдэхүйн онцлогт тохируулан дэд сэдвийн агуулга бүрт сонгож оруулсан нь сурах бичгийн агуулгыг судлахад суралцагчийг сэдэлжүүлэхээс гадна мэдээллийн төрлүүдийг хослуулан хэрэглэх, харьцуулан жиших, хэрэгтэй мэдээллээ олж авах боломжоор хангаж байгаа хэдий ч цаашид сайжруулах хэрэгцээ байна. Харин дээрх сурах бичгүүдэд Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйлсийг мэдлэг эзэмшүүлэх агуулга, дасгал даалгавар хангалтгүй хэмжээнд туссан байна (анги тус бүрийн дэлгэрэнгүй шинжилгээг эх тайланд хавсаргав).

СУРАХ БИЧГИЙН АРГА ЗҮЙД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

Хүснэгт 1. Дасгал, даалгаврыг тодорхой мэдлэгт суралцахаар боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн.


Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Мэдлэгийн төрөл				
		Баримтын мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Метакогнитив мэдлэг эзэмшүүлэх мэдлэгийн тоо
Биологи (I-XI)	810	315/39	289/36	113/14%	70/8%	23/3%

Сурах бичигт 39 хувь нь баримтын, 36 хувь нь ухагдахууны, 14 хувь нь үйлийн, 8 хувь нь ахуйн, 3 хувь нь метакогнитив мэдлэгийг дэмжсэн далгаварууд боловсруулсан байна.

Хүснэгт 2. Даалгаврын чадвар төлөвшүүлэхэд хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Чадварын тоо							
		Ойлгох чадвар тоо				Хэрэглэх чадварын тоо	Задлан шижлэх чадварын тоо	Бүтээх чадварын тоо	Метакогнитив
		Ангилах	Жишиж харьцуула	Жишээгээр тайлбарлах	Дүгнэлт гаргах				
Биологи (I-XI)	810	203/25%	195/24%	130/16%	120/15%	65/8%	34/4%	46/6%	17/3%

График 1. Даалгаврын чадвар төлөвшүүлэхэд хийсэн шинжилгээний дүн.



Даалгаврын 25 хувь нь ангилах, 24 хувь нь жиших, 15хувь нь дүгнэх,16 хувь нь жишээгээр тайлбарлах, 8 хувь нь хэрэглэх, 6 хувь нь бүтээх, 4 хувь нь задлан шинжлэх, 2 хувь нь метакогнитив мэдлэгийг дэмжсэн далгаврууд боловсруулсан байна.

Хүснэгт 3. Даалгаврын хүндрэл, хариултын хувилбарт хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Даалгаврын хүндрэлийн түвшний тоо		Даалгаврын хариултын хувилбарын тоо		
		Хөнгөн	Хүнд	Нээлттэй хариулт	Хаалттай хариулт	Олон сонголттой
Биологи (I-XI)	810	613/76%	197/24%	612/76%	182/22%	16/2%

76 хувь нь хөнгөн, 23 хувь хүнд даалгавар боловсруулсанаас гадна сурах бичгийн даалгаврын хариултын хувилбарын 76 хувь нь нээлттэй, 22 хувь хаалттай, 2 хувь нь олон сонголттой хувилбарууд эзэлж байна.

Хүснэгт 4. Даалгаврын контекст, сурах арга барилд хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Контекстийн хэлбэр /тоо			Сурах арга барил			
		Шинжлэх ухаан	Зохиомол	Бодит амьдралын жишээ	Асуудал	Мэдлэл	Шинжлэн судлах	Эрэл хайгуул
Биологи (I-XI)	810	427/53%	183/22%	200/25%	319/40%	278/34%	140/17%	73/9%

53 хувийг шинжлэх ухааны, 22 хувийг ахуйн, 25 хувийг ахуйн контексттэй, 40 хувийг асуудал шийдвэрлэх, 34 хувийг мэдээлэл боловсруулах, 17 хувийг шинжлэх ухаанч, 9 хувийг эрэл хайгуул хийх арга барилыг дэмжсэн даалгаврууд эзэлж байна.

Хүснэгт 5. Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага, хэл найруулга, дизайнд хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Үнэлгээ: хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1		
		Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага	Хэл найруулга	Техник
Биологи (I-XI)	244	2	3	3

Бага, суурь, бүрэн дунд боловсролын сурах бичигт тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлагын талаарх агуулгыг хангалтгүй тусгасан, хэл найруулга болон техникийн шаардлагыг хангасан гэж үзсэн байна.

ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

I-V ангийн сурах бичиг.

I-III ангийн “Хүн ба Орчин” болон IV-V ангийн “Хүн ба Байгаль” сурах бичгүүд үндэсний соёл, ёс заншил, уламжлалыг мэдэх, хүрээлэн буй орчноо таних, эх орноороо бахархах, хайрлан хамгаалах үндэс дээр тулгуурлан, хөтөлбөрт тусгагдсан агуулгын дагуу, суралцахуйн зорилтыг бүрэн хамруулан, зурагт эх, богино хэмжээтэй хялбар эхээр хүүхдэд ойлгогдохуйц бичигджээ.

Арга зүйн хувьд тухайн насны сурагчдын нас, сэтгэхүй, танин мэдэхүйн хөгжлийн онцлогт нийцсэн, сурах арга барил, мэдлэг, чадвар эзэмших, хандлага төлөвшихөд чиглэсэн, таамаглал дэвшүүлэх, төлөвлөх, ангилах, эрэл хайгуул хийлгэх, туршиж үзэх, үр дүнгээ тайлагнах зэрэг даалгавруудыг багтжээ.

Түүнчлэн бага ангийн сурагчдад тохирсон авч явахад хөнгөн, бүлэг бүрийг өнгөөр ялгасан, бичвэрийн үсэг тод харагдахуйц, уншихад тохиромжтой ба зураг, хүснэгт, графикийн өнгө үзэмж нийцтэй төдийгүй хэл, найруулга зүй болон зөв бичих дүрмийн хувьд харьцангуй алдаа багатай сурах бичгүүд байна.

Цаашид хүүхэд бүрийн авьяас, сонирхлыг нээх, суралцахуйг нь дэмжих зорилгоор шинжлэн судлах, ялангуяа мэдээлэл боловсруулах, бүтээх түвшний даалгаврын тоог нэмэгдүүлэн, эх орны нөхцөлд тохируулан, судлаачдын судалгааны ажлын үр дүнгээс оруулах, мөн ашигласан бүтээлийн эх үүсвэрүүдийг оруулах зэргээр улам боловсронгуй болгоход хангалттай.

VI-IX ангийн Биологийн сурах бичиг.

VI ангийн Байгалийн Ухаан болон VII-IX ангийн сурах бичгүүд нь арга зүйн хувьд тухайн анги бүрийн сурагчдын нас, сэтгэхүй, танин мэдэхүйн хөгжлийн онцлогт нийцсэн баримтын, ухагдахууны, үйлийн, ахуйн мэдлэг олгоход чиглэгдсэн, асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах, шинжлэн судлах, эрэл хайгуул хийх арга барилд суралцуулахаар хангалттай сайн боловсруулагдсан байна. Дасгал, даалгаварын хариултын хувилбарын хувьд дийлэнх хэсэг нь нээлттэй хариулттай дасгал байгаа нь сурагчид өөрсдийн үзэл бодлыг хариултад тусгаж өгөхөд илүү дөхөм болсон. Үүнээс гадна анги бүрийн сурах бичгийн агуулгаас хамааран цаашид бүтээх чадварыг тодорхойлох даалгаврын тоог нэмэгдүүлвэл илүү чанартай болно.

Мөн сурах бичгийн агуулгад боловсролын талаарх дэлхийн чиг хандлага, тогтвортой хөгжлийн агуулга, иргэнд зайлшгүй эзэмшсэн байх чадвар гүйцэд биш тусгагдсан байна.

Түүнчлэн сурах бичиг нь техникийн хувьд дунд ангийн сурагчдад тохирсон авч явахад хөнгөн, бүлэг бүрийг өнгөөр ялгасан, бичвэрийн үсэг тод харагдахуйц, уншихад тохиромжтой ба зураг, хүснэгт, графикийн өнгө үзэмж нийцтэй төдийгүй хэл, найруулга зүй болон зөв бичих дүрмийн хувьд харьцангуй алдаа багатай байна. Мөн сурах бичигт эх сурвалж нь тодорхойгүй зургийг ашигласан байна. Ийм тохиолдолд ашигласан зургийн эх сурвалжыг дурьдах хэрэгтэй.

X-XI ангийн сурах бичиг.

- X ангийн дасгалын хүндрэлийн түвшинг харвал хөнгөн, хүнд түвшний дасгалын харьцаа 80 болон 20 хувийн харьцаатай байна. XI ангийн дасгалын хүндрэлийн түвшинг харвал нийт дасгалын 83.4 хувь нь хөнгөн, 16.6 хувь нь хүнд түвшний дасгал, даалгавар байна

- Хөнгөн дасгал даалгавар их хувийг эзэлж байна. Танин мэдэх, хэрэглэх түвшний даалгаврууд цөөн байгаа тул нэмэгдүүлэх шаардлагатай. Хаалттай хариулт бүхий дасгал даалгаврын тоог багасгаж олон хариулттай болон бусад төрлийн дасгал даалгаврын төрөл, даалгаврын тавилыг нэмэгдүүлэх шаардлагатай.
- Дасгал даалгавруудыг үнэлэх аргачлалаа сайн дурдаагүй байна. Дасгал, даалгавар бүрийн алхмыг үнэлэх оноо байхгүй байна.
- Сурах бичгийн агуулгад жишээгээр тайлбарлах чадварын даалгаврын тоо давамгайлсан бөгөөд анги бүлгийн онцлогоос хамааран бүтээх чадварыг тодорхойлох даалгаврын тоог нэмэгдүүлэх шаардлагатай. Шинжлэх ухааны эрэл хайгуул хийх дасгал, даалгаврууд сурах бичигт ороогүй байна.
- Туршилт ажлуудын зарим нь хичээлийн бодит байдалд хэрэгжихүйц заавар зөвлөгөө дутмаг, XI ангид туршилт ажлын тоо цөөрсөн байна. Иймд, туршилт ажлуудын тоог нэмэгдүүлэх, туршилт ажлын сэдэвтэй холбоотой алхамчилсан нэмэлт өгөгдөл, тооцоолол оруулах замаар туршилтын заавруудыг сайжруулах хэрэгтэй.
- Сурах бичгийн төгсгөлд дасгал даалгавруудын хариултыг оруулах шаардлагатай.

Зөв бичиг, найруулгын дүгнэлт:

- Сурах бичгийн зөв бичгийн дүрмийн алдаа, нэг өгүүлбэр дэх үгийн тоо, зураг график, хүснэгтийн тайлбарын алдаа харьцангуй бага боловч найруулга болон учир зүйн алдаа зэрэгт анхаарах шаардлагатай.
- Зөв бичгийн дүрэм, найруулга, нэр томъёоны алдаа харьцангуй бага байгаа боловч гадаад үгийг эх хэл рүү оновчгүй хэрэглэсэн, буулгасан тохиолдлууд байна.
- Сурах бичгийн бичвэр, дасгал, туршилт ажлуудын хэл найруулга нь оновчтой, хэл найруулгын болон зөв бичих дүрмийн алдаа харьцангуй бага мэт боловч үгийн алдаа, найруулга тогтмол илэрч байгааг дараагийн хэвлэлд анхаарах шаардлагатай
- Зарим туршилт, дадлага ажлын зааврыг гадаад хэлнээс орчуулж оруулахдаа үг найруулгын хувьд дутмаг зүйлүүд байна.
- Техникийн дүгнэлт:
- Сурах бичгийн зургийн чанарыг сайн хангасан байна. Химийн цайруулалт хийгдээгүй, хэвлэлтийн цаас хэрэглэсэн.
- Бичвэр, зураг, дүрслэл, бүдүүвч, хүснэгтүүд тод, үзэгдэц сайн, уншигдах, өнгө будаг сайн, цаас, наалт шаардлагад нийцсэн байна.
- Зураг, хүснэгт, графикийн баталгаат эх сурвалжийг дурдахад анхаарах хэрэгтэй

ЭРҮҮЛ МЭНД

Хүснэгт 1. Сурах бичгийн суралцахуйн зорилтыг (агуулга) боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэв хоорондын залгамж холбоотой боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичиг	Анги хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн ангийн бүлэг сэдвийн залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн бүлгийн сэдэв хоорондын залгамж холбоо, эрэмбэ дараалал
Эрүүл мэнд (IV-XI)	3	3	3

Эрүүл мэндийн сурах бичгийн тухайд анги, бүлэг, сэдэв хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дарааллын шаардлагыг хангасан.

Хүснэгт 2. Сурах бичгийн мэдлэгт суралцахаар боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн


Сурах бичгийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Мэдлэгийн төрөл				
		Баримтын мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Меткогнитив мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо
Эрүүл мэнд (IV-XI)	92	19/21%	28/30%	20/22%	19/21%	6/6%

Сурах бичигт 30 хувь нь ухагдахууны, 21 хувь нь баримтын болон ахуйн, 22 хувь нь үйлийн, 6 хувь нь меткогнитив мэдлэгийг эзэмшүүлэхээр агуулгын шийдэл хийсэн байна.

Хүснэгт 3. Сурах бичгийн хандлага, (ёс суртахууны хүмүүжил төлөвшүүлэх)-ын шинжилгээний дүн

Сурах бичгийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Суралцах ёс суртахууны хүмүүжил төлөвшил)				
		Хамтарч ажиллах сэдвийн тоо	Байгаль орчноо хайрлах хамгаалах сэдвийн тоо	Өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хөгжүүлэх сэдвийн тоо	Өөрийгөө хүмүүжүүлэх сэдвийн тоо	Ёс суртахууны төлөвшил эзэмшүүлэх сэдвийн тоо
Эрүүл мэнд (IV-XI)	88	12/14%	8/10%	23/27%	22/26%	19/23%

График 1. Сурах бичгийн агуулгад хандлагын шинжилгээний дүн



Сурах бичигт 26 хувь нь өөрийгөө хүмүүжүүлэх, 27 хувь нь өөрийгөө таних, 23 хувь нь ёс суртахууны, 14 хувь нь хамтран ажиллах, 10 хувь нь байгаль орчноо хамгаалах агуулгын сонголт хийгдсэн байна.

Хүснэгт 4. Сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлын талаарх шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1	
	Сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, жишээ баримттай бичвэр, дасгал, даалгавар, туршилт ажил, дадлага ажлыг сурах бичигт оруулсан эсэх	Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг сурах бичигт тусгасан эсэх
Эрүүл мэнд (IV-XI)	2	1


Бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд авч үзвэл сурах бичиг бүрт бичвэр, зураг, диаграмм, дасгал, даалгавар болон тэмдэг тэмдэглээгээр сурагчдын сонирхол, хэрэгцээ, танин мэдэхүйн онцлогт тохируулан дэд сэдвийн агуулга бүрт сонгож оруулсан нь сурах бичгийн агуулгыг судлахад суралцагчийг мэдээллийн төрлүүдийг хослуулан хэрэглэх, харьцуулан жиших, хэрэгтэй мэдээллээ олж авах боломжоор хангаж байгаа хэдий ч цаашид сайжруулах хэрэгцээ байна. Харин дээрх сурах бичгүүдэд Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйлсийг мэдлэг эзэмшүүлэх агуулга, дасгал даалгавар хангалтгүй хэмжээнд туссан байна

СУРАХ БИЧГИЙН АРГАЗҮЙД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

Хүснэгт 1. Сурах бичгийн даалгаврын (мэдлэгийн хэлбэр) шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Мэдлэгийн төрөл				
		Баримтын мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Метакогнитив мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо
Эрүүл мэнд (IV-XI)	519	108/23%	277/41%	99/19%	35/16%	6/1%

График 1. Сурах бичгийн даалгаврын (мэдлэгийн хэлбэр) шинжилгээний дүн



Сурах бичигт 41 хувь нь ухагдахууны, 23 хувь нь баримтын, 19 хувь нь үйлийн, 16 хувь нь ахуйн, 1 хувь нь метакогнитив мэдлэгийг дэмжсэн агуулгын шийдэл хийсэн байна.

Хүснэгт 2. Сурах бичгийн даалгаврын (тодорхой чадвар) шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Чадварын тоо							
		Ойлгох чадвар тоо				Хэрэглэх чадварын тоо	Задлан шижлэх чадварын тоо	Бүтээх чадварын тоо	Метакогнитив
		Ангилах	Жишиж харьцуулах	Жишээгээр тайлбарлах	Дүгнэлт гаргах				
Эрүүл мэнд (IV-XI)	519	58/11%	62/12%	56/11%	170/33%	89/17%	71/14%	8/1%	5/1%

Сурах бичигт 33 хувь нь дүгнэх, 17 хувь нь хэрэглэх, 14 хувь нь задлан шинжлэх, 11 хувь нь ангилах болон жишээгээр тайлбарлах, 1 хувь нь метакогнитив чадварыг төлөвшүүлэхээр арга зүйн шийдэл хийсэн байна.

Хүснэгт 3. Даалгаврын хүндрэл, хариултын хувилбарт хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Даалгаврын хүндрэлийн түвшний тоо		Даалгаврын хариултын хувилбарын тоо		
		Хөнгөн	Хүнд	Нээлттэй хариулт	Хаалттай хариулт	Олон сонголттой
Эрүүл мэнд (IV-XI)	519	519/62%	320/38%	472/91%	45/8,6%	2/0.4%

62 хувь нь хөнгөн, 38 хувь хүнд, хариултын хувилбарын 91 хувь нь нээлттэй, 8.6 хувь хаалттай, 0.4 хувь нь олон сонголттой хувилбарууд эзэлж байна.

Хүснэгт 4. Даалгаврын контекст, сурах арга барилд хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Контекстийн хэлбэр /тоо			Сурах арга барил			
		Шинжлэх ухаан	Зохиомол	Бодит амьдралын жишээ	Асуудал	Мэдээлэл	Шинжлэн судлах	Эрэл хайгуул
Эрүүл мэнд (IV-XI)	519	317/61%	72/14%	130/25%	108/21%	277/53%	99/19%	35/7%

Даалгаврын 61 хувийг шинжлэх ухааны, 25 хувийг ахуйн, 14 хувийг зохиомол контекст эзэлж байна. Даалгаврын 53 хувийг мэдээлэл боловсруулах, 21 хувийг асуудал шийдвэрлэх, 19 хувийг шинжлэн судлах, 7 хувийг эрэл хайгуул хийх арга барил эзэмшүүлэхээр шийдэл хийсэн байна.

Хүснэгт 5. Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага, хэл найруулга, дизайнд хийсэн шинжилгээний дүн

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1		
		Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага	Хэл найруулга	Техник, дизайн
Эрүүл мэнд (IV-XI)		1	3	3

Бага, суурь, бүрэн дунд боловсролын сурах бичигт тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлагын талаарх агуулгыг хангалтгүй тусгасан, хэл найруулга болон техникийн шаардлагыг хангасан гэж үзсэн байна.

ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

Бага боловсролын IV болон V ангийн сурагчдад зориулан бичигдсэн сурах бичгүүд агуулгийн хувьд хөтөлбөрт тусгагдсан агуулга, суралцахуйн зорилтуудын дагуу чанартай сайн бичигдсэн байна. Сурах бичгийн нэлээдгүй хэсгийг дасгалууд эзэлж байна. Бүлэг, сэдэв бүрийн төгсгөлд тухайн бүлэг сэдэвт юу сурсан, юу чаддаг болсон, юуг зан үйл болгосон гэсэн нэгдсэн байдлаар үнэлгээ хийж байгаа нь давуу талтай байна.

Арга зүйн хувьд нээлттэй хариулт бүхий дасгал даалгавар зонхилсон байна. Энэ нь хүүхдэд мэдлэг, ойлголт өгөхөөс илүү чадвар, дадал олгох зорилготой байна. Зарим жишээ даалгаврууд нь бодит амьдралд ойр байгаа нь хүүхэд өөрт тулгарч болох асуудлыг шийдвэрлэхэд туслах, урьдчилсан мэдлэг ойлголттой болох боломжтой бичигджээ.

Түүнчлэн бага ангийн сурагчдад тохирсон авч явахад хөнгөн, бүлэг бүрийг өнгөөр ялгасан, бичвэрийн үсэг тод харагдахуйц, уншихад тохиромжтой ба зураг, хүснэгт, графикийн өнгө үзэмж нийцтэй төдийгүй хэл, найруулга зүй болон зөв бичих дүрмийн хувьд харьцангуй алдаа багатай сурах бичгүүд байна.

Бүх бүлэг сэдвүүдэд нэг өгүүлбэр нь 10-аас дээш үгтэй өгүүлбэрүүд тодорхой хэмжээгээр тохиолдож байгаа учраас бага боловсролын стандартын дагуу сурах бичгийн онол, агуулгыг алдагдуулахгүйгээр тухайн насны хүүхдүүдэд хялбар уншигдахуйц болгон өөрчлөх шаардлага байна.

Бичвэрийн бичлэг, зураг дүрслэл, бүдүүвч, хүснэгтийн зохиомж, өнгө будаг, дизайн, тэдгээрийн мэдээлэх чадвар сайн хийгдсэн. Бүлэг сэдэв бүрийг өнгөөр ялгаж өгсөн, номтой ажиллахад хялбар, тэмдэг тэмдэглэгээг сайн хийж өгсөн сурах бичгүүд байна.

VI-IX ангийн сурах бичиг

VI-IX ангийн сурах бичгүүд нь агуулгын хувьд сургалтын хөтөлбөрт тусгагдсан суралцахуйн зорилттойгоо нийцсэн байна. Бүлэг сэдвүүд болон дэд сэдвүүд өөр хоорондоо залгамж холбоо сайтай. Сурах бичигт баримтын, ухагдахууны, ахуйн болон үйлийн мэдлэгийг эзэмшүүлэхээр хялбаршуулсан байдлаар боловсруулагдсан байна. Сурагчдын өөрийгөө хөгжүүлэх, хүмүүжүүлэх хүрээнд хангалттай бичигдсэн. Үүнээс гадна бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх, задлан шинжлэх чадвар болон мэдээлэл боловсруулах, шинжлэн судлах арга барилын талаарх дасгал даалгавар бага байна. Мөн Монгол улсын түүх, нийгэм, эдийн засаг, хүн ба эдийн засгийн, оюуны, улс төрийн үнэт зүйлийн асуудал тусгагдаагүй.

Арга зүйн хувьд сурах бичгүүд нь анги бүлэг бүрийн сурагчдын нас, сэтгэхүй, танин мэдэхүйн хөгжлийн онцлогт нийцсэн баримтын, ухагдахууны, үйлийн мэдлэг эзэмшүүлэх дасгал даалгаврууд хангалттай сайн тусгагдсан ба сурах бичгийн ихэнх дасгал, даалгавар дүгнэлт гаргах, хэрэглэх чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн дасгалын тоо илүү тусгагдсан байна. Энэ нь сурагчдыг хичээлийн хүрээнд судалсан хэрхэн эрүүл байх, эрүүл амьдрах арга ухааныг өөрсдийн болон ойр дотны хүмүүсийн өдөр тутмын амьдралд хэвшил болгоход дөхөм болохуйц байна. Дасгал, даалгаврын хариултын хувилбарын хувьд дийлэнх хэсэг нь нээлттэй хариулттай дасгал байгаа нь сурагчид өөрсдийн үзэл бодлыг хариултад тусгаж өгөхөд илүү дөхөм болсон.

Түүнчлэн дунд ангийн сурагчдад тохирсон бүлэг бүрийг өнгөөр ялгасан, бичвэрийн үсэг тод харагдахуйц, уншихад тохиромжтой ба зураг, хүснэгт, графикийн өнгө үзэмж нийцтэй төдийгүй хэл, найруулга зүй болон зөв бичих дүрмийн хувьд харьцангуй алдаа багатай сурах бичгүүд байна.

Цаашид хүүхэд бүрийн авьяас, сонирхлыг нээх, суралцахуйг нь дэмжих зорилгоор шинжлэн судлах, ялангуяа мэдээлэл боловсруулах, бүтээх түвшний даалгаврын тоог нэмэгдүүлэн, эх орны нөхцөлд тохируулан, судлаачдын судалгааны ажлын үр дүнгээс оруулах, мөн ашигласан бүтээлийн эх үүсвэрүүдийг оруулах зэргээр улам боловсронгуй болгоход хангалттай.

Х-ХI ангийн сурах бичиг

Сурах бичгүүд нь агуулгын хувьд сургалтын хөтөлбөрт тусгагдсан суралцахуйн зорилттойгоо уялдаатай, сэдвүүд болон дэд сэдвүүд өөр хоорондоо залгамж холбоо харьцангуй сайтай бичигджээ. Сурах бичигт баримтын, ухагдахууны, ахуйн болон үйлийн мэдлэгийг эзэмшүүлэхээр сурагчдын өөрийгөө хөгжүүлэх, хүмүүжүүлэх хүрээнд хангалттай бичигдсэн. Харин шинжлэн судлах, бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх, задлан шинжлэх чадвар болон мэдээлэл боловсруулах арга барилын талаарх дасгал, даалгавар бага байна. Мөн үндэсний хэв шинжийг агуулсан тухайлбал, Монгол улсын түүх, нийгэм, эдийн засаг, хүн ба эдийн засгийн, оюуны, улс төрийн үнэт зүйлийн асуудал тусгагдаагүй. Гэхдээ энэ нь сурах бичгийн мэргэжлийн онцлогтой холбоотой байх талтай.

Арга зүйн хувьд сурах бичгүүд нь анги бүлэг бүрийн сурагчдын нас, сэтгэхүй, танин мэдэхүйн хөгжлийн онцлогт нийцсэн баримтын, ухагдахууны, үйлийн мэдлэг эзэмшүүлэх дасгал даалгаврууд хангалттай сайн тусгагдсан ба сурах бичгийн ихэнх дасгал, даалгавар дүгнэлт гаргах, хэрэглэх чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн байна. Энэ нь сурагчдыг хичээлийн хүрээнд судалсан хэрхэн эрүүл байх, эрүүл амьдрах арга ухааныг өдөр тутмын амьдралд хэвшил болгоход дөхөм болохуйц байна. Дасгал, даалгаврын хариултын хувилбарын хувьд дийлэнх хэсэг нь нээлттэй хариулттай дасгал байгаа нь сурагчид өөрсдийн үзэл бодлыг хариултад тусгаж өгөхөд илүү дөхөм болсон.

Сурах бичгийн техник тухайлбал, бүлэг бүрийг өнгөөр ялгасан, бичвэрийн үсэг тод харагдахуйц, уншихад тохиромжтой ба зураг, хүснэгт, графикийн өнгө үзэмж нийцтэй төдийгүй хэл, найруулга зүй болон зөв бичих дүрмийн хувьд харьцангуй алдаа багатай сурах бичгүүд байна.

Цаашид хүүхэд бүрийн авьяас, сонирхлыг нээх, суралцахуйг нь дэмжих зорилгоор шинжлэн судлах, ялангуяа мэдээлэл боловсруулах, бүтээх түвшний даалгаврын тоог нэмэгдүүлэн, эх орны нөхцөлд тохируулан, судлаачдын судалгааны ажлын үр дүнгээс оруулах, мөн ашигласан бүтээлийн эх үүсвэрүүдийг оруулах зэргээр улам боловсронгуй болгоход хангалттай.

ХИМИ

СУРАХ БИЧГИЙН АГУУЛГАД ТАВИХ ШААРДЛАГАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН.

Хүснэгт 1. Суралцахуйн зорилтыг (агуулга) боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэв хоорондын залгамж холбоотой боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичиг	Анги хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн ангийн бүлэг сэдвийн залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн бүлгийн сэдэв хоорондын залгамж холбоо, эрэмбэ дараалал
Хими (IV-XI)	3	2	2

Анги, бүлэг, сэдэв хоорондын болон анги хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал хангалттай, бүлэг, сэдэв хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалалыг сайжруулах хэрэгтэй гэж дүгнэж байна (анги тус бүрийн дэлгэрэнгүй дүнг эх тайланд хавсаргав).

Сурах бичиг тус бүрд боловсролын түвшингээр хийсэн дүн шинжилгээ

Бага боловсрол

Хүн байгаль IV-V ангийн сурах бичгүүдийн анги, бүлэг, сэдэв хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал алдагдаагүй хангалттай түвшинд бичигдсэн байна.

Суурь ба бүрэн дунд боловсрол

Сурах бичгүүдийн анги, бүлэг, сэдэв хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал алдагдаагүй байна.

Хүснэгт 2. Мэдлэгийн хэлбэрт хийсэн шинжилгээний дүн

Сурах бичгийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Мэдлэгийн төрөл				
		Баримтын мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Метакогнитив мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо
Хими (IV-XI)	304	42/14%	147/48%	67/22%	37/12%	11/4%

Бага боловсрол

Сурах бичгийн сэдвийн 48 хувь нь ухагдахууны, 22 хувь нь үйлийн, 12 хувь нь ахуйн, 14 хувь нь баримтын, 4 хувь нь метакогнитив мэдлэгийг дэмжсэн агуулгын шийдэл хийсэн байна (анги тус бүрийн дэлгэрэнгүй дүнг эх тайланд хавсаргав).

Сурах бичгийн агуулгад баримтын, ухагдахууны, үйлийн, ахуйн, метакогнитив мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулга давхцсан тоогоор хангалттай тусгагдсан байна.


Суурь ба бүрэн дунд боловсрол

Сурах бичгийн агуулгад баримтын, ухагдахууны, үйлийн мэдлэгийг түлхүү эзэмшүүлэхээр, метакогнитив мэдлэг эзэмшүүлэх агуулга тусгагдаагүй байна.

Хүснэгт 3. Хандлага (ёс суртахууны хүмүүжил төлөвшүүлэх)-ын шинжилгээний дүн

Сурах бичгийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Суралцах ёс суртахууны хүмүүжил төлөвшил				
		Хамтарч ажиллах сэдвийн тоо	Байгаль орчноо хайрлах хамгаалах сэдвийн тоо	Өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хөгжүүлэх сэдвийн тоо	Өөрийгөө хүмүүжүүлэх сэдвийн тоо	Ёс суртахууны төлөвшил эзэмшүүлэх сэдвийн тоо
Хими (IV-XI)	304	42/14%	147/48%	67/22%	37/12%	11/4%

График 1. Хандлага (ёс суртахууны хүмүүжил төлөвшүүлэх)-ын шинжилгээний дүн



Сурах бичгийн сэдвийн 48 хувь нь байгаль орчноо хамгаалах, 22 хувь нь өөрийгөө танин мэдэх, 14 хувь нь хамтран ажиллах, 12 хувь нь хүмүүжүүлэх, 4 хувь нь ёс суртахууны мэдлэгийг дэмжсэн агуулгын шийдэл хийсэн байна(анги тус бүрийн дэлгэрэнгүй дүнг эх тайланд хавсаргав).

Хүснэгт 4. Сэдэлжүүлэлт, Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын талаарх шинжилгээний дүн

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1	
	Сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, жишээ баримттай бичвэр, дасгал, даалгавар, туршилт ажил, дадлага ажлыг сурах бичигт оруулсан эсэх	Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг сурах бичигт тусгасан эсэх
Хими (IV-XI)	2	1

Бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд авч үзвэл-сурах бичиг бүрт бичвэр, зураг, диаграмм, дасгал, даалгавар болон тэмдэг тэмдэглээгээр сурагчдын сонирхол, хэрэгцээ, танин мэдэхүйн онцлогт тохируулан дэд сэдвийн агуулга бүрт сонгож оруулсан нь агуулгыг судлахад суралцагчийг сэдэлжүүлэхээс гадна мэдээллийн төрлүүдийг хослуулан


хэрэглэх, харьцуулан жиших, хэрэгтэй мэдээллээ олж авах боломжоор хангаж байгаа хэдий ч цаашид сайжруулах хэрэгцээ байна. Харин Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйлсийг мэдлэг эзэмшүүлэх агуулга, дасгал даалгавар хангалтгүй хэмжээнд туссан

СУРАХ БИЧГИЙН АРГА ЗҮЙД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

Хүснэгт 1. Дасгал, даалгаврыг тодорхой мэдлэгт суралцахаар боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Мэдлэгийн төрөл				
		Баримтын мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Метакогнитив мэдлэг эзэмшүүлэх мэдлэгийн тоо
Хими (IV-XI)	1162	174/15%	493/42%	182/16%	83/7%	230/20%

График 1. Дасгал, даалгаврыг тодорхой мэдлэгт суралцахаар боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн.




42 хувь нь ухагдахууны, 20 хувь нь метакогнитив, 15 хувь нь баримтын, 16 хувь нь үйлийн, 7 хувь нь ахуйн мэдлэгийг дэмжсэн агуулгын шийдэл хийсэн байна(анги тус бүрийн дэлгэрэнгүй дүнг эх тайланд хавсаргав).

Хүснэгт 2. Дасгал, даалгаврыг тодорхой чадварт суралцахаар боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Чадварын тоо							
		Ойлгох чадвар тоо				Хэрэглэх чадварын тоо	Задлан шижлэх чадварын тоо	Бүтээх чадварын тоо	Метакогнитив
		Ангилал	Жишиж харьцуулах	Жишээгэр тайлбарлах	Дүгнэлт гаргах				
Хими (IV-XI)	1162	30/3%	300/26%	211/18%	94/8%	252/22%	75/6%	38/3%	162/14%

График 2. Дасгал, даалгаврыг тодорхой чадварт суралцахаар боловсруулсан байдал хийсэн шинжилгээний дүн.



Даалгаврын 26 хувь нь жиших, 22 хувь нь хэрэглэх, 18 хувь нь жишээгээр тайлбарлах, 14 хувь нь метакогнитив, 6 хувь нь задлан шинжлэх, 3 хувь нь ангилах, хэрэглэх чадварыг дэмжсэн аргазүйн шийдэл хийсэн байна (анги тус бүрийн дэлгэрэнгүй дүнг эх тайланд хавсаргав).

Хүснэгт 3. Даалгаварын хүндрэл, хариултын хувилбарт хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Даалгаврын хүндрэлийн түвшний тоо		Даалгаврын хариултын хувилбарын тоо		
		Хөнгөн	Хүнд	Нээлттэй хариулт	Хаалттай хариулт	Олон сонголттой
Хими (IV-XI)	1162	892/77%	270/23%	521/45%	438/38%	203/17%

Сурах бичгийн даалгаврын 77 хувь нь хөнгөн, 23 хувь хүнд байна. Даалгаврын хариултын хувилбарын 45 хувь нь нээлттэй, 38 хувь хаалттай, 17 хувь нь олон сонголттой байна.

Хүснэгт 4. Даалгаврын контекст, сурах арга барилд хийсэн шинжилгээний үр дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Контекстийн хэлбэр /тоо			Сурах арга барил			
		Шинжлэх ухаан	Зохиомол	Бодит амьдралын жишээ	Асуудал	Мэдээлэл	Шинжлэн судлах	Эрэл хайгуул
Хими (IV-XI)	1162	101/8.6%	1054/91%	7/0.4%	76/6%	622/50%	91/8%	449/36%

Даалгаврын 91 хувийг зохиомол, 8.6 хувийг шинжлэх ухааны, 0.4 хувийг ахуйн контексттэй даалгаврууд эзэлж байна. Даалгаврын 50 хувь нь мэдээлэл боловсруулах, 36 хувь нь эрэл хайгуул хийх, 6 хувь нь шинжлэн судлах, 6 хувь нь асуудал шийдвэрлэх арга барилыг дэмжсэн байна.

Хүснэгт 5. Тогтвортой хөгжил, сэдэлжүүлэлт, дизайнд хийсэн шинжилгээний дүн

Сурах бичгийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1		
		Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага	Хэл найруулга	Техник , дизайн
Хими	304	1	3	3

Бага, суурь, бүрэн дунд боловсролын сурах бичигт тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлагын талаарх агуулгыг хангалтгүй тусгасан, хэл найруулга болон техникийн шаардлагыг хангасан байна.

ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

Нэг. Сурах бичгийн агуулгад баримтын, ухагдахууны, үйлийн мэдлэгийг түлхүү эзэмшүүлэхээр метакогнитив мэдлэг эзэмшүүлэх агуулга үндсэн утгаараа бүрэн тусгагдаагүй байна.

Агуулга

Давуу тал

- Агуулга нь байгалийн ухааны суурь мэдлэг, өдөр тутмын амьдралд тохиолдох үзэгдлийн шалтгаан зүй тогтлыг сурагчдаар өөрсдөөр нь нээн илрүүлэх ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн
- Юмс үзэгдлийн талаар таамаглал дэвшүүлэх, турших, нотлох, нэгтгэн дүгнэх, эргэцүүлэл хийх шинжлэн судлах арга барилд суралцахаар тогтоогдсон.

Сайжруулах санал зөвлөмж

- Хатуу, шингэн хийн төлөвт оршин буй бодисын байгаль, амьдрал ахуйд тохиолдох тодорхой жишээ баримт оруулах
- Бодисын хатуу, шингэн, хийн төлөвт орших, харилцан шилжих талаарх сурагчдын мэдлэгийн хүрээг тэлэх агуулгыг сонгож оруулах
- Сурагчид олж авсан мэдлэгээ ижил болон шинэ нөхцөлд хэрэглэх агуулга, дасгал даалгаврыг ялгавартай байдлаар сонгон оруулах. Тухайлбал: Жүржийн ундаанд ямар бодис ууссан, ямар бодис уусаагүй вэ? гэх мэт
- Хатуу, шингэн хийн төлөвт оршин буй бодисын байгаль, амьдрал ахуйд тохиолдох жишээ тайлбар оруулах
- Бодисын хатуу, шингэн, хийн төлөвт орших талаарх сурагчдын мэдлэгийн хүрээг тэлэх агуулгыг товч тодорхой тусган оруулах

Аргазүй

Давуу тал

- Шинжлэн судлах, шинжлэх ухаанч арга барил эзэмшүүлэх туршилтууд дээр тулгуурлан тухайн төлөвт орших бодисын хэлбэр, шахагдах, урсах, юунаас тогтох, усанд уусах шинжийг судлах арга зүйг энгийн хялбар туршилтаар танин мэдэхүйн ач холбогдлыг тооцон боловсруулсан.
- Мэдээллийн эх сурвалжаас тухайлбал, зураг дүрслэл, бичвэрээс мэдлэг бүтээх арга хэрэглэсэн
- Харьцуулах, жиших, нэгтгэн дүгнэх зэрэг сэтгэхүйн үйл үйлдлийг хийх арга барилд сурагчид сурах үйл ажиллагааг хандуулахад чиглэгдсэн.

Сайжруулах санал зөвлөмж

- Янз бүрийн төлөвт оршин буй бодисын байгаль, амьдрал ахуйд тохиолдох жишээг сурагчдаар гаргуулах асуулт дасгал оруулж сурагчдын бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх арга хэрэглэх
- Бодисын хатуу, шингэн, хийн төлөвт орших талаарх сурагчдын мэдлэгийн хүрээг тэлэх сонирхлыг өрнүүлэх, сэдэлжүүлэх үйл ажиллагааг тусган оруулах

Тухайлбал: бодис хатуу төлөвөөс нэгэн зэрэг хийн, шингэн төлөвт шилжиж болох уу? Яагаад?

- Дасгал, даалгаврыг дугаарлах, зөв хариуг оруулах.
- Сурагчдын мэдлэгийн хүрээг тэлэх сонирхлыг өрнүүлэх, сэдэлжих үйл ажиллагааг хөгжүүлэх асуулт дасгал оруулах. Тухайлбал: Бүх бодисууд хатуу, шингэн, хийн төлөвт орших уу? Төмөр ямар нөхцөлд шингэн төлөвт орших вэ? гэх мэт
- Сурагчдын өөрсдийн мэдлэг, төсөөлөл дээрээ тулгуурлан бодисын төлөв байдлын шилжилтийг янз бүрийн хувилбараар тайлбарлах, бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх арга хэрэглэх боломжтой
- Сурагчид бодисын төлөв байдлын олж авсан мэдлэгээ ижил болон шинэ нөхцөлд хэрэглэх дасгал даалгавар оруулах.

Хэл найруулга, зөв бичгийн дүрэм.

Давуу тал

Хэл найруулга тухайн ангийн сурагчдын нас, сэтгэхүйд нийцсэн сурах бичигт тавигдах стандарт шаардлагыг хангасан байна

Сайжруулах санал зөвлөмж

- Байгалийн ухааны хэл, хэллэг түүнийг тухайн насны сурагчдын онцлогт нийцүүлэн энгийншүүлэх, хялбаршуулах, түүнийгээ сурагчид цаашид шинжлэх ухааны хэл, хэллэгээр ярих тайлбарлах асуудлыг судлан үзэж сайжруулах
- Сурах бичгийн агуулга, арга зүйн боловсруулалтыг хийхдээ шинжлэх ухааны хэл түүнийг тухайн насны сурагчдын онцлогт нийцүүлэн энгийншүүлэх, хялбаршуулах, түүнийгээ сурагчид цаашид хөгжүүлэн шинжлэх ухааны хэл, хэллэгээр ярих тайлбарлаж сурах асуудлыг нэгдмэл байдлаар авч үзэж сурах бичгийнхээ хэл найруулагыг сайжруулах
- Нэр томьёо, түүнийг зөв зохистой сонгож хэрэглэх асуудлыг тухайн сурах бичгийн зохиогчдын баг, бусад ангийн сурах бичгийн багуудтай хамтран шийдвэрлэх

Техник

Давуу тал

Бичвэрийн бичлэг, өнгө будаг, зохиомж, дизайн, тэдгээрийн мэдээлэх чадвар, сурагчдын бие даан ажиллах боломжид нийцсэн байна

Сайжруулах санал зөвлөмж

- Зураг дүрслэл тус бүрийн сурагчдад өгөх мэдээллийг сурагч хэрхэн тусган авах, тайлбарлах талаас нь анхаарч аргагүйн боловсруулалтаа хийх
- Зохиогчид хүснэгт, зураг, дүрслэлийн мэдээлийн өгөгдлүүд дээр ажиллаж хоорондын уялдаа холбоо, ялгааг сайн гаргах түүнийгээ дасгал, даалгавар бүтээлч ажилтай холбох

ФИЗИК

СУРАХ БИЧГИЙН АГУУЛГАД ТАВИХ ШААРДЛАГАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН.

Хүснэгт 1. Суралцахуйн зорилтыг (агуулга) боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэв хоорондын залгамж холбоотой боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичиг	Анги хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн ангийн бүлэг сэдвийн залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн бүлгийн сэдэв хоорондын залгамж холбоо, эрэмбэ дараалал
Физик (IV-XI)	3	3	3

Тухайд анги, бүлэг, сэдэв хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дарааллын шаардлагыг хангасан байна.

Бага боловсрол

IV-V ангийн сурах бичгүүдийн анги, бүлэг, сэдэв хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал алдагдаагүй, шаардлага хангасан түвшинд бичигдсэн байна.

Суурь ба бүрэн дунд боловсрол

Сурах бичгүүдийн анги, бүлэг, сэдэв хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал алдагдаагүй шаардлага хангасан түвшинд бичигдсэн гэж үзсэн байна.

Хүснэгт 2. Агуулгын (мэдлэгийн хэлбэр) боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн

	Сурах бичгийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Мэдлэгийн төрөл				
			Баримтын мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Метокөгнитив мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо
1	Физик	116	16/14%	27/23%	45/39%	18/16%	9/8%

Хүснэгт 3. Хандлага (ёс суртахууны хүмүүжил төлөвшүүлэх)-ын байдалд хийсэн шинжилгээний дүн

Сурах бичгийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Суралцах ёс суртахууны хүмүүжил төлөвшил)				
		Хамтарч ажиллах сэдвийн тоо	Байгаль орчноо хайрлах хамгаалах сэдвийн тоо	Өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хөгжүүлэх сэдвийн тоо	Өөрийгөө хүмүүжүүлэх сэдвийн тоо	Ёс суртахууны төлөвшил эзэмшүүлэх сэдвийн тоо
Физик	116	40/35%	21/18%	50/43%	5/4%	0

43 хувь нь өөрийгөө танин мэдэх, 35 хувь нь хамтарч ажиллах, 18 хувь нь байгаль орчноо хайрлах хамгаалах, 4 хувь нь өөрийгөө хүмүүжүүлэх хандлагыг төлөвшүүлэхээр шийдлийг хийсэн байна.

Хүснэгт 4. Сэдэлжүүлэлт, Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын талаарх шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1	
		Сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, жишээ баримттай бичвэр, дасгал, даалгавар, туршилт ажил, дадлага ажлыг сурах бичигт оруулсан эсэх	Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг сурах бичигт тусгасан эсэх
Физик	116	2	2


Бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд сурах бичиг бүрт бичвэр, зураг, диаграмм, дасгал, даалгавар болон тэмдэг тэмдэглээгээр сурагчдын сонирхол, хэрэгцээ, танин мэдэхүйн онцлогт тохируулан дэд сэдвийн агуулга бүрт сонгож оруулсан нь суралцагчийг сэдэлжүүлэхээс гадна мэдээллийн төрлүүдийг хослуулан хэрэглэх, харьцуулан жиших, хэрэгтэй мэдээллээ олж авах боломжоор хангаж байгаа хэдий ч цаашид сайжруулах хэрэгцээ байна. Харин дээрх сурах бичгүүдэд Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйлсийг мэдлэг эзэмшүүлэх агуулга, дасгал даалгавар хангалтгүй хэмжээнд тусгасан байна.

СУРАХ БИЧГИЙН АРГА ЗҮЙД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Хүснэгт 1. Дасгал, даалгаврыг тодорхой мэдлэгт суралцахаар боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн.

	Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Мэдлэгийн төрөл				
			Баримтын мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Метакогнитив мэдлэг эзэмшүүлэх мэдлэгийн тоо
1	Физик (IV-XI)	1169	171/14%	254/22%	435/37%	219/19%	90/8%

График 1. Дасгал, даалгаврыг тодорхой мэдлэгт суралцахаар боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн.



Даалгаврын 37 хувь нь үйлийн, 22 хувь нь ухагдахууны, 19 хувь нь ахуйн, 14 хувь нь баримтын, 8 хувь метакогнитив мэдлэгийг дэмжсэн агуулгын шийдэл хийсэн байна.

Хүснэгт 2. Дасгал, даалгаврыг тодорхой чадварт суралцахаар боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн.

	Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Чадварын тоо							
			Ойлгох чадвар тоо				Хэрэглэх чадварын тоо	Задлан шинжлэх чадварын тоо	Бүтээх чадварын тоо	Метакогнитив
			Ангилгах	Жишиж харьцуулах	Жишээгэр тайлбарлах	Дүгнэлт гаргах				
1	Физик (IV-XI)	1169	71/6%	118/10%	139/12%	188/16%	382/33%	154/13%	35/3%	82/7%

Даалгаврын 33 хувь нь хэрэглэх, 16 хувь нь дүгнэх, 13 хувь нь задлан шинжлэх, 10 хувь нь жиших, 7 хувь нь метакогнитив, 6 хувь нь ангилгах, 3 хувь нь бүтээх чадварыг дэмжсэн арга зүйн шийдэл хийсэн байна.

Хүснэгт 3. Даалгаврын хүндрэл, хариултын хувилбарт хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Даалгаврын хүндрэлийн түвшний тоо		Даалгаврын хариултын хувилбарын тоо		
		Хөнгөн	Хүнд	Нээлттэй хариулт	Хаалттай хариулт	Олон сонголттой
Физик	1169	947/81%	222/19%	1135/97%	10/3%	24/0

81 хувь нь хөнгөн, 22 хувь хүнд даалгавар боловсруулсан байна. Сурах бичгийн даалгаврын хариултын хувилбарын 97 хувь нь нээлттэй, 1-2 хувь нь хаалттай, олон сонголттой хувилбарууд эзэлж байна.

Хүснэгт 4. Даалгаврын контекст, сурах арга барилд хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Контекстийн хэлбэр /тоо			Сурах арга барил			
		Шинжлэх ухаан	Зохиомол	Бодит амьдралын жишээ	Асуудал	Мэдээлэл	Шинжлэн судлах	Эрэл хайгуул
Физик	1169	79/93%	0	1090/7%	602/51%	263/23%	207/18%	97/8%

93 хувийг ахуйн, 51 хувийг асуудал шийдвэрлэх, 23 хувийг мэдээлэл боловсруулах, 18 хувийг шинжлэх ухаанч, 8 хувийг эрэл хайгуул хийх арга барилыг дэмжсэн даалгаврууд эзэлж байна.

Хүснэгт 5. Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага, Хэл найруулга, дизайны талаарх шинжилгээний дүн

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1		
	Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага	Хэл найруулга	Техник, дизайн.
Физик	1	3	3

Бага, суурь, бүрэн дунд боловсролын сурах бичигт тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлагын талаарх агуулгыг хангалтгүй тусгасан, хэл найруулга болон техникийн шаардлагыг хангасан гэж үзсэн байна.

ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

Агуулга

- Ерөнхий боловсролын сургуулийн XI ангийн сурах бичиг нь бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн X, XI ангийн хүрээнд тодорхойлсон суралцахуйн зорилтыг сурах бичигт сайн тусгаж өгсөн байна.
- Физикийн хичээлийн X, XI ангийн сурах бичгийн агуулгад суралцагчдыг хамтарч ажиллах, байгаль орчноо хайрлах, өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хөгжүүлэхэд чиглэсэн сэдэв, агуулга их байгаа нь сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилттой нийцэж байна.
- Сурах бичигт боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэв хоорондын залгамж холбоог сайн хангасан байна.
- Сурах бичиг бүрт бичвэр, зураг, диаграмм, дасгал, даалгавар, болон тэмдэг тэмдэглэгээгээр сурагчдын сонирхол, хэрэгцээ, танин мэдэхүйн онцлогт тохируулан дэд сэдвийн агуулга бүрт сонгож оруулсан нь суралцагчдыг сэдэлжүүлэхээс гадна мэдээллийн төрлүүдийг хослуулан хэрэглэх, харьцуулан жиших, хэрэгтэй мэдээллээ олж авах боломжоор хангаж байна.
- Харин ахлах ангийн сурах бичигт Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагыг таниулах агуулга хомс байсан. Мөн ахлах ангийн зарим бүлэг сэдвийн хүрээнд суралцагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулга бүхий жишээ баримттай бичвэр, дасгал даалгавар дутмаг байна.

Арга зүй

- X, XI ангийн сурах бичгүүд нь арга зүйн хувьд тухайн анги бүрийн сурагчдын нас, сэтгэхүй, танин мэдэхүйн хөгжлийн онцлогт нийцсэн баримтын, ухагдахууны, үйлийн, ахуйн мэдлэг олгоход чиглэгдсэн, асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах, шинжлэн судлах, эрэл хайгуул хийх арга барилд суралцуулахаар хангалттай сайн боловсруулагдсан байна.
- Даалгаврын хүндрэлийн түвшинг харахад хөнгөн төрлийн даалгавар дийлэнх хувийг эзлэж байгаа нь тухайн суралцагчдын танин мэдэхүй болон сэтгэхүйн онцлогт тохируулсан байна.
- Дасгал, даалгаврын хариултын хувилбараас харахад нээлттэй хариулт бүхий дасгал, даалгавар нь нийт даалгаврын ихэнх хувийг эзлэж байгаа нь ахлах ангийн сурах бичиг нь суралцагчдыг нээлттэй байлгах, хөгжүүлэх, сэтгэн бодох шийдлүүдтэй байна.
- Ахлах ангийн сурах бичигт бүлэг сэдвийн агуулганд тохирсон туршилт дадлага ажлын тоо бага байна.
- Мөн суралцагч бие даан хийх дасгал даалгаварын тоо хангалтгүй байна.
- Сурах бичгийн төгсгөл хэсэгт дасгал, даалгавруудын хариултыг оруулах хэрэгтэй байна.
- Дэлхийн чиг хандлага, тогтвортой хөгжлийн агуулга, суралцагчдын шүүмжлэлт сэтгэлгээний чадвар, нийгэмд эв зүйтэйгээр амьдрах чадвар сэтгэлгээг хөгжүүлэх даалгавруудын эзлэх хувийг нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

Хэл найруулга

Ахлах ангийн сурах бичгийн найруулга нь оновчтой, товч тодорхой, энгийн ойлгомжтой байна.

- Сурах бичгийн зөв бичгийн дүрэм, найруулга, нэр томъёоны алдаа дутагдал байхгүй.
- Сурах бичигт оруулсан зураг, хүснэгт тайлбартай, тайлбар нь найруулгын алдаагүй.

Дизайн, техник

X, XI ангийн сурах бичгийн бичвэр, зураг, хүснэгтэн мэдээлэл нь тод, үсгийн хэмжээ хэвийн, мөр хоорондын зай хэвийн, уншихад ямар нэгэн бэрхшээл байхгүй.

- Сурах бичгийн наалт чанартай, ахлах ангийн суралцагчдын хэрэглээг бүрэн хангахаар байна.

ГАЗАРЗҮЙ

Хүснэгт 1. Суралцахуйн зорилтыг (агуулга) боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэв хоорондын залгамж холбоотой боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичиг	Анги хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн ангийн бүлэг сэдвийн залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн бүлгийн сэдэв хоорондын залгамж холбоо, эрэмбэ дараалал
Газар зүй (VII-XI)	3	3	3

Анги, бүлэг, сэдэв хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал бүхий шаардлагыг хангалттай биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Агуулгын (мэдлэгийн хэлбэрт) боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн


Сурах бичгийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Мэдлэгийн төрөл				
		Баримтын мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Метокөгнитив мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо
Газар зүй (VII-XI)	128	58/45%	15/12%	8/6%	24/19%	23/18%

Агуулгын 45 хувь нь баримт, 19 хувь нь ахуйн, 18 хувь нь метокөгнитив, 2 хувь нь ухагдахууны, 6 хувь нь үйлийн мэдлэгийг дэмжсэн агуулгын шийдэл хийсэн байна.

Хүснэгт 3. Хандлага (ёс суртахууны хүмүүжил төлөвшүүлэх)-ын шинжилгээний дүн

Сурах бичгийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Суралцах ёс суртахууны хүмүүжил төлөвшил				
		Хамтарч ажиллах сэдвийн тоо	Байгаль орчноо хайрлах хамгаалах сэдвийн тоо	Өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хөгжүүлэх сэдвийн тоо	Өөрийгөө хүмүүжүүлэх сэдвийн тоо	Ёс суртахууны төлөвшил эзэмшүүлэх сэдвийн тоо
Газар зүй (VII-XI)	128	78/61%	50/39%	0	0	0

График 1. Хандлага (ёс суртахууны хүмүүжил төлөвшүүлэх)-ын байдалд хийсэн шинжилгээний дүн



Дээрх графикаас үзэхэд 61 хувь нь хамтран ажиллах, 39 хувь нь байгаль орчноо хамгаалах талаар хандлага төлөвшүүлэх агуулгын сонголт хийгдсэн байна.

Хүснэгт 4. Сэдэлжүүлэлт, Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын талаарх шинжилгээний дүн

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1	
		Сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, жишээ баримттай бичвэр, дасгал, даалгавар, туршилт ажил, дадлага ажлыг сурах бичигт оруулсан эсэх	Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг сурах бичигт тусгасан эсэх
Газар зүй (VII-XI)	244	2	2


Бага, суурь, бүрэн дунд боловсролын сурах бичиг бүрт бичвэр, зураг, диаграмм, дасгал, даалгавар болон тэмдэг тэмдэглэгээгээр сурагчдын сонирхол, хэрэгцээ, танин мэдэхүйн онцлогт тохируулан дэд сэдвийн агуулга бүрт сонгож оруулсан нь суралцагчийг сэдэлжүүлэхээс гадна мэдээллийн төрлүүдийг хослуулан хэрэглэх, харьцуулан жиших, хэрэгтэй мэдээллээ олж авах боломжоор хангаж байгаа хэдий ч цаашид сайжруулах хэрэгцээ байна. Харин Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйлсийг мэдлэг эзэмшүүлэх агуулга, дасгал даалгавар хангалтгүй хэмжээнд туссан байна

СУРАХ БИЧГИЙН АРГА ЗҮЙД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Хүснэгт 1. Даалгаврын (мэдлэгийн хэлбэр) шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Мэдлэгийн төрөл				
		Баримтын мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Метакогнитив мэдлэг эзэмшүүлэх мэдлэгийн тоо
Газар зүй (VII-XII)	332	84/27%	86/22%	80/15%	82/18%	332/18%

График 1. Даалгаврын (мэдлэгийн хэлбэр) шинжилгээний дүн



Даалгаврын 27 хувь нь баримтын, 22 хувь нь ухагдахууны, 18 хувь нь ахуйн болон метакогнитив, 15 хувь нь үйлийн мэдлэгийг эзэмшүүлэх арга зүйн шийдлийг хийсэн.

Хүснэгт 2. Дасгал, даалгаврыг тодорхой чадварт суралцахаар боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн.

	Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Чадварын тоо							
			Ойлгох чадвар тоо				Хэрэглэх чадварын тоо	Задлан шижлэх чадварын тоо	Бүтээх чадварын тоо	Метакогнитив
			Ангилах	Жишиж харьцуулах	Жишээгээр тайлбарлах	Дүгнэлт гаргах				
2	Газар зүй (VII-XII)	332	26/8%	45/13%	61/18%	42/13%	49/15%	42/13%	46/14%	21/6%

Даалгаврын 18 хувь нь жишээгээр тайлбарлах, 15 хувь нь хэрэглэх, 14 хувь нь бүтээх, 13 хувь нь дүгнэх, задлан шинжлэх, жиших, 6 хувь нь метакогнитив, 8 хувь нь ангилах чадварыг эзэмшүүлэхээр аргазүйн шийдлийг хийсэн.

Хүснэгт 3. Газарзүйн сурах бичгийн(VII-XI) даалгаварын хүндрэл, хариултын хувилбарт хийсэн үр дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Даалгаврын хүндрэлийн түвшний тоо		Даалгаврын хариултын хувилбарын тоо		
		Хөнгөн	Хүнд	Нээлттэй хариулт	Хаалттай хариулт	Олон сонголттой
Газарзүй (VII-XII)	332	332/52%	172/48%	174/53%	21/6%	137/41%

Даалгаврын 52 хувь нь хөнгөн, 48 хувь хүнд, хариултын 53 хувь нь нээлттэй, 6 хувь хаалттай, 41 хувь нь олон сонголттой хувилбарууд байна.

Хүснэгт 4. Даалгаврын контекст, сурах арга барилд хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Контекстийн хэлбэр /тоо			Сурах арга барил			
		Шинжлэх ухаан	Зохиомол	Бодит амьдралын жишээ	Асуудал	Мэдээлэл	Шинжлэн судлах	Эрэл хайгуул
Газарзүй	332	187/56%	13/4%	132/40%	84/25%	86/26%	80/24%	82/25%

Даалгаврын 56 хувь нь шинжлэх ухааны, 40 хувь нь ахуйн, 4 хувь нь зохиомол контексттэй байна. Даалгаврын 25 хувь нь эрэл хайгуулын, асуудал шийдвэрлэх, 24 хувь нь шинжлэн судлах, 26 хувь нь мэдээлэл боловсруулах арга барилыг дэмжсэн байна.

Хүснэгт 5. Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага, хэл найруулга, дизайны талаарх шинжилгээний дүн.

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1		
	Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага	Хэл найруулга	Техник, дизайн.
Газарзүй	1	3	3

Бага, суурь, бүрэн дунд боловсролын сурах бичигт тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлагын талаарх агуулгыг хангалтгүй тусгасан, хэл найруулга болон техникийн шаардлагыг хангасан байна.

ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

Бага, суурь, бүрэн дунд боловсролын сурах бичигт баримтын мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулга нь бусад төрлийн мэдлэгээс илүү агуулгаар орсон байна. Сэдэв тус бүрээр ухагдахууны, үйлийн мэдлэг, ахуйн, метакогнитив мэдлэгт суралцахаар боловсруулсан нь давуу тал болж байна.

Сэдвийн агуулгаас шалтгаалаад ёс суртахууны хүмүүжил төлөвшүүлэх агуулгыг дэлгэрэнгүй оруулах боломжгүй юм. Сурах бичгийн төрөл, онцлогоос шалтгаалаад хамтарч ажиллах болон байгаль орчны талаарх сэдвийн тоо түлхүү орсон байгаа нь ажиглагдаж байна.

Сурах бичгийн сэдэв тус бүрд хийж гүйцэтгэх даалгавруудын олонх нь харьцуулах, жиших болон амьдрал ахуйн холбоотой жишээгээр тайлбарлах аргууд түлхүү орсон харагдаж байна. Сурах бичгийн нэр томъёог хэрэглээ болон танин мэдэхүйн түвшинд тохируулан буулгаж, зөв оновчтой томъёолсон, шинжлэх ухааны хувьд алдаагүй, хялбаршуулж оруулсан байна.

Сурах бичигт тусгагдсан агуулгад тохирсон байдлаар Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйлийн талаар тодорхой хэмжээнд тусган өгсөн.

Сурах бичигт баримтын, ухагдахууны, үйлийн, ахуйн, мэдлэг эзэмшүүлэх дасгал даалгаврууд тодорхой хэмжээгээр орсон байна. Метакогнитив мэдлэг эзэмшүүлэх дасгал даалгавруудын тоо цөөн байна.

Сурах бичигт ангилах, жиших, жишээгээр тайлбарлах, дүгнэлт гаргах, мэдлэгээ хэрэглэх, задлан шинжлэх, бүтээх, метакогнитив чадвар эзэмшүүлэх дасгал даалгаврууд тодорхой хэмжээнд тусгагдсан боловч ихэнх нь жишээгээр тайлбарлах чадваруудад суралцахаар боловсруулалт хийжээ. Тиймээс задлан шинжлэх, бүтээх түвшний даалгаврын тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна. Сурах бичгийн дасгал, даалгавар нь агуулгын хувьд уялдаа холбоотой, хийж гүйцэтгэхэд хүнд төрлийн даалгавар ажиглагдаагүй.

Нээлттэй хариулттай даалгаврууд зонхилсон бөгөөд олон сонголттой, сурагч өөрөө бүтээх даалгавруудтай байв. Сурах бичгийн дасгал даалгавар нь тухайн судлагдахууны онолд нийцсэн, бодит жишээ баримтад тулгуурласан байлаа.

Сурах бичиг мэдээлэл боловсруулах, эрэл хайгуул хийх арга барилд суралцах даалгавар зонхилсон, асуудал шийдвэрлэх даалгавар зохих тоогоор орсон байна. Харин шинжлэн судлах даалгаврын тоо харьцангуй цөөн тусгагдсан байна.

МОНГОЛ ЁС, ХҮМҮҮЖИЛ

СУРАХ БИЧГИЙН АГУУЛГАД ТАВИХ ШААРДЛАГАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН.

Хүснэгт 1. Суралцахуйн зорилт (агуулга)-ыг боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэвтэй залгамж холбоотой боловсруулсан байдлын шинжилгээний дүн


Сурах бичиг	Анги хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн ангийн бүлэг сэдвийн залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн бүлгийн сэдэв хоорондын залгамж холбоо, эрэмбэ дараалал
Монгол ёс, хүмүүжил (I-V анги)	3	3	2

Анги хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал хангалттай, бүлэг болон сэдэв хоорондын залгамж холбоог сайжруулах шаардлагатай гэж үзсэн байна (анги тус бүрийн дэлгэрэнгүй анализыг эх тайланд хавсаргав).

Хүснэгт 2. Мэдлэгийн хэлбэрийн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр /Анги	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Мэдлэгийн төрөл				
		Баримтын мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Метокөгнитив мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо
1. Монгол ёс, хүмүүжил (I-V анги)	186	19 /10.21%	16/8.6%	44/23.65%	39/20.96%	68/36.55%

График 1 Мэдлэгийн хэлбэрийн шинжилгээний дүн.




Сурах бичигт 36 хувь нь метакогнитив, 24 хувь нь үйлийн, 21 хувь нь ахуйн, 10 хувь нь баримтын, 9 хувь нь ухагдахууны мэдлэг дэмжсэн агуулгын шийдэл хийсэн.

Хүснэгт 3. Хандлага (ёс суртахууны хүмүүжил төлөвшүүлэх) эзэмшүүлэх шинжилгээний дүн.

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Суралцах ёс суртахууны хүмүүжил төлөвшил				
		Хамтарч ажиллах сэдвийн тоо	Байгаль орчноо хайрлах хамгаалах сэдвийн тоо	Өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хөгжүүлэх сэдвийн тоо	Өөрийгөө хүмүүжүүлэх сэдвийн тоо	Ёс суртахууны төлөвшил эзэмшүүлэх сэдвийн тоо
Монгол ёс, хүмүүжил (I-V анги)	186	9/4.83%	1/0.53%	79/42.4%	50/26.88%	47/25.26%

График 2 Хандлага (ёс суртахууны хүмүүжил төлөвшүүлэх) эзэмшүүлэх шинжилгээний дүн.



Сурах бичигт 42 хувь нь өөрийгөө танин мэдэх, 27 хувь нь өөрийгөө хүмүүжүүлэх, 25 хувь нь ёс суртахуун, 5 хувь нь хамтран ажиллах, 1 хувь нь байгаль орчноо хамгаалах хандлагыг дэмжсэн агуулгын шийдэл хийсэн байна.

Хүснэгт 4. Сэдэлжүүлэлт, Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын талаарх шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1	
	Сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, жишээ баримттай бичвэр, дасгал, даалгавар, туршилт ажил, дадлага ажлыг сурах бичигт оруулсан эсэх	Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг сурах бичигт тусгасан эсэх
Монгол ёс, хүмүүжил (I-V анги)	2	2


Сурах бичигт сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, жишээ баримттай бичвэр, дасгал, даалгавар, туршилт ажил, дадлага ажлыг нэмэгдүүлэх, монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг нэмж тусгах шаардлагатай байна.

СУРАХ БИЧГИЙН АРГА ЗҮЙД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

Хүснэгт 1. Сурах бичгийн даалгаврын (мэдлэгийн хэлбэр) шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Мэдлэгийн төрөл				
		Баримтын мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Метакогнитив мэдлэг эзэмшүүлэх мэдлэгийн тоо
Монгол ёс, хүмүүжил (I-V анги)	288	76/26.38%	20/6.94%	59/20.48%	76/26.38%	57/19.79%

График 1. Сурах бичгийн даалгаврын (мэдлэгийн хэлбэр) шинжилгээний дүн



Сурах бичигт 26 хувь нь ахуйн болон баримтын, 21 хувь нь үйлийн, 20 хувь нь метакогнитив, 7 хувь ухагдахууны мэдлэгийг дэмжсэн аргазүйн шийдэл хийсэн байна.

Хүснэгт 2. Дасгал, даалгаврыг тодорхой чадварт суралцахаар боловсруулсан байдал хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Чадварын тоо							
		Ойлгох чадвар тоо				Хэрэглэх чадварын тоо	Задлан шинжлэх чадварын тоо	Бүтээх чадварын тоо	Метакогнитив
		Ангилах	Жишиж харьцуулах	Жишээгээр тайлбарлах	Дүгнэлт гаргах				
Монгол ёс хүмүүжил (I-V анги)	244	41/16.8%	52/21,3%	48/19,7%	43/17,6%	21/8,6%	33/13,5%	6/2,6%	0/0%

Даалгаврын 21.3 хувь нь жишиж харьцуулах, 20 хувь нь жишээгээр тайлбарлах, 17.6 хувь нь дүгнэлт гаргах, 16.8 хувь нь ангилах, 13.5 хувь нь задлан шинжлэх чадварыг дэмжсэн аргазүйн шийдэл хийсэн.

Хүснэгт 3. Сурах бичгийн даалгаврын хүндрэл, хариултын хувилбар.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Даалгаврын хүндрэлийн түвшний тоо		Даалгаврын хариултын хувилбарын тоо		
		Хөнгөн	Хүнд	Нээлттэй хариулт	Хаалттай хариулт	Олон сонголттой
Монгол ёс, хүмүүжил (I-V анги)	288	179/62.15%	109/37.84	178/61.8%	41/14.23%	69/23.95%

62 хувь нь хөнгөн, 38 хувь нь хүнд даалгавар боловсруулсан. Сурах бичигт 62 хувь нь нээлттэй, 14 хувь нь хаалттай, 24 хувь нь олон хувилбартай хариулт байхаар боловсруулсан байна.

Хүснэгт 4. Сурах бичгийн даалгаврын контекст, сурах арга барил шинжилгээний дүн

Сурах бичгийн нэр	Контекстийн хэлбэр/тоо			Сурах арга барил			
	Шинжлэх ухааны	Зохиомол	Бодит амьдралын жишээ	Асуудал шийдвэрлэх	Мэдээлэл боловсруулах	Шинжлэн судлах	Эрэл хайгуул хийх
Монгол ёс, хүмүүжил (I-V анги)	35/12.15%	44/15.27%	209/72.56%	23/7.98%	122 /42.36%	26/9.02%	117/40.62%

Сурах бичигт 73 хувь нь ахуйн , 15 хувь нь зохиомол, 12 хувь нь шинжлэх ухааны контексттэй даалгавар боловсруулсан. 41 хувь нь эрэл хайгуул хийх, 42 хувь нь мэдээлэл боловсруулах, 7.98 хувь нь асуудал шийдвэрлэх 9.02 хувь нь шинжлэх судлах арга барилыг дэмжсэн даалгавар боловсруулсан.

Хүснэгт 5. Сурах бичгийн тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага, сэдэлжүүлэлт, хэл найруулгад хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1			
	Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага	Сэдэл	Хэл найруулга	Техник
Монгол ёс, хүмүүжил (I-V анги)	2	3	3	3

Сурах бичгүүдэд тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлагын асуудлыг илүү тусгаж сайжруулах шаардлагатай байна. Сэдэлжүүлэлт, хэл найруулга, зөв бичгийн дүрмийн алдаагүй, дизайн шаардлагыг хангасан байна.

ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

1. Сурах бичгийн агуулгын шаардлагын хувьд:

- Бага боловсролын “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрийн хүрээнд тодорхойлсон суралцахуйн зорилт (агуулга)-д нийцүүлэн сурах бичгийн агуулгыг боловсруулжээ.
- Бага боловсролын “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрт тодорхойлогдсон суралцахуйн зорилт нь анги хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал болон тухайн ангийн бүлэг сэдвийн залгамж холбоо, эрэмбэ, дарааллыг үндсэнд нь хангасан байна.
- “Монгол ёс, хүмүүжил” сурах бичгийн агуулгыг баримтын, ухагдахууны, үйлийн, ахуйн, метакогнитив гэсэн мэдлэгийн төрлүүдэд суралцахаар боловсруулжээ.
- Бага боловсролын сурах бичгийн агуулгад суралцагч өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хөгжүүлэхэд чиглэсэн сэдэв, агуулга их (шалгуур В.4.2), бичвэр, шүлэг, зураг, тэмдэг, тэмдэглэгээ, дасгал, даалгавар хангалттай оруулсан (шалгуур В.5) байгаа нь суралцагчийн танин мэдэхүйн хөгжил, нас сэтгэхүйн онцлогт ерөнхийдөө тохирсон гэж үзэж байна.
- Бага боловсролын сурах бичгийн агуулгад амьдрал ахуйн холбоотой жишээгээр тайлбарласан агуулгын тоо, зургаар тайлбарласан агуулгын тоо их (шалгуур В.6) байгаа нь суралцагчийн сонирхол, хэрэгцээнд нийцсэн, ахуй амьдралын тодорхой асуудлыг судлахад чиглэжээ.

Гэвч цаашид анхаарч зайлшгүй засч сайжруулах зүйлс ч байна. Үүнд:

- Сурах бичгийн агуулгын бүтцийг шинээр боловсруулах шаардлагатай. Ёс зүйн шинжлэх ухааны ухагдахуун, нэр томъёог /сайн үйл, хүнлэг ёс, шударга ёс, хайр, ухаалаг байдал, хариуцлага, нинжин сэтгэл, тэвчээр, хүлээцтэй байдал, нэр төр, нэр хүнд, ачийг ачаар хариулах ёс гэх мэт/ сурах бичгийн агуулгад хялбаршуулан оруулах хэрэгтэй. Сайн ба муу гэсэн ёс зүйн шинжлэх ухааны тогтсон ойлголт нэр томъёо байхад, заавал буян, нүгэл гэсэн шашны нэр томъёог хэрэглэх шаардлагагүй. Ёс зүй бол философи үүсэхтэй хамт үүсэж хөгжиж ирсэн мэдлэгийн бие даасан чухал салбар ухаан билээ. Иймд сургалтын хөтөлбөрийг монгол хэлний багшаар бус, философи, ёс зүйн мэргэжлийн багш, судлаачдаар ёс зүйн шинжлэх ухааны

агуулгаар шинээр боловсруулж, сурах бичгийг шинэ хөтөлбөрийн агуулгаар бичих нь ёс суртахуунлаг иргэдийг төлөвшүүлэх боловсролын зорилгод нийцнэ.

- Сургалтын хөтөлбөрийн нэр ба сурах бичгийн нэр өөр байгааг анхаарч, сургалтын хөтөлбөрийн нэрээр сурах бичгийн нэрийг бичих шаардлагатай. Ер нь сургалтын хөтөлбөрийг ёс зүйн мэргэжлийн багш, судлаач боловсруулаагүйгээс болж, хөтөлбөрийн агуулга дахь ёс зүйн шинжлэх ухааны мэдлэгийн агуулга бараг ороогүй бөгөөд буддист шашны ёс зүй болон монгол ёс заншлын талаар голдуу бичсэнийг өөрчилж, сургалтын хөтөлбөрийг бүхэлд нь шинээр шинжлэх ухааны мэдлэгийн агуулгыг нэмж боловсруулах шаардлагатай гэж үзэж байна. Тухайлбал: Монголын уламжлалт баяр цагаан сар, наадмыг судлах, таван хошуу мал, үр төлийг мэдэх зэрэг агуулга бол монголын түүх, монгол хэл, уран зохиолын хичээлийн агуулгад илүү холбогдоно. Иргэний ёс зүйн боловсрол хөтөлбөрийн энэ агуулгадаа тохируулан сурах бичгийг өөрөөр нэрлэсэн гэж үзэж байна. Энэ гажуудлыг буюу алдааг манай яам, холбогдох байгууллагууд яаралтай засч залруулах хэрэгтэй. Учир нь ёс зүй бол ёс суртахуун хэмээх оюун санааны үзэгдлийг судалдаг философийн салбар ухаан бөгөөд хүний өдөр тутмын харилцааг зохицуулагч ёс суртахууны зарчим, хэм хэмжээний нийлбэр цогц мөн. Ер нь бусад ямар ч хичээлийн сургалтын хөтөлбөр, сурах бичгийн нэр яг тохирч байгаа болно.
- Бас нэг анхаарах зүйл бол сургалтын хөтөлбөр дэх бүлэг сэдвийн нэр ба сурах бичгийн бүлэг сэдвийн нэр өөр байна. Ийм байж болохгүй. Сургалтын хөтөлбөрт “Өөрийгөө таньж хөгжүүлэе”, “Бусдыг хүндэлж баярлуулъя”, “Уламжлалт өв соёлоос суралцъя” агуулга тус бүрээр арван бүлэг сэдэв судална гэсэн байна. Гэтэл сурах бичигт 10 бүлэг сэдэв байхгүй, агуулгын нэрийг /”Биеэ таньж, билиг авьяасаа хөгжүүлэе”, “Ачлах ариун ёс, хүндлэх хүний ёс”, “Уламжлалт аж төрөх ёс, зан үйл” 3 бүлэг сэдвээр бичсэн байна. Энэ алдааг ч зайлшгүй залруулах нь чухал. Сурах бичгийн агуулга нь бүтцийн хувьд ёс суртахууны ухамсар, ёс суртахууны харилцаа, ёс суртахууны үйл ажиллагаа гэсэн 3 ай, ай тус бүр 3-5 бүлэг сэдвээр бичих нь зохистой гэж үзэж байна.
- Сурах бичиг дэх “Өөрийгөө танин мэдэх” сэдвийн агуулга нь хангалтгүй байгааг анхаарч, би хэн бэ буюу хүн бол зөвхөн бие, хэл, сэтгэлийн нэгдлээр тодорхойлогдохгүй бөгөөд оюун санаа, ёс суртахуун нь хүний оршихуйн мөн чанарыг тодорхойлогч хүчин зүйл болохыг нэмж оруулах шаардлагатай. “Өөрийгөө танин мэдэх” сэдвийн агуулгыг хүн өөрийн бие, хэл, сэтгэл, оюун санааны ертөнцөө танин мэдэх, үнэлэх, эргэцүүлэн бодох, шүүн тунгаах, өөрийгөө нээх буюу олох, өөрийн ухамсаргүйгээ ухамсарлах үйл ажиллагаа болох талаар оновчтой болгох хэрэгтэй.
- Монгол нутаг дахь эртний нүүдэлчдийн дурсгал, Монгол улсын нийгэм эдийн засгийн хөгжил, онцлог дархан цаазат, дурсгалт газар, байгалийн нөөц баялаг, хүн ба байгалийн харилцааны үнэт зүйл, хүн ба эдийн засгийн үнэт зүйл болон улс төрийн үнэт зүйл эзэмшүүлэхэд чиглэсэн агуулга хангалтгүй байна. Эдгээр агуулга нь тус сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилгод тусгагдаагүй байгаа тул “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрт нэмж тусгах шаардлагатай.
- Сурагчдын нас сэтгэхүйн онцлогт таарсан үндэсний хэмжээнд түгээн дэлгэрсэн контентуудын баатруудыг оруулбал суралцагчдад илүү сонирхолтой, үр дүнтэй байх боломжтой. Жишээ нь: Аами Таами

- Сургалтын хөтөлбөр болон сурах бичгийн нэрийн хувьд шинжлэх ухааны ангиллын үүднээс “Ёс зүйн удиртгал” хэмээн нэрлэх нь оновчтой.
- Мөн сурах бичгийн дэд сэдвүүдийн давхцал, дарааллыг ч эргэн нягтлах шаардлагатай байна.
- Сурах бичгийн агуулгад хөдөө орон нутгийн амьдралыг түлхүү оруулсан нь хэр зохимжтой вэ? Манай улсын иргэдийн ихэнх нь хот суурин амьдралын хэв маягтай байгааг бодолцох, суралцагчдын өдөр тутмын амьдралд тохиолдох ёс суртахууны харилцааны ээдрээтэй асуудлуудыг зөв шийдэх арга ухаантай холбоотой агуулгыг түлхүү оруулах нь илүү ач холбогдолтой. Жишээ нь: “Хурдан морины уралдаан, түүний дэг ёс” сэдэв агуулгын хувьд хэт уламжлалаа барьсан нь харагдаж байна. Хурдан морь унадаг хүүхэд хамгаалалтын малгай, хамгаалах хэрэгсэл хэрглэдэг болсон. Хүүхдийн эрхийн хамгааллын ойлголт байхгүй байна. Зураг дээрх хүүхдийг ямар ч хамгаалалтын хэрэгсэлгүй дүрсэлсэн байна.
- “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр болон суралцахуйн зорилт нь өөрөө дэлхийн иргэн гэхээсээ илүүтэй үндэсний онцлог бүхий иргэнийг бэлтгэхэд чиглэсэн агуулгатай байгааг анхаарч, үндэсний уламжлалт ёс суртахууны сэтгэлгээ болон хүн төрөлхтний ёс суртахууны үнэт зүйлсийг хослуулсан агуулгатай байх нь зүйтэй.

2. Сурах бичгийн арга зүйн хувьд:

- Дасгал, даалгаврын хариултын хувилбараас харахад нээлттэй хариулт бүхий дасгал, даалгавар болон олон сонголттой хариулттай дасгал, даалгаврын тоо харьцангуй их байгаагаас харахад тус сурах бичгийн дасгал, даалгавар нь суралцагчийг нээлттэй байлгах, хөгжүүлэх, сэтгэн бодох шийдлүүдтэй байна. (шалгуур С1.4)
- Даалгаврын хүндрэлийн түвшинг харахад харьцаа нь хөнгөн даалгавар их, хүнд даалгавар бага байгаа нь тухайн суралцагчийн танин мэдэхүй, болон сэтгэхүйн онцлогт тохируулан хялбаршуулсан байна.
- Дасгал, даалгаврууд бодит амьдралын жишээ баримтад тулгуурласан бөгөөд ахуй, амьдралтай холбоотой асуудал шийдвэрлэх арга зүйд суурилсан нь зүйтэй.
- Мэдээлэл боловсруулах, мэдлэг бүтээхэд зураг, хүснэгт, бичвэр зэргийг оновчтой хослуулсан.
- Бага боловсролын сурах бичгийн дасгал, даалгавар нь суралцагчийг ангилах, жишиж харьцуулах, тайлбарлах, дүгнэлт гаргах, хэрэглэх, задлан шинжлэх, бүтээх чадваруудад жигд суралцах, хөгжих боломжийг олгосон байна.
- Тухайн сурах бичгийн бичвэр, зураг зэргийн агуулга нь жендэрийн хэвшмэл ойлголт, жендэрийн өрөөсгөл хандлагыг илэрхийлээгүй байна.

Гэвч цаашид арга зүйн хувьд анхаарч нэмж сайжруулах зүйлс ч байна. Үүнд:

- “Монгол ёс хүмүүжил- 1 сурах бичигт хараахан уншиж бичиж, сураагүй хүүхдүүдэд хэт их хэмжээтэй бичвэр байгааг анхаарах.
- Туршилт, дадлага ажил хийх дасгал даалгавар байхгүйг анхаарч нэмж оруулах шаардлагатай. Бага боловсролын сурах бичигт суралцагч бие даан сайн суралцах арга барилыг эзэмшихтэй холбоотой даалгавар бага байна.

- Ёс зүй бол хүн байхуйн ухаан билээ. Иймд сурах бичигт мөндөл, далайн яст мэлхий, дэгдээхэйний амьдралын жишээнээс илүү энэ насны хүүхдийн өдөр тутмын бодит амьдрал дахь тулгамдсан ёс суртахууны асуудлыг шийдвэрлэх даалгавар, дасгал, дадлага ажил түлхүү оруулах шаардлагатай. Амьтдын тухай үлгэрийг монгол хэлний хичээлээр ёс суртахууны боловсрол олгоход ашиглах нь илүү тохиромжтой.
- Сурах бичигт боловсролын талаарх дэлхийн чиг хандлага, тогтвортой хөгжлийн агуулга, иргэнд зайлшгүй эзэмшсэн байх чадварыг тусгасан эсэх шалгуур (С2.1)-аас өөрийгөө таньж мэдэх, нийгэмд эв зүйтэй амьдрах, сэтгэлээ жолоодож сурах зөөлөн чадвараас бусад чадвар болох өөртөө үнэнч байх, өөрийгөө халамжлах, хайрлах, хүндлэх, өөртөө санаа тавих, өөрөө өөрийгөө өөд нь татах, өөртөө итгэлтэй байх, өөртөө урам өгөх, өөртөө туслах ухаантай байх, өөртөө шүүмжлэлтэй хандах, өөртөө өндөр шаардлага тавих, өөрийн бурууг хүлээх, эрсдэлээ өөрөө үүрэх зэрэг чадварыг нэмж оруулах хэрэгтэй. Хүн байх ухаанд суралцах арга барил, суралцагчийн харилцааны болон бие даах чадварыг сайжруулах даалгавар дасгал, дадлага ажлыг нэмж оруулах шаардлагатай.
- Зарим сэдэв дээр дасгал, даалгаврууд давхардах, нэг асуултаа дахин давтан асуух, оновчгүй, тухайн нөхцлөөс хариулах боломжгүй асуултууд ч байгааг анхаарч засах хэрэгтэй. Жишээ нь: “Би чадна” гэсэн сэдэвт хурдан морь унахаас илүү ач холбогдолтой, ёс суртахуунлаг амьдрахтай холбоотой хот болон хөдөөгийн суралцагчийн амьдралын нийтлэг жишээ баримттай даалгаврыг оруулж өгөх нь илүү ач холбогдолтой.

3. Сурах бичгийн хэл найруулгын хувьд:

- Бага боловсролын сурах бичгийн хэл найруулга нь ерөнхийдөө оновчтой, товч тодорхой, энгийн ойлгомжтой бичсэн байна.
- Хэл найруулгын болон зөв бичих дүрмийн алдаагүй.
- Зураг, хүснэгт тайлбартай, тайлбар нь найруулгын алдаагүй.
- Гадаад үг ашиглаагүй.
- Буруу хариулттай, эсвэл хариулах боломжгүй дасгал, даалгавар байхгүй байна.

Гэвч цаашид анхаарч зайлшгүй сайжруулах зүйлс ч байна. Үүнд:

- Ёс зүйн шинжлэх ухааны бус хэллэг, нэр томьёо (биеэ таньж, билиг авьяасаа хөгжүүлбэ, авхаалж самбаа, дэмий чалчих, мэндийг мэдэх ёс, ах захаа мэддэг хүн, олз омог ихтэй, бие, хэл нь сэтгэлийн зарц, муу сэтгэл, буруу сэтгэл, мундаг хүү, сэтгэлээ жолоодох гэх мэт) эдгээр сурах бичигт их хэрэглэсэн байгааг анхаарч, ёс зүйн шинжлэх ухааны ойлголт, тодорхойлолт, нэр томьёог хялбаршуулан оновчтой хэрэглэх,
- Сурах бичигт сэдвийн нэр ба агуулга зөрсөн алдаа байгааг анхаарч засах хэрэгтэй. Тухайлбал, “Алтан намар” сэдэвт өвөл, зун, хаврын мэндчилгээ орсон байгаа тул агуулгадаа тохирсон “Дөрвөн улирлын мэнд” гэсэн гарчиг байх нь зүйтэй. “Гэгээн өглөө” гэсэн сэдэв дотор “Орой болж нар жаргалаа” гэсэн өгүүлбэр байх юм. Энд гарчгийг “Мэндлэх ёс” гэж солих хэрэгтэй.
- Цаг, цаг хугацаа, үр дүн, үр ашиг, тус, ач тус, эрдэм, эрдэм ном, эрдэм мэдлэг, уучлал, уучлалт зэрэг ойролцоо утгатай нэр томьёог жигдэлж, нэг мөр хэрэглэх,

- Сурах бичгийн зарим бүлэгт нэг өгүүлбэрт байх үгийн тоог тухайн суралцагчийн насанд тохируулан багасгах шаардлагатай.

4.Сурах бичгийн техникийн шаардлагын хувьд:

- Тус сурах бичгийн бичвэр, зураг, хүснэгтэн мэдээлэл нь тод, үсгийн хэмжээ том, мөр хоорондын зай их, уншихад ямар нэгэн бэрхшээл байхгүй.
- Сурах бичгийн зурагнууд нь монгол хүүхдийн дүр төрх, соёл, уламжлалын санааг илэрхийлсэн, зургийн өнгө будаг, сайн байна.
- Сурах бичгийн наалт чанартай бага ангийн хүүхдийн хэрэглээг хангахаар байна.

Гэвч цаашид анхаарч сайжруулах зүйлс ч байна. Үүнд:

- “Монгол ёс хүмүүжил-3” сурах бичгийн 22 дугаар хуудасны доод хэсгийн дасгал ажил нь уруу харсан байгаа техник алдааг засах,
- Зургийн олон хэлбэр ашиглах,
- Зарим зургийн хэмжээ өнгө үзэмжийг стандартад нийцүүлэх шаардлагатай.

Эцэст нь нэмж хэлэхэд, Ёс зүйн боловсрол, сэтгэл судлалын боловсрол, шашин судлалын боловсрол ялгаатай.

Энэ бага боловсролын сурах бичгийн зохиогчийн багийн ахлагч хэвлэлийн компанийн захирал байх нь мэргэжлийн ёс зүй болон боловсролын ёс зүйд хэр нийцэж байна вэ? Зохиогчийн багийн ахлагч болон сурах бичгийн редактор нь ёс зүйн мэргэжлийн хүн байх ёстой. Мэргэжлийн ба шинжлэх ухааны ёс зүйн энэ асуудлыг цаашид манай яам онцгой анхаарах шаардлагатай.

Мөн зайлшгүй анхаарах нэг чухал асуудал бол энэ хичээлийг заах багшийг сайдын тушаалд нийгмийн ухааны багш заана гэсэн мөртлөө бодит амьдрал дээр сургагч багш нарыг монгол хэлний багш нараар бэлтгэж заалгаж байгаа асуудлыг ч цэгцлэх ёстой. Монгол хэлний багш нар монгол хэлээ л сайн заах хэрэгтэй. Нийгмийн ухааны багш нар монгол хэлний хичээл заана гэвэл гайхна биздээ.

- Бага боловсролын багш нар бэлддэг их, дээд сургуулиудад иргэний ёс зүйн боловсрол хичээлийн агуулга, арга зүйн талаар системтэй ойлголт өгөх, заавал судлах сургалтын хөтөлбөр боловсруулж, хичээл заах хэрэгтэй.
- Багш мэргэжлээр суралцаж буй оюутнууд “Ёс зүйн удиртгал” хичээлийг заавал судалдаг байх ёстой.

ИРГЭНИЙ ЁС ЗҮЙН БОЛОВСРОЛ

СУРАХ БИЧГИЙН АГУУЛГАД ТАВИХ ШААРДЛАГАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН.

Хүснэгт 1. Суралцахуйн зорилтыг (агуулга) боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэв хоорондын залгамж холбоотой боловсруулсан байдал.


Сурах бичиг	Анги хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн ангийн бүлэг сэдвийн залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн бүлгийн сэдэв хоорондын залгамж холбоо, эрэмбэ дараалал
Иргэний ёс зүйн боловсрол	3	3	3

Сурах бичгийн тухайд анги, бүлэг, сэдэв хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалалын шаардлагыг хангаж бичигдсэн байна.

Хүснэгт 2. Мэдлэгийн хэлбэрийн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Мэдлэгийн төрөл				
		Баримтын мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Метокөгнитив мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо
Иргэний ёс зүйн боловсрол (VI-XII)	268	33/12.31%	47/17.53%	86/32.08%	31/11.56%	71/26.49%

График 1 Мэдлэгийн хэлбэрийн шинжилгээний дүн.




Сурах бичигт 32 хувь нь үйлийн, 26 хувь нь метакогнитив, 18 хувь нь ухагдахууны, 12 хувь нь баримт болон ахуйн мэдлэгийг дэмжсэн агуулгын шийдэл хийсэн байна.

Хүснэгт 3. Хандлага (ёс суртахууны хүмүүжил төлөвшүүлэх) эзэмшүүлэх байдалд хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Суралцах ёс суртахууны хүмүүжил төлөвшил)				
		Хамтарч ажиллах сэдвийн тоо	Байгаль орчноо хайрлах хамгаалах сэдвийн тоо	Өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хөгжүүлэх сэдвийн тоо	Өөрийгөө хүмүүжүүлэх сэдвийн тоо	Ёс суртахууны төлөвшил эзэмшүүлэх сэдвийн тоо
Иргэний ёс зүйн боловсрол (VI-XII)	268	42/15.67%	11/4.1%	105/39.17%	53/19.77%	57/21.26%

График 2. Хандлага (ёс суртахууны хүмүүжил төлөвшүүлэх) эзэмшүүлэх байдалд хийсэн шинжилгээний дүн.



Сурах бичигт 39 хувь нь өөрийгөө танин мэдэх, 20 хувь нь өөрийгөө танин мэдэх, 21 хувь нь ёс суртахууны, 16 хувь нь хамтран ажиллах, 4 хувь нь байгаль орчноо хамгаалах мэдлэгийг дэмжсэн агуулгын шийдэл хийсэн байна.

Хүснэгт 4. Сэдэлжүүлэлт, Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын талаарх шинжилгээний дүн.

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1	
	Сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, жишээ баримттай бичвэр, дасгал, даалгавар, туршилт ажил, дадлага ажлыг сурах бичигт оруулсан эсэх	Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг сурах бичигт тусгасан эсэх
Иргэний ёс зүйн боловсрол (VI-XII)	2	2


Сурах бичигт сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, жишээ баримттай бичвэр, дасгал, даалгавар, туршилт ажил, дадлага ажлыг нэмэгдүүлэх, монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг нэмж тусгах шаардлагатай байна.

СУРАХ БИЧГИЙН АРГА ЗҮЙД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

Хүснэгт 1. Дасгал даалгаврын шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Мэдлэгийн төрөл				
		Баримтын мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Метакогнитив мэдлэг эзэмшүүлэх мэдлэгийн тоо
Иргэний ёс зүйн боловсрол (VI-XII)	881	146/16.57%	138/15.66%	168/19.06%	106/12.03%	323/36.66%

График 1. Дасгал даалгаврын шинжилгээний дүн




Сурах бичгийн даалгаврын 37 хувь нь метакогнитив, 19 хувь нь үйлийн, 16 хувь нь баримтын болон ухагдахууны, 12 хувь нь ахуйн мэдлэгийг дэмжсэн арга зүйн шийдэл хийсэн байна.

Хүснэгт 2. Сурах бичгийн дасгал, даалгаврыг тодорхой чадварт суралцахаар боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр / Анги	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Чадварын тоо							
		Ойлгох чадвар тоо				Хэрэглэх чадварын тоо	Задлан шинжлэх чадварын тоо	Бүтээх чадварын тоо	Метакогнитив
		Ангилал	Жишиж харьцуулах	Жишээгээр тайлбарлах	Дүгнэлт гаргах				
Иргэний ёс зүйн боловсрол (VI-XII)	927	37/3.4%	57/6.1%	224/24.2%	163/17.6%	124/13.4%	92/10%	62/6.7%	168/18.1%

График 2. Сурах бичгийн дасгал, даалгаврыг тодорхой чадварт суралцахаар боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн.



Сурах бичгийн даалгаврын 24 хувь нь жишээгээр тайлбарлах, 18 хувь нь дүгнэлт, метакогнитив, 13 хувь нь хэрэглэх, 10 хувь нь задлан шинжлэх, 7 хувь нь бүтээх, 6 хувь нь жишиж харьцуулах, 4 хувь нь ангилал чадварыг дэмжсэн аргазүйн шийдэл хийсэн байна.

Хүснэгт 3. Сурах бичгийн даалгаврын хүндрэл, хариултын хувилбарт хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Даалгаврын хүндрэлийн түвшний тоо		Даалгаврын хариултын хувилбарын тоо		
		Хөнгөн	Хүнд	Нээлттэй хариулт	Хаалттай хариулт	Олон сонголттой
Иргэний ёс зүйн боловсрол	881	549/62,31%	332/37,68%	708/80,27%	119/13,49%	55/6,23%

Сурах бичигт 62.31 хувь нь хөнгөн, 38 хувь нь хүнд түвшний, 80.27 хувь нь нээлттэй, 14 хувь нь хаалттай, 6.23 хувь нь олон хувилбартай хариулт бүхий даалгавар боловсруулсан байна.

Хүснэгт 4. Сурах бичгийн даалгаврын контекст, сурах арга барилд хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Контекстийн хэлбэр /тоо			Сурах арга барил			
	Шинжлэх ухааны	Зохиомол	Бодит амьдралын жишээ	Асуудал шийдвэрлэх	Мэдээлэл боловсруулах	Шинжлэн судлах	Эрэл хайгуул хийх
Иргэний ёс зүйн боловсрол (VI-XII)	347/39,34%	155/17,57%	380/43,08%	22/2,48%	308/34,76%	115/12,97%	441/50,45%

Сурах бичгийн 43 хувь нь ахуйн, 39 хувь нь шинжлэх ухааны, 18 хувь нь зохиомол контексттэй, 50 хувь нь эрэл хайгуул, 35 хувь нь мэдээлэл боловсруулах, 13 хувь нь шинжлэн судлах, 2 хувь нь асуудал шийдвэрлэх арга барилыг дэмжсэн даалгавар боловсруулсан байна.

Хүснэгт 5. Сурах бичгийн тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага, сэдэлжүүлэлт, хэл найруулгад хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1			
	Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага	Сэдэл	Хэл найруулга	Техник
Иргэний боловсрол	2	3	3	3

Сурах бичигт тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлагын асуудлыг илүү тусгаж оруулах шаардлагатай байна. Сэдэлжүүлэлт, хэл найруулга, дизайны шаардлагыг хангасан байна.

ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

1. Сургалтын хөтөлбөрийн хүрээнд тодорхойлсон 9 суралцахуйн зорилт (агуулга)-д нийцүүлэн сурах бичигт 3 бүлэг 46 сэдвийн агуулгыг сонгон оруулсан байна. Сурах бичгийн бүлэг сэдвүүдийн агуулга нь сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилттой нийцэж байна
2. Сурах бичгийн агуулгыг баримтын, ухагдахууны, үйлийн, ахуйн, метакогнитив гэсэн мэдлэгийн төрлүүдэд суралцахаар боловсруулсан байна. Үүнээс Үйлийн

болон метакогнитив мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо харьцангуй их байгаа нь тухайн суралцагчийн онцлог, хөтөлбөрийн зорилготой нийцэж байна. (шалгуур В 4.1.)

3. Сурах бичгийн агуулгад хамтарч ажиллах болон өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хөгжүүлэхэд чиглэсэн сэдэв, агуулга их (шалгуур В.4.2) байгаа нь сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилттой нийцэж байгааг харуулж байна.
4. Сурах бичигт сонирхолтой бичвэр, зураг, тэмдэг, тэмдэглэгээ, дасгал, даалгавар хангалттай оруулсан (шалгуур В.5) байгаа нь суралцагчийн танин мэдэхүйн хөгжил, нас сэтгэхүйн онцлогт тохирсон гэж үзэж байна.
5. Монголын уламжлалт аж төрөх ёс, зан үйлээс үндэсний дээл хувцас, төрт ёсны уламжлалтай холбоотой агуулгаар дамжуулан суралцах боломж олгожээ. Тодруулбал, Монгол үндэстэн, ястны соёл, боловсрол, сэтгэлгээ, Монгол үндэстний үнэт зүйл, хүн хүний харилцааны ёс суртахууны үнэт зүйлтэй холбоотой агуулга их байна. (шалгуур В7.1)
6. Сурах бичгийн I бүлэгт эшлэл зүүлт оруулсан нь ахлах ангийн сурагчдад мэдээллийг гүнзгийрүүлэн судлах сэдэл өгөх болон оюуны бүтээл зохиогчийн эрхийн ойлголт мэдлэгийг өгсөн давуу талтай. Жишээ нь: 5 дугаар хуудас.
7. Сэдвүүдийн эхэнд сурагчдын сайн мэдэх кино болон суут сэтгэгчдийн афоризм, бодит кейс оруулсан.
8. Монгол үндэстэн, ястны соёл, боловсрол, сэтгэлгээ, Монгол үндэстний үнэт зүйлтэй холбоотой агуулга их. (шалгуур В7.1)
9. Бүх бүлэгт эшлэл зүүлт оруулсан нь ахлах ангийн сурагчдад мэдээллийг гүнзгийрүүлэн судлах сэдэл өгөх болон оюуны бүтээл зохиогчийн эрхийн талаар ойлголт мэдлэгийг өгсөн.
10. Мөн подкаст оруулсан нь сурагчдын сонирхлыг орчин үеийн чиг хандлагад нь нийцүүлсэн

Сул тал

1. Энэ сурах бичгийн нэр ба агуулга ихээхэн зөрөөтэй байна. Энд зохиогч нарын буруу гэж байхгүй. Энэ нь “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрийн агуулгын гажуудалтай шууд холбоотой.
2. Сурах бичгийн агуулгад Х ангийн суралцагчийн өдөр тутмын бодит хэрэгцээ шаардлагыг хангасан ёс зүйн шинжлэх ухааны боловсролын агуулга бага тусгагдсан. Энэ нь “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрийн агуулгын гажуудалтай шууд холбоотой байна.
3. Боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэв хоорондын залгамж холбоо, эрэмбэ дарааллыг бүрэн бус, 80-90 хувь тогтоогдож байна.
4. Сурах бичигт ёс зүйн шинжлэх ухааны онол, үзэл баримтлал тусгаагүй. Жишээ нь, Үүрэг хариуцлагын ач тус сэдэвт ёс суртахууны үүрэг, хариуцлагын тухай ойлголт, агуулга байхгүй.
5. Сурах бичигт буддын философи, буддист сэтгэл судлал, шашны агуулга харьцангуй ихэнх хувийг эзлэж байна. Төв үзэл, арга билгийн ухаан, арга, арга ухаан, билиг,

билиг ухаан, билиг оюун г.м. 23 дахь талд байгаа буддын гүн ухааны ойлголтууд иргэний ёс зүйд хэрхэн холбогдож байгааг анхаарах,

6. Байгаль орчноо хайрлах, хамгаалах ёс зүй, ёс суртахууны хүмүүжил, төлөвшил олгох агуулга бага.
7. Сурах бичгийн 87-р хуудасны Зөв ойлголцол нь эе эеийг бэхжүүлнэ сэдэв нь “эв эе” гэх
8. Сурах бичгийн 17 дугаар хуудсанд “өөрт ачтай хүмүүсийнхээ сайн сайхны төлөө” гэж бичсэнийг анхаарах, бүх хүний л сайн сайхны төлөө байх ёстой
9. Сурагчдын сонирхолыг татсан, эрэлт хэрэгцээ, танин мэдэхүйн түвшинд тохирсон график, диаграмм хомс байна.

Сайжруулах санал:

- Орчин үеийн хүүхдийн бодит хэрэгцээ шаардлага тулгамдаж буй ёс суртахууны асуудлыг нэмж оруулах
- Суурь боловсролын иргэний ёс зүйн боловсрол хичээлийн агуулгыг болон XI ангийн агуулгыг харж агуулгын давхцал, залгамж холбоо, агуулгын хүндрэл, агуулгын гүнзгийрэл болон агуулгын өргөслийг эргэн харах.
- Сурах бичгийн агуулга болон сурах бичигт төлөвлөсөн дасгал, даалгаварт байгаль орчноо хайрлан хамгаалах ёс зүйн агуулгыг нэмэгдүүлэх,
- XXI зууны иргэн хүнд байх ёс суртахууны үнэт зүйл, эрхэмлэл, төлөвшил болон орчин үеийн иргэний ёс зүйн боловсролд хувь нэмэр оруулах агуулгыг нэмэгдүүлэх.
- Сурах бичгийн буддын шашны агуулгыг багасгах.
- Иргэний ёс зүйн боловсрол хичээлийн агуулгыг бусад хичээлийн судлагдахуунтай холбох, интеграцчилах байдлаар агуулга боловсруулж болох боломжийг эрэлхийлэх.
- Сурагчдын сонирхолыг татсан, эрэлт хэрэгцээ, танин мэдэхүйн түвшинд тохирсон график, диаграмм оруулах,
- Сурах бичгийн агуулга, багтаамжийг инвариант байхад анхаарах,

НИЙГЭМ СУДЛАЛ

СУРАХ БИЧГИЙН АГУУЛГАД ТАВИХ ШААРДЛАГАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН.

Хүснэгт 1. Суралцахуйн зорилтыг (агуулга) боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэв хоорондын залгамж холбоотой боловсруулсан байдал.


Сурах бичиг	Анги хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн ангийн бүлэг сэдвийн залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн бүлгийн сэдэв хоорондын залгамж холбоо, эрэмбэ дараалал
Нийгэм судлал (IV-XII)	3	3	3

Анги, бүлэг, сэдэв хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал шаардлагыг хангасан байна.

Хүснэгт 2. Агуулгын (мэдлэгт суралцахаар боловсруулсан байдал) шинжилгээний дүн.

	Сурах бичгийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Мэдлэгийн төрөл				
			Баримтын мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Метакогнитив мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо
3.	Нийгэм судлал (IV-XII)	454	52/11.45%	63/13.87%	130/28.63%	70/15.41%	139/30.61%

График 1. Агуулгын (мэдлэгт суралцахаар боловсруулсан байдал) шинжилгээний дүн.




31 хувь нь метакогнитив, 29 хувь нь үйлийн, 14 хувь нь ухагдахууны, 15 хувь нь ахуйн, 11 хувь нь баримтын мэдлэгийг эзэмшүүлэхээр агуулгын шийдэл хийгдсэн байна.

Хүснэгт 3. Хандлага (ёс суртахууны хүмүүжил төлөвшил) эзэмшүүлэх байдал.

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр /Анги	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Суралцах ёс суртахууны хүмүүжил төлөвшил)				
		Хамтарч ажиллах сэдвийн тоо	Байгаль орчноо хайрлах хамгаалах сэдвийн тоо	Өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хөгжүүлэх сэдвийн тоо	Өөрийгөө хүмүүжүүлэх сэдвийн тоо	Ёс суртахууны төлөвшил эзэмшүүлэх сэдвийн тоо
Нийгэм судлал (IV-XII)	268	42/15.67%	11/4.1%	105/39.17	53/19.77%	57/21.26/

График 2. Хандлага (ёс суртахууны хүмүүжил төлөвшил) эзэмшүүлэх байдал.



35 хувь нь өөрийгөө танин мэдэх, 30 хувь нь хамтран ажиллах, 15 хувь нь ёс суртахууны, 16 хувь нь байгаль орчноо хамгаалах, 4 хувь нь өөрийгөө хүмүүжүүлэх хандлага төлөвшүүлэхээр агуулгын шийдэл хийгдсэн байна.

Хүснэгт 4. Сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлын талаарх шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1	
	Сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, жишээ баримттай бичвэр, дасгал, даалгавар, туршилт ажил, дадлага ажлыг сурах бичигт оруулсан эсэх	Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг сурах бичигт тусгасан эсэх
Нийгэм судлал (IV-XII)	2	2


Сурах бичигт сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, жишээ баримттай бичвэр, дасгал, даалгавар, туршилт, дадлага ажлыг нэмэгдүүлж, монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг нэмж тусгах шаардлагатай байна.

СУРАХ БИЧГИЙН АРГА ЗҮЙД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

Хүснэгт 1. Дасгал, даалгаврыг тодорхой мэдлэгт суралцахаар боловруулсан байдал.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Мэдлэгийн төрөл				
		Баримтын мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Метакогнитив мэдлэг эзэмшүүлэх мэдлэгийн тоо
Нийгэм судлал (IV-XII)	471	193/40.97%	101/21.44%	51/10.82%	60/12.73%	66/14.01%

График 1. Дасгал, даалгаврыг тодорхой мэдлэгт суралцахаар боловсруулсан байдал.




Нийт даалгаврын 41 хувь нь баримтын, 21 хувь нь ухагдахууны, 13 хувь нь ахуйн, 14 хувь нь метакогнитив, 11 хувь нь үйлийн мэдлэг эзэмшүүлэхээр аргагүйн шийдэл хийгдсэн байна.

Хүснэгт 2. Дасгал, даалгаврыг тодорхой чадварт суралцахаар боловсруулсан байдал.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Чадварын тоо							
		Ойлгох чадвар тоо				Хэрэглэх чадварын тоо	Задлан шинжлэх чадварын тоо	Бүтээх чадварын тоо	Метакогнитив
		Ангилах	Жишиж харьцуулах	Жишээгээр тайлбарлах	Дүгнэлт гаргах				
Нийгэм судлал (IV-XII)	665	37/5.6%	47/7%	94/14.1%	93/14%	39/5.9%	77/11.6%	66/10%	212/31.9%

График 2. Дасгал, даалгаврыг тодорхой чадварт суралцахаар боловсруулсан дүн



Нийт даалгаврын 32 хувь нь жишиж харьцуулах, 14 хувь нь жишээгээр тайлбарлах болон дүгнэлт гаргах, 12 хувь нь задлан шинжлэх, 10 хувь нь ангилах, 7 хувь нь жишиж харьцуулах, 5 хувь нь ангилах чадварыг төлөвшүүлэхээр аргагүйн шийдэл хийгдсэн байна.

Хүснэгт 3. Даалгаврын хүндрэл, хариултын хувилбар.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Даалгаврын хүндрэлийн түвшний тоо		Даалгаврын хариултын хувилбарын тоо		
		Хөнгөн	Хүнд	Нээлттэй хариулт	Хаалттай хариулт	Олон сонголттой
Нийгэм судлал	402	187/46.51%	215/53.48	302/67.86%	54/12.13%	89/20%

47 хувь нь хөнгөн, 53 хувь нь хүнд даалгавар боловсруулсан нь даалгаврын харьцааг тохиромжтой хийсэн байна. 68 хувь нь нээлттэй, 12 хувь нь хаалттай, 20 хувь нь олон хувилбартай даалгавар боловсруулсан байна.

Хүснэгт 4. Даалгаврын контекст, сурах арга барил.

Сурах бичгийн нэр	Контекстийн хэлбэр /тоо			Сурах арга барил			
	Шинжлэх ухааны	Зохиомол	Бодит амьдралын жишээ	Асуудал шийдвэрлэх	Мэдээлэл боловсруулах	Шинжлэн судлах	Эрэл хайгуул хийх
Нийгэм судлал	382/32.64%	199/17.0%	589/50.34%	50/9.9%	154/30.49%	96/19.0%	205/40.59%

50.34 хувь нь ахуйн, 33 хувь нь шинжлэх ухааны, 17 хувь нь зохиомол даалгавар боловсруулсан байна. Нийт даалгаврын 41 хувь нь эрэл хайгуул хийх, 30.49 хувь нь мэдээлэл боловсруулах, 19 хувь нь шинжлэн судлах, 10 хувь нь асуудал шийдвэрлэх арга барилыг дэмжсэн байна(анги тус бүрийн дэлгэрэнгүй анализыг эх тайланд хавсаргав).

Хүснэгт 5. Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага, сэдэлжүүлэлт, хэл найруулга, дизайн дийсэн шинжилгээний дүн

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1			
	Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага	Сэдэл	Хэл найруулга	Техник
Нийгэм судлал (IV-XII)	2	3	3	3

Сурах бичгүүдэд тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлагын асуудлыг тусгаж сайжруулах шаардлагатай байна. Сэдэлжүүлэлт, хэл найруулга, зөв бичгийн дүрмийн алдаагүй, дизайн хангасан байна(анги тус бүрийн дэлгэрэнгүй анализыг эх тайланд хавсаргав).

ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

Давуу тал

Сургалтын хөтөлбөрийн хүрээнд тодорхойлсон 14 суралцахуйн зорилт (агуулга)-д нийцүүлэн сурах бичигт 5 бүлэг 22 сэдвийн агуулгыг сонгон оруулсан. Сурах бичгийн 2-5 дугаар бүлгийн агуулга нь сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилттой нийцэж байна. Сурах бичигт бүлгийн сэдэв хоорондын залгамж холбоо, эрэмбэ дарааллыг үндсэндээ хангасан.

Агуулга нь баримтын, үйлийн, ухагдахууны, метакогнитив гэсэн мэдлэгийн төрлүүдэд суралцахаар боловсруулсан. (шалгуур В 4.1.)

Сурах бичгийн агуулгад хамтарч ажиллаж, амьдрах эерэг хандлага, өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хөгжүүлэх, өөрийгөө хүмүүжүүлэх, ёс суртахууны төлөвшил, олгоход чиглэсэн байхаар агуулгыг боловсруулсан. Сонирхолтой бичвэр, зураг, тэмдэг, тэмдэглэгээ, дасгал, даалгавар хангалттай, хослуулан ашиглах боломж олгосон (шалгуур В.5) нь суралцагчийн танин мэдэхүйн хөгжил, нас сэтгэхүйн онцлогт тохирсон. Сурах бичигт ойлголт, хууль, зарчим, тодорхойлолт зэрэг онолын агуулгыг бүдүүвчээр болон энгийн өгүүлбэрээр тайлбарласан. Суралцахуйн зорилтыг бүлэг сэдэв бүрийн эхэнд оруулж өгсөн

нь суралцагч болон багш нарт сургалтаа хэрэгжүүлэхэд дөхөм болсон. Дасгал, даалгавар нь суралцагчийг ангилах, жишиж харьцуулах, тайлбарлах, дүгнэлт гаргах, хэрэглэх, задлан шинжлэх, бүтээх чадваруудад жигд суралцах, хөгжих боломжийг олгосон. Тэдгээрийг гүйцэтгэхэд танин мэдэхүйн хоёроос дээш чадвар шаардаж байгаа нь суралцагчийн чадварыг хөгжүүлж байна. Сурах бичгийн агуулга тухайн суралцагчаас танин мэдэхүйн хоёроос дээш чадварыг шаардсан, шинжлэн судлах арга барилд сургах хөтөлбөрийн үзэл санаатай нийцэж байна. (шалгуур С1.3)

Дасгал, даалгаврын нээлттэй хариулт 70 хувь, байгаагаас харахад тус сурах бичгийн дасгал, даалгавар нь суралцагчийг нээлттэй байлгах, хөгжүүлэх, сэтгэх шийдлүүдтэй байна. (шалгуур С1.4) Дасгал, даалгаврууд нь нийгмийн ахуй, амьдралтай холбоотой асуудал шийдвэрлэх арга зүйд суурилсан байна.(шалгуур С1.5) Дасгал, даалгаврууд нь суралцагчийг мэдээлэл боловсруулах, эрэл хайгуул хийх арга барил эзэмшүүлэхэд чиглэгдэж байна. Сурах бичгийн 14 дүгээр хуудасны хамтран ажиллах даалгаварт УСК ашиглах даалгавар нь сонирхолтой, мөн олон даалгаварт интернетийн эх сурвалж оруулсан. Суралцагчдад системтэй мэдлэг олгохуйц оюуны зураглал схемүүдийг оруулсан. Мэдээлэл олгох, боловсруулах, мэдлэг бүтээхэд зураг, хүснэгт, бичвэр, график, диаграмм, бүдүүвч зэргийг оновчтой хослуулсан. (шалгуур С3)

Бичвэр, зургийн агуулга нь жендэрийн хэвшмэл ойлголт, жендэрийн өрөөсгөл хандлагыг илэрхийлээгүй.

Сайжруулах санал

- Сурах бичгийн бүх сэдвийн агуулгад байгаль орчноо хайрлан хамгаалах, өөрийгөө хүмүүжүүлэхэд чиглэсэн агуулгыг нэмэгдүүлэх.
- Сургалтын хөтөлбөр болон сурах бичгийн бүлэг сэдвийн нэр зөрөөтэй байгааг нэг нэршилтэй болгох. (IV болон V бүлэг)
- Зарим сэдвийн агуулгыг бүрэн тодорхой тайлбарлах. Жишээ нь, 1.3. “Бусадтай хэрхэн үр дүнтэй харилцах вэ?” сэдэв, 1.4. Зөрчилдөөнийг хэрхэн даван туулж, үр дүнд хүрэх вэ? Эдгээр асуудалд харилцааны ёс зүй болон харилцааны соёл хэрхэн холбогдох талаар нэмж өгөх
- Агуулга хоорондын залгамж холбоо, эрэмбэ дараалал, агуулгын давхардалыг нягтлах.
- Сурах бичигт асуудлын шалтгаан, үр дагаврыг тодорхойлох дасгал, даалгаврыг нэмэгдүүлэх.
- Сурах бичигт асуудлыг шийдвэрлэх арга замуудаас нөхцөл байдалд тохируулан сонголт хийх, үр дүнг тооцох дасгал, даалгаврыг нэмэгдүүлэх.
- Зарим дасгал, даалгаврын асуултын чанар, ач холбогдлыг дээшлүүлэхэд анхаарах
- Зарим дасгал, даалгаврын хүндрэлийн түвшинг эргэж харах.

МОНГОЛЫН ТҮҮХ

СУРАХ БИЧГИЙН АГУУЛГАД ТАВИХ ШААРДЛАГАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН.

Хүснэгт 1. Суралцахуйн зорилтыг (агуулга) боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэв хоорондын залгамж холбоотой боловсруулсан байдал.


Сурах бичиг	Анги хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн ангийн бүлэг сэдвийн залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн бүлгийн сэдэв хоорондын залгамж холбоо, эрэмбэ дараалал
Түүх (VII-XII)	3	2	2

Анги, бүлэг, сэдэв хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал хангалттай, монгол хүмүүжил сурах бичгийн тухайд анги болон бүлэг хоорондын залгамж холбоо, эрэмбэ дараалал хангалттай түвшинд бичигдсэн байна.

Хүснэгт 2. Сурах бичгийн агуулгын (мэдлэгийн хэлбэр) шинжилгээний дүн.

	Сурах бичгийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Мэдлэгийн төрөл				
			Баримтын мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Метакогнитив мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо
4.	Түүх (VII-XII)	722	85/11.77%	110/15.23%	216/29.91%	101/13.98%	210/29.08%

График 1 Сурах бичгийн агуулгын (мэдлэгийн хэлбэр) шинжилгээний дүн




30 хувь нь үйлийн, 29 хувь нь метакогнитив, 15 хувь нь ахуйн, 14 хувь нь ухагдахууны, 12 хувь нь баримтын мэдлэг эзэмшүүлэхээр агуулгын шийдэл хийсэн байна.

Хүснэгт 3. Хандлага (ёс суртахууны хүмүүжил төлөвшүүлэх) эзэмшүүлэх байдал.

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр/Анги	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Суралцах ёс суртахууны хүмүүжил төлөвшил)				Ёс суртахууны төлөвшил эзэмшүүлэх сэдвийн тоо
		Хамтарч ажиллах сэдвийн тоо	Байгаль орчноо хайрлах хамгаалах сэдвийн тоо	Өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хөгжүүлэх сэдвийн тоо	Өөрийгөө хүмүүжүүлэх сэдвийн тоо	
Түүх (VII-XII)	199	84/42.21%	11/5.52%	41/20.60%	26/13.06%	37/18.59%

График 2 Хандлага (ёс суртахууны хүмүүжил төлөвшил) эзэмшүүлэх байдал.



42 хувь нь хамтран ажиллах, 21 хувь нь өөрийгөө таних, 19 хувь нь ёс суртахуун, 13 хувь нь өөрийгөө хүмүүжүүлэх хандлагыг тус тус төлөвшүүлэхээр агуулгын шийдэл хийсэн.

Хүснэгт 4. Сэдэлжүүлэлт, Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын талаарх шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1	
	Сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, жишээ баримттай бичвэр, дасгал, даалгавар, туршилт ажил, дадлага ажлыг сурах бичигт оруулсан эсэх	Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг сурах бичигт тусгасан эсэх
Түүх (VII-XII)	2	2


Сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, жишээ баримттай бичвэр, дасгал, даалгавар, туршилт-дадлага ажлыг нэмэгдүүлэх, монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг нэмж тусгах шаардлагатай байна.

СУРАХ БИЧГИЙН АРГА ЗҮЙД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

Хүснэгт 1. Дасгал, даалгаврыг тодорхой мэдлэгт суралцахаар боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Мэдлэгийн төрөл				
		Баримтын мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Метакогнитив мэдлэг эзэмшүүлэх мэдлэгийн тоо
Түүх (VII-XII)	557	125/22.44%	154/27.64%	82/14.72%	57/10.23%	139/24.95%

График 1. Дасгал, даалгаврыг тодорхой мэдлэгт суралцахаар боловсруулсан байдал хийсэн шинжилгээний дүн.



Даалгавруудын 28 хувь нь ухагдахууны, 25 хувь нь метакогнитив, 22 хувь нь баримтын, 15 хувь нь ахуйн, 10 хувь нь үйлийн мэдлэг эзэмшүүлэхээр арга зүйн шийдэл хийсэн байна.

Хүснэгт 2. Дасгал, даалгаврыг тодорхой чадварт суралцахаар боловсруулсан байдал.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Чадварын тоо							
		Ойлгох чадвар тоо				Хэрэглэх чадварын тоо	Задлан шинжлэх чадварын тоо	Бүтээх чадварын тоо	Метакогнитив
		Ангилах	Жишиж харьцуулах	Жишээгээр тайлбарлах	Дүгнэлт гаргах				
Түүх (VII-XII)	556	6/1%	25/4.5%	54/9.7%	95/17%	38/6.8%	110/19.8%	67/12%	161/29%

29 хувь нь метакогнитив, 20 хувь нь задлан шинжлэх, 17 хувь нь дүгнэх, 12 хувь нь бүтээх, 9.7 хувь нь жишээгээр тайлбарлах, бүтээх, 4.5 хувь нь жишиж харьцуулах 1 хувь нь ангилах чадварыг дэмжсэн даалгавар бүхий арга зүйн шийдэлтэй байна.

Хүснэгт 3. Даалгаврын хүндрэл, хариултын хувилбар.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Даалгаврын хүндрэлийн түвшний тоо		Даалгаврын хариултын хувилбарын тоо		
		Хөнгөн	Хүнд	Нээлттэй хариулт	Хаалттай хариулт	Олон сонголттой
Түүх	557	279/50.08%	278/49.91%	6/1.96%	70/22.95%	229/75.08

50.08 хувь нь хөнгөн, 49.9 хувь нь хүнд, 75.08 хувь нь олон сонголттой, 22.95 хувь нь хаалттай, 1.96 хувь нь нээлттэй хувилбар бүхий даалгаврууд боловсруулсан байна.

Хүснэгт 4. Даалгаврын контекст, сурах арга барил

Сурах бичгийн нэр	Контекстийн хэлбэр /тоо			Сурах арга барил			
	Шинжлэх ухааны	Зохиомол	Бодит амьдралын жишээ	Асуудал шийдвэрлэх	Мэдээлэл боловсруулах	Шинжлэн судлах	Эрэл хайгуул хийх
Түүх	112/19.47%	182/31.65%	281/48.86%	100/17.95%	100/17.95%	260/46.97%	97/17.41%

48.86 хувь нь бодит амьдралын жишээ, 31.65 хувь нь зохиомол, 19.47 хувь нь шинжлэх ухааны контексттэй, 46.97 хувь нь шинжлэн судлах, 17,95 хувь нь асуудал шийдвэрлэх, болон мэдээлэл боловсруулах, 17,41 хувь нь эрэл хайгуул хийх шийдэлтэйгээр даалгавар боловсруулсан байна.

Хүснэгт 5. Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага, сэдэлжүүлэлт, хэл найруулга, дизайн дийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1			
	Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага	Сэдэл	Хэл найруулга	Дизайн
Түүх	2	3	3	3

Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлагын асуудлыг илүү тусгаж сайжруулах шаардлагатай байна. Сэдэлжүүлэлт, хэл найруулга, дизайн дийсэн шаардлагыг хангасан байна.

ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

Дэлхийн түүх монголын түүхийн сэдвийг хамтатган оруулсан.

Дасгал даалгавар хамтран ажиллах метакогнитив хэлбэртэй байгаа нь сайн

Түүхэн цаг хугацаа, үйл явдал, газар нутаг, зүтгэлтэн зэрэг цогц байдлаар тусгасан нь газрын зурагтай ажиллаж сурах, эртний хүмүүс болон тэдний ахуй амьдралтай танилцах, тэр үеийн амьдралын өнөө үетэй харьцуулан дүн шинжилгээ хийх он тооллын ойлголттой болох, хэд хэдэн эх сурвалжийг шинжлэн судлах талаар хүүхдүүд бие даан суралцах ажиллах боломжтой байдлаар орсон.

Дахин хэвлэлтүүдэд засварлахдаа анхаарлаа хандуулж агуулга болон дасгал даалгаврыг нягтлах

ЗУРАГ, ТЕХНОЛОГИ

СУРАХ БИЧГИЙН АГУУЛГАД ТАВИХ ШААРДЛАГАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН.

Хүснэгт 1. Суралцахуйн зорилтыг (агуулга) боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэв хоорондын залгамж холбоотой боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн.


Сурах бичиг	Анги хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн ангийн бүлэг сэдвийн залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн бүлгийн сэдэв хоорондын залгамж холбоо, эрэмбэ дараалал
Зураг технологи (I-V анги)	3	3	3

Анги, бүлэг, сэдэв хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалалын шаардлагыг хангасан байна (анги тус бүрийн дэлгэрэнгүй анализыг эх тайланд хавсаргав).

Хүснэгт 2. Агуулгын (мэдлэгт суралцахаар боловсруулсан байдалд) хийсэн шинжилгээний дүн

Сурах бичгийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Мэдлэгийн төрөл				
		Баримтын мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Метакогнитив мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо
Зураг технологи (I-V анги)	136	29/21%	32/24%	42/31%	19/14%	14/10%

График 1 Агуулгын (мэдлэгт суралцахаар боловсруулсан байдалд) хийсэн шинжилгээний дүн.



31 хувь нь үйлийн, 24 хувь нь ухагдахууны, 21 хувь нь баримтын, 14 хувь нь ахуйн, 10 хувь нь метакогнитив мэдлэгийг эзэмшүүлэхээр агуулгын шийдэл хийсэн байна(анги тус бүрийн дэлгэрэнгүй анализыг эх тайланд хавсаргав).

Хүснэгт 3. Хандлага (ёс суртахууны хүмүүжил, төлөдшүүлэх)-ын шинжилгээний дүн

Сурах бичгийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Суралцах ёс суртахууны хүмүүжил төлөвшил)				
		Хамтарч ажиллах сэдвийн тоо	Байгаль орчноо хайрлах хамгаалах сэдвийн тоо	Өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хөгжүүлэх сэдвийн тоо	Өөрийгөө хүмүүжүүлэх сэдвийн тоо	Ёс суртахууны төлөвшил эзэмшүүлэх сэдвийн тоо
Зураг технологи (I-V анги)	137	31/23%	25/18%	47/34%	18/13%	16/12%

34 хувь нь өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хөгжүүлэх, 23 хувь нь хамтарч ажиллах, 18 хувь нь байгаль орчноо хайрлах хамгаалах, 13 хувь нь өөрийгөө хүмүүжүүлэх, 12 хувь нь ёс суртахууны төлөвшүүлэх агуулгын шийдэл хийсэн байна.

Хүснэгт 4. Агуулгын сэдэлжүүлэлт, Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын талаарх шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1	
	Сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, жишээ баримттай бичвэр, дасгал, даалгавар, туршилт ажил, дадлага ажлыг сурах бичигт оруулсан эсэх	Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг сурах бичигт тусгасан эсэх
Зураг технологи	3	2

Сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, жишээ баримттай бичвэр, дасгал, даалгавар, туршилт дадлага ажлыг хангалттай оруулсан, монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг сайжруулж тусгах хэрэгтэй байна(анги тус бүрийн дэлгэрэнгүй анализыг эх тайланд хавсаргав).

СУРАХ БИЧГИЙН АРГА ЗҮЙД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Хүснэгт 1. Дасгал, даалгаврыг тодорхой мэдлэгт суралцахаар боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний үр дүн.


Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Мэдлэгийн төрөл				
		Баримтын мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Метакогнитив мэдлэг эзэмшүүлэх мэдлэгийн тоо
Зураг технологи	261	43/17%	48/18%	107/41%	40/17%	23/9%

41 хувь нь үйлийн, 18 хувь нь ухагдахууны, 17 хувь нь баримтын, 15 хувь нь ахуйн, 9 хувь нь метакогнитив мэдлэгийг эзэмшүүлэх аргазүйн шийдлийг хийсэн байна(анги тус бүрийн дэлгэрэнгүй анализыг эх тайланд хавсаргав).

Хүснэгт 2. Даалгаврын чадвар төлөвшүүлэхэд хийсэн шинжилгээний дүн.

	Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Чадварын тоо							
			Ойлгох чадвар тоо				Хэрэглэх чадварын тоо	Задлан шинжлэх чадварын тоо	Бүтээх чадварын тоо	Метакогнитив
			Ангилах	Жишиж харьцуулах	Жишээгээр тайлбарлах	Дүгнэлт гаргах				
1	Зураг технологи	261	24/9%	30/11%	39/15%	28/11%	48/18%	29/11%	38/15%	25/10%

График 2. Даалгаврын чадвар төлөвшүүлэхэд хийсэн шинжилгээний дүн.



15 хувь нь жишээгээр тайлбарлах болон бүтээх, 11 хувь нь жишиж, дүгнэлт, задлан шинжлэх, 10 хувь нь метакогнитив, 9 хувь нь ангилах чадварыг дэмжсэн аргазүйн шийдлийг хийсэн байна(анги тус бүрийн дэлгэрэнгүй анализыг эх тайланд хавсаргав).

Хүснэгт 3. Хүндрэл, хариултын хувилбарт хийсэн үр дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Даалгаврын хүндрэлийн түвшний тоо		Даалгаврын хариултын хувилбарын тоо		
		Хөнгөн	Хүнд	Нээлттэй хариулт	Хаалттай хариулт	Олон сонголттой
Зураг технологи	261	136/52%	125/48%	141/54%	76/29%	44/17%

Даалгавруудын 52 хувь нь хөнгөн, 48 хөнгөн, 54 хувь нээлттэй, 28 хувь нь хаалттай, 17 хувь нь олон сонголттой, хариулттай байна.(анги тус бүрийн дэлгэрэнгүй анализыг эх тайланд хавсаргав).

Хүснэгт 4. Даалгаврын контекст, сурах арга барилд хийсэн шинжилгээний үр дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Контекстийн хэлбэр /тоо			Сурах арга барил			
		Шинжлэх ухаан	Зохиомол	Бодит амьдралын жишээ	Асуудал	Мэдээлэл	Шинжлэн судлах	Эрэл хайгуул
Зураг технологи	261	94/36%	112/43%	55/21%	55/21%	58/22%	49/19%	99/38%

Даалгаврын 43 хувь нь зохиомол, 36 хувь нь шинжлэх ухааны, 21 хувь нь бодит амьдралын контексттэй, 38 хувь нь эрэл хайгуул хийх, 22 хувь нь мэдээлэл боловсруулах, 21 хувь нь асуудал шийдвэрлэх, 19 хувь нь шинжлэн судлах арга барилыг дэмжсэн арга зүйн шийдэлтэй байна(анги тус бүрийн дэлгэрэнгүй анализыг эх тайланд хавсаргав).

Хүснэгт 5. Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага, Хэл найруулга, дизайн хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1		
	Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага	Хэл найруулга	Техник
Зураг технологи	2	3	3

Тогтвортой хөгжил болон дэлхийн чиг хандлагын талаарх асуудлыг сайжруулж боловсруулах хэрэгтэй. Хэл найруулга болон техникийн шаардлага хангалттай түвшинд бичигдсэн байна (анги тус бүрийн дэлгэрэнгүй анализыг эх тайланд хавсаргав).

ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

Бага ангийн сурах бичигт технологи бүлэг нь анхны бие даасан сурах бичиг юм. Зургийн хичээлд үндэслэсний үр дүнд цаас, даавууг нугалах, элдэв дүрс гаргах, геометрийн дүрсүүд зурах, байгуулах улмаар байгалын байдлыг хайчилбараар өнгийн цаас ашиглан байгуулах, цэцэг навч хайчлан урлах, амьтны дүрс урлах зэргээр технологийн үйл ажиллагаанд оролцуулах нь хамгийн оновчтой хувилбар гэж үзэж байна. Харин жишээ баримт, хийх эдлэлийн сонголтыг оновчтой болгоход анхаарах нь зүйтэй.

Давуу тал

- Сурах бичгийн агуулага цөм хөтөлбөрийн дагуу боловсруулагдсан.
- Анги хоорондын болон хичээл, сэдэв хоорондын залгамж холбоо алдагдаагүй.
- Сурах бичгүүдийн бүтэцийн элементийн хувьд / 22,15,16,16, / агуулагын хүрээнд ойролцоо тоотой боловсруулагдсан.
- Сурах бичиг бүхэлдээ сурагчид номын зураг хараад л шууд буюу сонгож зурах, гүйцээж зурах, номын тэмдэг тэмдэглэгээний дагуу ажиллахаар боловсруулагдсан.
- Нийт номын зургийн сонголтыг гадны орны адил сурах бичгийн туршлагыг үр ашигтай судлаж сайн хийсэн, тэгэхдээ янз бүрийн насны хүүхдүүдийн зурсан бүтээлүүдийг ашигласан нь номын боловсруулалтын нэг давуу тал.
- Технологийн хичээлийн сурах бичиг нь дүрслэх урлагаар суурилсан анхны сурах бичиг юм. Технологийн үйл ажиллагааг дүрслэх урлагийн арга аргачлалаар цаасаар нугалаж элдэв дүрс үүсгэх, геометрийн дүрсүүд зурах, байгуулах, хайчилбараар өнгийн цаас ашиглан байгалын байдал, цэцэг навч, амьтаны дүрс урлах зэргээр технологийн үйл ажиллагаатнд татан оролцуулах нь илүү оновчтой хувилбар гэж үзсэн.
- Бага ангийн технологийн хичээлийн хөтөлбөрийг дүрслэх урлагт суурилан боловсруулж, уг хөтөлбөрийн дагуу сурах бичгийг боловсруулсан.
- Гадаадын орнуудын адил ангиудын сурах бичгийн агуулага аргачлалыг авч ашигласан нь хийх эдлэлүүдийн сонголтыг зөв хийхэд чухлаар нөлөөлсөн байна.

Анхаарч засвал зохих зарим асуудал

- Нийт ангиудын сурах бичгийн бичвэр бүхэлдээ сурах бичигт тавигдах шаардлагыг хангаагүй. Зурагт үзүүлсэн зургийн агуулгыг тайлбарлахаар хязгаарлагдсан.
- Нийт ангиудын дасгал, даалгавруудын өгөгдлийг тодорхой болгох. дидактик / жиших, харьцуулах, задлан ялгах, нэгтгэн дүгнэх/ зорилгыг хэрэгжүүлэхэд анхаарах
- Дасгал, даалгавруудад хийх эдлэлийн сонголтыг зөв хийхэд онцгой анхаарах. Даалгаврын өгөгдлийг монгол ахуй, соёлтой холбон зохистой, ач холбогдолтойгоор сайжруулан сонгох шаардлагатай. Тухайлбал: Бага ангид “Оцон шувуу” хийх дадлага ажил оруулах нь зохистой бус сонголт байна. Үүний оронд Таван хошуу мал, ишиг хурга гэх мэт амьтдаас сонгож болох.
- Шинжлэх ухааны нэршил, нэр томъёо дээр анхаарах асуудал байна. ДУТ I ангийн сурах бичгийн 17 дугаар талын 1,33 дугаар зургийн 2-т “Хурц өнцөг үүсгэсэн зураасыг” Тахир, 1,35 дугаар зургийн 2 ”Тахир зураас үүсгэх”, 1,39,40 дүгээр зургуудад “хагас дугуй зураасуудыг” Нуман зураас гэж нэрлэсэн. Мөн ДУТII,III,IV ангиудад ийм нэршилтэй. Мөн ДУТҮI ангийн сурах бичгийн 7 дүгээр талд, мохоо өнцөг үүсгэсэн зураасыг “тахир”, хагас алхан хээ үзүүлсэн зураасыг “махир” гэхчилэн хүснэгтлэж зургаар үзүүлсэн бий. Хүснэгтэд “тэгш өнцөгт зураасыг “тахир” гэх мэт
- Технологийн хичээлийн хөтөлбөрийн агуулга нь зургийн хичээлийн шууд үргэлжлэл хэлбэртэйг анхаарах.
- Зузаан нимгэн цаас, бөс даавуу, баримлын шавартай харьцахад материалын бүтэц, онцлог шинж чанарын талаар товч боловч дурьдах
- Хайч, зүү, хуруувч, цаасны хутгатай харьцахад анхаарах хөдөлмөр хамгааллын асуудалыг зайлшгүй дурьдах.

ДИЗАЙН ТЕХНОЛОГИ

СУРАХ БИЧГИЙН АГУУЛГАД ТАВИХ ШААРДЛАГАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН.

Хүснэгт 1. Суралцахуйн зорилтыг (агуулга) боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэв хоорондын залгамж холбоотой боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн.


Сурах бичиг	Анги хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн ангийн бүлэг сэдвийн залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн бүлгийн сэдэв хоорондын залгамж холбоо, эрэмбэ дараалал
Дизайн технологи (VI-XII)	3	3	3

Анги, бүлэг, сэдэв хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дарааллын шаардлагыг хангасан байна.

Хүснэгт 2. Тодорхой мэдлэгт суралцахаар боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн

Сурах бичгийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Мэдлэгийн төрөл				
		Баримтын мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Метокөгнитив мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо
Дизайн технологи	140	23/16%	43/31%	43/31%	24/17%	7/5%

График1. Тодорхой мэдлэгт суралцахаар боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн



31 хувь нь ухагдахууны болон үйлийн, 17 хувь нь ахуйн, 16 хувь нь баримтын, 5 хувь нь метакогнитив мэдлэгийг эзэмшүүлэхээр агуулгын шийдэл хийсэн байна.

Хүснэгт 3. Хандлага (ёс суртахууны хүмүүжил төлөвшүүлэх)-ын шинжилгээний дүн

Сурах бичгийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Суралцах ёс суртахууны хүмүүжил төлөвшил				
		Хамтарч ажиллах сэдвийн тоо	Байгаль орчноо хайрлах хамгаалах сэдвийн тоо	Өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хөгжүүлэх сэдвийн тоо	Өөрийгөө хүмүүжүүлэх сэдвийн тоо	Ёс суртахууны төлөвшил эзэмшүүлэх сэдвийн тоо
Дизайн технологи (VI-XI)	139	34/24%	19/14%	51/37%	33/24%	2/1%

Агуулгын 37 хувь нь өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хөгжүүлэх, 24 хувь нь хамтарч ажиллах болон өөрийгөө хүмүүжүүлэх, 14 хувь нь байгаль орчноо хайрлах хамгаалах, 1 хувь нь ёс суртахууныг төлөвшүүлэх дидактик шийдлийг хийсэн байна.

Хүснэгт 4. Сэдэлжүүлэлт, Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг сурах бичигт тусгасан талаарх шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1	
	Сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, жишээ баримттай бичвэр, дасгал, даалгавар, туршилт ажил, дадлага ажлыг сурах бичигт оруулсан эсэх	Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг сурах бичигт тусгасан эсэх
Дизайн технологи (VI-XI)	3	2

Сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, жишээ баримттай бичвэр, дасгал, даалгавар, туршилт, дадлага ажлыг хангалттай оруулсан, монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг сайжруулж тусгах хэрэгтэй байна.

СУРАХ БИЧГИЙН АРГА ЗҮЙД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Хүснэгт 1. Дасгал, даалгаврыг тодорхой мэдлэгт суралцахаар боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн.


Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Мэдлэгийн төрөл				
		Баримтын мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Метакогнитив мэдлэг эзэмшүүлэх мэдлэгийн тоо
Дизайн технологи (VI-XI)	140	23/16%	43/30%	43/31%	24/17%	7/5%

31 хувь нь үйлийн, 30 хувь нь ухагдахууны, 17 хувь нь ахуйн, 16 хувь нь баримтын, 5 хувь нь метакогнитив мэдлэгийг эзэмшүүлэхээр даалгаврын шийдэл хийгдсэн байна.

Хүснэгт 2. Дасгал, даалгаврыг тодорхой чадварт суралцахаар боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Чадварын тоо							
		Ойлгох чадвар тоо				Хэрэглэх чадварын тоо	Задлан шижлэх чадварын тоо	Бүтээх чадварын тоо	Метакогнитив
		Ангилал	Жишиж харьцуулах	Жишээгээр тайлбарлах	Дүгнэлт гаргах				
Дизайн технологи (VI-XI)	409	54/13%	72/17%	73/18%	44/11%	69/17%	38/9%	52/13%	7/2%

График 1. Дасгал, даалгаврыг тодорхой чадварт суралцахаар боловсруулсан байдал хийсэн шинжилгээний дүн.



18 хувь нь жишээгээр тайлбарлах, 17 хувь нь жишиж харьцуулах болон хэрэглэх, 13 хувь нь бүтээх, 9 хувь нь задлан шинжлэх, 3 хувь нь ангилах 2 хувь нь дүгнэх чадварыг дэмжсэн аргазүйн шийдэлтэй байна.

Хүснэгт 3. Даалгаврын хүндрэл, хариултын хувилбарт хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Даалгаврын хүндрэлийн түвшний тоо		Даалгаврын хариултын хувилбарын тоо		
		Хөнгөн	Хүнд	Нээлттэй хариулт	Хаалттай хариулт	Олон сонголттой
Дизайн технологи (VI-XI)	409	237/57.9	172/42.1%	246/60.1	48/11.8%	115/28.1%

Нийт даалгаврын 57.9 хувь нь хөнгөн, 42.1 хувь нь хүнд; 60.1 хувь нь нээлттэй, 28.1 хувь нь олон сонголттой, 11.8 хувь нь хаалттай хэлбэрийн хариулттай боловсруулсан байна.

Хүснэгт 4. Даалгаврын контекст, сурах арга барилд хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Контекстийн хэлбэр /тоо			Сурах арга барил			
		Шинжлэх ухаан	Зохиомол	Бодит амьдралын жишээ	Асуудал	Мэдээлэл	Шинжлэн судлах	Эрэл хайгуул
Дизайн технологи (VI-XI)	409	106/26%	154/37.6%	149/36.4%	149/37%	71/17%	77/19%	112/27%

Даалгаврын 37.6 хувь нь зохиомол, 36.4 хувь нь бодит амьдралын жишээ, 26 хувь нь шинжлэх ухааны контексттэй боловсруулсан байна. 37 хувь асуудал шийдвэрлэх, 27 хувь нь эрэл хайгуул хийх, 19 хувь нь шинжлэн судлах, 17 хувь нь мэдээлэл болосруулах арга барилыг дэмжсэн байна.

Хүснэгт 5. Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага, хэл найруулгад хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр/Анги	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1		
	Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага	Хэл найруулга	Техник
Дизайн технологи (VI-XI)	2	3	3

Тогтвортой хөгжил болон дэлхийн чиг хандлагын талаарх асуудлыг сайжруулж боловсруулах, хэл найруулга болон техникийн шаардлага хангалттай түвшинд бичигдсэн байна.

ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

”ДҮРСЛЭХ УРЛАГ” VI-VIII ангийн сурах бичгийн хувьд бие даасан сурах бичиг зохиогдсоноор өөрийн орны болон гадаад орны соёл, урлагийн ололт, амжилт, онцлог, уламжлалаас нилээд гүнзгийрсэн агуулгатай суралцах өргөн боломжтой болсон.

Давуу тал

- Сурах бичгийн агуулга, Дүрслэх урлагийн хэл, Урлан бүтээх, Соёлын үнэт зүйл гэсэн 3 бүлгээр боловсруулагдсан нь агуулга цөм хөтөлбөрийнхөө дагуу боловсруулагдсан,
- Сурах бичигт Соёлын үнэт зүйл гэсэн маш чухал бүлэг бие даан орсон нь өөрийн орны болон гадаад орны соёл, урлагийн ололт, амжилт онцлог, уламжлалаас суралцах өргөн боломж олгосон,
- VI ангийн дасгал даалгавар бусад ангиудаасаа арай илүү тодорхой /зургийн бүтэцийг ажигла, өнгийн дагнаасыг 3 шатлалаар гарга гэх мэт/ болсон.
- Дасгал, даалгавруудыг “сонирхон судлах”, /дасгал/, “Илэрхийлэн харьцах”
- “Бүтээн хөгжих” /Дадлага ажил/ гэсэн тэмдэг, тэмдэглэгээнүүд нь сурагчдыг бие даан сурах бичигтэй харьцахад нь чиглэгдсэн.

Анхаарч засвал зохих зарим асуудал:

- Сурах бичгийн бичвэрийг тодорхой мэдлэг олгох агуулгад чиглүүлэн боловсруулах,
- Дасгал, даалгавруудыг тодорхой болгон, хүүхдийг сурах бичигтэй ажиллуулах тэмдэг, тэмдэглэгээнээс ялган “Дасгал”, “Даалгавар” гэсэн нэршлээр нь оруулах,
- Сурагчдын сонирхолыг татсан, мэдэлжүүлэх дасгал даалгаварыг ялгаж, бие даасан судалбарууд нэлээдийг хийх
- Монголын уламжлалт өнгийн нэршлийг VI ангид оруулж, Эцэг өнгө, Эх, Хүү өнгөнүүдийн тухай дурьдаад, сурагчдаар Эцэг өнгөөс /тэр нь 7 өнгө/ эх өнгө дээр хүү өнгөнүүдийн дагнаас гаргах даалгавар өгсөн нь бодож үзэх асуудал юм. /Энэ бол эртний монголчуудын өндөр түвшний урчуудын нарийвчилсан дагнаас хийдэг өндөр түвшний аргачлал юм.
- Технологи хэсэг дизайны үндсэн ойлголтоор эхлэж, гурвалжин, тэгш өнцөгт, тойрог зэрэг геометрийн элементүүд орж эхлэж байгааг анхаарч үзэж сайжруулах хэрэгтэй.

ДИЗАЙН ТЕХНОЛОГИ VI-IX ангийн сурах бичгийн хувьд шинэ нэр томъёололд орж дизайны ухагдахууныг бие даасан хэрэглэгдэхүүн болгосноороо онцлог юм. VI ангиас Дизайны үндсэн ойлголтыг оруулсан.

“Дизайн” гэдэг нь хүний гараар болон үйлдвэрлэлийн аргаар бүтээгддэг бүх бүтээгдэхүүний гоо сайханы асуудал юм. Гоо сайхны асуудал байгаль дэлхийгээс эхлээд бодит биет /амьтай, амьгүй/-д байдаг, байсаар байсан нийтлэг ойлголт юм. Дэлхий нийтийн хөгжлийн дагуу “ДИЗАЙН” биеэ даасан /нийгмийн салбар бүрд адилхан/ Шинжлэх ухааны салбар болон хөгжиж байна.

Давуу тал

- Суурь боловсролын шатанд энэхүү хичээл бие даан орох болсоноор сурагчдын анхаарал, сонирхолыг татсан нэг чухал сургалтын хөдөлгүүр болох болсон юм.
- VI ангиас эхлээд дизайны /хамгийн зөв зохимжтой/ үүднээс геометрийн биетүүдийг /хурц өнцөгт, тэгш өнцөгт, мохоо өнцөгт, тойрог, дугуй г.м./ үздэг байсан “байгуулалтын аргыг” дизайны үүднээс аль байрлалаар авбал илүү аятай болох асуудлаар сольсон нь сурагчдын сайханы төлөөх мэдлэгийн бүтэц нь биетийн проекцлолыг “хэлбэрийн” аргаар ойлгох боломж руу шилжиж илүү сонирхол, сэдэл тэмүүлэлийг суралцагчдад төрүүлэх болсон,
- VI-VIII ангийн Дизайн Технологи хичээлийн сурах бичгүүд бүгд адилхан Мэдлэг, Дасгал, даалгавар, Туршилт, Нэмж судлах зүйл, Асуулт, санамж гэсэн тусгай тэмдэг, тэмдэглэгээнүүд гэсэн бүтэцтэй боловсруулагдсан байна.

Анхаарч засвал зохих зарим асуудал:

- VI ангийн сурах бичгийн эхний “Дизайн, Зураг зүй” бүлгийн Дизайны тухай ойлголтыг тодруулах, Чимэглэлийн дизайн гэсэн бүхэллэг бус, салангад ойлголтуудаас Хэрчим, Тойргийн нум, Зөв олон мөнцөгт зурах гэсэн хичээлийн сэдвүүдээр агуулгыг товчлосныг эргэж харах шаардлагатай,
- Дасгал, даалгавруудыг суралцагчдын сэдэл тэмүүлэлийг хөтлөх хэмжээнд тодорхой зорилгого чиглэлтэй боловсруулах шаардлагатай байсаар байна.
- Суурь боловсролын Дизайн Технологи хичээлийн агуулага, хөтөлбөрийг нэгдсэн агуулгаар шинэчлэн боловсруулбал зохилтой.
- Дээрхи Диизайн, Зураг зүй, Технологийн нийтлэг ба ялгаатай талыг хөтөлбөрийн агуулгад маш тодорхой гаргаж нэг бүхэл зүйлийн 3 тал болохыг тодруулах шаардлагатай.
- **ДИЗАЙН ЗУРАГ ЗҮЙ, ТЕХНОЛОГИ X-XI** сурах бичгийн хувьд Дизайн зураг зүйн байгуулалтын төвөгтэй аргачлалыг хөнгөвчилж, суралцагчдад сурацахад хялбар болсон хийгээд технологид нэвтрүүлэн, хэрэглээнд ашиглах боломжтой болсон давуу талтай байна. Технологи IX ангиас эхлээд техникийн механик дамжуулгын зориулалтуудыг, X ангиас хөдөлгөөнт холболт тэдгээрийн тооцоолол, XI ангиас автомат ажиллагаатай механизмуудыг тус тус хийж Зохион бүтээх хөтөлбөрөөр сурах бичиг боловсруулагдсан байна.
- Дизайн зураг зүй, Технологийн хичээл нь ахуйн хэрэглээний болон үйлдвэр техникийн салбарын эд зүйлс, материал, багаж хэрэгслэл тэдгээртэй харьцах, ашиглах зэрэг бүх талаараа амьдралын үйл ажиллагаатай, нөгөө талаараа зориулагдсан бөгөөд үйл үйлдэлд суурилагдсан сургалт юм.
- Технологийн сургалт нь VI ангиас эхлэн үйл ажиллагааны технологид үндэслэгдсэн сургалтын технологид бүрэн шилжсэн бөгөөд
- Дээрх ангиудын сурах бичиг нь төслийн сургалтын арга зүйгээ сургалтын зорилгын дагуу 5-6 танин мэдэхүйн шатлал бүхий /сэдвээ хэлэлцэж сонгох, материалаа сонгох, зургаа гаргах, арга зүйгээ ярилцах, технологио тодорхойлох, багаж хэрэгслэлээ сонгох г.м/ хамтын шийдвэрээр төслийн ажлыг гүйцэтгэх тул суралцагч нэг бүрд танин мэдэхүйн чадвар хэрэглэдэгээрээ давуу, үр дүнд суурилсан сургалт болох юм.

Анхаарч засмаар зарим асуудал:

- Ахлах ангиудын сургалтын хөтөлбөрийг шинээр дэвшүүлэн хэрэгжүүлж эхлээд байгаа бодлогын хөтөлбөрөө туршин сайжруулах, /МУБИС /
- Дасгал, даалгаврыг өөрийнх нь нэршлээр тодорхой зорилого, зориулалттай болгох,
- Сурагчдыг сэдэлжүүлэх, агуулгатай ажлыг нэмэгдүүлэх,
- Суралцагчдаас техник,тоног төхөөрөмж, багаж хэрэгслэлтэй харьцан ажиллахад илүү их их арга ухаан байнга шаардаж байх дасгал даалгаврын тоог нэмэгдүүлэх,
- Ухагдахуун, онол, хууль, зарчим, нэр томъёог энгийн өгүүлбэрээр болон зураг, эдлэлтэй хамтатгасан үйл, үйлдлийн онол арга зүйн үүднээс нэгтгэсэн дүгнэлт үгүйлэгдэж байна.
- X ангийн хөтөлбөрийн суралцахуйн зорилт хөдөлгөөнтэй холбогдсон эд ангийн судалгааг явуулахад чиглэгдсэнээрээ бусад ангиудаас ялгаатай байгааг дахин нарийвчилж сайжруулах,
- XI ангийн хөтөлбөрийн суралцахуйн зорилт автомат ажиллагаатай эгэл машин, техник хэрэгслэл зохион бүтээхэд чиглэгдсэн байна.

Ахлах шатны /IX–XI/ ангийн Дизайн Технологийн сурах бичгүүдийн суралцагчдад төлөвшүүлэх хандлага, сурагчдын сонирхолыг татах, сэдэлжүүлэх агуулгатай ажлууд, ухагдахуун хууль, зарчим, нэр томъёоны хэрэглээ гэх зэрэг шалгуур үзүүлэлтүүд, хичээлд оролцсон сурагч нэг бүрд зохих хэмжээгээр үйлчлэл үзүүлсэн гэдэгт эргэлзэхгүй байна.

Бага, дунд, ахлах шатны бүгдийнх нь сурах бичгийн бичвэр сурах бичигт тавигдах шаардлагыг бүрэн хангаагүй, анги бүрийн хөтөлбөрийн онол арга зүйн шаардлагад тэр бүр нийцээгүй, сурах бичгийн бүтэц хэлбэрийг механикаар хэлбэрдсэн байдал сурах бичигт бичигдчихсэн байгааг дурдах байна.

Дүрслэх урлаг, Технологийн хичээлийн шинжилгээний шалгуур асуултуудад бүрэн хариулт өгсөн байгаа нь мэдлэгийн когнитив бүтцийн, суралцах үйл ажиллагааны хувьд урьдчилсан нөхцөл болдогийн үр дүн гэж үзэж болох юм.

МУБИС-ийн Дүрслэх урлаг технологийн сургууль нь сүүлийн жилүүдэд лабораторийн шинэчлэл хийх, электроникийн микро схемээр ажиллах жижиг хөдөлгөөнт техник, робот, цахим эд ангиудыг ашиглах мэдлэг чадвар олгох, цаг үетэйгээ нийцсэн урлаг дизайн технологийн сайн багш бэлтгэхээр зорин ажиллах бодлогыг баримтлаж боловсон хүчнээ бэлтгээд эхэлсэн байна.

ХӨГЖИМ

СУРАХ БИЧГИЙН АГУУЛГАД ТАВИХ ШААРДЛАГАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН.

Хүснэгт 1. Суралцахуйн зорилтыг (агуулга) боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэв хоорондын залгамж холбоотой боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн.


	Сурах бичиг	Анги хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн ангийн бүлэг сэдвийн залгамж холбоо, эрэмбэ дараалал	Тухайн бүлгийн сэдэв хоорондын залгамж холбоо, эрэмбэ дараалал
1	Хөгжим (I-IX)	3	3	3

Анги, бүлэг, сэдэв хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал, хөтөлбөрийн дагуу боловсруулсан байна.

Хүснэгт 2. Тодорхой мэдлэгт суралцахаар боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн

	Сурах бичгийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Мэдлэгийн төрөл				
			Баримтын мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Метакогнитив мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо
1	Хөгжим	512	49/9%	139/27%	242/46%	53/10	39 /8%

График 1 Тодорхой мэдлэгт суралцахаар боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн



46 хувь нь үйлийн, 27 хувь нь ухагдахуун, 10 хувь нь ахуйн, 9 хувь нь баримтын, 8 хувь нь метакогнитив мэдлэг эзэмшүүлэхээр агуулгын сонголт хийгдсэн байна (анги тус бүрийн дэлгэрэнгүй анализыг эх тайланд хавсаргав).

Хүснэгт 3. Хандлага (ёс суртахууны хүмүүжил төлөвшил)-ын шинжилгээний дүн

	Сурах бичгийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Суралцах ёс суртахууны хүмүүжил төлөвшил)				
			Хамтарч ажиллах сэдвийн тоо	Байгаль орчноо хайрлах хамгаалах сэдвийн тоо	Өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хөгжүүлэх сэдвийн тоо	Өөрийгөө хүмүүжүүлэх сэдвийн тоо	Ёс суртахууны төлөвшил эзэмшүүлэх сэдвийн тоо
	Хөгжим	523	129/25%	101/19%	202/38%	14/3%	77/15%

38 хувь нь өөрийгөө танин мэдэх, 25 хувь нь хамтран ажиллах, 19 хувь нь байгаль орчноо хамгаалах, 15 хувь нь ёс суртахууны хандлага төлөвшүүлэх шийдэл хийжээ.

Хүснэгт 4. Сэдэлжүүлэлт, Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг сурах бичигт тусгасан талаарх шинжилгээний дүн.

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1	
	Сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, жишээ баримттай бичвэр, дасгал, даалгавар, туршилт ажил, дадлага ажлыг сурах бичигт оруулсан эсэх	Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг сурах бичигт тусгасан эсэх
Хөгжим	3	1


Сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, жишээ баримттай бичвэр, дасгал, даалгавар, туршилт, дадлага ажлаар сэдэлжүүлэлт хангалтгүй, монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг сайжруулж тусгах хэрэгтэй байна.

СУРАХ БИЧГИЙН АРГА ЗҮЙД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Хүснэгт 1. Дасгал, даалгаврыг тодорхой мэдлэгт суралцахаар боловсруулсан байдал хийсэн шинжилгээний дүн.

Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Мэдлэгийн төрөл				
		Баримтын мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Үйлийн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Ахуйн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Метакогнитив мэдлэг эзэмшүүлэх мэдлэгийн тоо
Хөгжим	723	11/0	269/38%	382/54%	15/3%	35/5%

График 1. Дасгал, даалгаврыг тодорхой мэдлэгт суралцахаар боловсруулсан байдал хийсэн шинжилгээний дүн.




54 хувь нь үйлийн, 38 хувь нь ухагдахууны, 5 хувь нь метакогнитив, 2 хувь нь ахуйн, 1 хувь нь баримтын мэдлэгийн хэлбэрийг дэмжсэн байна (анги тус бүрийн дэлгэрэнгүй анализыг эх тайланд хавсаргав).

Хүснэгт 2. Дасгал, даалгаврыг тодорхой чадварт суралцахаар боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн.

	Сурах бичгийн нэр	чадварын тоо							
		Ойлгох чадвар тоо				Хэрэглэх чадварын тоо	Задлан шижлэх чадварын тоо	Бүтээх чадварын тоо	Метакогнитив
		Ангилах	Жишиж харьцуулах	Жишээгээр тайлбарла	Дүгнэлт гаргах				
1	Хөгжим	101/14%	80/11%	21/3%	50/7%	60/8%	55/7%	337/46%	26/4%

График 2. Дасгал, даалгаврыг тодорхой чадварт суралцахаар боловсруулсан байдалд хийсэн шинжилгээний дүн.



46 хувь нь бүтээх, 14 хувь ангилах, 11 хувь нь жишиж харьцуулах, 7-8 хувь нь дүгнэлт гаргах, анализ хийх, хэрэглэх, 3-4 хувь нь метакогнитив, жишээгээр тайлбарлах чадварыг дэмжсэн байна (анги тус бүрийн дэлгэрэнгүй анализыг эх тайланд хавсаргав).

Хүснэгт 3. Даалгаврын хүндрэл, хариултын хувилбарт хийсэн шинжилгээний дүн.


Сурах бичгийн нэр	Сурах бичиг бүрийн даалгаврын тоо	Даалгаврын хүндрэлийн түвшний тоо		Даалгаврын хариултын хувилбарын тоо		
		Хөнгөн	Хүнд	Нээлттэй хариулт	Хаалттай хариулт	Олон сонголттой
Хөгжим	723	210/29%	513/71%	469/64.8%	34/4.8%	220/30.4%

29 хувь нь хөнгөн, 71 хувь нь хүнд даалгавар байгаа нь хөтөлбөрийн үнэлгээний зорилтын жинд харуулж байна.

Хүснэгт 4. Даалгаврын контекст, сурах арга барилд хийсэн шинжилгээний дүн.


Сурах бичгийн нэр	Контекстийн хэлбэр /тоо			Сурах арга барил			
	Шинжлэх ухаан	Зохиомол	Бодит амьдралын жишээ	Асуудал	Мэдээлэл	Шинжлэн судлах	Эрэл хайгуул
Хөгжим	422/58.3%	189/26.1%	112/15.6%	97/13%	123/17%	344/48%	159/22%

График 3. Даалгаврын контекстийн шинжилгээний дүн.



Даалгаврын 58 хувь нь шинжлэх ухааны, 16 хувийг ахуйн, 26 хувь нь зохиомол даалгаврууд эзэлж байна.

График 4. Даалгаврын арга барилд хийсэн шинжилгээний дүн.



48 хувь нь шинжлэн судлах, 22 хувь нь эрэл хайгуул, 17 хувь нь мэдээлэл боловсруулах, 13 хувь нь асуудал шийдвэрлэх арга барилыг дэмжсэн даалгаврууд байна.

Хүснэгт 5. Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага, хэл найруулга болон техникийн шаардлагад хийсэн шинжилгээний дүн

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Үнэлгээ : хангалттай-3, сайжруулах -2, хангалтгүй -1		
	Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага	Хэл найруулга	Техник
Хөгжим	3	3	3

Тогтвортой хөгжил, дэлхийн чиг хандлага, хэл найруулга болон техникийн шаардлага хангалттай түвшинд бичигдсэн байна.

ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

Бага боловсрол

Бага боловсролын сурах бичигт хийсэн шинжилгээний дүнгийн зарим зүйлээс онцлон дурдвал:

1. I-V ангийн сурах бичгийн бүтцийн элементүүд хангалттай сайн бөгөөд ай, бүлэг сэдэв нь дэд бүлэгтэйгээ холбогдож, нэгж сэдэв, дэд сэдвийн тоо, сэдвийн агуулга, гарчиг зэрэг нь суралцахуйн зорилттойгоо залгамж холбоотой байна.
2. Таван бүлэгт суралцахуйн зорилтод үндэслэн (агуулга) боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэв хоорондын залгамж холбоо хангалттай сайн боловсруулсан.
3. Нийт даалгаврын 72.6 хувь нь хүнд, 27.4 хувь нь хөнгөн байна. Энэ дүнгээс хархад бага боловсролын хөгжмийн хичээлийн сурах бичигт орсон дасгал даалгаврууд сурагчдын нас, сэтгэхүйн онцлогт хүндэвтэр байна.
4. Агуулга нь хялбар уншигдахаар бичигдсэн байдалд шинжилгээ хийхэд 70.8 хувь нь 5-10 үгэнд багтсан хялбар уншигдахаар бичигдсэн байна. Харин 29.2 хувь нь дээрх шаардлагуудыг хангаагүй байна.
5. Бага боловсролын сурах бичигт үндэсний уламжлалт урлагийн төрлөөс цөөн тусгагдсан байна.
6. Сурах бичигт агуулга, арга зүйн олон сайхан шинэлэг зүйлүүд их байна. Жишээлбэл:
 - Сурах бичгийн агуулга нь хөтөлбөрийн суралцахуйн зорилттойгоо нийцсэн
 - Бага боловсролын хөгжмийн хичээлээр 5 чадвар эзэмших бөгөөд, чадварууд нь сэдэвтэйгээ залгамж холбоотой байна.
 - Бишгүүр хөгжим сурах явцад хөгжмийн онолыг ахиулан судлах боломжтой болсон.
 - Сурагчдын уран сайхны сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор утга санааг бүжгийн хөдөлгөөн, дуу хөгжмийн ая эгшгээр илэрхийлэх чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн.
 - Зураг дизайн, дасгал даалгаврууд, сонсох хөгжим, бүжгийн сонголтууд нь тэдний нас сэтгэхүүд тохирсон.
 - Төрийн дуулал болон эх орны сэдэвт дуу хөгжмөөр тэдний Эх оронч үзэлтэй болгон төлөвшүүлэх.
 - Хөгжмийн онолын анхан шатны мэдэгдхүүнийг судлаж хэрэглээнд оруулж байгаа зэрэг сайн талтай боловч сайжруулах зүйл олон байна.

Сурах бичигт цаашид анхаарах засан сайжруулах зүйлс:

- Дасгал даалгавар болон дууны үг, хөгжмийн онолын нэр томъёо, тэмдэг тэмдэглэгээг буруу бичсэн нь бүх ангиудад давтагдсан.
- Дуу, хөгжмийн урын сангийн сонголт нь цөөн тооны хөгжмийн зохиолчдын бүтээл байсан.
- Нэг утга сэдэвтэй дууны бүтээл олон байсан. Жишээлбэл: Шинэ жилийн холбогдолтой дуу

- Хөгжмийн нэр томъёог гадаад нэрээр бичихдээ монголоор тайлбар бичээгүй.
- Хоёр ба түүнээс дээш хөгжмийн зэмсгээр тоглохыг хоёр хоолойгоор гэж бичсэн нь буруу
- Бүх сурах бичгийн гарчигт зохиогчийн нэр бичигдээгүй байсан.
- Сурах бичиг сонсох хөгжим хоёр нь тусдаа салангид байгаа.
- Сурагчдад CD-г тоглуулах хүндрэлтэй.
- Даалгавар , дасгалын нэрийг зохиогчийн хамт бичих.
- Дууны үгийн мөрийг том үсгээр бичих ба үгийн хуваарийг үеэр зөв таслан бичих зэрэг нийтлэг алдаа олон байгаа бөгөөд анги бүрийн дүгнэлтийн хүснэгтээс харж болно.

Мөн шинжилгээ судалгаа хийх явцад зарим асуулгад хариулт өгөхөд ойлгомжгүй бэрхшээлтэй зүйл байлаа. Үүнийг дурдвал:

Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг сурах бичигт тусгасан эсэх сэдэвт шинжилгээ хийхэд зарим асуулгад хариулт бэрхшээлтэй байлаа. Энэ сэдвийн асуултыг монгочуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйлийг тэмдэглэсэн эрдэнийн судрыг дээдлэн залах тухай Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг гарсаны дагуу боловсруулах санал оруулж байна. Зарлигийн бичвэрийг хавсралтаар оруулав.

Суурь боловсрол

Давуу тал

- Сурах бичгийн агуулга нь хөтөлбөрийн суралцахуйн зорилттойгоо нийцсэн
- Бага ангид судалсан 5 чадвараас дуулья, хөгжимдье, өөрийгөө сориорой залгамж холбоотой хадгалагджээ.
- Гитар хөгжим сурахад хөгжмийн онолын мэдлэг гүнзгийрэх боломжтой болсон
- Сурагчид дэлхийн сонгодог болон үндэсний хөгжмийн зохиолчдын бүтээсэн дуурь, симфони, бүжгэн жүжгийн сор болсон бүтээлүүдтэй танилцах, сонсох чадварт сурахад чиглэсэн
- Хөгжим сонсох цаг, сонсголын сорил, мэдлэг сорих асуулгаар өөрийн мэдлэгээ сорих сонголтууд нь тэдний нас сэтгэхүйд тохирсон

Сул тал:

- Дууны ноотны лигато, шүлгийн буруу бичих байдал давтагдсан
- “Төрийн дуулал”-ын лигатог буруу бичсэн
- Дуурь, симфони, бүжгэн жүжгийн 18 сэдвийн 6 нь монголын хөгжмийн зохиолчдын бүтээл байна
- Гитараар хөгжимдөх 6 хөгжмийн зөвхөн 1 монголынх бусад нь гадаадынх байна.
- Монгол үндэстний бүтээсэн Юнеско-гийн Хүн төрөлхтөний төлөөлийн соёлын биет болон биет бус өвд бүртгэгдсэн хөгжмийн өв уламжлал болон орчин цагийн хөгжмийн зохиолчдын бүтээлийг ядахдаа 51 хувь оруулах
- Аялгуут жүжгийг Саран хөхөөний намтараас эхэлсэн гээд түүнээс өмнө Монгол хаадын ордонд аялгуут жүжиг байгаагүй мэтээр бичсэн.

Боломж

- Хөгжмийн том хэлбэрийн бүтээлийг судалж сэдэв агуулга нь гүнзгийрч байгаа ч суралцагчдад дуурь, симфони, бүжгэн жүжгийг биеэр очиж үзэх, сонсох орчин хараахан бүрдээгүй учир, түүнийг орлуулах оновчтой хялбаршуулсан хэлбэрийг сонгох
- Хүн бүхний мэдэх дэлхийд алдартай хүүхэлдэйн кинонд ашигласан П. И. Чайковскийн “Хунт нуур”, В. А. Моцартын зарим хөгжмөөр дамжуулан суралцагчдад сонгодог хөгжмийн боловсрол олгох
- Сонголын сорил, мэдлэг сорих асуулга нь боломжтой
- Суралцагчдад дан ганц гитарыг тулгах биш өөрт нь байгаа бусад хөгжмийн зэмсэг сонгох боломж бүрдүүлэх
- Сурах бичигт тусгагдсан гитар, бишгүүр зэрэг хөгжмийн зэмсгийг суралцагчдад тулгахгүй, албадахгүй сонголт олгодог боломж бүрдүүлэх

Сайжруулах санал:

- Дуурь, симфони, бүжгэн жүжгийн 18 сэдвийн 50-аас дээш хувийг үндэсний хөгжмийн зохиолчдын бүтээлээс оруулах
 - Гитараар хөгжимдөх 6 хөгжмийн бүтээлийн англи болон франц ардын дууны оронд монголын рок попынхны гитараар хөгжимддөг нийтэд түгсэн бүтээлээс сонгож оруулах
 - Монгол үндэстний бүтээсэн Юнеско-гийн Хүн төрөлхтөний төлөөлийн соёлын биет болон биет бус өвд бүртгүүлсэн уртын дуу, цуур, хөөмэй, морин хуур, монгол лимбэний битүү амьсгаа, бий биелгээг хичээлийн хөтөлбөрт оруулах
 - Эртний Хүннүгээс эхлүүлээд Монгол хаадын ордонд үүсгэж байсан аялгуут жүжгийн тухай оруулах
 - Дууны ноотны лигато-г зөв болгож засах
 - Дууны шүлэг, ноотноос хоцорч зөрж бичсэнийг зөв болгох
- Өгүүлбэрт оногдох үгийн тоог нас сэтгэхүйд тохируулан бичих

Сурах бичгийн арга зүй

Давуу тал

- Гитарыг хөгжимдөх чадварт таб-табулятор болон ноот бичлэгийг хослуулан суралцах аргыг хэрэглэсэн
- Суралцагчдын хөгжмийн ой тогтоолтыг сайжруулах чадварыг хөгжүүлэх зорилгоор сонголын сорил хийдэг болсон
- Дэлхийн сонгодог дуурь, симфони, бүжгийн жүжгийн тухай мэдэх
- Дуурь, симфони, бүжгийн жүжгийн хөгжим бүтээдэг үндэсний хөгжмийн зохиолчид, тэдний бүтээлтэй танилцах
- Дууляа бүлэгт Жаргалын зам дуурийн Халиуны ари, Ф. Шубертын Форель, П.И. Чайковскийн Неаполитан дуу, тэрчлэн монгол ардын дууны найрал дууны

найруулга зэрэг хүндрүүлсэн дуу орсон нь өмнөх ангитайгаа залгамж холбоо сайн байна.

- Анги хамт олноороо ардын дууны найрал дууг дуулах, боломжтой

Сул тал

- Сурагчдын мэдлэгийн хүрээг хөгжүүлэх зорилгоор хичээлээс гадуур уншиж судлах боломжтой хөгжмийн зохиолчдын түүх, намтар зэрэг ном сурах бичиг үгүүлэгдэж байна.
- Бүжиглэх чадвар хасагдсан нь суралцагчид хөгжмийн утга санааг биеийн хөдөлгөөнөөр илэрхийлэх, биеэ зөв авч явах чадварыг хөгжүүлэхэд муу үр дүн үзүүлж байна.
- Хүүхдийн бүтээлч сэтгэхүй, сэтгэн бодох үйл ажиллагааг хөгжүүлэх зохион найруулах арга зүй багассан.
- Суралцагсадыг өөрт байгаа хөгжмөө бие даан цахимаар суралцах боломжийг бий болгох

Сайжруулах санал:

- Сурагчдыг дуурь, симфони, бүжгэн жүжгийн хөгжимд дур сонирхолтой болгоход чиглэсэн сонирхолыг өрнүүлэх арга хэрэглэх. Тухайлбал орчин цагийн хэмнэлд оруулсан рок симфони, рок бүжгэн жүжиг, поп симфони зэргийг сонгох
- Бүлэг сэдвийн болон асуулт, даалгаврын үгийн тоог цөөлж оновчтой болгох
- Найрал дуу болон гитар хөгжимд суралцах цагийг хэрхэн яаж зохицуулж байгааг тодорхой болгох. Гитар хөгжимд суралцах хүүхэд бүрийн авьяас чадвар харилцан адилгүй учир сургалтын тэгш бус байдлыг хэрхэн зохицуулах, ганцаарчилсан хэлбэрээр буюу бүлэг хэсгээр зохион байгуулах зэргийг ойлгомжтой болгох
- Дууны үгийг зөв бичих
- Сэдвийн агуулга нь 15-аас дээш үгтэй бөгөөд сайжруулах шаардлагатай.8-р ангид
- 8 дүгээр хуудсанд найрал дуу нь (хор) хэмээжээ. Үүнийг тайлбарлах
- 11 дүгээр хуудсанд дуугүй дүрүүдээ бүтээдэг гэжээ.
- 26 дугаар талд тэмдэглэгдсэн кастаньет хөгжмийн зэмсгийг Хөгжим I -ийн 15 дугаар талд товшвор хэмээн нэрлэсэн байна.
- 27 дүгээр хуудсанд нэг өгүүлбэрт регистрт, форшлаг, трелээр гэсэн 3 орос үг оржээ.
- 36 дугаар хуудсанд там-там нэмэгдэн орж ирнэ гэдгийг суралцагчид там хэмээн ойлгох учраас тайлбар хийх.
- 45-р хуудсандТокката-г токатта хэмээжээ
- 46 дугаар хуудсанд Шекспирийн зохиолоос сэдэвлэгдэн эмгэнэлт сэдэв хэмээсэн нь утгын хувьд алдаатай байна.
- 51дүгээр хуудсанд Эх орон танаа дууны шүлгийг алдаатай бичжээ.
- IX ангид Орчин үеийн хөгжмийн урлаг 71, 72, 73, 74, 75, 76, 77, 78, 80, 81, 82, 83, 84, 85, 86, 87, 88,

- Монголын орчин үеийн хөгжим 90, 91, 92, 93, 94, 96, 97, Эстрад хөгжим 98, 99, 100, 102, 103, 106, 107, 108, Дуулья – 116, Хөгжимдье – 123, 128 хуудсуудад алдаа байна

Сайжруулах санал

- Өгүүлбэрийг товч бөгөөд тодорхой цөөн үгтэй байх
- Үг найруулгын алдаагүй байх
- 1 өгүүлбэрт олон гадаад үг оруулахгүй байх.
- Гадаад үгийг орос хэлнээс биш, цаад уг эхээс нь авч бичих
- Дууны шүлгийн мөрийг том үсгээр бичих, үеэр зөв таслах

Техник

Сул тал

- Сурах бичиг сонсох хөгжим хоёр нь тусдаа саланга байгаа
- CD-г тоглуулхад хүндрэлтэй
- гитар сурах гарын авлага, Гитарт хөрвүүлсэн монголын хөгжмийн зохиолчдын бүтээлийн урын сан бий болоогүй.

КАЗАХ ХЭЛ ДЭЭРХ СУРАХ БИЧГИЙН СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ, САЙЖРУУЛАХ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичигт дүн шинжилгээ хийж, сайжруулах санал, зөвлөмж боловсруулах энэхүү ажлын хүрээнд манай дэд баг казах хэлээрх сурах бичгүүдэд шинжилгээ үнэлгээ хийх үүрэг хүлээн, казах хэлээр гарсан нэр бүхий 36 сурах бичгийг судлан шинжилж үзсэний үндсэн дээр дараах дүгнэлт, санал зөвлөмжийг гаргаж байна.

ДҮГНЭЛТ:

Үндэсний хэмжээнд 2019 онд “Бага боловсролын сургалтын хөтөлбөр”-ийг сайжруулан гаргаж мөрдөж буй хэдий ч “Хос” хэлээр сургалт явуулдаг ЕБС-ийн эх хэлний сургалтын хөтөлбөр”-ийг 2013 оноос хойш одоо болтол шинэчлээгүй явж иржээ. Энэ нь үндэстний цөөнх казах хүүхдүүдэд эрх зүйн хувьд хүчингүй баримт бичгээр сургалт явуулж нэгдсэн бодлого, стандартаар сургалт явуулах зарчим зөрчигдөж, сурах, суралцах эрх бодитойгоор хэрэгжихгүй байгаа хэрэг юм.

Казах хэлээр сурах бичиг зохиох, үндсэн сурах бичгийг монгол хэлнээс казах хэлнээ орчуулах эрх зүйн орчин бүрдээгүй байна. Ер нь үндэстний цөөнх казах хүүхдүүдийн сургалт, сурах бичиг зэрэг олон асуудал эрх зүйн баримт бичгүүдэд тусгагдалгүй орхигдсоор олон жилийн нүүр үзсэн байна. Тухайлбал, 2008 онд гаргасан хэвлэмэл сурах бичгийн стандарт, “Сурах бичиг зохиох, хэвлэх, түгээх журам” зэрэг эрхзүйн актуудад энэ асуудлыг зохицуулсан ямар нэгэн заалт байхгүй. Энэ нь казах сурах бичгийн чанар чансаанд нөлөөлж байна гэсэн дүгнэлтэд хүрэв. Хос хэлээр сургалт явуулдаг Баян Өлгий аймгийн ЕБС-дад үзэх казах сурах бичгийг цаашид чанарын өндөр түвшинд боловсруулж гаргах хэрэгтэй байна.

Орчуулгын сурах бичгүүдийн хувьд: Монгол сурах бичгүүдийг шууд орчуулсан казах хэлээрх сурах бичгүүд бүхэлдээ орчуулга, хэл найруулгын хувьд боломжийн, шалгуурт өгсөн голлох үзүүлэлтүүдийг хангасан гэж үзэв. Орчуулгын сурах бичгийн агуулга, хэл, найруулгын чанарыг улам сайжруулах шаардлагатай. Төслийн удирдлагын багаас боловсруулсан арга, аргачлалын дагуу орчуулгын казах сурах бичигт шинжилгээ хийж үзээд, монгол сурах бичгийн зохиогчдын баг цаашид сурах бичгийн агуулга, арга зүйгээ шинэчлэн сайжруулах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн болно.

Казах хэлээр зохиосон сурах бичгийн хувьд: Цаашид казах хэлээр гарах сурах бичгийг нэгдсэн бодлогоор зохицуулах, чадварлаг мэргэжлийн баг бүрдүүлж ажиллах шаардлагатай гэж үзэж байна. Боловсролын хүрээлэнд “Үндэстний цөөнх болон гадаадад амьдарч байгаа хүүхдийн сектор” ажиллаж байгаа нь сайшаалтай хэдий ч хүн хүч, мэргэжилтэн дутмаг тул төдий л анхаарч чаддаггүй бололтой.

Ана тілі I, V сурах бичгийг санал зөвлөмжийн дагуу зохих стандартад нийцүүлэн сайжруулж, сургалтанд хэрэглэх боломжтой,

- Харин **Ана тілі II, III, IV** ангийн сурах бичгийг дахин боловсруулж, агуулгын уялдаа холбоог сайжруулж, эхийг шинэчлэн бэлтгэх шаардлагатай,
- Бага болон суурь боловсролын казах хэл, уран зохиолын сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжийг сайжруулах, шинэчлэн боловсруулах
- Сурах бичгийн агуулгыг **Казах хэл-VI, VII, VIII, IX, Уран зохиол- VI, VII, VIII, IX** гэж салган, тус тусдаа 8 сурах бичиг болгож зохиох хэрэгтэй гэж үзэж байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ:

1. Казах хэлээр сурах бичиг зохиох, үндсэн сурах бичгийг монгол хэлнээс казах хэлэнд орчуулах, хэвлэх шаардлагыг тусгайлан тогтоож сурах бичгийн нэгдсэн бодлого, стандартад тусгуулах зэргээр эрх зүйн орчинг бүрдүүлэх. Казах сурах бичиг болон орчуулгын сурах бичгийн чиглэлээр хийгдсэн судалгааны ажлуудын дүнг нэгтгэж, эрх зүйн орчин бүрдүүлэх үндэслэл, тусгах заалт, шаардлагуудыг шинээр боловсруулах,
2. ЕБС-ийн үндэсний сургалтын хөтөлбөрийг шинэчлэхэд хос хэлээр сургалт явуулдаг сургуулиудын эх хэл, уран зохиолын хөтөлбөр, суралцахуйн удирдамж"-ийг шинэчлэх эрхзүйн орчныг бий болгох,
3. 2019 оны сайжруулсан сургалтын хөтөлбөрийн дагуу 2020 онд ихэнх сурах бичгийн агуулгад өөрчлөлт орж шинэчлэгдэн, өмнөхөөс 10-25 хувь хүртэл агуулгын өөрчлөлт орсон, өөрчлөгдсөн агуулга бүхий сурах бичгүүдийг өнөө хүртэл орчуулж сургалтад нэвтрүүлээгүй байгаа тул энэ ажлыг зохион байгуулах,
4. Энэхүү төслийн ажлын дүн, сурах бичиг тус бүрээр ажилласан мэргэжлийн багуудын санал дүгнэлтийн үндсэн дээр бүх сурах бичгүүдийг шинэчлэн сайжруулсаны дараа түүнийг нэн даруй казах хэл рүү мэргэжлийн түвшинд орчуулан гаргаж, сургалтад нэвтрүүлэх,
5. Орчуулгад баримтлах стандарт, нэгдсэн шаардлага, зарчим, шалгуурыг тусгайлан боловсруулж, чанд мөрддөг болох. Энэ талаар мэргэжлийн хүрээнд тусгай хэлэлцүүлэг зохион байгуулах. Тухайлбал, ямар тохиолдолд дуу, шүлгийн үгийг орчуулж болох, газар усны уламжлалт нэр, бусад оноосон нэр, зарим тогтсон нэр томъёо ухагдахууныг орчуулж болох эсэх гэх мэт асуудлыг мэргэжлийн түвшинд хэлэлцэн шийдвэрлэж тодорхой болгох, түүнийгээ орчуулгын сурах бичигт баримталдаг болох,
6. Багш тухайн орон нутагт хөтөлбөр хэрэгжүүлэхдээ сургалтын агуулга, арга зүйд нийцүүлэн, өөрсдийн онцлогийг тусгах, дуу, бүжиг зэрэг өв соёлоос оруулж агуулгаа баяжуулах боломжийг суралцахуйн удирдамжид тусган оруулах
7. Тухайн мэргэжлийн чиглэлээр ажиллах орчуулгын баг, орчуулгын сурах бичгийн редактор зэрэг хүний нөөцийг бэлтгэх, чанаржуулахад анхаарах,
8. Казахстан болон бусад хос хэлээр сургалт явуулдаг гадаад улс орны туршлагыг судлах
9. Цаашид сурах бичгийн хэвлэлийн стандартыг яаралтай шинэчлэн боловсруулж гарган, дэлхийн жишигт нийцсэн хэвлэлт бүхий сурах бичгийг хэрэглэх боломжийг бүрдүүлэх,
10. ЕБС-иуд сургалтын төлөвлөгөө, шинэчилсэн хөтөлбөрийн дагуу сургалтаа явуулах ёстой атал “Монгол ёс, хүмүүжил” I-V, “Эрүүл мэнд” IV-V хичээлийн Казах хэлээрх сурах бичиг одоо хүртэл гараагүй, тиймээс Баян-Өлгий аймгийн казах сургуулиудад эдгээр хичээлүүд хэрэг дээрээ бараг ордоггүй, хөтөлбөр хэрэгждэггүй. Эдгээр хичээлийн сурах бичгийг яаралтай казах хэлээр орчуулж сургалтанд нэвтрүүлэх,
11. Казах сурах бичгийн багийг сонгон шалгаруулах, мэргэжлийн баг бүрдүүлэх, багийн удирдлагыг зөв сонгох, багийн уялдаа холбоог сайжруулах, сурах бичиг

- зохиох багийг чадавхижуулах тусгай хөтөлбөр боловсруулан үе шаттайгаар сургалт, судалгаа явуулах орчин бүрдүүлэх,
12. Сурах бичгийг зохиохдоо өмнөх болон дараах ангийн сурах бичгийн агуулгын залгамж холбоо, уялдаа холбоог анхаарч, багууд хамтран анги, ангиар ямар сэдэв үзэх боломжтойг урьдчилан тогтоож, түүнийгээ баримтлах,
 13. Сурах бичгийн бүтэц, бүрдэл, техник шаардлагыг жигдлэх, харилцан адилгүй байгаа зүйлсийг нэг жигд стандартад оруулах,
 14. Казах сурах бичгийн хэвлэлийн эх бэлтгэхдээ аль болох казах хэлтэй эх бэлтгэгчийг татан оролцуулах, Китаб хэвлэлийн газар зэрэг казах хэлээр ном хэвлэн гаргадаг газартай хамтарч ажиллах,
 15. Цаашид сурах бичгийг: Үндсэн сурах бичиг, унших бичиг, багшийн ном, дасгал ажлын дэвтэр зэргээс бүрдсэн цогц хэрэглэгдэхүүн болгож зохиох. Суурь боловсролын Уран зохиолын сурах бичгийг дагалдуулан “Унших бичиг” гаргаж, эх бичвэр, шүлэг, дуу гэх мэт өргөн агуулгыг оруулах,
 16. Агуулгын залгамж чанар, ахисан түвшинг зөв оновчлох, нэр томьёо, ухагдахууны тайлбар, тодорхойлолт дутмаг, зарим өгөгдөл бичвэр төдий л оновчтой бус, зорилго нь тодорхойгүй г.м дутагдалтай талууд анзаарагдаж буйг засаж сайжруулах,
 17. Казах хэлээр гарсан сурах бичиг бүрт хэл найруулга, зөв бичих дүрмийн хийгээд үг сонголт оновчгүй болсон гэх зэрэг алдаа мадаг, сайжруулах зүйлс цөөнгүй буй нь судалгаагаар тодорхой харагдлаа. Үүнийг цаашид анхаарах,
 18. Сурах бичгийн агуулгад үндэсний соёл, өв уламжлалыг боломжийн ашиглан аль болох тусган оруулахад анхаарах,
 19. Орчуулгын сурах бичигт жендерийн ойлголт, харьцаа анхаарах хэр тусгагдаж буйд анхаарал хандуулах,
 20. Олон соёлын бодлогыг Монгол улсад мөрдөгдөж буй бүх сурах бичигт аль болох оруулах, XXI зууны иргэнд НҮБ, ЮНЕСКО-оос дэвшүүлж буй үзэл баримтлалыг сурах бичгээр дамжуулж ойлгуулах хэрэгтэй байна. Үндэстний цөөнх болон угсаатны цөөнхийн аж амьдрал, түүх соёл, улс орныхоо хөгжилд оруулсан хувь нэмрийг тусган харуулж, эв найртай, бие биенээ хүлээн зөвшөөрч, хүлцэн тэвчиж аж төрдөг болгоход орчин үеийн сурах бичгийн агуулгыг хандуулахад анхаарах,
 21. Бидний гаргасан санал шүүмжийг бага боловсролын монгол, казах сурах бичгийн зохиогчдын баг тусган авч, сурах бичгээ сайжруулахдаа ашиглахыг зөвлөж байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Сурах бичгийн агуулгын шаардлагын хувьд:

Сурах бичгүүдийн агуулгын бүтцийн авч үзвэл бага, суурь, бүрэн дунд боловсролын мэдээллийн технологи, физик, хими, биологи, газарзүй, эрүүл мэнд, орос хэл, нийгэм судлал, хөгжим зэрэг сурах бичгүүд нь бүлэг сэдэв нь нэгж сэдэвт, нэгж сэдэв нь сэдэвт эрэмбэ дараалалтай, тодорхой шаардлагыг хангаж бичигдсэн байхад математик, монгол хэл, уран зохиол, англи хэл, зураг технологи, дизайн технологи, монгол ёс хүмүүжил, иргэний ёс зүйн боловсрол зэрэг сурах бичгүүд нь боловсролын түвшин бүрт ялгаатай агуулгын бүтцээр бичигдсэн байна. Иймд цаашид сурах бичгийн гарчгийн бүтцэд тавих шаардлагад нийцүүлж сурах бичгийг зохиох хэрэгтэйг судалгааны дүн харуулж байна.

Бага, суурь, бүрэн дунд боловсролын сурах бичгүүд нь тухайн сургалтын хөтөлбөр тус бүрийн суралцахуйн зорилт (агуулга)-д нийцүүлэн сурах бичгийн агуулгыг боловсруулсан байна. Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрт тодорхойлогдсон суралцахуйн зорилт нь анги хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал болон тухайн ангийн бүлэг сэдвийн залгамж холбоо, эрэмбэ, дарааллыг үндсэнд нь хангасан байна. Цөөн сурах бичгийн тухайд, бага, суурь, бүрэн дунд боловсролын монгол хэл, математик, англи хэлний зарим ангийн сурах бичигт тухайн ангийн бүлэг сэдвийн залгамж холбоо, эрэмбэ, дараалал алдагдсан дутагдал байна. Иймд дараагийн хөтөлбөр, сурах бичгийн сайжруулалтаар дутагдлыг засах боломжтой юм.

Бага, суурь, бүрэн дунд боловсролын хүн орчин I-III, хүн байгаль IV-V, монгол ёс хүмүүжил, зураг технологи, дизайн технологи, монгол хэл, хөгжим, мэдээллийн технологи, хими, физик зэрэг сурах бичгийн агуулгыг баримтын, ухагдахууны, үйлийн, ахуйн, метакогнитив гэсэн мэдлэгийн төрлүүдэд суралцахаар жигд боловсруулсанаас гадна үйлийн мэдлэгийг түлхүү эзэмшүүлэхээр агуулгын шийдлийг хийсэн байна. Бүрэн дунд боловсролын түвшний сурах бичгүүдэд баримтын болон ухагдахууны мэдлэгийг эзэмшүүлэх агуулга зонхилж, үйлийн мэдлэгийг эзэмшүүлэх агуулга цөөхөн байв.

Бага, суурь, бүрэн дунд боловсролын байгалийн ухаан, хөгжим, зураг, дизайн технологийн сурах бичгүүдэд суралцагч өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хөгжүүлэх, ёс суртахууны агуулга бүхий сэдвүүдийг хангалтгүй тусгаж; монгол хэл, уранзохиол, англи хэл, орос хэл, монгол ёс, хүмүүжил, нийгмийн ухаан, түүхийн сурах бичгүүдэд дээрх агуулгыг хангалттай тусгасан нь суралцагчийн танин мэдэхүйн хөгжил, нас сэтгэхүйн онцлогт ерөнхийдөө тохирсон гэж үзэж байна. Бага боловсролын сурах бичгийн агуулгад амьдрал ахуйн холбоотой жишээгээр тайлбарласан, зургаар тайлбарласан агуулгын тоо их байгаа нь суралцагчийн сонирхол, хэрэгцээнд нийцсэн, ахуй амьдралын тодорхой асуудлыг судлахад чиглэжээ.

Бага, суурь, бүрэн дунд боловсролын ихэнх сурах бичгүүдэд Монгол нутаг дахь эртний нүүдэлчдийн дурсгал, Монгол улсын нийгэм эдийн засгийн хөгжил, онцлог дархан цаазат, дурсгалт газар, байгалийн нөөц баялаг, хүн ба байгалийн харилцааны үнэт зүйл, хүн ба эдийн засгийн үнэт зүйл болон улс төрийн үнэт зүйл эзэмшүүлэхэд чиглэсэн агуулга хангалтгүй тусгагдсан байна.

Сурах бичгийн арга зүйн хувьд:

Бага, суурь, бүрэн дунд боловсролын сурах бичигт сэргээн санах, ойлгох, хэрэглэх түвшний (доод эрэмбийн) чадварыг дэмжсэн даалгавруудыг түлхүү боловсруулж, задлан

шинжлэх, үнэлэх, бүтээх түвшний чадварыг (дээд эрэмбийн) дэмжсэн дасгал даалгавар цөөн боловсруулсан байна. Энэ нь нэг талаас дасгал даалгаврыг сурагчдын нас сэтгэхүйн онцлогт нийцүүлэн хялбаршуулсан гэж үзэх үндэслэл байж болох ч, тухайн сургалтын хөтөлбөрийн үнэлгээний зорилтын жин буюу нийт боловсруулсан даалгаврын 50 хувь нь хөнгөн, 50 хувь нь ур чадвар илрүүлэх даалгавар боловсруулахад цаашид анхаарах шаардлага байна.

Бага, суурь, бүрэн дунд боловсролын сурах бичгийн дасгал, даалгавар нь суралцагчийг ангилах, жишиж харьцуулах, тайлбарлах, дүгнэлт гаргах, хэрэглэх чадваруудад жигд суралцах, хөгжих боломжийг олгосон байна. Зөвхөн суурь, бүрэн дунд боловсролын сурах бичгийн ихэнх дасгал, даалгавар нь асуудал шийдвэрлэх, шинжлэн судлах, эрэл хайгуул хийх, мэдээлэл боловсруулах арга барилыг хөгжүүлэх, дэмжихэд чиглэсэн байна.

Дасгал, даалгаврын хариултын хувилбараас харахад нээлттэй хариулт бүхий дасгал, даалгавар болон олон сонголт бүхий хариулттай дасгал, даалгаврын тоо харьцангуй их байгаа нь суралцагчийг нээлттэй байлгах, хөгжүүлэх, сэтгэн бодох шийдлүүдтэй байна. Мэдээлэл боловсруулах, мэдлэг бүтээхэд зөвхөн бичвэр эхийг дангаар бус зураг, хүснэгт, бичвэр зэргийг хослуулан оновчтой хэрэглэж боловсруулсан нь түвшин харгалзахгүй нийтлэг сурах бичигт байгаа нь сурах бичгийн арга зүйд гарсан өөрчлөлт юм.

Тогтвортой хөгжлийн гол үзэл санааг илэрхийлсэн тогтолцоот сэтгэлгээний чадвар (аливаа зүйлийн харилцан хамааралд таних, нийлмэл тогтолцоог задлан шинжлэх), урьдчилан тооцох чадвар (урьдчилан сэргийлэх), шүүмжлэлт сэтгэлгээ, хариуцлага хүлээх, ухамсартай зөв сонголт хийх, нийгэмд эв зүйтэй амьдрах зэрэг чадвар бүхий агуулга бага, суурь, бүрэн дунд боловсролын сурах бичгүүдэд тусгагдаагүй байгааг судалгааны дүн харуулж байна.

Сурах бичгийн хэл найруулгын хувьд:

Бага, суурь, бүрэн дунд боловсролын сурах бичгийн хэл найруулга нь ерөнхийдөө оновчтой, товч тодорхой, энгийн ойлгомжтой, хэл найруулгын болон зөв бичих дүрмийн алдаагүй, зураг, хүснэгт тайлбартай, тайлбар нь найруулгын алдаагүй, буруу хариулттай, эсвэл хариулах боломжгүй дасгал, даалгавар байхгүй байна. Цөөн сурах бичгийн тухайд нэг өгүүлбэрийн доторх үгийн тоо насны онцлогт тохироогүй, зарим техникийн болоод санамсаргүй үгийн алдаа байсныг тухайн ангийн сурах бичгийн хэл найруулгын сайжруулах хэсэгт тодорхой засаж бичсэнийг дараагийн сурах бичгийн сайжруулалт хийхэд авч хэрэгжүүлэх хэрэгтэй.

Сурах бичгийн дизайн, техникийн шаардлагын хувьд:

Бага, суурь, бүрэн дунд боловсролын сурах бичгийн бичвэр, зураг, хүснэгтэн мэдээлэл нь тод, үсгийн хэмжээ том, мөр хоорондын зай их, уншихад ямар нэгэн бэрхшээл байхгүй. наалт чанартай, өнгө будаг сурагчдын эрүүл ахуйн шаардлагыг хангасан байна.

СУРАХ БИЧГИЙГ САЙЖРУУЛАХ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Дараагийн хөтөлбөр, сурах бичигт сайжруулалт хийхдээ сурах бичгийг зохиохоор шалгарсан багууд энэхүү судалгааны анги тус бүрийн үр дүнг авч танилцаж, хэрэгжүүлэх хэрэгтэй байна.
2. Нийтлэг сурах бичгийн дасгал, даалгавар, сурах арга барилыг илрүүлэх шинжилгээний статистик дүнгээс үзэхэд задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, үнэлэх, бүтээх чадварыг дэмжсэн даалгавар цөөн байна. Иймд 2022 оноос олон улсын жишгээр 15 настай сурагчдыг PISA үнэлгээгээр үнэлэхэд илт доогуур үзүүлэлттэй байх магадлал өндөр байна. Сургахаас суралцахуйд шилжих парадигмд дэлхийн хөгжилтэй улс орнууд шилжээд байгааг анхаарч манайх ч ийм шилжилт хийх ёстой.
3. Байгалийн ухаан, мэдээлэл зүйн хичээлүүдийг кабинетийн системээр хичээллэх нөхцлийг хангаж, шинжлэх ухаан технологийн өнөөгийн хөгжлийн түвшинд нийцсэн лабораторийн тоног төхөөрөмжөөр хангаж өгөх нь сургалтын хөтөлбөрийг хэрэгжилтэд чухал ач холбогдолтойгоос гадна сурах бичгийн зарим туршилт, дадлага ажлыг хийхэд хэрэгтэй юм.
4. Зарим сурах бичгийн тухайд бүлэг сэдэв, дэд сэдвүүд болон түвшин хоорондын, хичээл хоорондын логик холбоо алдагдсан байна. Энэ нь сурах бичиг зохиогчдыг зөв сонгоогүй, анги болгоны сурах бичиг өөр өөр зохиогчид, өөр өөр редакторуудтай байгаагаас шалтгаалж байна. Сурах бичиг зохиогчдыг сонгохдоо дан ганц тендер зарлах биш ерөнхий боловсролын сургуульд уг хичээлийг сайн зааж, амжилттай сургадаг багш нарыг урилгаар оролцуулж ч болох юм. Сурах бичиг зохиох редакторлах ажлыг эрхэлдэг нэгдсэн нэг зөвлөл, ажлын хэсэгтэй болгох шаардлагатай байна.
5. Сурах бичгийг зохиох, хэвлэх, түгээх ажил цаг хугацааны боломжоос болон доголджээ. Бага ангиас бусад ангийн сурах бичиг туршигдалгүй шууд хэрэглээнд орж байна. Сурах бичгийг цөөн тоогоор хэвлэж тодорхой сургууль дээр 1 жил хэрэглэж туршаад сайжруулсаны дараа орон даяар хэрэглэдэг болох шаардлагатай байна. Сурах бичгийг ойр ойрхон солихгүйгээр тогтвортой хэрэглэхэд анхаарах хэрэгтэй байна. Зөв бичгийн дүрэм, уншихад ойлгомжтой цөөн үгтэй байх болон найруулгын хувьд анхаарч зөв бичгийн дүрмийн толь гарсантай холбогдож уг толийг ашиглан засах шаардлагатай байна.
6. Нэгдүгээр ангийн цагаан толгой, унших бичиг хоёрыг салгаж бие даасан сурах бичиг болгон хэвлэх шаардлагатай байна. Энэ сурах бичиг хүнд, удаан хугацаанд судлах тул хүүхдүүд залхах хандлагатай байна.
7. Нэгдүгээр ангийн сурах бичгийг жил бүр дахин, суурь боловсролын болон ахлах ангийн сурах бичгийг сурагч бүрт хүрэлцэхээр хэвлэдэг болох, мэдээллийн технологи зэрэг хурдан хугацаанд агуулгад нь өөрчлөлт ордог хичээлийн сурах бичигт тодорхой хугацаанд нэмэлт хийж жижиг товхимол хэвлэдэг болох.
8. Өндөр хөгжилтэй орны ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг судалж үлгэр дуурайл авах, математик, физик, хими зэрэг байгалийн ухааны сурах бичгийн хувьд гадаадын сонгодог сурах бичгийг орчуулан ашиглах бололцоог ч бодолцох хэрэгтэй.

9. Боловсролын хүрээлэнгийн сурах бичгийн секторын хүний нөөцийг бүрдүүлэхдээ судлагдахуун бүрийг хариуцсан эрдэм шинжилгээний ажилтантай болгон нэмэгдүүлэх, чадваржуулах хэрэгтэй байна.
10. Казах сурах бичгийн хувьд хос хэлний боловсролд ихээхэн анхаарч казак монгол хэлийг эн чацуу эзэмшсэн иргэн болгон төлөвшүүлэх, казах хэл, казахын уран зохиолоос бусад судлагдахууны сурах бичгийг монгол сурах бичгийг орчуулж хэрэглэх, орон нутгийн сургуульд тухайн нутгийн онцлог, тухайн ястны зан заншил, үнэт зүйлсийг хөтөлбөрт оруулж тусгайлан сургуулийн мэдлийн цагт оруулдаг болох шаардлагатай байна.

ХАВСРАЛТ

1. ТӨСЛИЙН БАГААС БОЛОВСРОЛЫН ХУУЛЬ, ЖУРАМД ӨГСӨН САНАЛ

1.Боловсролын ерөнхий хуулийн төсөлд өгсөн санал

А. Боловсролын ерөнхий хуульд

- 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёо гэсэн хэсэгт “Боловсролын түвшин” гэдэгт мэргэжлийн болон дээд боловсрол гэж салгах биш мэргэжлийн анхан, дунд, дээд түвшин гэх, ”Зайн сургалт” гэж...орон зай, цаг хугацаанаас хамаарч ашиглах ..гэснийг үл хамаарч, “Насан туршийн боловсрол” гэж бүх насны иргэний ёс суртахуун, өөрийн хэрэгцээ сонирхолд нийцүүлэн мэргэжил, боловсрол, чадвар, хандлага, төлөвшлөө тасралтгүй дээшлүүлэх үйл ажиллагаа гэж нэмэх, ”Цахим сургалт” гэж технологи ашиглан гэснийг “Мэдээлэл, холбоо, харилцааны технологид суурилан мэдлэг, ур чадвар олгоход чиглэсэн бүх хэлбэрийн сургалтын үйл ажиллагаа” хэмээн өөрчлөх, 4.1.7-д орсон сургалтын орчны томъёололд “Суралцагчийн хүрээлэн буй бодит орчин (анги танхим, сургууль), сурах үйл ажиллагааг дэмжих нөөц бололцоо, сургалтад хамааралтай эсвэл нөлөө үзүүлэх нийгмийн харилцан үйлчлэл, харилцааны хэлбэрүүд” гэсэн агуулгыг багтааж оруулах мөн 7.3-д оруулсан “Хос хэл 11.1-д байгаа сурах бичгийн багц, 11.5-д байгаа цахим сурах бичиг,11.13-д байгаа сургалтын нээлттэй нөөц материал гэх ойлголтын хүрээг нь тодорхойлоод, 13.1-д оруулсан ”Суралцагч”, 19.1-д байгаа боловсролын байгууллага гэснийг оруулах
- 15 дугаар зүйлд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш тангараг өргөнө гэжээ. Өргөвөл бүх шатныхан өргөх гэх аль эсвэл хасах
- 17.9-д эдийн засаг санхүүгийн боловсрол олгох гэж нэмэх
- 17.11-д. Сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын агуулгыг нөхөн эзэмшүүлэхэд албан боловсролын хөтөлбөрийг баримтална гэж өөрчлөх
- 20.2-т өмчийн хувьд ашгийн болон ашгийн бус байна гэжээ. Ийм ойлголт байдаггүй. Харин төрийн, орон нутгийн, байгууллагын, хувийн болон холимог өмчийн гэсэн хэлбэртэй байдаг. Ашгийн, ашгийн бус гэдэг ойлголт бол өөр Жишээлбэл хувийн өмчийн сургууль ашгийн ч байж болно, ашгийн биш ч байж болно.
- 21.1.3-т дунд гэсэн үгийг суурь, бүрэн дунд гэж дэлгэрүүлэх, 21.3-т байж болно гэснийг байна гэж өөрчлөх.
- 27.1-д 5 жилийн хугацаагаар олгоно гэх
- 47.1-д цэцэрлэг, сургуулийн зөвлөлийн үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцох, хараа хяналтгүй орхихгүй байх гэснийг үүрэгт нь оруулах
- 31.1.8-д Сурах бичгийг зохиох, эхийг турших, сурах бичигт боловсрол, шинжлэх ухааны байгууллага, олон нийтийн оролцоог хангах, үнэлгээ, дүгнэлт гаргуулах үйл ажиллагааг зохицуулах журам, сургалтын хэрэглэгдэхүүнд тавих шаардлаг

Б.Сургуулийн өмнөх болон суурь, ерөнхий боловсролын тухай хуулийн төсөл

1. 11.6-д хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд гэснийг хасаж тогтвортой хэрэглэгдэхүйц болгох
2. 11.7-д бага ангийн гэсэн хэсгийг суурь боловсролын түвшин болгон өөрчилж дунд гэх үгийг хасаж, ахлах ангийн суралцагчид сургуулийн номын сангаар дамжуулан төлбөртэй ашиглана болгон өөрчлөх
3. 11.9-д Сурах бичгийг хүүхдийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн брайл болон бусад хэлбэрээр хэвлэн хэрэглэнэ болгон өөрчлөх
4. 11.9-д Казак хэл дээр сургалт явуулдаг сургуульд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрсөн сурах бичгийг Казак хэл дээр хөрвүүлэн хэрэглэнэ гэж нэмэлт заалт оруулах

Жич: Сургалтын хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлага, үйл ажиллагааг зохицуулах журмыг боловсруулж хүргүүлэх болно:

Ажлын хэсгийн ахлагч:

Монгол Улсын гавьяат багш, Доктор,
Проф. С.Төмөр-Очир

Ажлын хэсгийн гишүүд:

Монгол Улсын Гавьяат багш Академич
Б.Жадамба

Ардын багш, Доктор, Проф. Ц. Өнөрбаян
Доктор, Проф. Ч.Ганзориг

Доктор, С.Цогбадрах

2. СУРАХ БИЧИГ ЗОХИОХ, ХЭВЛҮҮЛЭХ, ТҮГЭЭХ ЖУРАМД ОРУУЛСАН САНАЛ

1. Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн багцын эх зохиох, хэвлэлийн эх бэлтгэх, хэвлэх, түгээх үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмыг баримтална.
2. Сурах бичгийн багцын эх зохиох, сайжруулах, хэвлэлийн эх бэлтгэх, хэвлэх, түгээх үйл ажиллагааны дунд хугацааны төлөвлөгөөг /цаашид «Дунд хугацааны төлөвлөгөө» гэх/ Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид «ям» гэх/ батална.
3. Дунд хугацааны төлөвлөгөө нь ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүй, үнэлгээ, хэрэгжүүлэх хугацаатай уялдсан байна.
4. Сурах бичгийн багцын эх зохиох, сайжруулах гэдэгт шинээр зохиох, хэрэглээнд буй сурах бичгийг хөтөлбөрийн өөрчлөлттэй уялдуулан сайжруулах үйл ажиллагааг ойлгоно.
5. Боловсролын эрдэм шинжилгээ арга зүйн байгууллага /цаашид «Боловсролын хүрээлэн» гэх/ хэрэглээнд байгаа сурах бичгүүдэд судалгаа хийж, зохиох, сайжруулах сурах бичгийн жагсаалтыг гаргаж, дунд хугацааны ажлын төлөвлөгөөнд тусгуулна.
6. Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн /цаашид “сайд” гэх/-ний тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөө”-нд заавал судлахаар тусгасан хичээлийн сурах бичгийн багцыг хөтөлбөрт нийцүүлэн зохиох, сайжруулах ажлыг сайдын тушаалаар баталсан ажлын хэсэг гүйцэтгэнэ.
7. Энэ журмын 1.4-д заасан төлөвлөгөөнд сонгон судлах хичээлийн сурах бичгийн багцын эхийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шалгаруулна.
8. Энэ журмын 1.4, 1.5 -д заасны дагуу зохиосон сурах бичгийн багцыг ашиглах онцгой эрхийг яам эзэмшинэ.
9. Сурах бичгийн багцыг мэдээлэл технологийн хэрэгсэл ашиглан цахим хэлбэрээр, үнэ төлбөргүй ашиглах боломжийг яам бүрдүүлнэ.
10. Сурах бичгийн багцын эх зохиох, эх бэлтгэх ажлыг сургалтад хэрэглэхээс хоёр хичээлийн жилийн өмнө эхлүүлнэ.
11. Боловсролын хүрээлэн сурах бичгийн багцын эх зохиох, сайжруулахад оролцох
12. хүний нөөцийг бүрдүүлэх, шалгуур хангасан ерөнхий боловсролын болон их дээд сургуулийн мэргэжлийн багш, арга зүйч, мэргэжлийн хүрээлэнгийн эрдэмтэн, судлаач, аймаг нийслэлийн боловсрол, урлаг соёлын газрын мэргэжилтэнгүүдийг сонгон оролцуулна. Багийн бүрэлдэхүүнд тухайн хичээлийг заадаг ерөнхий боловсролын сургуулийн багш заавал орно.
13. Боловсролын хүрээлэн доорх үйл ажиллагааг зохион байгуулна.
 - Үндэсний радио телевиз, сонинд сурах бичгийн багцын эх зохиогчдын баг шалгаруулах зарлалыг 1 сараас доошгүй хугацааны өмнө нийтэд мэдээллэнэ.
 - Зохиогчдын багийн шалгаруулалтад тавих шаардлагад нийцсэн материалыг хүлээж авах

- Боловсролын хүрээлэнгийн захиралын тушаалаар сурах бичгийн баг шалгаруулах ажлын хэсгийг байгуулж зохиогчдын багийн шалгаруулалтыг хийж, тэнцсэн багийн нэрсийг БСШ-ны яаманд хүргүүлж, батлуулна.
 - Тухайн сурах бичгийн багцыг зохиох 3-аас дээш баг санал ирүүлбэл эхний 2 багыг боловсролын хүрээлэн шалгаруулж, аль нэгийг сонгуулахаар яаманд хүргүүлж, батлуулна.
14. Сурах бичгийн багц болон сонгон судлах сурах бичгийн төсөв, гэрээ, сургалт зохион байгуулах
 15. Боловсролын хүрээлэн сурах бичгийн багц болон сонгон судлах сурах бичгийн эх зохиох, сайжруулах үйл ажиллагааны нийт зардлыг дунд хугацааны төлөвлөгөөнд нийцүүлэн тооцоолж, төсвийн төслийг яаманд танилцуулна.
 16. Боловсролын хүрээлэнгээс ирүүлсэн сурах бичгийн багц болон сонгон судлах сурах бичгийн эх зохиох, сайжруулах төсвийн төслийг яам хянаж батална.
 17. Тухайн жилд сурах бичгийн багц болон сонгон судлах сурах бичгийн эх зохиох, сайжруулах ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, ажиллах талаар яам Боловсролын хүрээлэнтэй, Боловсролын хүрээлэн сурах бичгийн багийн гишүүдтэй тус тус гэрээ байгуулна.
 18. Боловсролын хүрээлэн сурах бичиг зохиох онол, арга зүйн асуудал, өөрийн болон гадаад улс орны сурах бичгийн харьцуулсан судалгаа, сурах бичгийн ашиглалтын явцад хийсэн судалгааны үр дүн, сурах бичгийг зохиох үзэл баримтлалыг тусгасан удирдамжийг боловсруулж сурах бичиг зохиох багийн гишүүдэд сургалтыг зохион байгуулна.
 19. Сурах бичгийн багийн ахлагч нь “Багийн үйл ажиллагааны төлөвлөгөө” /цаашид “үйл ажиллагааны төлөвлөгөө” гэх/-г дунд хугацааны төлөвлөгөө, гэрээг тус тус үндэслэн боловсруулж, Боловсролын хүрээлэнгийн захирлаар батлуулан мөрдөж ажиллана.
 20. Боловсролын хүрээлэн болон багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн байгууллагатай зөвлөлдсөний үндсэн дээр сурах бичгийн эх зохиож, сайжруулсан агуулга, арга зүйн нийцлийг тандан судлах сургуулийг сонгож батлуулах
 21. Энэ журмын 2.3-д заасан гэрээнд сурах бичгийн эх зохиох, сайжруулах, эх бэлтгэлийн үйл явцын хугацааг дор дурдсанаар тооцож тусгана.
 - Сургалт дууссанаас хойш ажлын 14 хоногт багтаан сурах бичгийн агуулгын бүтцийг тогтоож батлуулах
 - Сурах бичгийн агуулгын бүтэц батлуулснаас хойш арван сарын хугацаанд сурах бичгийн эхийг анхны байдлаар бэлэн болгох;
 - Сурах бичгийн бэлэн болсон эхийг эх бэлтгэлд шилжүүлсэнээс хойш нэг сарын хугацаанд агуулга, техникийн редакторуудын зөвлөмжийн эхний засварыг бүрэн оруулна. (14 хоногт сурах бичгийн эхийг агуулга, техникийн редакторт уншуулж, 14 хоногт сайжруулах засварыг эх бэлтгэлд оруулна.)
 - Агуулга, техникийн редакторуудын зөвлөмжийн хоёр дахь засварыг нэг сарын хугацаанд бүрэн оруулна. (14 хоногт сурах бичгийн эхийг агуулга, техникийн редакторт уншуулж, 14 хоногт сайжруулах засварыг эх бэлтгэлд оруулна.)

- Агуулга, техникийн редакторуудын зөвлөмжийн гурав дахь засварыг нэг сарын хугацаанд бүрэн оруулна. (14 хоногт сурах бичгийн эхийг агуулга, техникийн редакторт уншуулж, 14 хоногт сайжруулах засварыг эх бэлтгэлд оруулна.)
 - Сурах бичгийг бүрэн эхээр нь долоон сарын хугацаанд сонгогдсон ерөнхий боловсролын дунд сургуульд агуулга, аргазүй, хэл найруулга, үнэлгээний тохироцыг шалгах туршилтын ажлыг эхлүүлж хэрэгжүүлнэ.
 - Сурах бичгийн эхийг бүрэн эхээр нь сургуульд дээр туршилт ажлыг хийж дуусгасны дараа хоёр сарын хугацаанд сайжруулах засварыг эх бэлтгэлд хийж дуусгана. (2 жил буюу 24 сар)
 - Сурах бичгийн эх зохиох, сайжруулсан эцсийн хувилбарыг ажлын 7 хоногт багтаан яаманд хүлээлгэн өгөх.
21. Сонирхолын бүлгийн төлөөлөлөгч буюу боловсролын болон бусад хүрээлэн, шинжлэх ухааны академийн эрдэмшинжилгээний ажилчид, нийслэл, орон нутгийн боловсрол соёл урлагын газрын мэргэжилтэн, багшийн мэргэжил дээшлүүлэх институтын мэргэжилтэн, ерөнхий боловсролын сургууль, техник мэргэжлийн төв, их дээд сургуулийн дидактикийн багш нар, төрийн бус байгууллага, эцэг эхийн төлөөлөгч оролцоно.
- Сонирхолын бүлгийн төлөөлөгчид бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага (MNS5412:2008)”, стандартад нийцүүлсэн шаардлага, шалгуур, үзүүлэлт болон бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрт нийцүүлэн боловсруулсан санал авах, сурах бичгийн эхийг сайжруулах шинжлэх хуудасны дагуу санал өгнө.
 - Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага (MNS5412:2008)”, стандартад нийцүүлсэн шаардлага, шалгуур, үзүүлэлт болон бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрт нийцүүлэн боловсролын болон бусад хүрээлэн, шинжлэх ухааны академийн эрдэмшинжилгээний ажилчид, их дээд сургуулийн дидактикийн багш нар дүгнэлт гаргаж болно.
 - Сурах бичгийн зохиогчийн эхийг 1 удаа, хэвлэлийн эхийг 2 удаа, нийт 3 удаагийн уншилт хийх бөгөөд санал зөвлөгөөг бүрэн хүлээн авах эсэх асуудлыг зохиогчдын багийн гишүүдтэй харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.
 - Нэг удаагийн уншилт эхийг хүлээн авсан өдрөөс хойш хуанлийн 14 хоног байна.
 - Сурах бичгийн эхийг шинжлэх хуудсаны дагуу хийж, холбогдох санал, дүгнэлийг боловсролын хүрээлэнгийн сурах бичгийн секторт ирүүлнэ.
22. Төлбөргүй ашиглуулах сурах бичгийг бага ангийн болон суурь боловсролын нийт суралцагчид хүрэлцэхүйц, ахлах ангийн нийт суралцагчийн 60 хувиас хэтрэхгүй тоогоор хэвлүүлнэ.
23. Сурах бичгийн эх зохиох, эх бэлтгэх, хэвлэх, түгээх үйл ажиллагааг, түүний хангамжийн тогтолцоо гэнэ. (Сурах бичгийн хангамжийн тогтолцоо гэсэн нэр томъёог боловсролын нэр томъёонд албажуулах)

24. БСШЯ-н ы сайдын тушаалаар бага, суурь, бүрэн дунд боловсролын сурах бичигт хэсэгчилсэн болон түүврээр сурах бичгийн агуулга, арга зүй, хэл найруулгад тавих шаардлагын дагуу экспертийн баг байгуулж судалгааг хийлгэх ажлыг тогтмол хийх.

25. Онлайнаар бага, суурь, бүрэн дунд боловсролын сурах бичгийн агуулга, арга зүй, хэл найруулгад тавих шаардлагын талаар мэргэжлийн багш, мэргэжилтэн, арга зүйч нараас судалгааг явуулж, дүн шинжилгээ хийх.

26. Сурах бичгийн хүртээмж, ашиглалтанд судалгаа хийх, хяналт тавих

2.13. Боловсролын хүрээлэн дэргэдээ эрдэмтэн, судлаач, багшийн төлөөлөл бүхий орон тооны бус сурах бичгийн мэргэжил арга зүйн зөвлөлийг хэл, математик, байгалийн ухаан, нийгмийн ухаан, урлаг-гоо зүйн чиглэл тус бүрээр байгуулна.

2.14. Боловсролын хүрээлэн шинэчилсэн сурах бичгийн эхийн агуулга, арга зүй, хэл найруулга, дизайн нь сургалтын хөтөлбөр, сурах бичгийн стандартад нийцсэн, зохиогчийн эрхийн зөрчилгүй эсэхэд хөндлөнгийн дүгнэлт гаргуулна.

2.15. Боловсролын хүрээлэн нь сурах бичгийн эхэд хөндлөнгийн дүгнэлт гаргуулах ажлын хүрээнд дараах ажлыг зохион байгуулна.

2.15.1. Сурах бичиг тус бүрд 2-3 шинжээч томилж, дүгнэлт гаргуулах;

2.15.2. Сурах бичгийн эхийг цахим хуудсанд нээлттэй байршуулж, санал, шүүмж авч, үр дүнг нэгтгэх;

2.15.3. Их, дээд сургууль, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага, эцэг эх, олон нийтийн байгууллага, суралцагчийн төлөөллөөр хөндлөнгийн хяналт хийлгэх.

2.15.4. Шинжээчдийн дүгнэлт, хөндлөнгийн хяналтын хуудас, нээлттэй санал шүүмж авах, нэгтгэх арга хэлбэрийг боловсруулж батлах

2.16. Шинжээчдийн дүгнэлт, хөндлөнгийн хяналт, нээлттэй санал шүүмжийн үр дүнг нэгтгэн энэ журмын 2.14-д заасан мэргэжил арга зүйн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, сурах бичгийн эхэд засвар, сайжруулалт хийх асуудлыг шийдвэрлэнэ.

2.13-2.16 заалтууд нь цаг хугацааны тухайд бодит байдалд хэрэгжих боломжгүй нөгөө талаас сурах бичгийн эхийг сургуульд туршиж хэрэглэдэггүй үед хэрэгжүүлж байсан заалтууд байна. Иймд журмаас хасах саналыг хүргүүлж байна.

Төслийн баг

1. С. Төмөр-Очир

2. Ч. Ганзориг

3. Б. Жадамба

4. Ц. Өнөрбаян

5. С. Цогбадрах

3. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН ХЭВЛЭМЭЛ СУРАХ БИЧИГТ ТАВИХ ШААРДЛАГАД ӨГСӨН САНАЛ

Стандартчилал, Хэмжил Зүйн Үндэсний Зөвлөлийн 2008 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 06 тоот тогтоолоор баталсан Монгол улсын стандарт, Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага (MNS 5418 : 2008)-ыг сайжруулах санал.

Хамрах хүрээ.

1. Энэхүү стандарт нь бага дунд боловсролыг албан, албан бус арга замаар эзэмшигчдэд хэрэглэх сурагчийн хэвлэмэл сурах бичгийг зохиох, хэвлэлийн эх бэлтгэх, хэвлэх, хэвлэлийн эхэд ба бэлэн болсон сурах бичигт үнэлгээ өгөх үйл ажиллагаа явуулахад баримтлах нийтлэг болон тусгай шаардлагуудыг тогтооно.
2. Стандарт нь сурах бичиг, дэвтэр, атлас, хэвлэмэл дидактик материал, сурах бичигдэх хавчуурга хуудсуудад хамаарна.

1. Ерөнхий шаардлага.

1. Боловсрол эзэмших тэгш байдлыг хангасан байна.
2. Боловсролын стандарт, киррикулим (В хавсралтыг үзнэ үү) болон эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байна.
3. Суралцагчдын нас, сэтгэцийн онцлог, танин мэдэхүйн түвшинд нийцсэн байна.
4. Материаллаг, сэтгэл зүйн болон үйлийн орчны харилцан хамаарлыг хангасан байна.
5. Үндэсний хэл, сэтгэлгээ, түүх, уламжлал соёл, үнэт зүйлд түшиглэсэн, хүн төрөлхтний хөгжлийн дэвшилтэт чиг хандлагыг баримжаалсан байна.
6. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, дэлхийн иргэний, XIX зууны боловсролын үзэл санаа, жендерийн эрх тэгш байдлын гол санааг агуулгын онцлогт нийцүүлэн тусгасан байна.
7. Агуулга нь танин мэдэхүйн тухайн түвшний шалгуураар үнэлэгдэхүйц байна.
8. Тухайн боловсролын агуулгын айгаар тодорхойлсон цогц чадамжийг илрүүлэх жишиг даалгаврын тавил, нөхцөл нь цогц чадамжуудын ай бүрийн агуулгыг үнэлж болохуйцаар боловсруулагдсан байна.

2. Сурах бичгийн агуулгад тавих шаардлага.

1. Агуулга нь танин мэдэхүйн хөгжлийн үе шат, нас сэтгэхүйн онцлогт тохирсон, боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэв хоорондын залгамж холбоог хангасан байна.
2. Боловсролын стандартын цогц чадамжийн ай бүрийн агуулгыг боловсролын болон суралцагчийн танин мэдэхүйн тухайн түвшинд бүрэн эзэмших боломжтой, тэдний мэдлэг бүтээх үйл ажиллагаа нь үр өгөөжтэй байхаар сурах бичгийн агуулгыг сонгоно.
3. Ухагдахуун, хууль, зүй тогтлыг хэрэглээ болон танин мэдэхүйн түвшинд тохируулан буулгаж, зөв оновчтой томъёолсон, шинжлэх ухааны хувьд алдаагүй байна.
4. Дидактикийн оновчтой шийдлээр агуулгын нэгжийг томсгон нэгжилж, бүтэцчилэх үндсэн дээр агуулгын айн инвариант чанарыг хангасан байна.

5. Монгол улсын хөгжил, даяаршлын тулгамдсан асуудал болон олон соёлын бодлогыг тусгасан байна.
6. Суралцагчдын сонирхол хэрэгцээнд нийцэж, ахуй амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн, нээлттэй байна.
7. Агуулга нь шинжлэх ухаан, технологийн сүүлийн үеийн ололтыг тусгасан, мэдлэгийн бусад салбартай холбогдсон байна.
8. Агуулга нь монгол улсын түүх, соёл, уламжлал, хөгжлийн үнэт зүйлсээс тухайн агуулгын онцлогт тохируулан заавал тусгасан байна.
9. Агуулгын багтаамж, бүтэц нь сургалтын төлөвлөгөөнд нийцэж, хичээлийг төлөвлөх, зохион байгуулах нөхцөлийг хангасан байна.

3. Арга зүйд тавих шаардлага

1. Тухайн агуулгыг эзэмшүүлэх арга зүй нь суралцагчийн танин мэдэхүйн, суралцахуйн болон эзэмшхүйн зүй тогтолд нийцсэн үйлийн баримжааг тодорхой, гүйцэд, бусад асуудалд зөөж хэрэглэх боломжтой байхаар боловсруулагдсан байна.
2. Сурах бичгийн агуулгын нэгжүүдийн арга зүйн сонголтууд нь зөв хосолж, даалгаврын нөхцөл нь суралцагчдыг нээлттэй байлгах, сэтгэн бодуулах, хөгжүүлэх, шийдлүүдтэй байна.
3. Агуулгын бүтцийн элемент (бүрдүүлбэр) бүрт суралцагчдын сэдэл, хэрэгцээг үндэслэл сайтай гаргана.
4. Баримтын, ухагдахууны, үйлийн, ахуйн, метакогнитив мэдлэг, чадвар, даалгаврын хүндрэлийн түвшин, хариултын хувилбар, контекст(бодит нөхцөл байдал), арга барилыг хөгжүүлэх зорилготой сурагчдад зориулсан дасгал, даалгавар, дадлага, туршилт ажлыг боловсруулсан байна.
5. Бие даан гүйцэтгэх дасгал даалгавар, сорил, туршилт, төслийн ажлуудын тавил нь танин мэдэхүйн болон ахуй, амьдралтай холбоотой асуудал шийдвэрлэх арга зүйд суурилсан байна.
6. Мэдээлэл олох, ашиглах, боловсруулах, мэдлэг бүтээхэд хүснэгт, график, бүдүүвч, зураг, бичвэр зэрэг мэдээллийн арга, хэлбэрийг оновчтой хослуулан хэрэглэнэ
7. Суралцагчдад үйл ажиллагаагаа бүтээлчээр зохион байгуулж, нээлт бүтээл хийхэд нь туслах арга замыг зөвлөн, нэмэлт мэдээллийн эх үүсвэрийг оновчтой сонгож тусгана.

4. Үнэлгээ хийгдэх бололцоонд тавигдах шаардлага.

1. Суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагыг гүйцэтгэлийн чанараар бодитой үнэлэх бололцоотой байна.
2. Явцын болон үр дүнгийн үнэлгээ хийх нөхцөлийг хангасан байна.
3. Сурах, сургах, суралцах үйл явцын үр дүн, өөрчлөлтийг бие даан үнэлж болохуйц байна.
4. Суралцагчдыг хүндэтгэсэн, нээлттэй, уян хатан, чөлөөтэй, хувилбартай үнэлэхэд чиглэгдсэн байна.

5. Хэл найруулгад тавих шаардлага.

1. Танин мэдэхүйн тухайн түвшинд тохирсон хэл найруулгын болон зөв бичих дүрмийн алдаагүй, оновчтой, товч тодорхой, энгийн ойлгомжтой, эмх цэгцтэй байна.
2. Сурах бичигт шинжлэх ухааны нэг мөр нэр томъёог хэрэглэнэ.
3. Танин мэдэхүйн тухайн түвшинд нь тохирсон нэр томъёоны тайлбартай байна.
4. Бүлэг, сэдвийн гарчиг, дэд гарчгууд нь агуулгын үзэл санаа, бүтэц, үндсэн нэр томъёог оновчтой илэрхийлсэн байна.
5. Таних тэмдгийн хэрэглээ нь хялбар, ойлгомжтой байна.

Санал боловсруулсан

Док. Проф.С.Төмөр-Очир.

Акад.Б.Жадамба.

Ардын багш Ц.Өнөрбаян.

Док.Проф Ч.Ганзориг

Док, С. Цогбадрах

5. ЦАХИМ СУРАХ БИЧИГТ ТАВИХ ШААРДЛАГАД ӨГСӨН САНАЛ

Цахим сурах бичигт тавих шаардлага

3.1 Хэвлэмэл сурах бичигтэй нэгэн адил агуулга, аргазүй, хэл найруулга бүхий (найруулах)

4.1 Техникийн шаардлага

4.1.13 Цахим сурах бичиг нь хэвлэмэл сурах бичгийн нэгэн ижил агуулга, арга зүйтэй байна. (найруулах)

4.1.15 Цахим сурах бичигт хэвлэмэл сурах бичгийн агуулга, арга зүйг мультимедиа материалаар баяжуулсан байна. (найруулах)

Суралцахуйн нэмэлт материал, үнэлгээний материал гэсэн ухагдахууныг нэр томьёо хэсэгт оруулж тайлбарлах.

4.2 Цахим сурах бичигт тавих хэрэглээний шаардлага

4.2.1 Гарчиг, хүснэгт, зураг, график, дасгал, даалгавар, дадлага, туршилт ажил зэргийг товъёогоор холбоосжуулсан байна. Тухайн холбоосоор дамжин агуулга (агуулгатай холбоотой гарчиг, хүснэгт, зураг, график,) болон арга зүйн хэсэгт (дасгал, даалгавар, дадлага, туршилт ажил) шууд очдог байна. (найруулах)

4.2.2 Сэдэвтэй холбоотой нэмэлт мэдээлэл, дасгал даалгавар, дадлага болон туршилт ажлыг үзэх холбоосыг байршуулсан байна. (найруулах)

4.3 Цахим сурах бичигт тавих тусгай шаардлага.

4.3.1 Хараа, сонсгол, хэл, хөдөлгөөний бэрхшээлтэй хэрэглэгчдэд зориулж цахим сурах бичгийн горимыг тусгай шаардлагаар тохируулах боломжтой байна. (найруулах)

4.3.4 Видео хэлбэрийн мэдээллийг дохионы хэлний арга зүйгээр тайлбарласан байна.

4.3.5 болон 4.3.6 эдгээр нь тусгай шаардлагатай хамааралгүй тул хамааралтай заалттай хэсэгт оруулна уу?

4.4.2 Монголын түүх, өв уламжлал, соёл, ёс суртахууны эерэг хандлага, үнэт зүйлийг сурагчдад төлөвшүүлэхийг дэмжсэн байна.

4.4.3 Гоо зүйн мэдрэмж гэсэн ухагдахууныг нэр томьёонд тайлбарлаж оруулах

Нээлттэй материалд тавих шаардлага

Цахим хэрэглэгдэхүүний багц гэсэн ухагдахууныг нэр томьёоны тайлбар хийх хэрэгтэй.

6.1 Ээлжит хичээлийн цахим контентийн бүтцэд тавих шаардлага. (найруулах)

6.1.2 чиглэсэн үйл ажиллагааны заавар дасгал, даалгавар, дадлага, туршилт ажил зэргээс бүрдэнэ.

6.2 Ээлжит хичээлийн цахим контентын агуулгад тавих шаардлага (найруулах)

6.3 Ээлжит хичээлийн цахим контентын арга зүйд тавих шаардлага(найруулах)

6.3.1 Тухайн агуулгыг эзэмшүүлэх арга зүйг суралцагчдын танин мэдэхүйн (сэргээн санах, ойлгох, хэргэлэх, задлан шинжлэх, үнэлэх, бүтээх чадвар) болон эзэмшихүйн зүй тогтолд нийцсэн (үйлийн баримжааг ялган таних, эзэмшүүлэх, хөгжүүлэх) байхаар боловсруулсан байна. (найруулах)

6.3.2 Шинжлэх ухааны нарийн төвөгтэй асуудлыг амьдрал ахуйн холбоотой жишээ баримт, зураг дүрслэлийн олон хэлбэр, загвар, бүдүүвч, харьцуулан жиших, ангилах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх зэрэг аргыг өргөн ашиглаж элементарчлах (**найруулах**)

Төслийн баг.

1. С. Төмөр-Очир
2. Ч. Ганзориг
3. Ц. Өнөрбаян
4. Б. Жадамбаа
5. С. Цогбадрах

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Байгальмаа, Ч. (2015). Боловсролын судалгааны арга зүй
2. Бэгз, Н.(2019). XXI зууны глобаль орчин дахь монгол хүний боловсролын агуулгыг тодорхойлох философи үндэслэл, эрдэмшинжилгээний өгүүлэл, дугаар 24
3. Бэгз, Н., Санжаабадам, С., Энхбаяр, Б., Лхагвасүрэн, Ц., Баяраа, Б., Баярсайхан, Б.,бусад (2018). Хүүхэд залуучуудын хөгжлийн онол, арга зүй, Улаанбаатар, соёмбо притинг.
4. Бадарч, Б.(2019). Боловсролын хөгжлийн чиг хандлага, эрдэмшинжилгээний өгүүлэл, дугаар 24
5. Төмөрчир, С., (2020). Ерөнхий хийгээд боловсролын социологи. Улаанбаатар, Монголын улсын засгийн газрын хэвлэх үйлдвэр.
6. Төмөр-Очир.С.(2020).Дэлхийн боловсролын харьцуулсан судалгаа. Улаанбаатар, Монголын улсын засгийн газрын хэвлэх үйлдвэр.
7. Чимгээ, Д., Болор, А., Энэрэл, А., (2013). Судалгаа шинжилгээний аргазүй “SPSS” программ, Улаанбаатар хот
8. Цогбадрах, С., (2018). Сурах бичгийн агуулга, аргазүйд тавих шаардлагыг боловсронгуй болгох нь (Биологийн сурах бичгийн жишээн дээр).Боловсрол судлалын докторын (Ph.D) зэрэг горилсон диссертаци.
9. Боловсролын салбарын шинэчлэл төсөл. МОН-0125.(2011). Суралцагчдын эзэмшсэн боловсролыг үнэлэх аргазүй. монгол улсын боловсрол, шинжлэх ухааны яам

СУРАХ БИЧГИЙН БАГЦ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ (ЗАГВАР ХУУДАС)

ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

- Сурах бичиг, түүний дагалдах багцийн (дасгалын ном, багшийн ном, хэрэглэгдэхүүн) өнөөгийн хөгжлийн төлөв байдалд дүгнэлт хийж, цаашид сурах бичгийн талаар баримтлах бодлого, үзэл баримтлал, стандарт, үнэлгээний үндсэн асуудлуудыг олж шийдвэрлэх арга замыг тодорхойлоход үндсэн зорилго оршино.
- Сурах бичиг ангилах, харьцуулах, тайлбарлах, задлан шинжилгээ хийх, үнэлэх, бүтээх, асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах, шинжлэн судлах аргуудыг бодлого дасгал, даалгавар, туршилт сорилын ажил, кейстэй ажиллаж үйлийн явцдаа мэдлэгт суралцахаас гадна амьдрахуй ухааны арга, ёс суртахууны хүмүүжил төлөвшлийн арга зүйг дэмжих боломжтой эсэхийг тодруулна.
- Сурах бичиг бүхий багцад XXI зууны боловсрол, дэлхийн иргэний боловсрол, тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санаа, сурагчдын танин мэдэхүй, нийгэмшил, сэтгэл хөдлөл, зан үйл, үнэт зүйл, хандлагын агуулга болон монголын түүх, соёл, өв уламжлалын талаар тусгасан байгааг илрүүлж тогтооно.

ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ҮЙЛ ЯВЦ

- Тухайн судлагдахууны дэд ажлын хэсгийн багийн ахлагч бүр үйл ажиллагааны календарчилсан ажлын төлөвлөгөөний дагуу гишүүдийн ажил үүргийн нарийвчилсан хуваарь хийж танилцуулна.

- Багийн ахлагч болон гишүүд бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих стандарт (MNS5418:2008)-ыг уншиж танилцана.
- Шинжээч болон багийн ахлагчид өөрийн судлагдахууны бага, суурь, бүрэн дунд боловсролын хөтөлбөр, сурах бичгийг бүрэн уншиж, сайтар танилцана.
- Багийн гишүүд сурах бичгийн судалгааны арга зүйтэй танилцаж, агуулга, арга зүй , үнэлгээ, хэл найруулга, техникийн шаардлагад шинжилгээ хийх талаар баг дотроо ярилцаж ойлголтоо нэгтгэнэ.
- Агуулгын шаардлагын B1, B 4.1, B4.2, B6 гэсэн шаардлагуудын үзүүлэлтийн дор тоон тэмдэглэгээг бичнэ, B2, B3, B5, B7 шаардлагуудын үзүүлэлтийн доторх дугуй хаалтан дотор (1,2,3) байгаа кодоос үзүүлэлтийн нөхцлийг уншиж тохирохыг сонгож, сонгогдоогүй нүдэн 0 гэсэн тэмдэглэгээ бичнэ.
- Арга зүйн шаардлагын C1.1-C1.7 шаардлагуудын үзүүлэлтийн дор тоон тэмдэглэгээг бичнэ, C2, C3 шаардлагууд нь үзүүлэлтийн доторх дугуй хаалтан дотор (1,2,3) байгаа кодоос үзүүлэлтийн нөхцлийг уншиж тохирохыг сонгож, сонгогдоогүй нүдэнд 0 гэсэн тэмдэглэгээ бичнэ.

Хэл найрууллагын D1 шаардлага нь үзүүлэлтийн доторх дугуй хаалтан дотор (1, 2, 3) байгаа кодоос үзүүлэлтийн нөхцлийг уншиж тохирохыг сонгож, сонгогдоогүй нүдэн 0 гэсэн тэмдэглэгээ бичнэ. D2 шаардлагаас ямар боловсролын түвшинд (бага, суурь, бүрэн дунд) хамаарах сурах бичигт шинжилгээ хийж байгаагаас хамаарч сонгож үзүүлэлтийг тоо тэмдэглэгээ хийнэ.

Техникийн E1 шаардлага нь үзүүлэлтийн доторх дугуй хаалтан дотор (1, 2, 3) байгаа кодоос үзүүлэлтийн нөхцлийг уншиж тохирохыг сонгож, сонгогдоогүй нүдэнд 0 гэсэн тэмдэглэгээ бичнэ.

Багийн гишүүд бүр шинжилгээ хийхдээ эхлээд word-ийн судалгааны арга зүйг нарийн гаргана. Дараа нь багаараа нийлүүлж үр дүнг эцсийн хувилбараар үнэн зөв гаргана. Үүний дараа зөвхөн тухайн шаардлага тус бүрийн хөлийн нийт үрдүнг илгээсэн эксель программд алдаагүй шивж оруулна. Эксель программийн хүснэгтийн толгойд шаардлага тус бүрийн үзүүлэлтийн код бичигдсэн тул word-ийн судалгааны арга зүйн үзүүлэлтийн кодтой тулгаж нягтлаарай. Бэлтгэж өгсөн эксель программын багана, мөр дураараа нэмж хасаж хэрэглэхгүй байхыг анхаарна уу? Сурах бичгийн талаарх суурь судалгааг хийхээ мартаж болохгүй.

Судалгааны үр дүнг өөрсдөө боловсруулж тайлан бичих үр дүнг гаргаж авна.

- Биологи, эрүүл мэнд, нийгэм, иргэний боловсрол, монгол хэл, уранзохиол, дүрслэг урлаг, дизайн технологи зэрэг 2 сурах бичигтэй шинжээчид сурах бичгийг тус бүрт нь шинжилгээний үр дүнг хэлэлцэж шийдвэрлэнэ.
- Үр дүнгийн хүснэгтийн ажлын хуудас нийтлэг тохирч байвал түүнийг нэгтгэж багийн ахлагчдад хүлээлгэн өгнө. Эсрэг тохиолдолд зөрүүтэй ажлын хуудасны тэмдэглэгээг багаараа дахин ярилцаж нэг мөр шийдвэрлэж эцэслэнэ.
- Судлагдахуун тус бүрийн багууд SWOT загварын дагуу сурах бичигт дүн шинжилгээг хийхдээ тухайн судалгааны арга зүйн агуулгын 7, аргазүйн 3 хэл найруулгын 2, техникийн 1 шаардлага тэдгээрийн үзүүлэлт тус бүрийг харгалзан бүлэг сэдэв болон тухайн сурах бичгийн нийт тоон үзүүлэлт болон тухайн хөтөлбөрийн зорилго, зорилт, агуулга, арга зүй, үнэлгээтэй уялдаа холбоотой дүн шинжилгээ хийж дэлгэрэнгүй тайлан бичнэ.

- Төслийн удирдах баг, багуудаас SWOT загварын дагуу бичсэн нэгдсэн дүгнэлт бүхий тайлан, эксель праграммаар дээр шивсэн дата буюу мэдээллийг ажлын төлөвлөгөөний хуваарийн дагуу хугацаандаа боловсролын хүрээлэнгийн сурах бичгийн секторт tsogbadrakh@mier.mn хаягаар ирүүлнэ.
- Ерөнхий ажлын хэсгийн багийн гишүүд хамааралтай судлагдахууны ажлын хуудас бүртэй танилцаж, сайжруулах шаардлага байвал багт эргүүлж өгнө.

A. ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ

МЭДЭЭЛЭЛ

A1. Шинжээчдийн овог, нэр

A2. Шинжилгээ хийсэн огноо

Б. СУРАХ БИЧГИЙН ТУХАЙ СУУРЬ МЭДЭЭЛЭЛ

Б 1. Сурах бичгийн нэр

- 1.Зохиогчийн эрх олгосон огноо Б12
- 2.Сүүлийн дахин хэвлэлтийн огноо Б13
- 3.Хамгийн эхний зохиогчийн нэр Б14
- 4.Хэвлэлийн газрын нэр Б15
- 5.Хэвлэсэн газар Б16
- 6.Сурах бичгийн хэл Б17
- 7.Анги/түвшин Б18

Бага боловсрол	1	2	3	4	5
Суурьболовсрол	6	7	8	9	
Дунд боловсрол	10	11			

Сурах бичгийн хуудасны тоо (хамгийн сүүлчийн хэвлэлийн хуудасны тоо) Б19

В. СУРАХ БИЧГИЙН АГУУЛГАД ТАВИХ ШААРДЛАГА

В1. Сурах бичгийн агуулгын бүтцийг хэрхэн болосвруулсан байна вэ? (Тухайн сурах бичигт хамааралтай бүтцийн элементийн тоог тэмдэглэнэ, тухайн бүтэц байхгүй бол 0 гэж тэмдэглэнэ.)

	Сурах бичгийн нэр	Сурах бичгийн бүтцийн элементийн тоо						
		Код 1.1.1 Айн тоо	Код 1.1.2 Бүлэг сэдвийн тоо	Код 1.1.3 Дэд бүлгийн тоо	Код 1.1.4 Нэгж сэдвийн тоо	Код 1.1.5 Дэд сэдвийн тоо	Код 1.1.6 Сэдвийн агуулгын тоо	Код 1.1.7 Гарчгийн тоо
1								

В2. Сурах бичиг сургалтын хөтөлбөрийн суралцахын зорилт (агуулга)-ын дагуу бичигдсэн эсэх

В2.1 Тайлбар: Дугуй хаалтанд байгаа тооноос тохирохыг нүдэнд тэмдэглэнэ үү,

- Тухайн ангийн сургалтын хөтөлбөрөөс суралцахуйн зорилтыг тоолж бүлэг сэдэв тус бүрийн ард бичнэ.

	Бүлэг сэдвийн нэр	Сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилтын тоо	Үзүүлэлт		
			Код В2.1.1.Сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилтыг(агуулга) бүрэн 91-100 хувь сурах бичгийн агуулгад оруулсан бол хангалттай (3)	Код В.2.1.2.Сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилтын (агуулга) 80-90 хувь сурах бичгийн агуулгад дутуу оруулсан бол сайжруулах (2)	Код В2.1.3 Сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилтын (агуулга) 80-аас доош хувийг өөр агуулгаар сурах бичигт бичиж оруулсан бол хангалтгүй (1)
	Нийт бүлэг сэдэв/ суралцахуйн зорилтын тоо				

В3 Суралцахуйн зорилтыг (агуулга) боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэв хоорондын залгамж холбоотой боловсруулсан эсэх

	Шалгуур	Үзүүлэлт		
		Код В3.1.1 Залгамж холбоо, эрэмбэ дараалал бүрэн 90-100 хувь тогтоогдсон бол хангалттай (3)	Код В3.1.2 Залгамж холбоо, эрэмбэ дараалал бүрэн бус 80-90 хувь тогтоогдсон бол сайжруулах (2)	Код В3.1.3, Залгамж холбоо, эрэмбэ дараалал дутуу 80 -аас доош хувь тогтоогдсон бол хангалтгүй (1)
1	Анги хоорондын суралцахуйн зорилтын залгамж холбоо, эрэмбэ дараалал			
2	Тухайн ангийн бүлэг сэдвийн залгамж холбоо, эрэмбэ дараалал			
3	Тухайн бүлгийн сэдэв хоорондын залгамж холбоо, эрэмбэ дараалал			

В4. Сурах бичгийн агуулга нь ямар мэдлэг, хандлага (ёс суртахууны хүмүүжил, төлөвшил)-ыг боловсруулсан эсэх

В 4.1. Ямар мэдлэгт суралцахаар боловсруулсан байна бэ?

	Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Мэдлэгийн төрөл				Код В 4.1.5 Метоконгнитив мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо
			Код В 4.1.1 Баримтын мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Код В 4.1.2, Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Код В 4.1.3,Үйлийн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	Код В 4.1.4 Ахуйн мэдлэг эзэмшүүлэх сэдвийн агуулгын тоо	
	Нийт бүлэг сэдвийн тоо						

В.4.2 Ямар хандлага, (ёс суртахууны хүмүүжил төлөвшүүлэх) боловсруулалт хийсэн бэ?

	Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Суралцах ёс суртахууны хүмүүжил төлөвшил)				
			Код 4.2.1 Хамтарч ажиллах сэдвийн тоо	Код 4.4.2 Байгаль орчноо хайрлах хамгаалах сэдвийн тоо	Код 4.4.3 Өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хөгжүүлэх сэдвийн тоо	Код 4.4.4 Өөрийгөө хүмүүжүүлэх сэдвийн тоо	Код 4.4.5 Ёс суртахууны төлөвшил эзэмшүүлэх сэдвийн тоо
	I						
	II						
	Нийт бүлэг сэдвийн тоо	Нийт сэдвийн агуулгын тоо					

Тайлбар:

Өөрийгөө танин мэдэх сэдвийн агуулга нь: би хэн бэ буюу өөрийн бие, хэл, сэтгэл, оюун санааны ертөнцөө танин мэдэх, үнэлэх, эргэцүүлэн бодох, шүүн тунгаах, өөрийгөө нээх буюу олох, өөрийгөө ухамсарлах үйл ажилаагаа

Өөрийгөө хөгжүүлэх сэдвийн агуулга нь: өөрийнхөө сайн сайхан чадвартаа тулгуурлан, сул талаа засч залруулах замаар өөрөө бие даан амьдрах бодит чадвар / харилцах, хүндэтгэх, ойлгох, сонсох, итгэх, зоримог, шийдэмгий байх, хүлээн зөвшөөрөх г.м/, чадамжаа сайжруулах, өөрийн асуудлыг өөрөө шийдвэрлэх чадвараа нэмэгдүүлэх, өөрийн сонголтыг өргөжүүлэх

Өөрийгөө хүмүүжүүлэх сэдвийн агуулга нь: Өөрийгөө хүмүүжүүлэх нь сэтгэл хөдлөлөө удирдах, өөрөө өөртөө үнэнч байх, өөрийгөө халамжлах, хайрлах, хүндлэх, өөртөө санаа тавих, өөрөө өөрийгөө өөд нь татах, өөртөө итгэлтэй байх, өөртөө урам өгөх, өөртөө туслах ухаантай байх, өөрийгөө шинжиж, зан аашаа засах, өөртөө шүүмжлэлтэй хандах, өөртөө өндөр шаардлага тавих, өөрийн бурууг хүлээх, эрсдэлээ өөрөө үүрэх

Ёс суртахууны төлөвшил сэдвийн агуулга нь: хүнлэг ёс, шударга ёс, нийтэч, ухаалаг, тэвчээр, эерэг хандлага, нэр төр, хувийн зохион байгуулалт, сахилга бат, хариуцлага

B5. Сурагчдын сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, жишээ баримттай бичвэр, дасгал, даалгавар, туршилт ажил, дадлага ажлыг сурах бичигт оруулсан эсэх

	Сонирхолыг татсан сэдэлжүүлэх агуулгатай, жишээ баримттай оруулах зүйлсийн нэрс	Үзүүлэлт		
		Код 5.1.1 Нийт бүлэг сэдвийн 91-100 хүртэлх хувьд оруулсан бол хангалттай. (3)	Код 5.1.2, Нийт бүлэг сэдвийн 81-90 хувьд оруулсан бол сайжруулах(2)	Код 51.3, Нийт бүлэг сэдвийн 80 хувиас доош оруулсан бол хангалтгүй (1)
1	Бичвэр			
2	Шүлэг			
3	Дуу			
4	Зураг			
5	График			
6	Диаграмм			
7	Дасгал			
8	Даалгавар			
9	Дадлага ажил			
10	Туршилт ажил			
11	Тэмдэг, тэмдэглэгээ			

В6. Ухагдахуун, онол, хууль, зарчим, тодорхойлолт, нэр томъёог хэрэглээ болон танин мэдэхүйн түвшинд тохируулан буулгаж, зөв оновчтой томъёолсон, шинжлэх ухааны хувьд алдаагүй, хялбаршуулж оруулсан эсэх

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Бүлэг сэдэв бүрийн агуулгын тоо	Хялбарчлах аргууд					
		Код 6.1 Амьрал ахуйн холбоотой жишээгээр тайлбарласан сэдвийн агуулгын тоо	Код 6.2 Зургаар тайлбарласан сэдвийн тоо	Код 6.3 Загварчилж тайлбарласан сэдвийн тоо	Код 6.4 Бүдүүвчээр тайлбарласан сэдвийн тоо	Код 6.5 Энгийн өгүүлбэрээр тайлбарлах	Код 6.6 Харьцуулан жиших аргаар тайлбарлах
I							
II							
Нийт бүлэг сэдэв, агуулгын тоо							

В 7. Монгол улсын түүх, уламжлалт соёл, үнэт зүйл, хандлагын асуудлыг сурах бичигт тусгасан эсэх

В7.1

	Монголын түүх, соёлын сэдвүүд	Үзүүлэлт		
		Код 7.1.1 Сурах бичгийн нийт бүлгийн агуулгын 40-50 хувьд тусгасан бол хангалттай (3)	Код 7.1.2 Сурах бичгийн нийт бүлгийн агуулгын 30-40 хувьд тусгасан бол сайжруулах (2)	Код 7,1,3. Сурах бичгийн нийт бүлгийн агуулгын 30-аас доош хувьд тусгасан бол хангалтгүй (1)
1	Монгол нутаг дахь эртний нүүдэлчдийн дурсгал			
2	Монгол улсын нийгэм эдийн засгийн хөгжил, онцлог			
3	Монгол үндэстэн, ястны соёл, боловсрол, сэтгэлгээ			
4	Дархан цаазат, дурсгалт газар, байгалийн нөөц баялаг			
	Үнэт зүйлсийн сэдэв			
5	Монгол үндэстний үнэт зүйл (бэлэгдэл, шүтлэн, өнгө, тоо, хэл)			
6	Хүн хүний харилцааны ёс суртахууны үнэт зүйл			
7	Хүн ба байгалийн харилцааны үнэт зүйл			
8	Хүн ба эдийн засгийн үнэт зүйл			
9	Хүн ба оюуны соёлын үнэт зүйл			
10	Улс төрийн үнэт зүйл			

С. СУРАХ БИЧГИЙН АРГА ЗҮЙД ТАВИХ ШААРДЛАГА

С1. Дараах мэдлэг, чадвар, даалгаврын хүндрэлийн түвшин, хариултын хувилбар, контекст(бодит нөхцөл байдал), арга барилыг хөгжүүлэх зорилготой сурагчдад зориулсан дасгал, даалгавар, дадлага, туршилт ажлыг сурах бичигт оруулсан эсэх

С1.1. Дасгал, даалгаврыг ямар мэдлэгт суралцахаар боловсруулсан байна вэ?

	Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Бүлэг сэдэв бүрийн даалгаврын тоо	Мэдлэгийн төрөл				
			Код С1.1.1 Баримтын мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Код С1.1.2 Ухагдахууны мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Код С1.1.3 Үйлийн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Код С1.1.4 Ахуйн мэдлэг эзэмшүүлэх даалгаврын тоо	Код С1.1.5 Метакогнитив мэдлэг эзэмшүүлэх мэдлэгийн тоо
1	I						

С1.2. Дасгал, даалгаврыг ямар чадварт суралцахаар боловсруулалт хийсэн бэ?

	Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Бүлэг сэдэв бүрийн даалгаврын тоо	Чадварын тоо							
			Ойлгох чадвар тоо				Код С1.2.5 Хэрэглэх чадварын тоо	Код С1.2.6 Задлан шинжлэх чадварын тоо	Код С1.2.7 Бүтээх чадварын тоо	Код С1.2.8 Танин мэдэхүйн түвшний 2-оос дээш чадвар (сэргээн санах, ангилах харьцуулах гэх мэт) Метакогнитив
			С1.2.1 Ангилах	Код С1.2.2 Жишиж харьцуулах	Код С1.2.3 Жишээгээр тайлбарлах	Код С1.2.4 Дүгнэлт гаргах				
1	I									
	Нийт бүлэг сэдэв, даалгаврын тоо									

С1.3 Дасгал, даалгаврын хүндрэлийн түвшинг тодорхойлсон эсэх

	Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Бүлэг сэдэв бүрийн даалгаврын тоо	Код 1.3.1 Хөнгөн даалгаврын тоо			1.3.2 Хүнд даалгаврын тоо			Код 1.3.3 Хөнгөн багц даалгаврын тоо (сэргээн санах, ойлгох, хэрэглэх түвшний даалгаврын эзлэх хувиар тодорхойлно.)	Код 1.3.4 Хүнд багц даалгаврын тоо (задлан шинжлэх, үнэлэх, бүтээх түвшний даалгаврын эзлэх хувиар тодорхойлно.)
			Код 1.3.1 Сэргээн санах	Код 1.3.2 Ойлгох	Код 1.3.3 Хэрэглэх	1.3.4 Задлан шинжлэх	1.3.5 Үнэлэх	1.3.6 Бүтээх		

C1.4 Дасгал , даалгаврын хариултын хувилбарыг тооцсон эсэх

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Бүлэг сэдэв бүрийн даалгаврын тоо	Дасгал, даалгаврын хариултын хувилбар		
		Код 1.4.1 Нээлттэй хариулт бүхий даалгаврын(дасгал) тоо	Код 1.4.2 Хаалттай хариулт бүхий даалгаврын (дасгал)тоо	Код 1.4.3 Олон сонголттой хариулттай даалгаврын тоо (дасгал)
I				

C1.5 Дасгал , даалгаврын контекст (бодит нөхцөл байдал) ямар байна вэ?

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Бүлэг сэдэв бүрийн даалгаврын тоо	Контекстийн хэлбэр		
		1.5.1 Тухайн судлагдахууны онолын шинж, онцлог бүхий контексттэй даалгаврын(дасгал) тоо	1.5.2 Зохиомол контексттэй даалгаврын (дасгал) тоо	1.5.3 Бодит амьдралын жишээ баримтад тулгуурласан контексттэй даалгаврын(дасгал) тоо
I				
II				

C1.6. Дасгал, даалгаврыг ямар арга барилд суралцахаар боловсруулалт хийсэн бэ?

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Бүлэг сэдэв бүрийн даалгаврын тоо	Суралцах арга барилын тоо			
		C1.6.1 Асуудал шийдвэрлэх даалгаврын тоо	C1.6.2 Мэдээлэл боловсруулах даалгаврын тоо	C1.6.3 Шинжлэн судлах даалгаврын тоо	C1.6.4 Эрэл хайгуул хийх даалгаврын тоо
I					
II					

C1.7 Туршилт, дадлага ажлыг ямар арга барилд суралцахаар боловсруулсан байна вэ?

Сурах бичгийн бүлэг сэдвийн нэр	Бүлэг сэдэв бүрийн туршилт, дадлага ажлын тоо тоо	Суралцах арга барилын тоо			
		C1.7.1 Асуудал шийдвэрлэх бодлого туршилт , дадлага ажлын тоо	C1.7.2 Мэдээлэл бодлого, боловсруулах туршилт, дадлага ажлын тоо	C1.7.3 Шинжлэн судлах туршилт дадлага ажлын тоо	C1.7.4 Эрэл хайгуул хийх туршилт , дадлага ажлын тоо
I					

C2. Сурах бичигт боловсролын талаарх дэлхийн чиг хандлага, тогтвортой хөгжлийн агуулга, иргэнд зайлшгүй эзэмшсэн байх чадварыг тусгасан эсэх

	Асуудал	Үзүүлэлт		
		Код с2.1.1, Нийт дасгал, даалгаврын 40-50 хувьд оруулсан бол хангалттай (3)	Код с2.1.2, Нийт дасгал, даалгаврын 30-40 хувьд оруулсан бол сайжруулах (2)	Код с2.1.3, Нийт дасгал, даалгаврын 30 хувиас доош оруулсан бол хангалтгүй (1)
1	Тогтолцоот сэтгэлгээний чадвар (аливаа зүйлийн харилцан хамааралд таних, нийлмэл тогтолцоог задлан шинжлэх)			
2	Урьдчилан тооцох чадвар (Урьдчилан сэргийлэх)			

3	Хамтран ажиллах чадвар			
4	Шүүмжлэлт сэтгэлгээний чадвар			
5	Өөрийгөө таньж мэдэх чадвар			
6	Мэдээлэл, өгөгдөл техник, технологийн чадвар			
7	Өөрийгөө удирдах, эргэцүүлэн бодох чадвар			
8	Хариуцлага хүлээх чадвар			
9	Ухамсартай зөв сонголт хийх чадвар			
10	Нийгэмд эв зүйтэй амьдрах чадвар			
11	Сэтгэлээ жолоодож сурах зөөлөн чадвар			

С3. Сурах бичигт дасгал, даалгавар боловсруулахдаа мэдээллийн хэлбэрийг хослуулан ашиглаж хийсэн эсэх

	Асуудал/ байдал	Үзүүлэлт	
		С3.1.1 Зөвхөн дангаар хэрэглэсэн бол сайжруулах (2)	С3.1.2 Хоёр, түүнээс дээш мэдээллийн хэлбэрийг хослож хэрэглэсэн бол хангалттай (3)
1	Бичвэр эх		
2	Зураг		
3	График		
4	Хүснэгт		
5	Бүдүүвч		

D СУРАХ БИЧГИЙН ХЭЛ НАЙРУУЛГАД ТАВИХ ШААРДЛАГА

D1. Найруулга нь оновчтой, товч тодорхой, энгийн ойлгомжтой, хэл найруулгын болон зөв бичих дүрмийн алдаагүй боловсруулсан эсэх

	Найруулга, зөв бичгийн дүрмийн алдаагүй боловсруулсан байдал	Үзүүлэлт		
		Код D1.1.1 Нийт сэдэв, дасгал, туршилт ажлын 91-100 хувьд илэрсэн бол хангалтгүй (1)	Код D1.1.2 Нийт сэдэв, дасгал, туршилт ажлын 80-90 хувьд илэрсэн бол сайжруулах (2)	Код D1.1.3 Нийт сэдэв, дасгал, туршилт ажилд зөрчлүүд илрээгүй бол хангалттай.(3)
1	Зөв бичгийн дүрмийн алдаа			
2	Найрууллагын алдаа (Үгийн сонголт буруу хэрэглэсэн, алдаатай өгүүлбэр)			
3	Учир зүйн алдаа – (хоёрдмол санаа, ойлгомгүй)			
4	Нэр томъёог нэг мөр			
5	Нэг өгүүлбэр дэхь үгийн тоо олон			
6	Гадаад үгийг оновчгүй хэрэглэсэн			
7	Зураг, график, хүснэгтийн тайлбар үгийн алдаатай			

8	Зураг, график, хүснэгтийн тайлбар найруулагын алдаатай.			
9	Буруу хариутай асуулт, дасгал, даалгавар			
10	Хариултгүй асуулт, дасгал, даалгавар			
11	Эргэлзээ төрүүлэхүйц жишээ, баримт			
12	Хийх боломжгүй туршилт, дадлага ажил			

D2 Агуулга нь хялбар уншигдахаар бичигдсэн эсэх

Тайлбар: Сурах бичигт шинжилгээ хийхдээ доорх боловсролын түвшингээс сонгож хийнэ үү?

	Бүлэг сэдвийн нэр	Бүлэг сэдэв тус бүрийн сэдвийн агуулгын тоо	Боловсролын түвшин				
			Үзүүлэлт				
			Бага (6-8 насад нэг өгүүлбэрийн үгийн тоо 3-5, 8-10 насад нэг өгүүлбэрийн үгийн тоо 5-10)		Суурь		Бүрэн дунд
			Код D 2.1.1 Нэг өгүүлбэр нь 3-10 хүртэл үгтэй хялбар уншиг дах сэдвийн агуулгын тоо	Код D 2.1.2. Нэг өгүүлбэр нь 10 -аас дээш үгтэй сайжруулах сэдвийн агуулгын тоо (байхгүй бол 0 гэж тэмдэглэнэ.)	Код D 2.1.3. Нэг өгүүлбэр нь 10-15 хүртэл үгтэй хялбар уншигдах сэдвийн агуулгын тоо	Код D 2.1.4. Нэг өгүүлбэр нь 15 аас дээш үгтэй сайжруулах сэдвийн агуулгын тоо (байхгүй бол 0 гэж тэмдэглэнэ.)	Код D 2.1.5. Нэг өгүүлбэр нь 15-20 хүртэл үгтэй хялбар уншигдах сэдвийн агуулгын тоо
1	Бүлэг 1						
2	Бүлэг2						

Е. СУРАХ БИЧГИЙН ТЕХНИКТ ТАВИХ ШААРДЛАГА

E1. Сурах бичгийн бичвэр, зураг, хүснэгт, график нь харагдац, тод гаргац , өнгө будгийн ялгарал гаргаж зохиосон байна уу?

	Асуудал	Үзүүлэлт		
		Код E1.1 80 -аас доош хувь нь бүдэг, үзэгдэц муу, уншигдахгүй, өнгө будаг нь нийцгүй бол хангалтгүй (1)	Код E1.2 80-90 хувь нь тод, үзэгдэц сайн, уншигдах өнгө будаг нь нийцтэй, боловч үлдсэн хувь нь бүдэг, үзэгдэц муу уншигдахгүй бол сайжруулах (2)	Код E1,3 100 хувь нь тод, Үзэгдэц сайн, уншигдах, өнгө будаг нь нийцтэй бол хангалттай (3)
1	Бичвэр			
2	Зураг, хүснэгт, график (бусад дүрслэл) нь баталгаат эх сурвалж			

3	Зургийн агуулга монголын түүх, соёл, уламжлалын санааг илэрхийлсэн.			
4	Эх зураг нь чанарыг сайн хангасан байна. Хэвлэмэл зургийг эх болгохгүй.			
5	Химийн цайруулалт хийгдээгүй, хэвлэлтийн цаас хэрэглэнэ.			
6	Сурах бичгийн наалт чанартай байх. (наалт салсан эсэх)			

Ё. Сурах бичигт SWOT хийх ажлын хуудас

Тайлбар: SWOT загварын дагуу сурах бичигт дүн шинжилгээг хийхдээ тухайн судалгааны арга зүйн агуулгын 7, аргазүйн 3, хэл найруулгын 2, техникийн 1 шаардлага тэдгээрийн үзүүлэлт тус бүрийг харгалзан бүлэг сэдэв болон тухайн сурах бичгийн нийт тоон үзүүлэлт болон тухайн хөтөлбөрийн зорилго, зорилт, агуулга, арга зүй, үнэлгээтэй уялдаа холбоотойгоор давуу, сул, боломж, сайжруулах санал гэсэн чиглэлээр дүн шинжилгээ хийхийг зөвлөж байна.

	Агуулга	
	Давуу тал	Сул тал
	Боломж	Сайжруулах санал

	Арга зүй	
	Давуу тал	Сул тал
	Боломж	Сайжруулах санал
	Хэл найруулга	
	Давуу тал	Сул тал
	Боломж	Сайжруулах санал

Техник	
Давуу тал	Сул тал
Боломж	Сайжруулах санал

2. Сурах бичиг шинжлэх “TIMMS” аргазүй

Хүснэгт 1. Бүтэц-агуулгын шинжилгээнд ашигласан шалгуур, тодорхойлогч

	Шалгуур	Тодорхойлогч	Хэмжих шкал
1.	Сэдэлжүүлэх бичвэр	1.Эрдэмтдийн намтар	1/0
		2.ТХБ агуулга, хувийн зохион байгуулалт	
		3.Монголын уламжлал, ахуй соёл, түүх, үнэт зүйлс	
		4.Сэдэвтэй холбоотой математик асуудал	
		5.Бодит статистик мэдээ, тоо, баримт	
		6.Бусад	
2.	Сэдэлжүүлэх зураг	1.Эрдэмтдийн зураг	1/0
		2.Бодит юмс үзэгдлийн зохиомол зураг (а)	
		3.Бодит юмс үзэгдлийн фото зураг (б)	
		4.Математик (график, дүрс, диаграм, загвар гэх мэт)	
		5.(а) ба (б)-дэх Монголын уламжлал, ахуй соёл, түүх, үнэт зүйлсийн зураг	
		6.Бусад	
3.	Суралцахуй-багшлахуйд дэмжлэг үзүүлэх арга зүйн санаа	1.Туршилт хийх	1/0
		2.Шууд зааварчилгааны	
		3.Ухагдахуун таниулах	
		4.Ухагдахуун хөгжүүлэх	
		5.Асуудал дэвшүүлэх	
		6.Тусгайгаас ерөнхий рүү	
		7.Ерөнхийгөөс тусгай руу	
		8.Тодорхойгоос хийсвэр рүү	
		9.Хийсвэрээс тодорхой руу	
4.	Математик өгүүлбэр	Тодорхойлолт	Нийт тоогоор
		Дүрэм, чанар, теорем	Нийт тоогоор
5.	Дасгал, бодлого	Жишээ	Нийт тоогоор
		Бататгал	
		Нэмэлт даалгавар/өөрийгөө сорих	

Математик хэлний шинжилгээ нь тэмдэг/тэмдэгт/тэмдэглэгээ/үгийн сан, математик өгүүлбэр, график дүрслэл/хүснэгтэн мэдээлэл гэсэн 3 хэсгээс бүрдэх ба эдгээр тус бүрийн хувьд ашигласан шалгуур, тодорхойлогч, хэмжих шкалыг харгалзан Хүснэгт 2, Хүснэгт 3, Хүснэгт 4-д харуулав.

Хүснэгт 2. Тэмдэг, тэмдэгт, үгийн сангийн шинжилгээнд ашигласан шалгуур ба тодорхойлогч

	Шалгуур	Тодорхойлогч	Хэмжих шкал
	Тэмдэг, тэмдэгт, тэмдэглэгээ	Уг ангид шинээр орж ирсэн	1/0
		Мат. тэмдэг, тэмдэглэгээг хэрхэн унших тухай бичсэн	1/2/3
		Унших томъёолол нь зөв	1/0
		Тэмдэг тэмдэгтийг зөв хэрэглэсэн	1/0
	Үгийн сан	Товчилсон үг	1/0
		Өдөр тутмын/техник үг/ тусгай үг	1/2/3
		Уг ангид шинээр орж ирсэн	1/0
		Өмнөх ангиас ялгаатай үг эсвэл товчлол ашигласан	1/0

Хүснэгт 3. Математик өгүүлбэрийн шинжилгээнд ашигласан шалгуур ба тодорхойлогч

	Шалгуур	Тодорхойлогч	Хэмжих шкал
1.	Тодорхойлолт	Шинээр орж ирсэн	1/0
		Хялбаршуулсан	
		Томъёолол алдаагүй	
		Тухайн ангид тохирсон үг хэллэг ашигласан	
2.	Дүрэм, чанар, теорем	Шинээр орж ирсэн	1/0
		Хялбаршуулсан	
		Томъёолол алдаагүй	
		Тухайн ангид тохирсон үг хэллэг ашигласан	
		Баталгаа, нотолгоо, үндэслэл, тайлбар хийсэн	
		Баталгаа, нотолгоо, үндэслэл, тайлбар зөв	
		Баталгааны арга(гүйцэт биш индуктив арга/гүйцэд индуктив арга/дедуктив арга/эсрэгээс батлах арга/ математик индукцын бусад)	1/2/3/4/5/6

Хүснэгт 4. График дүрслэл ба хүснэгтэн мэдээллийн (математиктай холбоотой) шинжилгээнд ашигласан шалгуур ба тодорхойлогч

	Шалгуур	Тодорхойлогч	Хэмжих шкал
	График дүрслэл	График, зураг, дүрслэл шинээр орж ирсэн	1/0
		График зургийн контекст (цэвэр математикийн/бодит мэдээ баримт эсвэл судалгааны үр дүн/зохиомол)	1/2/3
		График, зурагтай холбоотой шаардлагуудыг (нэгж, тэнхлэг, өнгө, хэмжээ гэх мэт) хангасан,	1/0
		График, зурагтай холбоотой нэр томъёо (хэрэглээгүй/ хялбаршуулсан/хялбаршуулаагүй)	2/1/0
		График, зурагтай холбоотой нэршил зөв	1/0

Хүснэгтэн мэдээлэл	Шинээр орж ирсэн	1/0
	Хүснэгтэн мэдээллийн контекст (математикийн/функцийн утгын хүснэгт, хуримтлагдсан давтамжийн гэх мэт /бодит мэдээлэл / статистикийн хорооны, эрдэмдтийн судалгаа шинжилгээний өгөгдөл иш татсан гэх мэт/зохиомол	1/2/3
	Хүснэгтэн мэдээлэлтэй холбоотой математик нэр томъёо (хэрэглээгүй/хялбаршуулсан/хялбаршуулаагүй.)	2/1/0

Сурах бичгийн анализын гуравдугаар хэсэг болох дасгал даалгаврын шинжилгээг бодлогын тавил, томъёолол, уг бодлогыг бодоход хийх математик үйл ажиллагаанаас нь хамааруулан ангилсан даалгаврын төрөл, танин мэдэхүйн хүндрэл, хариултын хэлбэр, бодлогын контекст гэсэн шалгууруудын дагуу хийлээ. Эдгээр шалгуур болон харгалзах тодорхойлогч, хэмжих шкалыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 5. Бодлого, даалгаврын шинжилгээнд ашигласан шалгуур ба тодорхойлогч

	Шалгуур	Тодорхойлогч	Хэмжих шкал
1.	Бодлогын тавил, илэрхийлэх хэлбэр	Хүснэгт	1/0
		Текст	
		Схем, диаграмм, зүй тогтол	
		Зураг	
		Математик томъёо, илэрхийлэл, бичлэг	
		Бусад	
2.	Томъёолол	Алдаагүй/зөв бичих дүрмийн алдаа/ математик алдаа	1/0/2
		Найруулга, дүрслэл, заавар ойлгомжтой	1/0
		Бодлого нь тухайн ангид тохирсон (үг)	1/0
3.	Математик бодлогын төрөл	Дүрслэх илэрхийлэх, загварчлах/тооцоолох боловсруулах/	1/0
		Тооцоолох боловсруулах	
		Тайлбарлах	
		Үндэслэх нотлох, батлах	
4.	Танин мэдэхүйн хүндрэл	Сэргээн санах/Холбох нэгтгэх/Задлан шинжлэх, асуудал шийдвэрлэх	1/2/3
5.	Хариултын хэлбэр	нээлтэй/хаалттай /олон сонголтот	1/2/3
6.	Контекст	Цэвэр математикийн/зохиомол/жинхэнэ бодит	1/2/3
		Хувь хүний/бодит мэдээлэл, судалгааны өгөгдөл/дэлхийн дулаарал, ТХБ/физик хими гэх мэт бусад хичээл/Монголын түүх, ахуй, соёл уламжлал, үнэт зүйл/бусад	1/2/3/4/5/6

